

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-110
<hr/>	
1. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	8
2. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	8-110

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
10 дугаар сарын 03-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 01 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Алтанхуяг, Б.Батбаатар, Д.Батлут, Б.Батцэцэг, Э.Болормаа, С.Ганбаатар, М.Мандхай, Ц.Мөнхбат, Ч.Ундрэм, Д.Үүрийнтуяа;

Чөлөөтэй: Х.Баттулга, Г.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан;

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, Э.Одбаяр;

Тасалсан: С.Амарсайхан, Ж.Батсуурь, Ж.Бат-Эрдэнэ, П.Мөнхтулга, Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн;

Хоцорсон: Н.Алтаниагай -18 минут, Х.Баасанжаргал -06 минут, М.Бадамсүрэн -02 минут, Ш.Бямбасүрэн -31 минут, С.Бямбацогт -2 цаг 59 минут, Д.Ганбат -26 минут, П.Ганзориг -03 минут, Д.Ганмаа -03 минут, Ц.Даваасүрэн -01 минут, Г.Дамдинням -02 минут, Т.Доржханд -13 минут, Б.Жавхлан -25 минут, Б.Жаргалан -22 минут, Б.Заяабал -03 минут, Ж.Золжаргал -01 минут, Г.Лувсанжамц -13 минут, С.Лүндэг -30 минут, Б.Мөнхсөёл -06 минут, З.Мэндсайхан -07 минут, С.Одонтуяа -26 минут, Б.Пунсалмаа -29 минут, Б.Пүрэвдорж -1 цаг 57 минут, О.Саранчулуун -01 минут, Дам.Цогтбаатар -06 минут, С.Цэнгүүн -04 минут, Ж.Чинбүрэн -12 минут, Б.Чойжилсүрэн -3 цаг 00 минут, Б.Энхбаяр -24 минут, Ж.Энхбаяр -03 минут, С.Эрдэнэбат -07 минут, Р.Эрдэнэбүрэн -23 минут.

**Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсныг танилцуулав./10:03/

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

**Нэг. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга

Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

**Д.Амарбаясгалан:** “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	63
Татгалзсан:	19
Бүгд:	82

76.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:07/

*Уг асуудлыг 10 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.** “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батхуяг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Аж үйлдвэр,

эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатар, мөн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, мөн яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлогын газрын дарга Х.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга А.Хишигбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, О.Батнайрамдал, П.Сайнзориг, О.Амгаланбаатар, О.Цогтгэрэл, Ж.Ганбаатар, Ц.Сандаг-Очир, Ц.Идэрбат, Э.Батшугар, Р.Сэддорж, Ч.Лодойсамбуу нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, мөн яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож, Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хариулахыг сануулав.

*Үдийн завсарлагааны цаг болсон тул хуралдаан 12 цаг 57 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 04 минутад эхлэв.*

*Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 14 цаг 04 минутаас хуралдааныг даргалав.*

*“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.*

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Д.Батбаяр, Д.Жаргалсайхан, Л.Соронзонболд, Г.Уянгахишиг, Д.Энхтүвшин, Н.Батсүмбэрэл, М.Энхцэцэг, Л.Мөнхбаясгалан, Ж.Золжаргал, М.Бадамсүрэн, Г.Дамдинням, С.Эрдэнэбат, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 15 цаг 31 минутаас хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, Д.Бум-Очир, З.Мэндсайхан, Ч.Лодойсамбуу, Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэболд, Д.Энхтүвшин, Ц.Мөнхтуяа, Г.Лувсанжамц, Д.Ганбат, Л.Мөнхбаясгалан нар үг хэлэв.

**Д.Амарбаясгалан:** “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-т заасан шаардлагыг хангасан байна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	55
Татгалзсан:	46
Бүгд:	101

54.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Ч.Номин, Д.Энхтүвшин нарын 4 гишүүний “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсныг мэдэгдэж, дээрх санал хураалтад тус гишүүдийн саналыг “дэмжсэн”-ээр авсан болно.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 6 цаг 47 минут үргэлжилж, 126 гишүүнээс 103 гишүүн хүрэлцэн ирж, 81.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 55 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

**ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА**

**Б.БААСАНДОРЖ**

**Тэмдэглэл хөтөлсөн:**

**ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ**

**Д.УЯНГА**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 01 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Нийт 67 гишүүн ирж, ирц 53 хувь хүрсэн байгаа учраас өнөөдрийн 10 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар чуулганы нэгдсэн хуралдаанд зарлан мэдээлэх ажлыг хийе. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан байдаг.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг танилцуулъя. 1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газар 2024 оны 08 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн Төсвийн байнгын хороонд хуваарилсан байгаа. 2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг ЗГ 2024 оны 08

сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Төсвийн байнгын хороонд хуваарилсан. 3.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг ЗГ 2024 оны 09 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан байна.

Өнөөдрийн, мөн Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж үг хэлэх бичгийг өчигдөр 17 цагаас өмнө ирүүлсэн. Гэхдээ бас хуулийн зөрчилтэй байгаа учраас өнөөдөр бас үг хэлүүлэх боломжгүй юм байна. 6 дугаар зүйл. Хуралдааны тов дараалал тогтооход баримтлах журам. 6.9. Нам, эвслийн бүлэг энэ хуулийн 6.6-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэлээ тодорхой бичиж ирүүлнэ гэж заасан. 6.10 хуралдаан даргалагч тухайн өдрийн хуралдааныг нээж, хэлэлцэх асуудалтай холбоотой нам, эвслийн бүлгээс ирүүлсэн горимын саналыг уншиж танилцуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ гэж заасан байдаг. Энэ талаар хэлэлцүүлэг явуулах боломжгүй зүйл байна.

Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 4 асуудлыг хэлэлцэнэ. 1 дүгээрт Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. 2 дугаарт Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна. 3 дугаарт Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Энэ ҮХЦ-ийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан анхны хэлэлцүүлэг байгаа юм. 4 дүгээрт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний



мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэхээр 4 асуудлыг хэлэлцэнэ. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн нам, эвслийн бүлгээс ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж, Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдлагааг Улсын Их Хурлын ТББХ-ны, Гончигдоржийн Уянгахишигийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдлагааг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны, Гончигдоржийн Уянгахишигийг Улсын Их

Хурлын ТББХ-ны гишүүнээр тус тус баталсугай.

3. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолын төсөл байна. Ингээд Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт. 63 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 76,8 хувиар 63 гишүүн.

10.07 цаг

**Хоёр. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.09.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/**

Дараачийн асуудалд оръё. Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Лувсаньямын Гантөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Гантөмөр:** Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд 2025, 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн байдаг.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Монгол Улсыг 2021-ээс 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилттой уялдуулан ЗГ-аас санаачилсан Монголд зочлох жил, Залуучуудын жил, Шинэ хоршоо, Чинээлэг малчин, Атар 4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн нэн тэргүүнд хэрэгжүүлэх бодлогын төсөл, арга хэмжээнүүдийг тусгалаа.

Хамтарсан ЗГ-ын хурдтай хөгжлийн төлөөх зориг гэрээг удирдлага болгон Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг эдийн засаг, бүсчилсэн хөгжил, хүний хөгжил, хүний эрхийг дээдэлсэн засаглалын гэсэн 4 үндсэн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурийг бэхжүүлэх зорилгыг тодорхойлж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын 14 төсөл, тогтвортой хөгжлийг хурдасгах 149 төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, салбарын реформуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Эдийн засгийн бодлогын хүрээнд урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь дэд бүтцийг бий болгох 14 мега төслийг 2025 онд багтааж бүрэн эхлүүлнэ. Макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засагт төрийн оролцоог бууруулах, салбаруудад реформ хийх ажлуудыг хэрэгжүүлнэ. Эрчим хүч, тээвэр, ХАА, банк санхүүгийн салбарт реформ хийж, бүтээмж болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийг зорино. Уул уурхайн салбарт тусгай зөвшөөрлүүдийг ил тод болгож, биржээр арилжаалдаг уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, ил тод тогтолцоог

бэхжүүлэхийг зорино. Төр, хувийн хэвшлийн түншилэлийн хүрээнд эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлж, эрчим хүчний дамжуулах, түгээх шугам сүлжээг өргөтгөн шинээр байгуулж, эрчим хүчний найдвартай байдлыг хангах төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ.

Мөн шинжлэх ухаан, технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинийг үе шаттай ахиулах бодлогыг хэрэгжүүлнэ. Хувийн хэвшилд тулгуурласан бизнесийн орчныг дэмжиж, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх юм. Дижитал эдийн засаг, ногоон эдийн засгийг бодитой нутагишуулж, ногоон санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, start-up, инноацыг дэмжих бодлого хөшүүргийг тодорхойлж хэрэгжүүлнэ. Мөн гадаад худалдаан дахь техникийн болон тарифын саад тотгорыг арилгаж, гадаад зах зээлд өрсөлдөх чадвар бүхий экспортыг нэмэгдүүлж, төрөлжүүлэх замаар олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож эдийн засгийг тэлнэ.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд байгалийн баялаг, нөөц, байршлын давуу талд тулгуурласан бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлж, бүс бүрд ач холбогдолтой томоохон төслүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангана. Бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх татварын ялгаатай бодлогыг 2025 оноос эхлэн хэрэгжүүлж, бүс орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бүс бие даан хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн бодлогоор өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ. Орон нутгийн төвлөрлийг дэмжих хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшиж буй иргэд, ААН-д үзүүлэх бодлогын дэмжлэгийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Улаанбаатар хотыг 20 минутын хот

буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулж түүнд суурилсан Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон бусад хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, дагуул хотуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлнэ. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийг дэмжин төвлөрлийг сааруулж улсын зэрэглэлтэй хотын дэд бүтэц, шинэ суурьшлын бүс байгуулах ажлыг эрчимжүүлж, санхүүгийн эдийн засаг, санхүүгийн хувьд бие даасан байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд. Иргэн бүр нийгмийн суурь үйлчилгээнд тэгш хамрагдах, орлого олох, хөгжих боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт нийцүүлсэн бодлогуудыг хэрэгжүүлнэ. Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж тус сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, Имонголиа платформоор дамжуулан иргэн бүрд хуримтлалын данс нээх юм. Хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэх зорилгоор бүх түвшний сургалтын байгууллагын чанар, суралцах орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Боловсролд бүх хүүхэд залуучуудыг тэгш хамруулах зарчмыг баримталж, ялгаатай хэрэгцээт хүүхэд залуучуудын тэдний гэр бүл орон нутгийн онцлог байдалд нийцсэн тохируулгат орчин, дэд бүтэц, хувилбартай гэрийн сургалттай боловсролын үйлчилгээг бүх түвшинд бий болгоно.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ, эрчимжүүлнэ. Иргэн эрүүл мэндийн

тусламж үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи, телемедицин, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлэх юм.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд. Төрийн албаны реформыг хэрэгжүүлж, үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Чадварлаг ухаалаг төрийн албаны тогтолцоог төлөвшүүлнэ. Төрийн үйлчилгээний цахимжилт, процессын дахин инженерчлэлийг үргэлжлүүлж, шийдвэр гаргалт, үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглан бүрдүүлж, иргэдэд ойр төрийн үйлчилгээг бий болгоно. Авлигын төсөөллийн индексийг сайжруулж, бүх нийтээрээ авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ хандлагыг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх юм.

Дээр дурдсан бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр улсын эдийн засаг 2025 онд 8 хувиар өсөж, Монгол Улсын экспорт 19 тэрбум ам.доллар-т хүрч, гадаад валютын улсын нөөц нэмэгдэж, инфляц зорилтот түвшинд хадгалагдана. Мөн ядуурлыг бууруулж, хүний хөгжлийн индекс, засаглалын индекс, дэлхийн сайн орны индексийг тус тус сайжруулна. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хэлэлцэж, шийдвэрлэж өгөхийг эрхэм гишүүдээсээ хүсэж байна. Баярлалаа та бүхэнд.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Лувсанжамц танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Лувсанжамц:** Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын

төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт. Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 9 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Төсөл санаачлагч нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нийцүүлэн Монгол Улсыг 2021-ээс 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоол зэрэг дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилттой уялдуулан боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгч, ЗГ-аас санаачилсан Хүнсний хувьсгал хөтөлбөр, Цагаан алт үндэсний хөтөлбөр, Монголд зочлох жил, Залуучуудын жил, Шинэ хоршоо Чинээлэг малчин, Атар 4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян зэрэг хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээнүүдийг тусгажээ.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг эдийн засаг, бүсчилсэн хөгжил, хүний хөгжил, хүний эрхийг дээдэлсэн засаглал гэсэн 4 үндсэн бодлогын тэргүүлэх чиглэлээр, чиглэлийн хүрээнд урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурийг бэхжүүлэх зорилгыг тодорхойлж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын 14 мега төсөл, тогтвортой хөгжлийг хурдасгах 149 төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж салбарын реформуудыг хэрэгжүүлэхээр

тусгасан байна. Тогтоолын төслийг [Dparliament.mn](http://Dparliament.mn) сайтад байрцуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар ЭТТ ХК-ийн биржээр нүүрс арилжаалах үйл ажиллагаа 17 хувь хүртэл буурсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Эрдэнэт үйлдвэрийн зэсийг биржээр дамжуулан арилжаалах үйл ажиллагаа нь зогсоосон зэрэг нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл дүүрэг орон нутаг дахь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эмч, эмнэлгийн байгууллагын албан хаагчдын орчин үеийн тоног төхөөрөмжтэй ажиллах мэргэжлийн ур чадварыг сайжруулах, ажлын байранд нь тогтвортой ажиллуулахад баримтлах бодлогын талаар болон аймгийн төвүүд дэх сумдыг татан буулгах, нэгтгэх, шинэчлэн зохион байгуулах, эдгээр сумдын удирдах албан тушаалтнуудын тоог цөөрүүлэхэд чиглэсэн тооцоо судалгаа хийсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганхуяг ТӨК-уудын засаглалын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, Хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан 14 мега төслийн хэрэгжилт, салбар хоорондын зохицуулалтыг хариуцах байгууллагын талаар, Нийгмийн даатгалын сангийн алдагдал болон улсын төсвөөс санхүүжүүлдэг олон төрлийн урамшууллаас гарсан бодит үр дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүд нь хөгжлийн төлөвлөгөөнд бүрэн тусгагдаагүй, 2025 онд хийгдэх ажлууд тодорхой бус байгаа талаар, мөн хөгжлийн төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын төслүүд тусгагдсан боловч хүрэх үр дүнг тодорхойлоогүй, батлагдсан бодлогын баримт бичгүүдэд заасан зорилт, шалгуур үзүүлэлтүүд



хоорондоо уялдаа холбоогүй, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Монголын ногоон санхүүгийн корпорацын Төр, хувийн хэвилийн түншилэлээр байгуулах тухай заалт нь хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй. Уг корпорацыг 2024 онд байгуулах эсэх талаар, хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг оршин суугчид, ААН-үүдээс санал авч боловсруулах ажил хэзээнээс хэрэгжих талаар,

Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг эрчим хүчний чиглэлийн 24 төсөл, арга хэмжээнээс зөвхөн 3 арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан нь оновчтой эсэх, гадаад улсаас зээл, тусламж авах явцад хугацаа алдсанаас эрчим хүчний салбарт үүсэж болзошгүй эрсдэлийн талаар, мөн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан цахилгаанаас үүдэлтэй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрчим хүчний системийн тогтворжилт, сэргээгдэх эрчим хүчийг зөв зохистой хөгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулахтай холбоотой арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд яагаад тусгаагүй талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахдаа орон нутгийн Засаг дарга нарын саналыг авсан эсэх, орон нутаг дахь хүнс, бараа бүтээгдэхүүн мөн орон сууцын үнийн өсөлтөд нөлөөлж байгаа шалтгаан нөхцөлийг судалсан эсэх, үүнийг зохицуулах бодлого дээр цааш хэрхэн анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг БНХАУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах арга хэмжээг тусгахдаа өмнө нь Япон улстай байгуулсан хэлэлцээрийн үр ашгийг үнэлж, дүгнэсэн эсэх, дагуул хотуудын бүтээн байгуулалтын хүрээнд хувиараа бизнес эрхлэгчид тухайн газар орон нутагт өөрсдийн санаачилгаар очиж үйл ажиллагаа эрхлэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарсан эсэх, ногоон хөгжлийн үзэл санааг нэвтрүүлэх хүрээнд

сэргээгдэх эрчим хүч ашигласан барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөсөн эсэх, мөн Монгол Улс эдийн засгийн өсөлтөө ирэх онд 8 хувь, инфляцын түвшнийг 6,5 байхаар төлөвлөсөн нь бодит байдалд биелэх боломжтой эсэх талаар,

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд орон нутагт бизнес эрхлэх эрхлэгчдэд зориулсан статистик мэдээлэл гаргах, Боомтын сэргэлтийн хүрээнд БНХАУ-аас бараа, бүтээгдэхүүн нэвтрүүлэх талаар хэлэлцээр хийх, мөн богино хугацаатай цагийн хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн хөдөлмөрийн харилцааг хамгаалах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг энэ төлөвлөгөөний төсөлд тусгасан эсэх, орон нутаг дахь бэлчээрийн маргааныг зохицуулахад баримтлах бодлого, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан эрчим хүчний хэмнэлттэй, бие даасан шийдэлтэй амины орон сууц барихад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ хэрэгжих эсэх, сумдын сургуулиудад багш нар дутмаг байдгаас дунд ангиудын сурагчид шилжилт хөдөлгөөн хийдэг асуудлаар авах арга авах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Хөгжлийн төлөвлөгөөнд хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай заалтууд тусгагдсан хэдий ч энэ чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүд хангалтгүй. Энэ төлөвлөгөөг боловсруулахад талуудын оролцоог хэрхэн хангасан, саналыг нь тусгасан эсэх талаар, нийгмийн даатгалын өр 2019 оны үеэс 3,6 дахин нэмэгдсэн тоон үзүүлэлт бодитой эсэх, улирлын шинжтэй, бага үнэлгээтэй ажлын байран дээр гадаадаас ажиллах хүчин оруулж ирэхэд холбогдох татварыг хөнгөлөх, чөлөөлөх чиглэлээр баримтлах бодлогын талаар, ТӨК-иудын зээл олголт, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах явцад хяналт шалгалт хангалттай хийгддэг эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн, М.Мандхай ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт МАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг

хоршоодыг чадавхжуулах, малчдад зөвлөх, зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш бэлтгэх, сургалт зохион байгуулах заалт тусгайлан нэмэгдсэн боловч хөгжлийн төлөвлөгөөнд уг зохицуулалт тусгаадаагүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Хэрлэн-Тооно, Орхон-Онги төсөл, Монгол Францын хамтарсан ураны төслийн бэлтгэл ажил, Тавантолгойн цахилгаан станцын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хугацаа, Гацуунсухайт-Ганцмод боомтод хил дамнасан төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминал барих, Шивээхүрэн-Сэхээ хил боомтын төмөр зам барих ажлуудын 2025 онд хүрэх түвшнийг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний төслийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцүүлэх хүрээнд төлөвлөгөөний төсөлд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийг сайтар нягталж, ирэх онд хийгдэх ажлуудыг тодорхой тусгах, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.4.3 дахь заалтад тусгагдсан хоршооны загвар төслийг бэлтгэх ажлыг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний баримт бичгийн хавсралтуудыг шинэчлэн боловсруулах шаардлагатай байгаа талаар санал хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг

та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд, Лувсаннъямын Гантөмөр Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сайнбуянгийн Амарсайхан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Тогмидын Доржханд Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын шадар сайд, Ням-Осорын Учрал Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Буяагийн Тулга Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Равжихын Эрдэнэбүрэн Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд 20 минутын хот үндэсний хорооны дарга, Батмөнхийн Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цэвэгдоржийн Туваан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Сандагийн Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн, байгаль орчин, уур амьсгалын, Батлан хамгаалахын сайд, Салдангийн Одонтуяа Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Улсын Их Хурлын гишүүн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд, Чинбатын Номин Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлалын жуулчлал, залуучуудын сайд, Жамбын Батсуурь Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндийн Баатархүү Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа

холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Лханаажавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны ТНБД, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны ТНБД, Сэрээтэрийн Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны ТНБД, бригадын генерал, Ханджавын Батжаргал Боловсролын яамны ТНБД, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн ТНБД, Адъяасүрэнгийн Даваажаргал Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сүхбаатарын Төмөрхүү Хот байгуулалт, барилга, хот, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Пушаагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны ТНБД, Дагвадоржийн Очирбат Эрүүл мэндийн яамны ТНБД, Шаравын Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Ням-Очирын Лхагвадорж ЗГХЭГ-ын Хяналт үнэлгээний үндэсний хорооны Ажлын албаны дарга, Болдын Цэнгэл ТӨБЗГ-ын дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал, Хүүгийн Мөнхжаргал Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Цэвээндоржийн Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Доржготовын Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газрын

дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга, Сүхбаатарын Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, Харнүдэнгийн Мөнхзул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлогын газрын дарга, Амарсайханы Хишигбаяр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын газрын дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн ТНБД. Энэ чинь буруу биччихсэн байна. Цогтын Баярбат Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга, Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Дугаржавын Амгалан НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга, Жамъяншиаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Болдбаатарын Марс-Од НЗДТГ-ын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Дэд бүтцийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга гэсэн байна. Тэгээд Болорчулуун даргын албан тушаалыг буруу бичсэн байх шиг байна шүү Хөдөө аж ахуйн яам.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.17-д улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй гэж заасны дагуу жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Нийт 28 гишүүн асуулт асуухаар нэр ирсэн байна. Өглөө ирсэн ирцийн дагуу асуултаа асууж эхэлье. Цагаанхүүгийн, энэ дараалал орж, Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуултаа асууя.

**У.Отгонбаяр:** Өглөө ирсэн ирцээрээ Идэрбат гишүүнээ. Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Сая ээлжит бус чуулганы ар дээр бид

бүхэн бас зүүн бүс нутгаар тойрогтоо бас нэлээдгүй ажиллалаа. Тэгээд ард иргэдтэй уулзаж, ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, ээлжит бүс чуулганаар хэлэлцсэн асуудлыг бас танилцуулж, санал бодлыг нь сонсож нэлээн явлаа. Их олон давтагдсан асуудлаар би бас холбогдох яамнаас бас яамнуудаас тодруулах асуулт байна. Төрийн цэргийн байгууллагын тэтгэвэрт гарсан албан хаагчдын талаар. Жишээ нь төрийн цэргийн байгууллагаас тэтгэвэрт гараад хэд хэдэн тохиолдол бид нараас асууж тодруулсан. Бурхан болсон хүмүүст тэтгэвэр тэтгэмж олддоггүй. 1 дүгээрт буяны ажлын зориулсан төрөөс олгогддог мөнгө олддоггүй. 2 дугаарт хань ижил нь бурхан болоод үлдэж байгаа хань ижилд нь тэтгэврийг өвлүүлэх асуудал бас хязгаарлагдмал, болохгүй гэдэг зүйл заалттай байдаг юм байна. Тэгээд энэ чиглэлээр бас төсөв төлөвлөгөөнд туссан, цаашидаа энэ чиглэлээр яахаар байгааг бас холбогдох яамнууд бас нэг тодорхой хариулт өгөөч.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан хариулна.

**Л.Энх-Амгалан:** 1 дүгээрт энэ оршуулгын зардлууд олдохгүй байна, авах ёстой улсууд нь авч чадахгүй байна гэсэн нэг ийм юу гарсан юм шиг байна. Энэ ер нь яагаад ийм асуудал үүссэн юм бол? Та яг энэ хүнийхээ нэр харьяаллын мэдээллүүдийг надад өгөх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Энэ бас нэг үл ойлголцол үүссэн болов уу гэж бодож байна. Бид нар хуулиараа энэ тэтгэмжийг олгох ёстой. Энэ мөнгө нь бол ингээд тусгагдаад явж байдаг. Энийг ингээд залруулъя гэж 1 дүгээрт бодож байна.

2 дугаарт нь болбол өнгөрсөн жил бид нар энэ Нийгмийн даатгалын багц хууль буюу нэлээн томоохон шинэчлэлийн энэ хуулиудаа эрх зүйн шинэчлэлүүдийг хийсэн. Энэ хүрээнд болбол бид нар

үндсэндээ энэ нөгөө хэрэв гэр бүлийнх нь нэг нь ингээд хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн тохиолдолд гэр бүлийнх нь нэг гишүүн нь авдаг авч байсан тэтгэврийнх нь 20 хувийг тэтгэвэр дээрээ нэмж авах ийм зохицуулалттай болсон байгаа. Тэгэхээр энэ зохицуулалтууд болбол энэ оноос ингээд хэрэгжээд эхэлнэ. Юуны өвлүүлэх тухай асуудлууд бас хуулиар бас энэ зохицуулалтууд бол нээсэн. Тэгэхдээ өвлүүлнэ гэдэг нь бүтэн тэтгэврийг өвлүүлэх тухай асуудал бол биш. Нөгөө хань бүлийнх нь, гэр бүлийнх нь хүний авч байсан тэтгэвэр дээр нь авч байсан тэтгэврийнх нь 20 хувийг гэр бүлийнх нь гишүүдэд нь 20 хувийг нь нэмдэг ийм зохицуулалттай хуулийн хэрэгжилт явагдаж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Ухнаагийн Отгонбаяр гишүүн тодруулга асуулт асууя.

**У.Отгонбаяр:** Энэ яагаад болохгүй байгаа гэвэл нийгмийн даатгалыг нь төрөөс хариуцдаг учраас тэр оршуулгын зардал, хань ижлийнх нь тэтгэвэр тэтгэмжийг өвлөх асуудал хаалттай байгаад байгаа юм билээ. Тийм учраас энэ дээр бас тодорхой ямар зохицуулалт байж болох вэ? Энэ дээр бас тодруулж өгөөч?

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулъя. Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Энэ цэргийн албан хаагчийн тэтгэвэр авагч нас барвал оршуулгын тэтгэмж олгодог. Ингээд цэргийн албан хаагчдын энэ асуудал болбол Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулагддаг ийм байгаа. Юуны 20 хувийн нөгөө хань бүлийнх нь, гэр бүлийнх нь гишүүнийх нь авч байсан тэтгэврийнх нь 20 хувийг нөгөө үлдсэн гэр бүлийнх нь гишүүн авах бол энэ зохицуулалтууд хийгдээд эхэлсэн. Гэхдээ энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой манай ард иргэдийн дунд байгаа ойлголтууд тодорхой энэ чинь бас тийм яг хүн бүхэнд



ингээд олгогдох асуудал биш. Тодорхой нөхцөл, шалгуур юу байгаа хуулиар тавьсан ийм шалгуурууд байгаа. Тэгээд нөгөө яг нөгөө НДШ-үүдээ тасралтгүй төлж байсан, нөгөө ханилсан нөгөө гэр бүл ханилж суусан нөгөө нэг гэр бүлийнх нь гэр бүл байсан хугацаа энэ тэр гээд ингээд шалгуурууд байгаа учраас энэтэй уялдуулсан ийм хуулийн зохицуулалттай холбоотой үл ойлголцлууд үүссэн юм болов уу л гэж би бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө ярьж байна. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн сайдаас асуумаар байгаа юм. 25 он онцлог жил болно. 25 онд макро эдийн засаг талаас аваад үзсэн ч гэсэн эдийн засгийн бүтэц талаас аваад үзэх юм бол 2 том үйл явдал бол болохоор харагдаж байгаа юм. 1 дүгээрт бол Оюу толгойтой /ОТ/ холбоотой. ОТ-н орд 2009 оноос хойш сүүлийн 15 жил бол уул уурхайн олборлогч компани гэхээсээ илүүтэйгээр бүтээн байгуулалтын төсөл явж ирсэн. Бүтээн байгуулалтын маш том мега төсөл. Сүүлийн 15 жил 24 оны эцэс гэхэд бараг 19 тэрбум долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтыг Монгол Улсад оруулж ирж байгаа манай макро эдийн засгийг тэгшитгэлээр аваад үзэх юм бол нэг хэмжигдэхүүн нь ингээд болсоор ирсэн. Жил, тэгэхээр жил болгон л 1-ээс 2 тэрбум доллар орж ирдэг гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр энэ бүтээн байгуулалт маань 2025 он хүрээд дуусаж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол ОТ-н энэ том төслийн мега төслийн хувьд бол бүтцийн маш том шилжилтийг 25 онд хийнэ. Тэгэхээр энэ шилжилт хийнэ гэдэг нь юу гэсэн үг вэ гэхээрээ ОТ бүтээн байгуулалтын компани биш, бүтээн байгуулалтын мега төсөл биш одоо бол зүгээр л олборлогч компани болно гэсэн үг. Тэгэхээр энэ бүтээн байгуулалт нь сүүлийн 15 жилийн хугацаанд бараг 20-

оос 22 мянган ажлын байрыг бий болсон. Маш их ур чадвар үүссэн. Одоо олборлогч компани болоод явахаар үндсэн ажил чинь үсрээд л нэг 4-өөс 5 мянган хүн л ажилтай үлдэнэ гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ буцаад эдийн засагт бол маш том шок болж ирнэ. Тэгэхээр 25 оны хөгжлийн төлөвлөгөө ярьж байхад энэ хэр туссан бол? Би бол энэ төлөвлөгөөнөөс хайгаад олсонгүй. 1 дүгээрт энд бид нар бэлэн үү?

2 дугаарт 25 онд бас нэг чухал үйл явдал хүн ам зүйн бүтэц, хүн ам зүй. Монгол Улс бол залуучуудын орон, нийт хүн амын 2/3 нь 39-өөс доош насны залуучууд. Тэгэхээр аливаа улсад хүн ам зүй талаас нь аваад үзэх юм бол энэ бол цонх үе дээрээ бид нар одоо хүртэл явж байна гэсэн үг. Энэ бол маш том боломжийг олгодог. Нэг ёсондоо ажил хийж байгаа хүмүүс нь тэтгэвэр авч байгаа эсвэл ахмадаасаа илүү олон байдаг гэсэн үг. Тэгэхээр энэ хөгжлийн төлөвлөгөөний 44 дүгээр хуудас дээр 2025 оноос эхлэн хүн ам зүйн цонх үе хаагдаж эхэлнэ гэж байгаа юм. Яах вэ хаагдах яг хаагдах биш гэж ойлгож байгаа. Ер нь бол гэхдээ хүн, энэ цонх үе 25 оноос өгсүүлээд цаашаагаа илүү тэлж байсан цонх үе илүү буурах эсрэг тренд рүүгээ орж ирнэ гэсэн үг юм. Энэ бол буцаад макро эдийн засагт ч гэсэн маш том нөлөө үзүүлнэ.

Өнөөдөр 5, 10 НДШ төлөгч 5 хүний тэтгэврийг дааж байгаа. Энэ 2030 он гэхэд 5-хан төсөв баталсны дараа 10 НДШ төлөгч 7 хүний тэтгэврийг даана, даах ёстой болж ирнэ гэсэн үг. Хүн ам зүйн бүтэц талаас аваад үзэх юм бол. Тэгэхээр энэ нэг ёсондоо боломжгүй болно гэсэн үг. 2030 он гэхэд хэрвээ бид нар энэ асуудлаа шийдэж чадахгүй бол улсын төсөв энэ орон зайг нөхөж чадахгүй, бараг Монгол Улс дампуурах хэмжээнд хүрэх том эрсдэл гарч ирнэ гэсэн үг л дээ. Тэгэхээр энэ тренд 2025 оноос ингээд эхэлж байна. Энэ 2 макро эдийн засгийн түвшинд маш өндөр ач холбогдолтой 2 зүйл гарч ирэх ийм чухал

он жил байгаа юм. Тэгэхээр энэ 25 оны хөгжлийн төлөвлөгөөнд хэрхэн тусаж байгаа вэ? Ер нь хоёулан дээр нь арга хэмжээ авах ч юм уу, төлөвлөгөө гаргахгүй бол аль хэдийн оройтчихсон дүр зураг харагдаад байгаа юм л даа. Тэгэхээр энэ талаар бас тодорхой хариулт авъя гэж бодож байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Хариулах хэн хариулах билээ? Лувсаньямын Гантөмөр сайд хариулъя Шадар сайд.

**Л.Гантөмөр:** Тэгэхээр ОТ болбол их сайн болж байгаа. Гүний уурхайн олборлолт эхэлж байгаа. Зах зээл рүү хамаагүй буруу мессеж бид нар шидээж болохгүй. Энийг болбол Монголын төр засаг жилийн өмнөөс харж байгаа, харж байсан. Харж байсан учраас болбол энэ том мега төслүүдийг хөдөлгөө гэж зориод байгаа юм. Жишээлбэл Монгол Францын ураны төслийг өнөөдөр бид хэлэлцээрээ шамдуулаад байгаа шалтгааны нэг нь энэ. Тийм учраас болбол бид нар хамаагүй 20 мянган хүн ажилгүй болох гэж байна энэ тэр гэсэн цуурхал бол тарааж болохгүй шүү. Мэдээж хэрэг яг тэр салбарт ажиллаж байсан хүмүүс он гараад хаана ажиллах вэ гэвэл Таватолгойн цахилгаан станц дээр тэр компаниуд ажиллана. Ураны төслийг хэрэгжүүлэхэд 5,4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт эхэлнэ. Энэ төсөл дээр ажиллана гэх мэтчилэн бид нар энэ мега төсөл байж манай эдийн засгийн өсөлт буюу эдийн засгийн тогтвортой байдал хангагдана шүү гээд ЗГ их олон удаа энэ 14 мега төслийн ард гарна гэж яриад байгаа шалтгаан энэ шүү.

Хуучин болбол бид нар ингээд нэг ОТ-гоор Монголын эдийн засгийг баримжаалдаг байсан бол тэр үе бол одоо ард үлдсэн. Одоо бид нар цоо шинэ түвшин рүү шилжчихсэн байгаа гэдгийг бүгдээрээ санаж, ухамсарлаж явцаах ёстой. Тэгэхээр болбол Тавантолгойг гацааж болохгүй. Гацуунсухайт-Ганцмодын хил холболтыг гацааж

болохгүй. Францын, Монгол Францын хамтарсан уран олборлох төслөө бид нар заавал явуулах хэрэгтэй, хамтдаа явуулах хэрэгтэй. Мөн эрчим хүчний шинэ хөрөнгө оруулалтуудыг бид нар татахад төр засаг хамгийн уян хатан бодлогыг явуулах ёстой. Тэгээд бидний хүсээж байгаа зүйл бол зэсийн олборлолтыг ОТ болбол чанарын хувьд сайжирна. Хэмжээ болбол бид нар дахиад дараагийн хэмжээс рүү шилжинэ гэсэн ийм төлөвлөлтийг хийж явах ёстой гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна. Тийм учраас болбол хөрөнгө оруулалтаа бид нар өнгөрсөн жилүүдэд 2-оос 3 тэрбум долларын хөрөнгө оруулалт татаж байсан бол яг энийгээ ЗГ ирэх онд 3 гэдэг тоогоо ямар ч тохиолдолд алдаж болохгүй гэдэг ийм л амбицтай төлөвлөгөөг өргөн барьж байгаа шүү дээ 1 дүгээрт.

2 дугаарт нийгмийн даатгалын системийн шинэчлэлтийг хийхээр бид нар бас нэг Засаг дээр ажлын хэсэг гараад энийгээ Энх-Амгалан сайд удирдаад ажиллаж байгаа. Удахгүй дүр зургийг нь харуулна. Мэдээж бид нар өнөөдрийн нийгмийн даатгал төлөгчдийн мөнгөөр өнгөрсөн цагийн хүмүүс, өнгөрсөн тэтгэвэрт гарсан хүмүүсийнхээ тэтгэврийг төлөөд 30 жил явсан, энийгээ бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр энэ зайг хэрхэн нөхөх вэ гэдэг бодлогыг хийхийн тулд Баялгийн сан, мөн Ирээдүйн өв сан гэдэг энэ бодлого руу бид нар шилжиж байгаа шүү дээ. Тэгэхээр болбол энэ тухай.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

**П.Сайнзориг:** Та бүгддээ бас энэ өглөөний мэндийг хүргэе. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг бид нар хэлэлцэж байна. Энэ төлөвлөгөө маань ер нь улс орны бүхий л нөхцөл байдалд нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл ялангуяа хувийн хэвилийн ирэх жилийн бас бизнесийн төлөвлөгөөгөө энэ улсын хөгжлийн төлөвлөгөөг бас харж, ямар үйл ажиллагааг төр хийх, ямрыг нь

дэмжлэгүүд орж ирэх ч гэдэг юм уу ийм зүйлүүд бас яригдаж байгаа ийм чухал төлөвлөгөө байгаа. Мөн ЗГ-ын үйл ажиллагааны 28 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх энэ гараанаасаа гарч байна уу гэдэг зүйлийг ч гэсэн энэ төлөвлөгөөг хэрхэн яаж батлахаас бол хамаарах байх гэж би бас хувьдаа бодож байгаа юм.

Тэгэхээр ерөөсөө дөрөвхөн зүйлийг би асууя гэж бодож байгаа юм. Ирэх жил бас сая хаврын чуулганаар баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль хэрэгжиж эхэлнэ. Өөрөөр хэлэх юм бол 25 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс 32 жилийн дараа батлагдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль энэ аймгийн төвүүд үндсэндээ цаашидаа хот болж хөгжих, суурин газруудыг бид нар хот нийтийн аж ахуйг нь хөгжүүлэх асуудал байгаа. Өнөөдөр илүү их тэр хэсгээ хаяад, хот төлөвлөгч жишээ нь аймгийн төвийн сумууд дээр ажиллахгүй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чиглэлийн бэлтгэл ажлын хүрээнд ямар зүйлүүд тусгагдсан бэ? Маш том хэмжээний суурь реформ хэрэгжих гараан дээр ирчхээд байдаг. Би ерөөсөө энэ хөгжлийн төлөвлөгөөнөөс Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг хэрэгжүүлэх асуудлыг ерөөсөө олж харсангүй. Тэгэхээр энэ дээр ЗГ ямар байр суурьтай байгаа юм бэ? Хууль бол батлагдчихсан байгаа.

Дээрээс нь энэ ипотекийн зээлийн асуудал байна. Нэлээн бас ЗГ-ын тэргүүн бас өмнө нь өгч байсан мэдээллүүд дээр бол нэлээн юу гэдэг юм энэ чиглэлийн бодлогыг ахиу тавина, эргээд энэ иргэдийн аятай тухтай амьдрах, эргээд энэ инженерийн байгууламжтай энэ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиглэлд нь бас нэлээн дэмжиж ажиллана. Ялангуяа анхдагч орон сууцаа авч байгаа залуучуудыг дэмжих, амины болон ногоон орон сууцын төслүүдийг ипотекийн зээлд илүү их түлхүү хамруулах, ялангуяа эндээ юу гэдэг юм төв магистраль шугамаас магадгүй амины орон сууцын хотхон руу орж

байгаа тэр шугам сүлжээ дээр хүртэл ипотекийн зээл олгох асуудал яригдаж байгаа тийм зүйл байна уу?

Магадгүй өөрөө өөрийнхөө эрчим хүчний асуудлыг шийдэх энэ тархмал эрчим хүчний эх үүсвэрээр шийдэх асуудал дээр ипотекийн зээлд хамруулах ийм бодлого энэ тэр ярьж байгаа зүйл байгаа юу? Энэ дээр бас нэг тодорхой өгөөч? Зөвхөн нийтийн зориулалттай орон сууц гэхээсээ илүүтэйгээр бас амины болон ногоон орон сууцын төслүүд дээр ипотекийн зээлийг ер нь хэрхэн яаж хамруулах байдалтай байгаа вэ? Бодлогын хувьд юу гэж орж байгаа вэ гэдэг зүйлийг бас нэг хэлж өгөөч.

Ер нь нэг зүйлүүд байна. Энэ ААН байгууллагуудын төлөвлөлтэй уулзахаар ажиллах хүчний хомсдол дутагдалд их орлоо. Зунжингаа бид нар 100 жил тэмдэглээд би алба хаагчдынхаа аль, аль аймаг сумын гаралтайг нь тодруулаад, бараг сумын 100 жилүүдэд нь тохируулж байж бас энэ хөдөлмөрийн хуваарилалт энэ тэрээ хийж байна. Ингээд сүүлдээ намартаа бүгд самарт гараад явчхаж байна. Ер нь ажиллах хүч маш хүнд байна л гэж байна. Тэгэхээр ер нь зүгээр энэ ажиллах хүчний квот гэдэг зүйлээр бид нар энэ бас жижиг ААН, дунд зэргийн гэдэг юм уу, дундаас доошоо ААН байгууллагуудаа боомилдог ийм зүйл байна. Шинээр тоног төхөөрөмж суурилуулаад тэр жилдээ ядаж ганц хүн ч гэсэн инженерийг оруулж ирээд тэр үйлдвэрийг зүгшрүүлтэл хүртэл ажиллах хүч оруулж ирэх боломжгүй байна шүү дээ. Улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг ААНБ дээр жишээ нь энэ боломж байхгүй байна. Тэгэхээр энэ зүйлүүдийг жоохон уян хатан болгох асуудал бол анхаарч ийм зүйлүүд байгаа юу?

Ер нь бусад оронд бол улирлын чанартай болон ер нь тодорхой шинэ тоног төхөөрөмж суурилуулах ч гэдэг юм уу, шинээр know how инновац тухайн улс орондоо авчирч байгаа байгууллагын тэр

энийг дагаж орж ирж байгаа ажиллах хүчийг жишээ нь квотгүйгээр оруулж ирдэг зүйлүүд байх юм. Тэгэхээр бид хэд болохоор ингээд хатуу ингээд хуульчилчихаад, тэгээд л нэг том ААН байгууллагууд л энэ квотыг эдэлдэг. Тэгээд ажлын байрны төлбөрөөс ЗГ-ын шийдвэрээр чөлөөлүүлдэг. Жижгүүд нь энэ боломжийг ерөөсөө хүртэхгүй байх юм. Энэ чиглэлийн бодлого өөрчлөлт юу байгаа юм бэ гэдэг зүйл байна.

Хамгийн сүүлийн 4 дэх асуулт.  
Шүүх эрх мэдлийн байгууллага.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энх-Амгалан сайд эхлээд хариулт өгье. Тэгээд нэмээд эрчим хүчний асуудал яригдлаа, ипотекийн зээлийн асуудлууд яригдлаа. Холбогдох хүмүүс хариултаа бэлдээрэй.

**Л.Энх-Амгалан:** Сайнзориг гишүүн ипотекийн зээлийн хүртээмжийн асуудал, ажиллах хүчний хомсдол үүссэнтэй 2 асуудал асууж байна. Ипотекийн зээлийн тогтолцоог ер нь Монгол Улс өөрөө ингээд үндэсний нэг ийм тогтолцоотой болж чадаагүй бид нар явсан юм байна. Ер нь бол орон сууцын зээлийн тогтолцоог ингээд Монголбанканд хариуцуулаад, Монголбанкны ипотекийн зээлийн нэг ийм хязгаарлагдмал нэг эх үүсвэр тавиад, тэгээд тэрийгээ бид нар энэ 3 хувийн, 6 хувийн, 8 хувийн гэсэн нэг ийм зээлийн тогтолцоотой өнөөдрийг хүртэл явж ирсэн. Тэгээд бид нар энэ Монгол Улс цаашидаа ер нь энэ орон сууцын зээлийн тогтолцоо үндэсний тогтолцоогоо бид нар урт болон дунд хугацаанд бий болгох ийм зайлиггүй шаардлага өнөөдөр үүссэн юм байна лээ. Зөвхөн энэ бол ганцхан Монголбанкны асуудал биш.

Тэгэхээр саяын байгуулагдсан хуримтлалын сан бид нар Хуримтлалын сантай болсон. Ингээд энэ жил Хуримтлалын сангийн эх үүсвэр дээр бол 490 тэрбум, ирэх жил болбол 524 тэрбум төгрөгийн эх үүсвэрүүд орж ирнэ.

Тэгэхээр Монгол Улсын энэ ипотекийн зах зээлийн энэ хүртээмжүүдийг хамгийн гол нь энэ орлогод нийцсэн орон сууц худалдаж авах гэж байгаа энэ иргэдийн ипотекийн энэ хүрэлцээг л нэмэхийн тулд бид нар энэ олон эх үүсвэрт ийм тогтолцоог бий болгох, цаашидаа энэ 2 дахь зах зээлийг бий болгож байж энэ ипотекийн үндэсний тогтолцоог бий болгох юм байна гэж харж байгаа. Тэгээд Ерөнхий сайдаар ахлуулсан Орон сууцын үндэсний ипотекийн хороо байгуулагдсан. Ингээд энэ хорооны гол зорилго болбол энэ ипотекийн Монгол Улсад байгаа өнөөдөр энэ ипотекийн зээлийн хүртээмж, цаашиаа үндэсний тогтолцоог бид нар урт хугацаанд ямархуу тогтолцоог авч явах вэ гэдэг ийм бодлогын шийдлүүдийг гаргах хороо ажиллаж байгаа.

Ирэх жил бид нар үндсэндээ ипотекийн зээлийн хүрэлцээг нэмэхийн тулд 1,3 их наядын шинэ эх үүсвэрүүд гаргаж ирж байгаа. Энэ болбол Хуримтлалын сангийн эх үүсвэрээс 524 тэрбум, 520 орчим тэрбум төгрөг, тэгээд арилжааны банкнуудаас 300 гэх мэтчилнээр, ингээд Монголбанкнаас 500 гээд ингээд үндсэндээ 1,1-ээс 1,2 их наядын эх үүсвэрүүдийг бид бий болгоно. Хамгийн гол асуудал болбол яг нөгөө орлогод нийцсэн орон сууцууд байна уу? Яг энэ нөгөө ипотекийн зээлийг яг нөгөө орлого багатай иргэд анх удаа орон сууц авч байгаа иргэд дээр бид нар яаж энэ зорилтот бүлгүүд рүү хүргэх вэ гэдэг асуудал болбол нэлээн тийм том сорилт юм байна лээ. Эрэлт, нийлүүлэлт талаасаа ч гэсэн. Жишээ нь амины орон сууцад бид нар энэ ипотекийн зээлүүдийг өгөх боломжуудыг бид нар нээсэн. Харамсалтай нь өнөөдөр хүртэл энэ амины орон сууцуудын стандарт, баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлтийн асуудлуудыг нэг мөр болгож чадаагүй учраас энэ хүмүүст боломж нээгдэж байгаа энэ боломжуудыг хүмүүс хүртэж чадахгүй байх ийм нөхцөл байдлууд үүсэж байна.



Тэгэхээр ойрын хугацаанд болбол Монгол Улсын ЗГ-аас холбогдох энэ бодлогын шийдлүүдийг гаргаж, иргэн бүрд тэр тусмаа анх удаа гэр бүл болж байгаа, анх удаа орон сууц авах гэж байгаа, олон хүүхэдтэй байгаа, амины гэр хороололдоо амины орон сууцуудаа сайжруулах, гэр хорооллоос орон сууц руу шилжих, Улаанбаатар хотоос.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулъя. Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Улаанбаатар хотоос орон нутаг руу шилжих энэ хүмүүсийн зорилтот бүлгүүд рүү чиглэсэн төрийн албан хаагчид руу чиглэсэн ийм ипотекийн бодлого, ипотекийн зээлийн хүртээмжүүдийг хийнэ Сайнзориг гишүүнээ.

2 дахь асуудал болбол энэ ажиллах хүчинтэй холбоотой асуудал байгаа. Энэ болбол үнэхээр манай Монголын өмнө бид нарын бас том толгойны өвчин болсон байна. Яг хөдөлмөрийн зах зээл дээр болбол маш тийм сонин парадокс гэж хэлэхээр ийм парадокс үүсчихсэн байж байгаа. Нэг талдаа бид нар ажилгүйдэлтэй, нөгөө талдаа ажиллах хүчний хомсдолтой болчихсон байж байгаа. Тэгэхээр ямар ч байсан ЗГ-аас хавар гарсан энэ нөгөө ажиллах хүчний 16 салбарт, эдийн засгийн 16 салбарт болбол бид нар квотгүй болгочихсон. Энэ нөгөө ажиллах хүчнээс төлдөг энэ төлбөрийн 50 хувийн хөнгөлөлтийг бий болгочихсон байгаа. Тэгээд харамсалтай нь энэ болбол тэр болгон энэ мэдээллүүд энэ ААН-үүд, тэр тусмаа жижиг, дунд ААН-үүдэд хүрээгүй учраас энэ асуудлуудыг бид нар хэрэгжүүлэх чиглэл рүү нэлээн анхаарна. Ер нь ирэх жилээс бид нар энэ хөдөлмөр эрхлэлтийн асуудал дээр.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар Эрдэнэбүрэн сайд хариулъя.

**Р.Эрдэнэбүрэн:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль 26 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхлэх гэж байгаатай холбоотой хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг хангах чиглэлээр бол ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна. 10 сарын 16-нд Үндэсний хороо хуралдаад, төлөвлөгөөг нь батлах гэж байгаа. Тэгээд энэ орон нутгийн сонгуулийн дараа болбол бүх шинээр сонгогдсон аймгийн дарга нарыг цуглуулаад хурал уулзалт хийх гэж байгаа. Тэгээд энэ ажлыг бас ажилд бас оролцъё гээд Алдаржавхлан гишүүн саналаа өгсөн байгаа. Сайнзориг гишүүнийг бас хамт оролцоод явбал сайн байна гэж ингэж хэлмээр байна. Энэ ажил бол ингээд төлөвлөгөөний, төлөвлөгөөгөө гаргаад явна. Тийм учраас энэ юун дээр бол бичигдсэн зүйл алга. Мэдээж нэлээн их олон ажлууд байгаа. Ажлын явц бол иймэрхүү байдалтай явж байгаа гэдгийг хэлмээр байна.

**Д.Амарбаясгалан:** Сайнзориг гишүүн тодруулъя. Энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг ер нь бараг нэг авч үзэх шаардлага гарсан ч байж магадгүй. Гишүүдийн байр суурь их өөр, өөр байр суурь илэрхийлдэг болчихсон байна лээ. Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Тэгээд ер нь зүгээр бид хэд бас энэ гол, гол суурь реформ болж байгаа хуулиудын бэлтгэл ажлыг нэг төлөвлөгөө гаргах байдлаар ч юм уу, яг хэрэгжих цаг хугацаанд тулгаад бас явмааргүй байгаа юм. Наад зах нь л ерөнхийдөө 21 аймгийн төвүүд дээр чинь хот төлөвлөгч хэрэгтэй болно. Энэ хот төлөвлөгчийг дагасан бас тодорхой хэмжээний санхүүгийн эх үүсвэр, хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний бас эхний асуудлууд, суурь дэд бүтцийн нөхцөл байдлуудаа тодруулахаас эхлээд маш олон асуудлуудыг бид урьдчилаад бас сонгууль гэхгүйгээр уг нь бол хийж байх ёстой юм байгаа юм. Тэгээд ер нь зүгээр юу гэдэг юм энэ чиглэл рүүгээ бас

анхаарал хандуулахыг би бас хүсээж байгаа юм.

Асууж чадаагүй нэг асуулт байна. Шүүх эрх мэдэл, авлигатай тэмцэх ажлын энэ 25 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнөөс бас яг бодитой ажлууд ерөөсөө харагдахгүй байна. Жоохон тунхаг байдалтай. Өнөөдөр яг бид хэд хөрөнгө оруулалт бизнесийг дэмжих, авлигатай тэмцэх гэдэг юм уу энэ хүний эрхийг хангах чиглэл дээр бол энэ шүүх эрх мэдлийн байгууллагын хөрөнгө оруулалтын асуудал ерөөсөө 1 л орхигддог.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулах хүн хэн байна вэ? Сая тодруулж асуух асуулт шинээр асуулт асуугаад л явчихлаа. Бас гишүүд дэгээ барина шүү. Хариулт өгөх хүн байна уу? Эрчим хүчний салбартай холбоотой асуудал. ТНБД Тавинбэх хариулт өгье. 2 дугаар индрийн микрофон өгье.

**Н.Тавинбэх:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Цэвэр ногоон эрчим хүчний хангамжийг сайжруулахын тулд Эрчим хүчний сайдын тушаалаар ахуйн хэрэглэгч дээр хэрэглээгээ бүрэн хангах, үйлдвэр, аж ахуйн газруудын хувьд авсан техникийн нөхцөлийнхөө өөрөөр хэлбэл хэрэглээнийхээ 50 хүртэл хувийг өөрөө санхүүжилтээ гаргаад цэвэр ногоон эрчим хүчээр хангах энэ боломжийг эрх зүйн хувьд бид нар бүрдүүлж өгсөн. Өнөөдөр гэхэд Улаанбаатар хотын хэмжээнд өөрийн хэрэглээгээ цэвэр ногоон эрчим хүчний эх үүсвэрээс бие даан хангасан 50 орчим өрх байна. Бид бас иргэдтэй энэ талаар уулзалт хийж, санал асуулга авахад болбол дорвитой өргөжихгүй байгаа энэ эх үүсвэрээс шийдэж байгаа байдал, өргөжихгүй байгаа шалтгаан болбол хөрөнгө оруулалтын санхүүжилт дээр хүндрэл байна л гэдэг ийм тайлбарыг хэлж байгаа. Эрчим хүчний хангамж талаасаа болбол бид хангах өөрийгөө хангах зөвшөөрлийг нь болбол ямар нэгэн

хүндрэлгүйгээр авах боломжийг нь бүрдүүлсэн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж өгье. Нэмж хариулъя.

**Н.Тавинбэх:** Дээр нь өөрийн байгуулсан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс нэгдсэн сүлжээнд өгөх эрчим хүчийг худалдаж авдаг эрчим хүчний үнээс арай өндөр үнээр худалдаж авч урамшуулах, дэмжих ийм зохицуулалтыг бүрэн хийсэн байгаа гэдгийг хэлье.

**Д.Амарбаясгалан:** Очирбатын Амгаланбаатар гишүүн асуулт асууна.

**О.Амгаланбаатар:** Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө гэдэг маань заавал биелэх ёстой ийм төлөвлөгөөг хэдүүлээ хэлэлцэж байна. Тэгээд энэ маш олон ажил хийнэ гэж тусгасан нь сайн боловч энэ ажлуудын хувьд бол төр, хувийн хэвшлийн түншлэл бусад эх үүсвэр гадаадын зээл гэх зэргээр ийм л зүйлүүд дийлэнх нь байна л даа. Тэгээд 14 мега төсөл гээд нэг том юм яриад байдаг. Тэд нарынх нь эх үүсвэр нь хаанаас вэ гэхээр л ер нь л нэг гадаадын зээл тусламж буюу өрөө нэмнэ гэсэн юмнууд л байгаад байна л даа. Энэ цуг өгсөн байгаа энэ өргөн мэдүүлсэн 2025 оны төсөв дээр гээд тэгэхэд чинь 2023 оны 12 сарын 31-нд ЗГ-ын нийт өр нь 30 тэрбум байсан болбол 25 оны 12 сарын 31-нд буюу ирэх жилийн эцсээр бол 40 тэрбум болоод 10 тэрбумаар ЗГ-ын өр нь нэмэгдэхээр байна. Нийт энэ том мега төслүүдийг хэрэгжүүлэхэд 120 их наядын буюу бараг энэ Монгол Улс өнөөдрийг хүртэл ингээд 35 тэрбум долларын өртэй гээд байдаг. Гэтэл яг тэр хэмжээний өрийг тавих ийм өр л батлах гээд байна л даа.

Тэгэхээр гишүүд энэ дээр бас нэлээн энэ хөтөлбөрийг батлахдаа нэлээн сайн ул суурьтай үзээд, хэдүүлээ энэ хэрэгжиж байгаа тэр зээлүүдээ юу юунд яасан, хэдэн зээл, 355 төсөл, хөтөлбөрийг

хэрэгжүүлсэн энэ тэр гээд ингээд байж байна. Энийг нэг бүрчлэн үзэж хэлэлцэхгүй болбол одоо хэдүүлээ баахан өр л батлах гээд байх шиг байх юм. Тэгээд сүүлд нь болохоор та нарын баталсан зүйлээр ийм өрийг зээлийг авч байна, том төслөө хөдлөхийн тулд ингээд өр авахаас өөр замгүй гэж байна. Гэтэл 10 их наядаар зөвхөн жил гаруйн хугацаанд 10 их наядаар өр нэмэгдэнэ гэдэг болбол бараг 3 тэрбум доллар. 3 тэрбум доллар гэдэг болбол 2 Чингис бондтой тэнцэх хэмжээний өрийг ингээд тавина гэдэг ийм л зүйлийг болбол ЗГ-ын өрнийхөө энэ хүснэгт дээр ороод ирсэн байна. Энэ 63 дугаар хуудас дээр байж байна.

Тэгэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд чинь тэр эрчим хүч, дэд бүтцийн зориулалтаарх зээлийг чинь өрөнд оруулахгүй, ЗГ-ын өрөнд оруулахгүй гэсэн ийм байгаа билүү. Тэгэхээр тэрүүгээрээ одоо далимдуулаад энэ бараг өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд авсан өр шиг ийм их хэмжээний өрийг тавихаар ингээд ороод ирж байгаа юм биш үү гэдгийг болбол асууя. Тэгэхээр энэ бүх өрнүүдийн чинь задаргаа дахиад яг энэ 25 онд хэдэн тэрбум долларын өр тавих гэж байгаа юм бэ гэдгийг бас дахиад асууя. Энэ дээр бол тодорхой хариулт авъя.

Ер нь бол Гантөмөр маань нэг Мах комбинатын улаан ямаа шиг ингээд л зайлуул ингээд л яваад байх шиг байна. Тэгээд л энэ нэг өр тавихыг манлайлаад л. Би нэг ийм нэг Эдийн засгийн хөгжлийн сайд гэдэг юм яачаад л, тэгээд л сүүлд нь ингээд л маш их хэмжээний өр тавьдаг. Тэгээд энэ Гантөмөр улаан ямаа болоод дуусгах, АН-ынхан та нар ингэсэн гэдэг ийм л юм руу оруулахаар ингээд явж байна л даа. Ер нь энэ 3 нам нийлсний чинь хамгийн цаад талын юм нь энэ хязгааргүй өр тавихад л байгаад байх шиг байна шүү дээ. Түүнээс ч энэ улсын төсвөөр юу ч тавиагүй мөртөө төр, хувийн хэвшил, бусад эх үүсвэр, гадаад зээл гэдэг ийм зүйлээр л энэ ажлуудаа хийх гээд, энэ том мега төсөл гэдэг сайхан малгайн доор

ингээд нэг маш их хэмжээний өр тавихаар зүйлийг л та хэд оруулаад ирж байна л гэж ингэж харагдаж байна. Тэгэхээр энийг болбол маш нухацтай харж, хэлэлцэхгүй бол болохгүй нь. Тэгээд бусад энэ яг хэдэн төгрөгийн, хэдэн долларын өр тавих гээд та нар энийг оруулж ирж байгаа юм бэ гэдгийг бол нэг тодорхой хариулаадхаач. Тэгээд тэгсний дараа эргүүлээд асууя.

#### **Д.Амарбаясгалан:**

Амгаланбаатар гишүүний асуултад Тэргүүн шадар сайд Гантөмөр сайд хариулъя. Гэхдээ гишүүд нэг зүйлийг анхаараарай. Яг хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуудлаар асуулт асууна. Хөрөнгө оруулалтын асуудал болбол төсөв дээр яригдах учиртай байгаа. Гантөмөр сайд хариулт өгье. Хөрөнгө.

**Л.Гантөмөр:** Ер нь болбол жишээлбэл Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцыг барина, зээл авна гээд шийдчихсэн юм байна лээ шүү дээ. Тэгээд одоо энийгээ хийхгүй гээд яах юм, юу гэх юм. Хятадын ЗГ-т бид нар авахгүй гэх юм уу? Тэр 1 тэрбум доллароор газрын тос боловсруулна гээд зээл авна гээд Энэтхэгийн ЗГ-тай тохирчихсон. Юу гэх юм авахгүй гэх юм уу гэх мэтчилэн тохирчихсон, шийдвэр гарчихсан энэ зээлүүд л өнөөдөр хэрэгжээд явах тухай л яриа байгаа шүү дээ. Яах вэ шинээр авах зээл бол гарна. Жишээлбэл бид нар хиймэл дагуултай болъё гэж байгаа юм. Үндэсний хиймэл дагуултай болъё. Тэрийгээ Их Хурал дээрээ ярина хэдүүлээ. Түүнээс биш 14 мега төслөөр дамжаад баахан зээл авах гэж байна гэдэг бол цуурхал шүү. Жишээлбэл Гашуунсухайт-Ганц модыг холбож байгаа. Энэ болбол тухайн холболтын хийх компани өөрөө хөрөнгө оруулалтаа хийх юм. Тэгээд үйл ажиллагаагаараа зардлаа нөхнө гэсэн ийм хэлэлцээр явж байгаа.

Шивээхүрэн адилхан, Хангимандал адилхан. Манайхан ингээд 2 нүүртэй л юм яримааргүй байгаа юм. Авна гээд

тохирчихсон байгаа зээлүүд чинь ингээд бичигдээд орж ирж байна гишүүдээ. Авч байна. Шинээр авъя, шинээр зээл авахад нууцаар авдаггүй юм. Их Хурлаар орж ирж, Их Хурал баталдаг. Тэгэхээр шинэ зээлийн тухайд болбол та бүхэн Их Хурал дээр батлагдах үед авна, авахгүй гэдгээ хэлэх хэрэгтэй. Авна гээд шийдчихсэн байсан юмнуудыг одоо юу гэх юм хамтарсан учраас авахгүй гэх юм уу? Ийм л зүйл байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Болсон уу? Тэгье Гантөмөр сайд нэмж хариулъя гүйцээж хариулъя.

**Л.Гантөмөр:** Амгаланбаатар гишүүний хэлж байгаа нэмэгдэж байгаа тоо болбол бодитой шүү дээ. Тэрнээс болбол бид нар зугтаагагүй. Юу вэ гэхээр 24 онд 2,2 их наядын зээлийг төсөв дээрээ бичээд ашиглая гэж байсан. Ашиглаад дуусчихсан учраас Сангийн яам ямар санал тавьсан бэ гэхээр нэмээд 2 их наядыг энэ ондоо ашиглая гэсэн. Ашиглаж амжиж магадгүй, амжихгүй байж магадгүй. Тэгэхдээ 1 юмыг ойлгох хэрэгтэй. Авчихсан зээл байхгүй юу даа. Авчихсан зээлээ ашиглахгүйгээр үгүй ээ хүнээс зээл авчхаад нөгөө мөнгийг нь ингээд хий байлгаад байсан л зүйлийг арилгасан шүү дээ хэдүүлээ энийг төсвийн тодотгол ярих үе зөндөө ярьсан. Энэ бол ингээд энэ жилдээ 4,3-аар нэмэгдсэн Амгаланбаатар гишүүнээ. Дээр нь нэмээд хот 600 сая долларын бонд гаргачихсан, гаргачихсан. Их Хурал шийдвэрээ гаргачихсан, ЗГ шийдвэрээ гаргачихсан, Дотооддоо.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулах уу Жавхлан сайд? Ер нь энэ зээлийн асуудал чинь нэг жилээр яригддаг зүйл биш юм байна лээ шүү дээ Төсвийн тодотгол дээр яригдаж байсан. 10, 15 жилийн хугацаанд гаднын баахан зээл авах асуудал гэрээ хэлцэл хийгээд, хөрөнгө оруулалтаа тогтоод, заримыг нь шавыг нь тавьчхаад, Монгол Улс өөрсдөөс хамаарах тодорхой хөрөнгө оруулалтын асуудлаа шийдэж чадахгүй өнөөдрийг

хүртэл явж ирснээс болж асуудал уягирсан байна. Тийм учраас энэ гэрээ хэлцэл нь хийгдчихсэн, өнгөрсөн хугацаанд яриа хэлцэл нь хийгдээд гарын үсэг зурагдчихсан зээлүүдээ ашиглая гэдэг зүйлийг л төсвийн тодотгол дээр ЗГ ярьж, та бид хэлэлцэж шийдсэн гэж ойлгож байгаа шүү дээ. Энэ дээр маш тодорхой хариулах нь дээр. Түүнээс нэг жилийн дотор өр тавиад, өрөнд уначих гээд байгаа зүйл мөн юм уу, биш юм уу ЗГ-ын энэ дээр яг байр суурийг гишүүдэд их сайн зөв ойлголт өгөөрэй. Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Амгаланбаатар гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье. Сая Амарбаясгалан дарга бараг хариулчихлаа даа. ЗГ дээр 10 их наядын зээлийн ашиглалт биднийг хүлээж байгаа. Өөрөөр хэлбэл сүүлийн 30 жилийн хугацаанд Улсын Их Хурлаар ороод, зөвшөөрөгдөөд ЗГ энэ төслүүдийг хэрэгжүүлэхдээ энэ зээлийг ашигла гээд. Энэ дотор бүгд эхэлчихсэн тодорхой хэмжээгээр. Сая Гантөмөр сайд хэлчихлээ. Нефть боловсруулах үйлдвэр 1,6, 1,4 тэрбум доллар аль хэдийн 230-аад сая долларыг нь хэрэглэчихсэн. Ирэх жил бид нараас 1 их наяд төгрөгийн нэмэлт санхүүжилт нэхэж байгаа төсөл өөрөө. 2026 онд дуусгахын тулд ирэх жил бидэнд 1 их наяд төгрөг хэрэгтэй байна гээд. Гэтэл төсвийнхөө орон зайнаас болоод бид нар дөнгөж 460 тэрбумыг л өгч чадна ирэх жил. Энэ орон зайг жоохон тэлье гэж сая тодотголоор л бид ЗГ-аас саналаа оруулсан. Их Хурал маань баталж өгсөн. Ирэх жил энэ жилийнхээ хэмжээнд бид.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Ингээд ирэх жил нэгэнт эхэлчихсэн байгаа төслүүд зээлийн хувьд болбол тоолуур нь эхэлчихсэн, бид нар хүүгээ төлөөд эхэлж байгаа. Тийм учраас маш хурдан зээлийн ашиглалтыг нь гүйцээгээд, ашиглалтад оруулаад, үнэхээр үр өгөөжтэй л юм



болбол бушуухан эдийн засгийнх нь үр өгөөжийг нь бид нар амсаж эхлэх хэрэгтэй. Хамгийн том төсөл маань нефть боловсруулах үйлдвэр байна. Үнэхээр дотоодын хэрэгцээний 55 хувийг хангах юм болбол жил бүр төлж байгаа 2,2 тэрбум долларынхоо талыг нь ядаж авч үлддэг болъё 26 оноос.

Тэрнээс биш шинээр авах зээлийг Их Хурал шийднэ сая хэллээ. Энэ намар бид нар 2 зээлийн санал орж ирнэ. Энэ Эрдэнэбүрэнгийн УЦС, мөн хиймэл дагуулын шинэ зээл орж ирнэ. Энд Их Хурал зөвшөөрвөл цаашаа үргэлжлээд энэ 2 төсөл маань энүүгээр зээлийн өр шинээр нэмэгдэнэ. Энэ ашиглалт бол өөр тусдаа ойлголт шүү. Энэ төсөв дээр орж ирж байгаа дүн бол нэгэнт эхэлчихсэн, нэгэнт авчихсан зээлээ үргэлжлүүлж байгаа ашиглалтын дээд хэмжээ гэсэн үг.

**Д.Амарбаясгалан:** Хариулт болсон уу Амгаланбаатар гишүүн? Энэ Жавхлан сайдын юун дээр одоо бас энэ орон нутгаас сонгогдсон гишүүд ялангуяа бас асуудал, нэг том жишээ байгаа шүү дээ. 2012 онд Монгол Улсын ЗГ, БНСУ Эксим банкттай дулааны станцуудыг барьж байгуулна гээд. 1 станц 12 орчим сая долларын хөрөнгө оруулалт гэсэн гэрээг хийсэн. Нөгөөдөх нь яг л ингээж хэрэгжихгүй явсаар байгаад 2022 онд хэрэгжээд эхэлсэн чинь нөгөө 10 жилийн хугацаан дахь өртөг нэмэгдэх, 40 орчим хувиар үнэ нь нэмэгдчихсэн. Одоо ингээд Монголын тал нөгөө 12 оны үнээр төслөө эхлүүлчихсэн, гүйцэтгэгч Солонгосын компаниуд нь 40 хувийн нэмэлт санхүүжилт өгөхгүй болбол хийж дуусгахгүй гэдэг ийм байдал дээр үүсчихсэн. Одоо ингээд л ЗГ ахиад яриа хэлэлцээрт орох болчхож байгаа. Тэгэхээр энэ гадна талтай хийсэн яриа хэлэлцээр зээлийн асуудлыг богино хугацаанд эргэлтэд оруулж, ашиглаж байхгүй бол өртөг нэмэгдэж байгаа байдлыг цаашидаа болбол бас энэ маш их хэмжээний асуудал үүсэх шинжтэй болсон юм байна лээ шүү дээ. Тэгэхээр ЗГ

бас энэ дээр анхаарах хэрэгтэй. Амгаланбаатар гишүүн тодруулж асууя.

**О.Амгаланбаатар:** Үгүй ээ энэ би төсөв гэж ялгаж байгаа л даа Амарбаясгалан даргаа. Монгол Улсын хөгжлийн 2025 оны энэ төлөвлөгөөнд чинь зорилтот түвшин 2025 он, санхүүжилтийн эх үүсвэр ангилал гээд байж байгаа юм л даа. Би энийг яриад байгаа юм. Тэгэхээр бид нар өнөөдөр энийг баталснаараа зээл авах, тэр гаднын хөрөнгө оруулалт, улсын төсөв гэдгийг чинь ингээд энэ цугт нь ингээд баталчхаж байна л гэсэн үг. Энэ чинь мөнгөн дүнтэйгээ байж байгаа юм. Тэгэхээр та хэд хэллээ шүү ямар ч байсан 2025 онд болбол зээл авахгүй юм байна. Ямар ч байсан өмнөх зээлээрээ ингээд явах юм байна гэдгээ ингээж сая хэллээ шүү. Гантөмөр ч хэллээ. Тэгэхээр та хэд энэ юу гэдэг юм өмнөх юмнууд явж байгаа шүү. Тэгээд энэ жилдээ болбол ингээд нэг ирэх 2025 онд зээл авахгүй нь гэсэн ийм л зүйл ярилаа. Тэгэхээр яг үнэндээ хэлэхэд яг ярих ондоо, цаас энэ дээр байгаа цаас чинь ондоо байна шүү дээ. Би энэ цаас хараад л яриад байгаа юм. Тэгэхээр цаасан дээр ондоо юм ярьчхаад, энд нэг дөнгөж нэг аргалж байгаад нэг батлуулаад л авах л юмыг л.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

**О.Цогтгэрэл:** Гишүүддээ ээлжит анхны чуулганы мэндийг хүргэе. Хэд хэдэн асуулт байна. Эхнийх нь эрчим хүчний салбарын барьж байгаа бодлогын талаар. Эрчим хүчний салбарт либералчлал чөлөөлөлт бий болгоно гэдгийг бодлогын хувьд болбол дэмждэг. Гэтэл сүүлийн үед гарч байгаа яриаг энэ үнэ чөлөөлнө гэдгийг үнэ нэмнэ гэдэг ойлголт болж хувираад байна. Монопол салбарт, монопол ААН-үүдтэй, нийлүүлэлтийн хомсдолтой энэ салбарт ерөөсөө тэр үнэ чөлөөлөлт чинь үнэ нэмэгдэл болгож л шууд л ойлгогдох ийм нөхцөл байдал үүсээд байна. Тэгвэл яг энэ эрчим хүчний салбарын реформ гээд

байгаа зүйлээ юу гэж ойлгоод байгаа юм бэ? Энэ дээрээ нэг тодорхой тайлбар хариулт бас энэ олон нийтэд, иргэдэд ч гэсэн мэдээлэл өгөөч. Яг та нарын төсөөлж байгаагаар үнэ тариф яаж өөрчлөгдөх гээд байгаа юм бэ?

Жишээ нь тэр Бөөрөлжүүтийн цахилгаан станц гэж байгаа. Бөөрөлжүүтийн цахилгаан станц төвийн эрчим хүчний системд хэдэн центээр нийлүүлэх гэрээтэй юм, хэдэн центээр нийлүүлэх гэрээтэй юм бэ? Энэ дээр албан бус авсан мэдээллээр болбол бас их өндөр дүнтэй л зүйл сонсогдож байна лээ. Бараг 300 төгрөгөөр нийлүүлэх юм уу даа хаашаа юм, 8,8 цент гэсэн. Тэгэхээр энэ мэдээллүүдээ өгөөч. Олон нийт ч гэсэн энийг бас хүлээгээд байх шиг байна. Тэгэхээр ер нь эрчим хүчний салбарын реформ гээд сая төсвийн тодотголын үеэр 200 тэрбум төгрөг харагдаж байсан. Одоо ч бас мөнгө төгрөг харагдаж байна лээ. Тэгэхээр энэ реформ гэдгийгээ ер нь юу гэж ойлгоод байгаа юм бэ гэдгийгээ энэ дээр бас нэг тодорхой мэдээллүүд бас хэрэгтэй байна.

2 дугаарт Улсын хөгжлийн төлөвлөгөө ярьж байгаа үед ч гэсэн төсөв санхүүгийн бодлого өөрөө бас их мэдээж энэний том бүрэлдэхүүн хэсэг. Улсын төсвөөр 4 их наядын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар 2,6 их наядын хөрөнгө оруулалт гэж байна лээ. Бараг дүйцэхүйц хэмжээний. 2,6 их наядын тэр хөрөнгө оруулалтын задаргаа гэдэг зүйл энэ ирсэн материалууд дээр алга. Яг юунд 2,6 их наядыг ямар, ямар зээл тусламжаар, зээлд нь хэд юм, тусламжид нь хэд юм, хаана юу хэрэгжиж байгаа юм бэ? Тэгэхээр улсын төсвийн хөрөнгө оруулалттай дүйцэхүйц хэмжээний зээл тусламжийг ерөөсөө ямар ч мэдээлэлгүй 2,6 гэдэг нэг багц тоо байна. Тэгэхээр Жавхлан сайд энэ дээр мэдээлэл өгөөд, гишүүдэд яаралтай энэ 2,6-гийнхаа задаргааг өгмөөр байна. Улсын төсөв хэлэлцэж эхлэхэд энэ дээр тодорхой тоо баримттай, мэдээлэлтэй цаас харж ярихгүй болбол мэдээж

болохгүй болно. Энэ дээр бас нэг тайлбар өгөөч.

3 дугаарт нь эдийн засгийн өсөлтийн тухай бид нар их өсөж байгаа, доллароор бараг мянга мянган доллароор нэмэгдэж байгаа гээд л ярьдаг. Одоо том, том төслүүд хэрэгжинэ гэж хэлдэг. Энэний цаана нэг бодлогын асуудал гараад байгаа. Алдаа гэх юм уу, гажуудал гэх юм уу, үр дүнгүй байдал гэх юм уу гараад байгаа зүйл эдийн засаг өсөж байна гээд байдаг ядуурал буурдаггүй. 29 хувь гэж байсан нь 29 хэвэндээ л байдаг. Ядуурлын шугамыг бид нар тооцохдоо өдрийн 13 мянган төгрөгөөр буюу өдрийн 13 мянга буюу жилдээ, нэг сардаа 300 гаруй, 400-гаад мянган төгрөгийн төгрөгөөс доош орлоготой иргэнийг ядуу гэж тооцож байгаа байх. Энэ дээр бас 1 тайлбарыг нь бас өгчхөөрэй. Тэгэхээр ийм иргэн чинь үндсэндээ хүн амын чинь 30 хувь байдаг. Энэ яг энэ эдийн засгийн өсөлт яагаад иргэндээ очихгүй байгаа юм бэ? Яг энэ хөгжлийн төлөвлөгөө дээр хэд байсан нь хэд болж буурна гэж тооцож байгаа вэ хөгжлийн төлөвлөгөө дээр.

Бараг хөгжлийн төлөвлөгөөний чинь явсаар, явсаар байгаад Монгол Улсын тэр 3,5 сая иргэнд хүрэх амин сүнс нь эндээ байгаа байх гэж бодож байна. Бид нар чинь их гоё, гоё, том, том тоонуудыг л их олныг ярьдаг, иргэн нь ядуу, гадагшаагаа дайжихад бэлэн, түрүүн бас нэг яриан дээр гарч байлаа. Ажилгүйдэлтэй, нөгөө талдаа ажил олгогчийнх нь шаардлага хангасан ажилтнууд байдаггүй гэх зэргийн маш олон, энэний цаана орлогын асуудал, энэний цаана олон, олон зүйлүүд яг тэнд очиж цуглаж байгаа байх л гэж бодож байна. Тэгэхээр эдгээр асуудлууд дээр асуултууд дээр эхлээд хариулт авъя.

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд эхлээд хариулъя. Нэмээд Гантөмөр сайд. Тэгээд ЭХЯ.

**Б.Жавхлан:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. 2 их наяд 626 тэрбум

төгрөгийн зээлийн ашиглалтын дүн нэмэгдэж байгаа. Үүнээс 2 их наяд 209 тэрбум төгрөг нь зээлийн ашиглалт, 417 тэрбум нь буцалтгүй тусламж байгаа юм гадаадын. Одоо бүртгэлийн хувьд энэ чинь нэг их ийм зүйл шүү дээ 417 тэрбум болбол өр биш буцалтгүй тусламж учраас өр дээр бичигдэхгүй. Буцалтгүй тусламж авсан хэдий ч бид нар зарлагадахын тулд заавал зардал тал дээрээ тэнцэл дээрээ бичиж орж ирдэг, зардал өсгөдөг. Бид нар бичихээс өөр арга байхгүй ингээд ороод ирнэ. 2,2 их наяд ирэх жилийн зээлийн ашиглалт бол сая нөгөө тодотголоор батлагддаг 987 тэрбум төгрөгийн л тэр том төслүүдийн үргэлжлэл байгаа. Та нөгөө төсвөө бүтэн үзэж арай амжаагүй юм шиг байна. Хавсралтын 14 дүгээр хуудас дээр энэ задаргаа нь нэг бүрчлэн төсөл бүрээрээ байж байгаа. Буцалтгүй тусламж нь ч хаанаас вэ, зээл ашиглалт нь аль, аль төслүүдээ үргэлжлүүлэх юм, ямар, ямар хэмжээгээр вэ гэдэг нь 14 дүгээр хуудас дээр байж байгаа. Та тэрийг олоод авчихна биз.

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр сайд, Тэргүүн шадар сайд Гантөмөр хариулъя.

**Л.Гантөмөр:** Тэгэхээр эдийн засгийн өсөлтийг ирэх жил бид нар 8 хувьтай гэж ингэж харж байгаа. Тэгээд ДНБ болбол 95 их наяд руу очно гэсэн ийм тооцоололтой юм байна. Энэ хэмжээгээр Монголын эдийн засаг сэргэнэ. Ер нь бидний бэрхшээл юу байсан бэ гэхээр ДНБ 5 мянган долларт хүрэх үед хүн болгон булаацалдсан. Аймгаа хөгжүүлнэ, сумаа хөгжүүлнэ, өөрийгөө хөгжүүлнэ, компания босгож ирнэ. Тэгээд булаацалдсаар байгаад тогтвортой бодлого гэдэг зүйл алга болсон. Салбар болгон дур дураараа татвар тогтоодог, салбар болгон дур дураараа бодлого гаргадаг. Ялангуяа явж байсан нөгөө явж байгаа дээшээгээ явж байгаа уул уурхайн салбараа дарж унагадаг, татаж унагадаг, өөртөө авахыг хичээдэг ийм бодлогын алдаануудаас болоод бид нар

нөгөө баялгийн хараал гэдэг зүйл чинь буцаж ороод байгаа юм л даа. Тэгэхээр одоо энэ 4 жилд нэг ингээд тууштай урагшаа.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр сайд нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Гишүүд маань нэг ийм зүйлийг л сайн ойлгочихмоор байна. Уул уурхайгаа хөгжүүлбэ, уул уурхай дотор зэсийн гарцаа бид нар нэмэгдүүлэх юм байна. Мөн хилийн нэвтрэх чадвараа сайжруулснаар бид нар нүүрснийхээ худалдааг 100 сая тоннд хүргэх юм байна. Дахиад зэсийнхээ олборлолт, боловсруулалтыг нэмэгдүүлэхийн тулд эрчим хүчээ нэмэгдүүлэх юм байна. Эрчим хүчээ нэмэгдүүлэхийн тулд бид нар хөрөнгө оруулах боломжийг нь өгнө. Өөр арга байхгүй. Эрчим хүч нэмэгдэж байж үйлдвэрлэл бий болно. Үйлдвэрлэл бий болж байж ажлын байр бий болно. Энэ үед ядууралд бид нар цэг тавих тухай ярина гэсэн нэг ийм л цикл байхгүй юу даа. Тэгэхгүй болбол ядуутай тэмцэж байна гээд л бид нар халамж өгөөд л байсан, мөнгө тараагаад л байсан үр дүнд нь юу болсон дандаа инфляц, ханшийн уналт. Яг өнөөдөр бид нар айж цочоод байгаа энэ том, том тоонууд болбол ерөөсөө үргэлжилсэн олон жилийн зүгээр л төгрөгөөр л ямар нэгэн байдлаар аргалъя.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя. ЭХЯ тэгвэл Тавинбэх ТНБД хариулт өгье.

**Н.Тавинбэх:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Бөөрөлжүүтийн ДЦС-ын хувьд 2016 онд 600мвт-ын хүчин чадалтай, нүүрсний технологитой хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдах эх үүсвэрийн тусгай зөвшөөрөл, эрчим хүч худалдаж авах үнэ тарифыг тогтсон, тогтоож гэрээ хийсэн байдаг юм. Тэгээд эндээс энэ эх үүсвэрээс эрчим хүчний салбар 1квт цаг цахилгаан эрчим хүчийг 28 жил гарааны үнэ гэж эхний нэг жил 7 центээр, үлдсэн 27 жилийн хугацаанд 8,9

центээр худалдаж авахаар гэрээ хийсэн байдаг. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд хэрэглэгчийн үнэ америк доллароор илэрхийлбэл 6,2 цент байгаа гэдгийг хэлье. Цаашидаа энэ эх үүсвэр ашиглалтад орвол гэрээний үүргээ биелүүлэхийн тулд хэрэглэгчийн үнийг нэмэгдүүлэх ийм шаардлага, нэмэх нэг хүчин зүйл болно гэдгийг хэлье.

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя. Тавинбэх ТНБД-ын 2 дугаар индрийн микрофон.

**Н.Тавинбэх:** Үнэ тарифын хувьд өнөөдөр байгаа эрх зүйн зохицуулалтаар болбол үнэ чөлөөлөх тухай ойлголт байхгүй. Үнийг зохих бодит өртөг, зохих ашгийн түвшинд болбол нэмэгдүүлэх ийм л зохицуулалт байгаа. Бид үнэ тарифыг хариуцсан олон улсад байдаг бүтэц, эрх зүйн зохицуулалттай гэдгийг албан ёсоор хэлье. Эрчим хүчний зохицуулах хороо бие даан хараат бусаар шийдвэрлэдэг. Эрчим хүчний зохицуулах хороонд өнөөдрийн байдлаар энэ төрлийн бизнес, эрчим хүчний бизнес эрхэлж байгаа ААН-үүд болбол үнэ тарифыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Тооцоо судалгаагаа хүргүүлчихсэн байна. Эрчим хүчний зохицуулах хорооны шийдвэрийг хүлээж байна.

Реформын хувьд эрчим хүчний салбар өнөөдөр чадлын дутагдалд орсон, санхүүгийн их хэмжээний алдагдалтай хүндрэлтэй нөхцөл байдал байна. Тийм учраас би реформ гэдгийг эрчим хүчний салбар өнөөдөр хүндрэл тулгамдсан хүндрэлтэй асуудлуудаа шийдэх, цэвэр ногоон технологид шилжих шилжилтийг хэлж байгаа гэж ингэж ойлгож байгаа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар асуултаа асууя. Уучлаарай, Цогтгэрэл гишүүн тодруулга.

**О.Цогтгэрэл:** Тэр зээл тусламжийн дүн дээр уг нь төсвийн цаасыг бас эргүүлж харсан даа. Тийм

ганц 14 дүгээр ганц хуудас хуудсанд багтах хэмжээний зүйл уг нь Монгол Улсад байх ёсгүй л дээ. Энэ чинь нийт дүнгээр зөвхөн энэ жил 2,6 их наядаар, нийт дүнгээрээ наадах чинь 30, 40 их наядын бараг хэлэлцээр байгаа байх. 30, 40 их наядын. Тэр чинь задалбал олон 100 төсөл, хөтөлбөр байгаа байх. Тэгэхээр би яг тийм тодорхой задаргаа болбол би дахиж үзье, хараагүй. Та яг нийт гишүүдэд хангалттай зээл тусламжаар санхүүжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хангалттай мэдээлэл болбол би байхгүй байсан л гэж хэлэх гээд байна. Тэр 1 дүгээрт нь.

2 дугаарт нь эрчим хүчний салбарын тэр реформ гэдгийг тэгэхээр яг энэ хариуцсан сайд нь байхгүй байгаа юм байна л даа. Тэгвэл тэгээд сайдаас нь л дараа асууя даа. Одоо болбол.

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр, Тэргүүн шадар сайд Гантөмөр сайд хариулт өгье.

**Л.Гантөмөр:** Ер нь Сангийн яамнаас ойрын үед Их Хуралд хэрэгжиж байгаа зээлүүдийн явц болоод, ирэх онд хэрэгжүүлэх зээл ажлуудын тайлбарыг болбол Их Хуралд хүргүүлчихнэ. Энэ дээр санаа зовох юм байхгүй, нууц юм байхгүй. Тийм учраас болбол төсөв батлагдахаас өмнө энэ их тодорхой болно, болох ёстой. Тэгэхээр бол тэр мэдээлэл ирнэ 1.

2 дугаарт болбол энэ эрчим хүчний шинэчлэлтэй холбоотой ажлыг Доржханд Шадар сайдаар ахлуулаад Үндэсний хороо байгуулаад ажиллаж байгаа. Эцэслэж бодлого нь гараагүй байна. Эцэслэж бодлого гараагүй үед бид нар хамаагүй нэгнээсээ нарийн ширийн тоо асуугаад ингээд будилаантай юм ард түмэнд буруу мэдээлэл өгмөөргүй байгаа юм. Ямар ч байсан нэг зүйл тодорхой байгаа. Чадал хүрэхээ больсон. Чадлаа 2 дахин нэмнэ. Тэгэхийн тулд юу хийж болох вэ гэдэг зүйлийг нэг бүрчлэн харж байгаад ард түмнийхээ амьдралд дарамтгүйгээр, ААН-үүдэд



дарамтгүйгээр, тэгсэн мөртөө.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Болсон тийм ээ? Жамбалын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**Ж.Ганбаатар:** Энэ сайд нар асуултад хариулахдаа хэтэрхий эмзэг юм. Тэгээд зүгээр энэ гишүүдийн мэдээлэл угаасаа л таныхад хүрэхгүй шүү дээ, та бүхнийхэд. Зүгээр л сайхан хариул л даа. Тэгээд л чи уншаагүй байна эсхүл чи буруу ярьж байна гэсэн маягтай. Тэр чинь гишүүдийн мэдээлэл сайдын мэдээлэл 2 хамаагүй өөр л дөө. Өчигдөр би Байнгын хороон дээр ЭТТ компаниас асуултаа асуусан. Энэ захирал нь байхгүй байсан юм. Өнөөдөр ирсэн юм байгаа юм байна. Тэгээд асуултад зөв хариулаарай. Өчигдөр ирээд хариулчихсан бол би чуулган дээр асуухгүй байсан шүү. Эрдэнэс, одоо би энэ орлого талд нь энэ Гантөмөр сайдын яриад байгаа үнэхээр энэ том, том төслүүдийг хэрэгжүүлэхэд орлого талд нь санаа зовж байгаа учраас 2, 3 зүйл асууя. Үнэхээр энэ өр зээл тавихаасаа илүү орлогоороо энэ төслүүдээ хэлэлцүүлэх бололцоо байна. Монгол Улсад мөнгө байна. ЭТТ компани 2024 оны эхний хагас жилд сонгуулиас өмнө 15 сая тонн нүүрс биржээр экспортлсны 10 саяыг нь биржээр зарсан 70 хувийг нь. Гэтэл сонгуулиас хойш 8 сая тонн нүүрс экспортлсны 1,4-хөн саяыг нь биржээр зарсан байна. Тэгээд шалтгаанаа л тайлбарлаад өгчхөөч. Тэгээд 2 тоогоо хооронд нь нэмээд та буруу яриад байна жилийн дүн нь 60 хувьтай байгаа, 17 хувьтай биш гээд байх юм. 17 хувьтай чинь танай сайт дээр чинь өөр дээр чинь байна шүү дээ.

2 дугаарт наад хуулиараа 100 хувь зарах ёстой биржээр. Биржийн тухай хуулиар 100 хувь зарах ёстой. Эрдэнэт үйлдвэр, ЭТТ компани, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, тэр жонши янз янзын шалтаг байж болохгүй. Үгүй ээ тэгээд энийгээ тэгээд сайжруулаад орлогоо олоход чинь санаа зовоод л хэлж

байна шүү дээ. Тэгээд энэ чинь сайн явбал тэгээд л баярлаад л, дэмжээд л араас чинь явна шүү. Үнэхээр том, том төсөл, хөтөлбөрүүд явах гэж байгаа нь сайн, зөв. Тэрэн дээр бол зоригтойхон шиг хөдөлгөөд явах ёстой. Тэгэхээр асуултаа яг тэр хаашаа зараад байгаа юм бэ? Тэр 8 сая тонн нүүрс зарчхаад, 8 сая тонн нүүрс зарчхаад 1,4-ийг нь биржээр зарсан, үлдсэнийг нь хаашаа зараад байгаагаа хэлчих л дээ. Тийшээ зарж байна гэдгээ хэлчих. ЭТТ-гоос асууж байгаа юм шүү. Уул уурхайн яам мэдэхгүй энийг би сайн мэдэж байна. Хэрвээ ажлын хэсгийг нь удирдаагүй л бол.

Тэр яагаад зэс яагаад биржээр зарахгүй байгааг бас энэ Хөрөнгийн бирж юм уу, холбогдох хүмүүс нь хариулах хэрэгтэй байна. Өчигдөр бас надад хариулахгүй байна лээ. Хариулчихвал дахин, дахин асуугаад байх шаардлага алга. Эрдэнэт үйлдвэрийн зэсийг биржээр зарах хуультай. Орлогоо олооч, олсон орлогоороо төслөө хэрэгжүүлээч. Энэ чинь боломж байна шүү дээ, мөнгө байна. Энэ мөнгөө олж аваач.

Тэгээд Энх-Амгалан сайдаас асууя. Сая нөгөө Сайнзориг гишүүн үнэхээр чухал асуудал хөндлөө. Энэ ажиллах хүчний асуудал бол 4, 5 жилийн өмнөөс хувийн хэвшилд тохиолдсон асуудал л даа. Өнөөдөр л дарга нар ойлгож байгаа. Намайг ярихлаар энэ капиталист юу билээ янз янзын үгээр дайрдаг байсан юм өмнө нь. Одоо яг үнэнд гүйцэгдэж байгаа юм шиг байгаа юм. Наад ажиллах хүчний асуудал чинь үнэхээр боомлогч болж байна шүү дээ. Эдийн засгийг боомлогч болж байна. Үнэхээр энийг хийхгүй бол бүтээмж байхгүй, экспорт байхгүй, өрсөлдөх чадвар байхгүй. Тэгээд энийгээ ямар нэгэн аргаар зоригтой хийх хэрэгтэй, зугтаад байхгүйгээр. Тэгэхдээ Энх-Амгалан сайд бол хийнэ л дээ. Тийм учраас танаас бас чуулганы танхимд тодорхой асуулт, хариулт сонсьё. Зоригтойхон шиг тод хариулчхаарай гэж хүсье. Баярлалаа. Тодруулъя дараа нь.

**Д.Амарбаясгалан:** ЭТТ ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал. Индрийн 2 дугаар микрофоныг өгье. 2 дугаар индрийн микрофон.

**Х.Мөнхжаргал:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ЭТТ компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. ЭТТ компани 2023 оны 2 дугаар сараас эхлээд нүүрсний худалдаа буюу арилжаагаа биржээр арилжиж эхэлсэн байгаа. 23 оны 2 дугаар сараас эхлээд нийтдээ 101 арилжаа арилжаа буюу арилжаагаар 21,9 сая тонн нүүрсийг 2 аравны тэрбум доллароор арилжсан байдаг. 24 оны, үүнээс 24 оны 3 дугаар улирлын байдлаар буюу 9 сарын 30-ны байдлаар нийт арилжсан 22 сая тонн нүүрсний 12 сая тонныг нь 24 онд арилжсан. Үнэндээ талаас илүү хувь нь гэсэн үг. Нийт биржээр арилжсан нүүрсний талаас илүү хувь нь 24 оны 3 дугаар улирлын байдлаар. Тэгээд нийт хөрөнгийн биржээр арилжаалж байгаа нүүрсний 59 хувийг 2023 онд эзэлж байсан болбол 24 онд энэ нь 24 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 65 хувь болж өссөн байгаа юм.

Тэгээд Уул уурхайн биржийн хуулиас бол гадуур ямар нэгэн арилжаа ам нөхцөлтэй гэрээ тэр яриад байгаа өөр хэлбэрийн юу байгаагүй. Бид болбол Уул уурхайн биржийн энэ хуулийг болбол ягштал дагаж мөрдөж байгаа гэдгээ болбол энэ энэ танхимд болбол удирдлагын зүгээс хариуцлагатайгаар мэдэгдэх нь зүйтэй байх. Биржийн хуулиас нэг алхам ч бид ухраагүй. Харин дэмжиж ажиллаж байгаа гэдгээ бас илэрхийлье. Тэр 17 хувь гээд яриад байгаа юун дээр бол, 17 хувь гэдэг дээр биржийн арилжаа болон экспортын тоо үзүүлэлт холигдоод байх шиг байна. Би энэ тоог, би танд харин яах вэ нарийн юуг нь тайлбарлаад өгч болно.

Компанийн санхүүгийн үзүүлэлтийн хувьд болбол яах вэ түрүүн

бас та асуусан. 3,5 их наядын ашигийг 23 оны жилийн эцсээр хийсэн болбол 24 оны хагас жилийн байдлаар 3,3 их наяд төгрөгийн цэвэр ашигтай балансын үзүүлэлт гарсан. Тэгэхээр болбол компанийн үйл ажиллагаа болбол хэвийн үргэлжилж байгаа. Арилжааны хувьд болбол эхний хагас жилд болбол нийтдээ ЭТТ компани болбол яах вэ нөгөө үнэ өндөр байгаа үед болбол борлуулалтыг болбол түлхүү хийсэн. Сүүлийн хагас жилд болбол яах вэ 5, 6, 7 дугаар саруудад Хятад Улсад бол нүүрсний үнэ унадаг тренд угаасаа байдаг, жил болгон давтагддаг. Борлуулалтын бодлогын хувьд болбол бид нар борлуулалтаа жосоохон бууруулаад, хүргэж өгөх тал дээрээ анхаарлаа хандуулсан. Одоо 4 дүгээр улирлаас эхлээд 9 сарын.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд, нэмж хариулна тийм ээ.

**Б.Жавхлан:** Би гишүүний асуултад зүгээр нэмэлт мэдээлэл өгье. Энэ сая нөхдүүд тэр биржийн болон биржийн бусыг нь хариулчих шиг боллоо. Зүгээр яах вэ би ерөнхийдөө нүүрсний борлуулалт маань ямар байгаа вэ гэдэг дээр гишүүддээ нийтлэг мэдээлэл өгье. Энэ жил 2024 оны төсвийн анх батлагдахад 60 сая тонн нүүрс гаргана гэж байсан юм жилийн туршид. Яг өчигдрийн байдлаар 62 сая тонн нүүрс гарчихсан байна. Дахиад 3 сар бидэнд байгаа. Ингээд хүлээгдэж байгаагаараа энэ хурдаараа 4 дүгээр улиралд болбол борлуулалт нь нэмэгддэг. Ингээд 75-аас дээшээгээ 78 сая орчим гүйцэтгэлтэй гарах болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Өнгөрсөн жил өдийд болбол 45 сая тонн гаргаж байсан. Одоо 62 сая тонн гарчихсан явж байгаа. Түүнээс хэд нь биржээр нь, хэд нь яаж явж байгааг сая мэдээлэл өгөх шиг боллоо. Ер нь манай энэ жил хувийн хэвшлийнхний гаргаж байгаа нүүрс экспорт бол маш сайн байгаа.

**Д.Амарбаясгалан:** Энх-Амгалан сайд хариулт өгье. Хөдөлмөр, ажиллах хүчний нөхцөл байдалтай холбоотой.

**Л.Энх-Амгалан:** Бид нар энэ ажиллах хүчний тэр тусмаа гадаадаас ажиллах хүчин авах энэ бодлогоо ер нь жаахан улс орныхоо өнөөгийн нөхцөл байдалд тулгуурласан, хөдөлмөрийн зах зээлийнхээ эрэлт, нийлүүлэлтэд тулгуурласан ийм зоригтой гээд хэлчихье дээ. Зоригтой бодлого явуулах ёстой гэж ойлгож байгаа. Гэхдээ мэдээж үндэсний хүний нөөцийнхөө чадавхыг хамгаалах, дотоод зах зээлээ хамгаалах бодлого бол байна. Гэхдээ ер нь цаашидаа Монгол хүн болбол ер нь жаахан өндөр бүтээмжтэй, өндөр цалин авдаг энэ салбарт л ажиллах ёстой юм байна гэж бодож байгаа юм. Бид нар угаасаа цөөхүүлээ, угаасаа хүний хүчний, хүний нөөцийн хомсдолтой ийм улс учраас.

Жишээ нь Монгол Улсад болбол ийм байна. Уул уурхайн салбар, банк, үйлчилгээний салбарууд, мэдээлэл технологийн салбаруудын цалин болбол яг олон улсын хэмжээнд хүрчихсэн байгаа. Бүтээмжийн хувьд ч хүрчихсэн, цалингийн хэмжээнд ч хүрчихсэн. Тийм учраас Монголчууд бид нар бол илүү их тийм бүтээмж бүтээдэг илүү их өндөр цалин авдаг энэ салбар дээрээ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Энэ салбар дээрээ түлхүү ажиллаж яг энэ үйлчилгээний салбар болсон бага бүтээмжтэй байдаг, бага цалинтай байдаг энэ дээр бол гаднын хүчин авахаас өөр арга байхгүй. Гэхдээ бид нар дээр бас түгжээ байна. Энэ ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль дээр ерөөсөө боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбар, дахиад дээрээс нь энэ гадаадын зээл тусламж, стратегийн ач холбогдолтой дэд бүтцийн салбарт ажиллах гадаадын ажиллах хүчнийг төлбөрөөс чөлөөлнө

гэсэн ийм ганцхан заалттай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ заалтыг бид нар өөрчлөх энэ хуулийг бид нар удахгүй Улсын Их Хуралд өргөн барих гэж байна. Энэ хуулийн заалтуудыг бид нар өөрчилж чадсанаар болбол гаднаас 16 эдийн засгийн төрлүүд дээр болбол бид нар энэ ажиллах хүчний квотгүй болох, тэгээд энэ төлбөрийг чөлөөлөх ийм боломжууд нь гарч ирнэ гэж ойлгож байна 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал болбол бид нар бас энэ хууль дээр өөрчлөлт хийж, одоогийн энэ гаднаас ажиллах хүчин авахад шаардагддаг энэ процесс зөвшөөрлийн энэ хүнд суртлуудыг арилгах зайлшгүй шаардлага байгаа юм байна лээ. Одоо бол 2 сар болдог юм байна лээ. Тэгэхээр энэ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** ЗГ дээр гарчихсан шийдвэр бас байгаа шүү дээ Энх-Амгалан сайд тийм ээ. 1 дүгээрт танай яам яг тэрийгээ хэрэгжүүлчих хэрэгтэй юм байгаа юм. Гадаадын ажиллах хүчийг квотоос чөлөөлөх шийдвэрийг бол ЗГ 2023 оны 11 сард гаргасан. Тэрнээс хойш өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй байгаагаа 1 дүгээрт нь хэрэгжүүлчих хэрэгтэй. Тэгээд 2 дугаарт нь таны саяын ярьж байгаа нөгөө процессуудаа байхгүй болгоод. 3 дугаарт нь тэр хуульд өөрчлөлт оруулж, төлбөрөөс чөлөөлөх эсэх асуудлыг 3 дугаарт нь шийдэх ёстой шүү. Тэгэхээр өнөөдөр тулгамдаж байгаа чинь тэр квотыг нь олгохгүй асуудал үүсээд байгаа шүү дээ. Гэтэл тэр нь чөлөөлөгдчихсөн байгаад байгаа юм тийм ээ. Тэгье. Жамбалын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

**Ж.Ганбаатар:** Тэр ЭТТ компанийн захирлаа тэр асуулт сайн сонсож байгаад хариул л даа. Энэ хар даа 6 сар хүртэл наад ажлын хэсгийг чинь би ахалсан юм. Тэгээд биржээр зарсан 70 хувиа зарсан, одоо наад гаргаж байгаа тэр 8 сая тонн нүүрснийхээ 80 хувийг, 90 хувийг биржээр зарах ёстой байхгүй юу

даа. Тэгээд урд талын юмыг хойд талынхаа юмтай нь холиод ингээд 53 хувиа зарсан гээд байгаа юм. 100 хувь биржээр зарах үүрэгтэй шүү дээ та. Тэр 4 компани чинь та хууль бус юм хийхгүй байх, хийгээгүй байх. Та тэр гэрээтэй айлуудтайгаа өгч байгаа байх. Тэгэхдээ тэр 4 компани чинь Монгол Улсад бэлэн мөнгө өгөхгүй. Би сайн мэдэж байна шүү дээ. Бирж чинь бэлэн мөнгө өгнө. Бирж чинь Монгол Улсын нөөцийг нэмэгдүүлнэ. Тэгээд холион бантан ингээд хутгаад байх юм. Удахгүй үнэнд гүйцэгдэнэ шүү. Удахгүй та жилийн эцсээр яг наад бирж чинь юу болсон талаар үнэнд гүйцэгдэнэ. Тэгээд хүний ярьсныг ингээд урд, хойно нь хольж холиод ингээд гишүүдэд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Тодруул, нэмж хариулах уу? Энэ Мөнхжаргал захирлаа ингэж байна шүү дээ Ганбаатар гишүүн. Борлуулж байгаа нүүрснийхээ дийлэнх хувийг нь биржээр буюу бэлэн мөнгөөр зардаг байгаач. Гэтэл танай өгөөд байгаа нүүрс чинь өмнөх гэрээ хэлцэлдээ илүү их нүүрс гаргаад байна. Нүүрсний чинь хэмжээ ихээр гарч байгаа хэр нь Монголд валютын нөөц нэмэгдэх гэдэг юм уу, эерэг өөрчлөлтүүд нь гарч ирэхгүй байна шүү дээ. Энийгээ яаж менежмент хийгээд байгаа юм бэ л гэж асуугаад байна. Энэ дээр тодорхой хариулья.

**Х.Мөнхжаргал:** 4 компани болохоор бэлэн мөнгө өгч байгаа. Нэг нь 1 компани нь болбол бүүр урьдчилгаа төлбөр өгч байж нүүрсээ ачиж байгаа. 3 нь болбол дараа төлбөртэй. Өмнө нь болохоор яагаад нүүрс өгдөггүй байсан бэ гэхээр, биш ээ бэлэн мөнгө валют орж ирдэггүй байсан бэ гэхээр зээл авчихсан байсан. Тэр зээлийн өрийг онцгой дэглэмийн хугацаанд бид бүгд бөөнөөрөө мэдэж байгаа төлж барагдуулсан. Одоо биржээр 100 хувь ЭТТ компанийн арилжаа хийгдэж байгаа. 100 хувь хийгдэж байгаа. 100 хувь хийгдэж байгаа. 2023 оны 2 дугаар сараас хойш буюу онцгой дэглэм тогтоосон өдрөөс хойш хийгдсэн ЭТТ компанийн бүх гэрээ 100

хувь биржээр хийгдэж байгаа. Энийг болбол.

**Д.Амарбаясгалан:** Энэ нэг нюанстай юмыг л яриад байна л даа. Тийм тэрийгээ сайхан зөв тайлбарууд өг. Дараачийн хүн Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Миний асуулт энэ Учрал сайдад хаяглагдах юм гараад явчих шиг болох юм. Учрал сайд үүдэнд байвал ороод ирээч. Хөгжлийн төлөвлөгөөний 1.3.14 дээр төрийн болон орон нутгийн өмчийн компаниудын засаглал, ил тод байдлын асуудал орсон байгаа юм 1 өгүүлбэр. Тэгэхээр ер нь цаашидаа энэ төрийн өмчийн компаниудын энэ худалдан авах ажиллагааг ил тод болгох асуудал дээр л онцгой анхаарал хандуулмаар байна л гэж хэлэх гээд байна. Өнөөдөр магадгүй парламент жилийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын 3, 4 их наяд төгрөгийн л хөрөнгө оруулалт баталж байгаа шүү дээ. Тэгвэл энэ төрийн өмчийн компаниуд дээр чинь бараг нийт дүнгээрээ жилдээ бид нарын баталдгаас өндөр үнэтэй худалдан авалтууд хийгдэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ худалдан авалтуудыг ил тод, нээлттэй болгох, энийг уялдуулах энэ чиглэлээр цаашидаа энэ Төрийн худалдан авах ажиллагааны хууль дээр өөрчлөлт оруулдаг юм уу яадаг юм. Тэгэхгүй бол ерөөсөө энэ төрийн өмчийн компаниуд дээр энэ хулгай нүүрлэхсэн асуудал чинь энэ үнэхээр яг энд нүүрлэхээд байна.

Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө болохоор хулгай луйварчдаараа дуудуулаад байдаг. Яг жинхэнэ дунд шатдаа энэ компаниуд дээр чинь жинхэнэ хулгай чинь энд явж байгаа юм. Хэдэн төгрөгийн сэлбэгийг хэдэн төгрөгөөр шахдаг вэ гэдэг асуудлууд олон нийтийн дунд маш өргөн хүрээтэй асуудал яригддаг. Тийм учраас энэ компаниудын худалдан авах ажиллагааг цэгцлэхгүй бол энэ хулгай луйвар чинь дуусахгүй. Энэ өөрөө эргээд авлигатай холбоотой



асуудал. Энэ өөрөө төрийн ил тод, нээлттэй байдлын асуудал. Тийм учраас энэ ЗГ энэ дээр энэ ил тод, нээлттэй байдлын асуудал дээр яаж ажиллах юм бэ? 25 оны хөгжлийн төлөвлөгөө дээр.

2-т бодвол энэ хөгжлийн төлөвлөгөөний асуудлууд ирэх жилийн төсөв төлөвлөгөөтэйгөө уялдсан байгаа байх. Эх үүсвэрээрээ баталгаажсан байгаа байх гэж бодож байна. Миний орон сууц миний түрээсийн орон сууцнууд гээд энэ хөтөлбөрүүд ирэх жилийн хөтөлбөр төлөвлөгөөнд яг ямар байдлаар явах юм бэ? Төрийн албан хаагчдад, багш, эмч нарт зориулагдсан орон сууцын ямар дэмжлэг туслалцаатай хөтөлбөрүүд явахаар байна вэ? Хэдий ийм хэмжээний төсөв хөрөнгө хуваарилаад байна вэ ирэх жил 25 оны хөгжлийн төлөвлөгөө дээр? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Түрүүн тэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас бид нар Нийгмийн даатгалын багц хууль маань 1 сарын 1-нээс хэрэгжиж энэ ахмадуудын 20-оос доошгүй жил амьдарсан ахмадуудад нэг нь бурхны оронд очвол үлдсэн ахмадад нь авсан тэтгэврийн 20 хувь. Энэ бол нийгмийн даатгалын сангаас бүрэн тэтгэвэр авч байсан ахмадуудад хамааралтай юм байна лээ. Харин одоо хуулиараа бид нар халамжаас тэтгэвэр авч байгаа, мэргэжлээс шалтгаалах өвчинд гарсан ийм ахмадууд энэ өвлөгдөх тэтгэврийн энэ заалтад хамрагдахгүй байгаа юм байна лээ Энх-Амгалан сайдаа. Тэгэхээр энэ улсууд өнөөдөр иргэдтэй хийх уулзалт дээр гомдол гаргаж байна лээ. Шаардлагыг нь хангаад байгаа 20-оос доошгүй жил ажиллачихсан, хамтран амьдарчихсан. Тэгсэн хэр нь тэр өвлөгддөг заалтад хамрагдахгүй байна, ялгасан байна гэж ингэж үзэж байгаа юм билээ. Тийм учраас танай яамнаас энэ салбарын энэ улсуудад хэчнээн хэмжээний ахмад тоогоороо байх юм, зардал мөнгө нь хэд байхаар байгаа юм энийг хуульд бас нэмж тусгах эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлагатай юм байна гэж би хувьдаа

харж байна. Тэгээд асуултдаа хариулт авъя.

**Д.Амарбаясгалан:** Учрал сайд хариулъя. Төрийн худалдан авах үйл ажиллагаатай холбоотой, ТӨК-удын худалдан авах үйл ажиллагаа ил тод байх ёстой гэдэг асуудлаар.

**Н.Учрал:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ намрын чуулганаар Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн хуулийг Их Хуралд өргөн мэдүүлэхээр ЗГ бас ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Энэ хүрээндээ болбол бид нар нэг л бодлогыг барина. Энэ төрийн өмчийн компаниуд болбол өнөөдөр засаглал нь ил тод биш байна. Дээрээс нь худалдан авах ажиллагаа ч гэсэн өөрийнх нь хуульд ил тод, нээлттэй байхыг гол шалгуур болгоогүй учраас Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулиар нөгөө ил тод байх шаардлагууд байгаад байхад энийг хэрэгжүүлэхгүй байна. Тийм учраас энэ 25 оны төсвийн хуулийг дагалдуулаад бид нар энэ төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хууль эрх зүйн орчинд өөрчлөлт хийгээд, энэ төрийн өмчийн компани болон орон нутгийн өмчийн компаниуд бүх мэдээллийг ил тод өөрсдийн веб хуудас, өөрсдийн үндсэн сүлжээгээрээ нээлттэй болгохыг үүрэг болгож байгаа.

Ингээд ил тод нээлттэй байдлыг л хангуулахгүй болбол цаашидаа бол ер нь худалдан авах ажиллагаа ч гэсэн ингээд далдуур хийгддэг, ойлгомжгүй байдаг, нийгэмд төөрөгдөл үүсгэдэг байдал болбол салахгүй. Тэгээд ер нь бол цаашидаа бид нар бол тийм төрийн өмчийн компаниудыг Их Хурлын тогтоол гарсны дагуу илүү хөрөнгө бүрдүүлэх зорилгоор гэдгээсээ илүүтэйгээр засаглалыг нь ил тод байлгах хүрээнд ер нь листэд болгох энэ зам руу орох ёстой. Ер нь компанийн засаглал гэдэг болбол ил тод, нээлттэй л болох ёстой. Тэгээд ЗГ орж ирж засаглал руу шууд ордог. Түрүүн бас Ганбаатар гишүүний яриад байгаагаар ч гэсэн энэ уул

уурхайн компаниудаас шаардлагагүй газар санхүүжилт хийлгэдэг энэ байдал үргэлжлээд байх юм бол компани бие дааж ажиллах бололцоо ерөөсөө бүрдэхгүй.

Тийм учраас ЗГ үүнд шууд оролцдог биш, листэд болгож Санхүүгийн зохицуулах хороо хяналтаа тавьдаг, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангадаг тогтолцоо руу л орж байж энэ байдал болбол бас эрүүлжинэ. Тийм учраас бид энэ уул уурхайн ТӨК-уд, уул уурхайн бус үйл ажиллагаа явуулж байгаа ТӨК-удыг зааглаж авч үзээд, уул уурхайн компаниуд болбол Үндэсний баялгийн санд орлогоо бүрдүүлэгч, эцэстээ болбол тэр уул уурхайн баялгийн тодорхой хувь хийгчийг нь ард түмэн хүртдэг энэ Үндэсний баялгийн сангийн хуулиа л хэрэгжүүлбэ гэж байгаа юм. Сая ЗГ шийдвэр гаргасан. Энэ стратегийн орд ашиглаж байгаа компаниуд өнөөдөр хуулийн дагуу 10 хувь нь нээлттэй болох ёстой шүү дээ. Гэтэл нэг нь ч нээлттэй болохгүй. Энэ юу вэ гэхээр үүний цаана засаглал нь ил тод биш байгаатай л холбоотой. Ингээд засаглал нь ил тод болоод, тэр хувьцаа эзэмшигч нартаа тайлан балансаа орлого, зарлагаа мэдээлээд, худалдан авах ажиллагаа нь ил тод болоод, ингээд иргэд үүнд нь хяналт тавьдаг зөв тогтолцоо руу л орохгүй болбол А-г Б-ээр солиод бол ямар ч өөрчлөлт гарахгүй юм байна гэдэг нь харагдаж байгаа. Тэгээд энэ энэ ажлыг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Батсуурь сайд байгаа юм уу? Барилга, хот байгуулалтын яамнаас хэн байна вэ, хариулт өгөх үү? Ипотекийн зээлтэй холбоотой Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. 1 дүгээр индрийн микрофон өгье.

**Ц.Баярбат:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны газрын дарга Баярбат. Ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх энэ бодлогыг

бол холбогдох яам, газруудтай хамтран хэрэгжүүлж эхлээд байгаа. Энэ асуудлаар бас Монголбанкттай хамтарч бид нар ажиллаж байна. Ер нь бол энэ оны байдлаар 9 сарын байдлаар бол нийтдээ 1 их наяд гаруй төгрөгийн ипотекийн зээл олгогдсон байгаа юм. Үүнд 9 сарын байдлаар бол 9 мянга гаруй иргэн хамрагдсан. Тэгэхээр цаашид энэ ипотекийн зээлийн нэмэгдүүлж, энэ 25 оны жилийн төлөвлөгөөнд бол 1,2 их наяд төгрөгийн ипотекийн зээлийг олгохоор төлөвлөж тусгасан ийм явж байгаа. Одоо бид нарын гол анхаарч ажиллаж байгаа юм бол эрэлт, нийлүүлэлтийн харьцааг зөв байлгах дээр анхаарч ажиллаж байна. Энэ хүрээндээ бол нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр 150.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулах юм уу? 1 дүгээр микрофон нэмж хариулъя. Монголбанкнаас хүн байна уу? Энэ ипотекийн зээлтэй холбоотой нэмж хариулна шүү. 1 дүгээр индрийн микрофон өгье.

**Ц.Баярбат:** 150 мянган айлын орон сууц хөтөлбөрийг энэ 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргах ажил хийгдэж явж байна. Зээлийн хувьд бол үндсэндээ Улаанбаатар хотод 6 хувь, орон нутагт бол 3 хувийн зээлүүд олгогдоод явж байгаа. Сүүлийн байдлаар бол орон нутагт олгогдсон зээлийн хэмжээ бол нэмэгдэж байна. Нийт эзлэх хувийн хэмжээ бол 40 гаруй хувьтай ийм статистик үзүүлэлттэй байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Монголбанкнаас хүн байхгүй юу? Алга байна. Энх-Амгалан сайд. Ипотекийн зээлтэй холбоотой. Энэ ипотекийн зээлийн энэ нэг Монголбанкнаас дээр бас нэг арилжааны банкнуудад хуваарилаад байгаа квотын асуудал гэж бас нэг юм хүндрэл үүсгээд байх шиг байгаа юм. Энэ ЗГ бас энэ дээр анхаарахгүй болбол цөөн тооны 2, 3-хан банкин дээр бүх юмыг нь төвлөрүүлчхээд, тэгээд зарим байдлаар

нөгөө арилжааны банкнууд нь эх үүсвэрийн дутагдалтай гэдэг шалтгаанаар орон нутагт зээл олгохгүй байгаа асуудал ч бас хөндөгдөж байна лээ. Тэгэхээр энийг бас нэг цэгцлэх нь зүйтэй юм шиг байна лээ. Энх-Амгалан сайд хариулъя. Дараа нь Жавхлан сайд нэмж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэхийн тулд л энэ Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний хороо ажиллаад ирэх жил болбол нэлээн энэ хүртээмж талд нь, орлогод нийцсэн орон сууц талд нь болбол нэлээн тийм дэмжсэн бодлогууд нийт 13 мянган хүний л боломжуудыг хангая гэсэн нэг ийм эх үүсвэрийг бас шийдэж байгаа.

Тэгээд Сандаг-Очир гишүүний асуусан асуулт болбол нөгөө төрийн албан хаагчдын орон сууцын асуудал дээр яг ямархуу бодитой боломжууд гарах юм бэ л гэж асуугаад байна шүү дээ. Хуучин бол ипотекийн зээлийн бараг үндсэндээ 70 хувь нь Улаанбаатарт олгогддог байсан бол ирэх жил ямар ч байсан 50, 50 хувийг нь, 50 хувийг нь Улаанбаатарт гэхдээ Улаанбаатарт болбол яг энэ төвд төвийн орон сууц биш захын орон сууц руугаа эсхүл гэр хороололд гэдэг юм уу энэ байдлаар нэг ийм 4 ийм зорилтот бүлэг бид нар гаргачхаад байгаа шүү дээ. 1 дүгээрт анх гэр бүл болсон эсхүл анх удаа орон сууц авч байгаа. Мэдээж олон хүүхэдтэй, ингээд нөгөө юутай амины орон сууц, тэгээд төрийн албан хаагчдын орлогод нийцсэн энэ орон сууцын.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Би зүгээр нэмэлт мэдээлэл өгье. Монголбанкнаас МИК-ээр дамжуулаад энэ ипотекийн тогтолцоо нэлээн олон жил явж ирсэн. Цаашидаа ЗГ Монголбанк хамтарсан байдлаар явах ийм тогтолцооны өөрчлөлт хийхээр ингээд шилжилтийн үед явж байна гэж ойлгож болно. Үндэсний хороо

байгуулагдаад энэ дээр онцгой ач холбогдол өгөөд Ерөнхий сайд өөрөө ахлаад явж байгаа. Ирэх жил нэг хэд хэдэн эх үүсвэрүүдээс одоо байгаа эргэлт, нэмэх нь Баялгийн сангаас шинээр хуваарилалтууд хийх, өөр мөн ямар боломжууд байна МИК өөрөө ч бас хөөцөлдөж байх шиг байгаа юм. Гаднын эх үүсвэр, хамтрах олон улсын санхүүгийн байгууллагууд бол хэд хэдэн институтууд хамтарч ажиллах боломж илэрхийлж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ ингээд болбол жигдрээд явна гэж харж байгаа. Энийг мөн хариуцсан яам нь БХБЯ-наас гадна.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайдад нэмэлт нэг минут өгье, хариулт өгье.

**Б.Жавхлан:** Тэгээд хэд хэдэн яамнууд энэ дээр хамтраад мэдээж Гэр бүл, нийгэм хамгааллын яамны зүгээс энэ дээр онцгой ач холбогдож манлайлал үзүүлээд явах ёстой ийм ЗГ-ын ажил үүргийн хуваарилалт гарсан байдаг. Дээрээс нь саяын тэр нөгөө банкны асуудлыг би зүгээр өөрийн авч байгаа мэдээллээр гэх юм бол энэ банкнууд сар бүр ямар хэмжээний эргэн төлөлт хийнэ тэрүүгээр нь эргээд яг тэр хувь хэмжээгээр нь хуваарилагдаад явдаг гэж бид ийм ойлголттой байгаа. Тийм учраас энэ нь яах вэ банкин дээр очоод энэ эрэлтдээ хүрэхгүй ийм талууд байх шиг байгаа юм. Тийм учраас нийлүүлэлтийг нь нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарч ажиллана гэж төлөвлөж байгаа юм ЗГ.

**Д.Амарбаясгалан:** Энэ барилга, орон сууц, ипотекийн зээлтэй холбоотой асуултыг бараг гишүүн болгон шахуу асуух гээд байдаг Барилга, хот байгуулалтын сайд хаана байна вэ? Хэрэг эрхлэхээс энд дуудаж бас энэ тодорхой хариулт өгөхгүй бол энэ ипотекийн зээлийн асуудлаар бас голлож санаачилга гаргаж хариуцдаг яам чинь Барилга, хот байгуулалтын яам шүү дээ. Тэгээд энэ яамны албан тушаалтнууд нь гүйцэд, тодорхой хариулт өгөөдхөөч. Гишүүн

болгон асуугаад байна. ТНБД-ын үүрэг гүйцэтгэгч. Учрал сайд энэ үүрэг гүйцэтгэгч нарынхаа асуудлыг яаралтай шийдээрэй. Төрийн албаны зөвлөлөөс орсон шалгалтын дүнгээр бас нэлээн олон зөрчил илэрсэн, тэрийг би бас Улсын Их Хурлын чуулган дээр удахгүй уншиж танилцуулахаар байгаа шүү. Тодорхой хариулт өгье.

**С.Төмөрхүү:** Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч. Орон сууцжуулалтын асуудал бол сая манай газрын дарга хариулсан. Энэ оны 9 сарын 20-ны байдлаар 1 их наяд 75 тэрбум төгрөгийг 9233 иргэнд ипотекийн зээл олгоод байгаа. Энэ эх үүсвэрийг ирэх жил 1,2 их наяд төгрөгт хүргэнэ гэж тооцоолж байгаа. Үүнээс 500 тэрбум нь Үндэсний баялгийн сангаас, 500 тэрбум нь өмнөх зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, 200 тэрбумыг арилжааны банкнуудын эх үүсвэрээр олгоно гэж ингэж тооцоолж байгаа. Орон нутагт олгож байгаа зээлийг 50 хувьд хүргэнэ. Улаанбаатар хотод мөн амины орон сууцыг ипотекийн зээлд хамруулах талаар яаман дээр ажиллаж байгаа. Амины орон сууцад ипотекийн зээл олгоход арилжааны банкнуудын тавьж байгаа шаардлага бол баталгаажуулалтын асуудал. Урт хугацаа.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулъя, 1 дүгээр индрийн микрофон өгье.

**С.Төмөрхүү:** Амины орон сууцыг ипотекийн зээлийн хугацаанд бат бөх байх тал дээр аудит хийж баталгаажуулах асуудал яригдаж байгаа. Энэ талаар амины орон сууцын Бэст гэр үнэлгээний аргачлалыг өнгөрсөн долоо хоногт манай яаман дээр аргачлалаа баталсан. Цаашид журмаа өөрчилнө. Ер нь бол энэ намрын чуулганаар Орон сууцжуулалтын тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж,

хэлэлцүүлж, энэ орон сууцын тогтолцооны асуудал илүү тодорхой болно гэж.

**Д.Амарбаясгалан:** Энэ сайд чинь хаачсан юм бэ?

**С.Төмөрхүү:** Сайд ирэх байх.

**Д.Амарбаясгалан:** Сайд ирэх байх аа? Үгүй ээ та нар энэ төсөв хэлэлцэж байгаа үе дээр энэ барилгынхаа орон сууцын хөтөлбөрийнхөө бодлогыг тодорхой болгоод авчихгүй намар араас нь хууль өргөн барих байх гээд сууж байх юм. Энэ төсөв хэлэлцээд, ирэх оны төлөвлөгөө батлагдаж байгаа үе дээр энэ том бодлогын асуудлыг шийдэж болдоггүй юм уу? Баялгийн сангийн хууль нь батлагдчихсан, ипотекийн зээлийн боломжийг өргөн хүрээтэй нэмчихлээ. Тэгээд ЗГ-аас хэрэгжүүлж байгаа маш олон төрлийн хөтөлбөр байгаа шүү дээ. Жишээлбэл сумд амьдарч байгаа иргэдэд 3 хувийн хүүтэй зээл олгох, аймагт амьдарч байгаа иргэдэд зээлийн боломжийг одоо байгаагаас хувь хэмжээг нь нэмэгдүүлэх, тэгээд сая яриад байгаа энэ анхны орон сууц хөтөлбөр зэрэг уялдаа холбоог нь сайжруулах зүйлс олон байна шүү дээ.

Үүгээрээ энэ Улсын Их Хурлын гишүүдэд нэг тодорхой мэдээлэл өгөхгүй болбол бүгд тал талаас нь өөр, өөр асуулт асууна. Тэгээд сайд нь байхгүй. Тэгээд тодорхой хариулж өгөхгүй, ТНБД нь үүрэг гүйцэтгэгч ийм байдалтай байж байгаа юм. Энэ дээр жоохон хариуцлагатай ажиллаарай. Тэгээд Монголбанк нэг өөр юм хариулдаг, танайх нэг өөр юм хариулдаг. Одоо Энх-Амгалан сайд орж ирж ахиад нэг өөр юм хариулж эхэлж байна. Тэгээд сүүлдээ бүр учир нь олдохгүй нь байна шүү дээ. Тийм, харин тийм гээд л тогтолцооны асуудал яриад. Тэгээд энэ дээрээ жоохон хариуцлагатай хандъя. Энх-Амгалан сайд нэмж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Үгүй ээ ийм л байгаа шүү дээ. Одоо ганцхан бас энэ орон



сууцын асуудлыг энэ Барилга, хот байгуулалтын яам хариуцна гээд ингээд бас болохгүй юм байна лээ. Энэ салбар дундын зохицуулалтууд үнэхээр шаардлагатай байгаа юм байна лээ. Тэгээд Үндэсний хороо гарч ирж ажиллаад нэг сар гаруй ажиллаж байна. Тэгээд 4 асуудалд бид нар хариулт өгөх ёстой 4 асуудалд. 1 дүгээрт нь болбол энэ урт хугацаанд Монгол Улсад ер нь ипотекийн зээлийн ямар тогтолцоогоор явах юм бэ гэдэг ийм тогтолцооны асуудал байгаа. Энийгээ бид нар хийх ёстой. Эрх зүйн шинэчлэлүүдээ ч гэсэн энийгээ дагаад хийх ёстой.

2 дугаар асуудал болбол яг ингээд санхүүжилтийн тогтолцоо нь бий болчихоор яг нөгөө иргэдийн орлогод нийцсэн тэр орон сууцын бүтээгдэхүүнүүд нь яг ямар байх юм бэ? Энэний нийлүүлэлт нь яах юм бэ гэдэг асуудал юм байна лээ.

3 дугаар асуудал болбол тэр нөгөө энэ амины орон сууцуудын баталгаажуулалт, стандарт, гэрчилгээжүүлэлтийн асуудлууд байгаа юм.

4 дүгээр асуудал болбол дэд бүтцийн асуудал. Энэ цэвэр, бохирын шугамын асуудлууд, тэгээд дулааны асуудлууд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд дулааны асуудал яриад яах вэ. Одоо байна шүү дээ энэ яагаад салбарын яам байдаг учир шалтгаан чинь ер нь бүх асуудал салбар дундын асуудал бүх асуудал. Гэхдээ салбар хариуцсан яам байна гэдэг болбол манлайлж, удирдаж, менежментийг нь зөв хийж авч явахад л оршиж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ жоохон ажиллахгүй болбол нээрээ энэ бид бас энэ төсвийг 11 сарын 15-даар төсвөө батлах байх. Тэрнээс өмнө энэ барилга, ипотекийн орон сууцын зээлтэй холбоотой асуудлыг их тодорхой болгож, иргэдэд нэг нэгдсэн ойлголт өгөх

хэрэгтэй. Барилга, хот байгуулалтын яам энэ дээрээ онцгой анхаараарай. Тэгэхгүйгээр салбар дундын асуудал гээд. Сая өнгөрсөн хугацаанд бас харж байхад анзаарагдаж байсан зүйл яг ипотекийн зээлийн асуудал ороод ирэхээр Барилгын яаман дээр үндсэн хариуцагч нь байж байгаа мөртөө Сангийн яам заавал зөвшөөрөл өгнө эсхүл Монголбанк заавал ингэж оролцоно гээд. Сүүлдээ Монголбанк чинь бид энэ ипотекийн зээлийг хариуцахаасаа татгалзаж байна гэдэг асуудлыг өнгөрсөн жил бас хөндөж байсан шүү. Ингээд сүүлдээ энэ эзэнгүй болох вий дээ. Энэ дээрээ анхаарч ажиллаарай. Сандаг-Очир гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

**Ц.Сандаг-Очир:** Дарга тийм энэ ЗГ-ын гишүүд жоохон энэ Улсын Их Хуралд хүндэтгэлтэй баймаар байгаа юм. Жилийн ажлын төлөвлөгөө, төсөв төлөвлөгөө хэлэлцэж байхад ингээд салбарын сайд нар нь хагас дутуу байхгүй ингээд байж байтал бид нар ингээд л энд ингээд баахан төлөвлөгөө юм яриад ингээд. Тийм учраас энэ салбарын сайд нарыг нь суулгаж байж, байлгаж байж энэ хөгжлийн төлөвлөгөөг, төсвийг хэлэлцүүлэхгүй бол байхгүй бол бараг энийг хойшлуулмаар байгаа юм. Ингэж Улсын Их Хуралд хүндэтгэлгүй хандаж байгаа сайд нарыг бас нэр усаар нь цолломоор байгаа юм ирэхгүй байгааг нь. Ирсэн нэг нь нүүрээ улалзуулаад, ирээгүй нэг нь ингээд магадгүй зарим нэг нь орон нутагт улс төр хийгээд явж байгаа шүү дээ ажлаа хийхгүй. Тэгээд энийг нь нэр усаар нь хэлмээр байгаа юм. Тийм учраас энэ ЗГ-ын гишүүд дээрээ жоохон сахилга батын асуудал яримаар байгаа юм гэж.

Ипотекийн орон сууцын зээл чинь өөрөө орон нутагт дэд бүтцийн асуудлыг нь шийдэхгүй бол өртөг нь нэмэгдээд бодлого бас эсрэгээрээ яваад байгаа юм. Үнэ өсгөх хандлагыг үүсгээд байгаа юм. Тийм учраас дэд бүтцийн асуудлыг нь эхэлж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энэ Учрал сайдаа энэ байхгүй байгаа сайд нараа дуудаарай. Өнөөдөр санал хураалттай гэдгийг манай ЗГ-ын гишүүд бүгдээрээ ойлгож байгаа байх. Улсын Их Хурлын гишүүд ч бас энэ дээр сайн ойлгож байгаа байх. Хөдөө орон нутагт энэ орон нутгийн сонгуулийн асуудлаар чөлөө хүссэн нэг 20-оод гишүүд бичиг нь ирчихсэн. Гэхдээ өнөөдрийн байдлаар би болбол албан ёсоор зураагүй. Намрын чуулган албан ёсоор эхлээд явж байхад гишүүд хурал чуулгандаа сууж байх ёстой. Сүүлийн үед нэг ажиглагдаж байгаа зүйл Тамгын газар энэ дээр сайн анхаарна шүү. Гишүүдэд сануулж хэлнэ. Зөвшөөрөл хүссэн бичиг өгчхөөд, зөвшөөрөл авчихсан гэж бодож яваад байгаа. Зөвшөөрлийг өгөх эсэх асуудал өөрөө Улсын Их Хурлын дарга чуулганы ирц, хэлэлцэж байгаа асуудлын цар хүрээтэй холбоотойгоор шийдвэрлэдэг.

Гэтэл бичиг шидчихээд өөрсдөө өөрсдөдөө чөлөө өгөөд явчихсан байна. Тэгэхээр энэ ЗГ-ын гишүүд, энэ Улсын Их Хурлын гишүүд чуулганыхаа хуралдаанд хүрэлцэн ирж суухыг хүсэж байна. Яг өнөөдөр над дээр жишээ нь 9 сарын 30-нд томилолтоор гадагшаа явж байгаа хүн бичгээ өгчхөөд л яваад өгсөн байна. Энэ ойлголтыг бүгдээрээ засаж, залруулна шүү аль, аль талдаа. Дараачийн хүн асуултаа асууя. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууна.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Сонгуулиас хойш зүүн бүсээс сонгогдсон гишүүд өөрсдийн сонгогдсон бүсийнхээ бүх сумдаар явж иргэд олон нийттэй уулзаж, энэ ЗГ мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөр гээд олон зүйлийн танилцуулгуудыг хийж, эргэх холбоо хөтөлбөрийг хэрэгжүүлээд ингээд ажилласан. Тэгээд иргэд бол энэ ЗГ-аас 14 мега төсөл гээд олон зүйлүүдээс бол бас их өндөр хүлээлттэй байгаа юм байна гэдэг нь бол бас уулзалт болгоноос л анзаарагдаж байсан. Тэгээд 2025 оны төсөв дээр энэ олон мега төслүүдийн

эхлэлүүдийг бас зөв тавих олон зүйлүүд бас яригдаж байгаа.

Бидний хувьд ч гэсэн энэ зүүн бүсийн хөгжлийн хувьд энэ бүсчилсэн хөгжлийн түүхэн аялал жуулчлалын, боомтын сэргэлтийн, хөдөө аж ахуйн гээд энэ олон томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх энэ ТЭЗҮ, зураг, төсөв гээд олон ажлууд руугаа бол орчихсон ингээд ажиллаад байж байгаа. Бидний хувьд энэ иргэдээс ирсэн хүсэлтүүдийг бас нэлээн ангилж, олон давтамжтай гарсан энэ зүйлүүд дээр бас нэлээн фокуслаж энэ 2025 оны төсөв Монгол Улсын цаашдын хөгжлийн бодлогод бас тусгуулах талаар анхаарч ингэж ажиллаж байгаа.

Эндээс нэг зүйл бол энэ дахиад л орон сууцтай холбоотой асуудал байгаа юм. Үндэсний баялгийн сангийн хууль батлагдаж эхэлсэн тэр цагаас хойш 3 буюу орон сууц, боловсрол, эрүүл мэнд гэсэн энэ чиглэлээр ажиллах санхүүжилт босгох ийм бололцоотой болсон. Орон сууцын хувьд бол би Улаанбаатар хотыг бол маш сайн ажиллаж байна гэж үзэж байгаа Нямбаатар сайдыг. Энэ Сэлбэ дэд төв, дараагийн дэд төвүүд эргэлтэд оруулах эх үүсвэрээ гаргаад авчихсан ингээд ажиллаж байна. Орон нутгийн хувьд бол энэ дэд бүтцийн асуудлууд ялангуяа хашаандаа сайхан амьдрах бололцоог гаргаж байгаа тэр инженерийн шугам сүлжээг холбох энэ ажлууд бол бас явах хэрэгтэй юм билээ.

Жишээ нь Хэнтий аймаг дээр 5 мянган өрх өнөөдөр 26 он гэхэд инженерийн шугам сүлжээ, дулаан, халуун, дулаан, цэвэр, бохирт холбогдоход бэлэн болж байгаа юм. Эдгээрийг 5 мянган өрхийг бид нар тэр хашаандаа сайхан амьдрах бололцоог нь бүрдүүлээд ингээд явбал Дорнодын төв Чойбалсан, Сүхбаатарын төв Баруун-Урт дээр ч гэсэн энэ төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх бололцоотой юм билээ. Тэгэхээр энэ төслүүдийг хэрэгжүүлэхэд Үндэсний баялгийн сангийн энэ уялдаа

холбоо заавал орон сууц гэхгүйгээр амины орон сууц, дэд бүтэцжүүлэх энэ ажил руу бас оруулах бололцоо, судалгаа юмнууд энэ юун дээр хийгдсэн байгаа юу? 2025 оны төсөв дээр гэж ингэж бас 1 дүгээрт асуумаар байгаа юм.

2 дугаарт иргэд, олон нийтээс ялангуяа ХАА-н салбар, МАА-н салбар өнгөрсөн өвлийн тэр хүндрэлүүдийг маш гарз хохиролтойгоор давсан. Тэр дундаа зүүн бүсийн хувьд бол бас зарим аймаг 70 хувиа хүртэл малаа алдсан ийм айхтар зүйл тохиолдсон. Байгалийн давагдашгүй хүчин зүйл. Тэгээд эндээс сөрж гарах энэ Шинэ хоршоо хөтөлбөрийг бас хэрэгжүүлээд энэ чинь бараг 60 гаруй мянган хоршоологчдод бас зээл, хүү олгоод ингээд явж байгаа. Тэгээд суулийн үед нэг ийм ойлгомжгүй нөхцөл байдал үүсээд байгаа юм. Ингээд 2025 оны төсөв батлагдахад энэ Шинэ хоршоо хөтөлбөр яг үргэлжлэх үү? Эхэлсэн шигээ тийм эрчтэй явах уу? Тэрэн дээр санхүү, хөрөнгийн асуудал, эх үүсвэрүүд найдвартай болсон уу гэдэг дээр би бүр онцгойлон тодруулга авмаар байна.

Яагаад гэвэл иргэд, малчид бол маш сайн мэдээлэлтэй болчихсон. Миний өнөөдрийн асууж байгаа энэ дараа нь хариулах гэж байгаа сайдын хариултыг хүлээгээд сууж байгаа. Он гарангуут энэ асуудал руугаа анхаарлаа хандуулдаг, шийд нь ирээгүй, бичиг хүлээгээд байна, та хүлээж бай гээд л ингээд л нэг ойлгомжгүй процессууд яваад байгаа учраас бид ингээд энэ зарим зүйл дээр түрүүлж яриад байгаа юм шиг, худлаа яриад байгаа юм шиг, бидэнд итгээд ажлаа төлөвлөчихсөн хүний ажлыг бас баллаад байгаа юм шиг ийм зүйлүүд байгаа юм. Тэгэхээр Шинэ хоршоо дээр би бүр тодорхой.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгөх үү? Ипотекийн зээл гээд л бас нэг баахан орон сууцын хөтөлбөр. Яах вэ? Харин тийм инженерийн шугам сүлжээтэй. Ер нь энэ бодлогын асуудал дээр яах вэ? Хариулах хүн байна уу? Энх-Амгалан сайд

хариулах уу? Түрүүн яг дулааны шугам сүлжээ гэж байгаад тасарчихсан. Энх-Амгалан сайд эхлээд нэг хариулт өгчихье.

**Л.Энх-Амгалан:** Харин тийм ээ тийм. Энэ ингээд салбар дундын зохицуулалт учраас тэгээд яах вэ Үндэсний хороон дээр, Үндэсний хороо байгуулагдсаны нэг давуу тал болбол бас ингээд нөгөө тухайн салбарууд дээр байсан асуудлуудыг нэгтгээд ингээд нэг шийдлүүд гаргаж байгаа бас нэг ийм сайн механизм болоод байна л гэж бид нар хараад байгаа байхгүй юу. Тэгэхээр мэдээж яг сая Идэрбат гишүүний асуусан асуулт болбол энэ хөдөө орон нутагт буюу энэ аймгийн төв дээр амьдарч байгаа хашаандаа амьдарч байгаа энэ хүмүүс хашаандаа сайхан амьдрах энэ боломж нь энэ ипотекийн зээлээр олгогдож байгаа юу? Энэ дэд бүтцүүдийн шийдэх асуудлуудыг нь бас ирэх 25 он дээр ямар асуудлууд шийдэж байгаа юм бэ л гэдэг асуудлууд яриад байх шиг байна л даа.

Тэгэхээр та Их Хурлын дарга ч гэсэн түрүүн хэлсэн. Энэ 10 аймагт байгаа нөгөө явж хэрэгжиж байгаа дулааны станцуудын асуудлуудыг түргэвчлэх, аймгуудын төв буюу сумуудын төвүүд дээр энэ цэвэр, бохир усны шугамуудын энэ дэд бүтцийн асуудлуудыг шийдэх энэ шийдлүүд нь энэ Барилга, хот байгуулалтын яам дээр бас тодорхой гараад явж байгаа юм байна лээ л дээ. Нийт миний ойлгосноор болбол 330 сумтай. 330 сумаас бол яг инженерийн шугам сүлжээнд холбогдчихсон яг энэ төслийг хэрэгжүүлэх бололцоотой 90 гаруй сум байна гэж ойлгоод байгаа шүү дээ. 90 гаруй сум. Тэгээд мэдээж аймгийн төвийн асуудлууд байгаа. Аймаг бүхэн бас өөр өөрөөр шийдсэн шийдлүүд байгаа. Жишээ нь би Улсын Их Хурлын гишүүний хувьд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод болбол 2 мянга гаруй гэр хорооллын иргэд рүү яг дэд бүтэц татаад ингээд оруулчихсан Мөрөндөө сайхан амьдаръя гэдэг энэ хөтөлбөр хэрэгжээд явж байгаа.

Тэгэхээр энэ хүмүүст л тэр ипотекийн энэ буюу амины орон сууцынх нь зээлийн хүртээмжүүдийг бий болгоё. Яаж бий болгох вэ гэхээр одоогийн амины орон сууцад байгаа стандарт тэр улсын комисст хүлээж авдаг, баталгаажуулдаг энэ журамдаа л бид нар өөрчлөлт хийгээд өгчих юм болбол энэний эх үүсвэрүүд нь нэмэгдээд явчих ийм л шийдлүүд байгаа гэж хараад байгаа байхгүй юу.

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр сайд нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Мэдээж хэрэг ипотекийн зээлийн сан болбол хүртээмж багатай. Одоо 7 их наяд орчим бүрдсэн байдаг юм. Энэ мөнгө чинь өөрөө төр өөрөө гаргаж байгаа л мөнгө шүү дээ. Энэ арилжааны мөнгө биш, зүгээр ингээд анх төр ЗГ санаачлаад л хямд хүүтэй мөнгө тусад нь салгаж аваад нийлүүлье гээд ингээд л явчихсан зүйл байхгүй юу. Тэгэхээр энэ хэмжээ хязгаартай шүү гишүүдээ. Мөнгө хэвлээд ингээд ипотекийн зээл гээд олгоод байх зүйл бол байхгүй. Ирэх жил бол 1,2 их наяд төлөвлөгдөж байна. Одоо бид нар болбол анхны мөнгөө Ипотекийн зээлийн корпорацаар явж байсан мөнгөө хэрхэн хажуугаас нь арвижуулах вэ гэдэг ийм л зүйл яригдаж байгаа шүү дээ. Тэгээд энэ бодлогын хувьд бол нэг л зүйлийг гишүүд маань байнга шаардах хэрэгтэй. Юу вэ гэвэл анхны орон сууц авч байгаа хүнээ дэмжье. 2 дахь, 3 дахь байхгүй шүү нөхдүүд ээ.

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулъя Гантөмөр сайд.

**Л.Гантөмөр:** Дахиад нэг зүйл дээр манай гишүүд маань Засгийн газраа дэмжиж өгөөсэй гэж хүсэж байгаа. Хотынхоо асуудлыг шийдье. Хөдөөг орхиё гэж байгаа зүйл биш шүү. Хотын асуудал шийдэхгүй бол Монгол Улсын эдийн засаг асар их хохирол амсаад байна. Хот утаанаас салахгүй болохоор жилд бараг 3-аас 4 их наядын хохиролтой байгаад байна. Тэгэхээр хотын асуудал шийдэж

байна гээд зэрэгцүүлээд л ингээд л аймаг, сум болгоныг миний тойрог гээд давчих юм болбол хэдүүлээ юуг нь ч шийдэж чадахгүй. Тийм мөнгө байхгүй, байхгүй шүү дээ. Бид бол байгаа мөнгөнийхөө хэмжээнд зөв бодлого гаргаад, урт хугацаандаа тогтвортой хэрэгжүүлэх бодлогыг зорьж байгаа шүү гэдгийг ойлгоорой.

**Д.Амарбаясгалан:** Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулга.

**Ц.Идэрбат:** Гантөмөр сайдаа ЗГ-ын бодлогоо дэмжиж байгаа. Ялангуяа Улаанбаатар хотод энэ барилгажуулалт хийж байгаа, сүүлийн үед хийгдэж байгаа энэ Нямбаатар даргын энэ шинэчлэлүүдийг бол 2 гараа өргөөд дэмжиж байгаа. Би ч бас хотын иргэн болчихсон хүн шүү дээ.

2 дугаарт миний яриад байгаа зүйл энэ нэг айлд ипотекийн зээл олгосноос хамаагүй хямд тусах зардал яриад байгаа байхгүй юу. Эх үүсвэр хязгаартайг мэдээд байгаа. Хязгаарлагдмал эх үүсвэрээ яаж олон нийтэд илүү хүргэх вэ гэдэг асуудал л би ярьж байгаа юм. Тэгэхээр та бол хариултдаа бас хязгаарлагдмал эх үүсвэр, хэн нэгэнтэй барьцаад миний тойрог гэж яриад байгаа зүйл огт байхгүй. Харин хийгдчихсэн байгаа боломжийг жзоохон дэмжээд өгвөл 5 мянгаараа орон сууц шиг тохитой орчинд хашаандаа сайхан амьдрах бололцоо бүрдэх талаар ярьж байгаа юм. Энийг бас та тэр талаас.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энхбаярын Батиугар гишүүн асуултаа асууя.

**Э.Батиугар:** Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ирэх жил эдийн засгийн өсөлтийг 8 хувьд өсгөнө гэсэн тийм төсөөлөл байна. Тэгээд яах вэ эдийн засгийн дотоодын бүтээгдэхүүнийг өсөлтийг нь хэмждэг томьёо байдаг. Энэ бол хэрэглээ, хөрөнгө оруулалт, ЗГ-ын хөрөнгө оруулалт болон цэвэр экспорт гээд. Тэгээд яг энэ томьёоллын задаргааг



нь бас авч аль өгөгдөл нь илүү тавьж байгаа юм бэ хармаар байна.

2-т нь бас л гишүүд ярьж байна л даа. Энэ ипотекийн зээл болон орон сууцын талаар. Тэгээд яах вэ энэ нэмж асуугаад яах вэ. Гэхдээ Үндэсний орон сууцжуулалтын хууль ЗГ-аас ахиж орж ирэх үү? Тухайн үед бол энэ хууль бол нэлээн тийм багцаар нь бүх асуудлыг шийдчихсэн хууль байсан. Ялангуяа түрээсийн орон сууц, орлогод нийцсэн орон сууц, бага, дунд орлоготой иргэдийн орон сууц гэх мэтчилэн зүйл.

Үнийн өсөлт. Энэ үнийн өсөлтийг болбол 7 хувьд Монголбанк 6 дээр нь -2, +2 гэж тавьсан байгаа. Тэгэхдээ ЗГ-аас энэ нийлүүлэлтийн тал дээр ялангуяа тэр хүнсний нийлүүлэлт болон махны нийлүүлэлтийн тал дээр ямар бодлого баримтлах вэ? Мөн магадгүй болзошгүй махны хомсдолд орох, зуд тохиолдох энэ үед болбол яаж энэ нийлүүлэлтийн гаралтай инфляцаа зөв зохицуулах вэ гэж асууя.

Нийт 5 төрийн өмчийн компанийг хувьчлах нэг ёсны листэд болгоно. Үүгээрээ дамжуулж 1,5 их наяд төгрөгийг төвлөрүүлнэ гэсэн тийм төсөөлөл байна. Үүнтэй холбоотойгоор 1 дүгээрт асуух нь болбол яг ямар байдлаар тухайн компаниудаа үнэлэх юм бэ, яг valuation-оо яаж хийх вэ, олон улсын аргачлалаар хийх үү, үгүй юу? 2-т нь болбол шинээр хувьцаагаа гаргаж тэрийгээ зарах юм уу, аль эсвэл одоо байгаа хувьцаагаа зараад, тэгээд Төрийн өмчийн хороо болон бусад хувьцаа эзэмшигчид нь аваад тэр мөнгөө зарцуулах юм уу? Мөн зарцуулалт нь яаж явах тийм төлөвлөгөө байгаа вэ гэж асууя.

Мэдээж юу байна Нийслэлийн түгжрэл бол хамгийн том тулгамдсан асуудлуудын нэг. Үүнтэй холбоотойгоор хамгийн амархан шийдэж болох арга болбол ухаалаг гэрлийн дохио болон камержуулалт. Үүнтэй холбоотойгоор

1500 шинэ ухаалаг гэрлийн дохио нэвтрүүлнэ болон 500 камер нэвтрүүлнэ гэсэн ийм төлөвлөгөө харагдаж байна. Үүнтэй холбоотойгоор яг ямар хугацаанд, мөн ямар хөрөнгөөр худалдаж авах вэ энэ? Үүгээрээ дамжуулж нийт түгжрэл хэдэн хувиар буурах бололцоотой вэ? Бусад том улс орнуудыг харахад ялангуяа Москва, Берлин, Хятадын улс орныг харах юм бол 15-аас 20 хувиар буурах бололцоотой гэсэн тийм судалгаа байдаг.

Нэмж асуухад болбол гадаадын хөрөнгө оруулалтыг ирэх онд болбол 15 хувиар нэмэгдүүлнэ гэсэн төсөөлөл байна. Тэгэхээр өнөөдөр байгаа гадаадын хөрөнгө оруулалтыг яаж гадаад хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээж, ямар бодлого баримталж байж энэ хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх вэ? Мөн үүнтэй холбоотойгоор нийт гадаадын хөрөнгө оруулалтын 30 хувийг сэргээгдэх эрчим хүчид зарцуулна, ингэснээрээ 250мвт-ыг нэмэгдүүлнэ, шинээр сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр гаргана гэсэн тийм төсөөлөл байна. Яг энэ яг бодитой юу? Мөн сэргээгдэх эрчим хүч гэхээр яг ямар эрчим хүч болон ямар улс орнуудаас татах вэ хөрөнгө оруулалтаа?

Бас үүнтэй холбоотойгоор стратегийн түнш орнуудтай 7 шинэ хэлэлцээр төлөвлөсөн байна. Тэгэхээр энэний талаар бас дэлгэрэнгүй тайлбар өгөөч гэж асууя. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү хариулна.

**И.Батхүү:** Батиугар гишүүний асуултад хариулъя. Таны хэлсэн эдийн засгийн ДНБ-ий өсөлтийн 2025 оны таамаглал зорилт бол 8 хувь гэж үзэж байгаа. Энэ эрэлт талаасаа харах юм бол энэ дотроо эцсийн хэрэглээ нь өөрөө 3,2 хувиар, хөрөнгийн хуримтлал 11,9 хувиар, цэвэр экспорт 3,2 хувиар өснө гэсэн хүлээлттэй байгаа. Ингээд нийлүүлэлт талаасаа бас гол энэ эдийн засгийн өсөлтийг тооцож байгаа

таамаглалуудаа бас танд хариулж өгье. 25-аас 27 оны хувьд бол ЗГ эдийн засгийн өсөлтийг өндөр хувьд хадгална гэсэн бодлогын зорилт тавьж ажиллаж байгаа. Яг 25 онд бол Оюу толгой төслийн зэс, алтны агууламж нэмэгдэж байгаа. Тухайлбал зэсийн агууламж нь бол бараг 50 хувиар нэмэгдэж байгаа далд уурхайн олборлолттой холбоотой. Алтны агууламж маань 2 дахин нэмэгдэж байгаа. Эдгээр нь бас эдийн засгийн өсөлтөд бас нэлээн өндөр хувь нэмэр оруулж байгаа.

Дээр нь бас өнгөрсөн жилүүдэд ХАА-н салбар бол дандаа уналттай байсан. Энэ онд өвөлжилтийн нөхцөл байдал, цаг агаарын нөхцөл байдал, гамшигийн нөхцөл байдал гайгүй байх юм бол ХАА-н салбарын бас сэргэлт нэлээн хувь нэмэр оруулна. Эдийн засгийн өсөлтөд дагаад бас ялангуяа уул уурхайн салбарын өсөлтийг дагаад худалдаа, тээвэр, боловсруулах үйлчилгээний салбарууд өсөлттэй гарахаар хүлээлттэй байж байгаа. Дээр нь бас ЗГ-ын зүгээс уул уурхайн бус салбарын экспортыг нэмэгдүүлэх бололцоо зах зээлээ тэлэх үүднээс тухайн хөрш улс орнуудтай тухайлбал Евро-Азийн эдийн засгийн холбоо, БНСУ-тай худалдааны хэлэлцээрүүд хийгдэж байгаа. Эдгээр хэлэлцээрүүдийг бас амжилттай дуусгана гэсэн тооцоололтой байж байгаа. Тэгээд яг тоон үзүүлэлтүүдийг та хүсвэл бас бичгээр хүргүүлж болно. Энэ эдийн засгийн тооцооллын.

Инфляцын хувьд бид нар 25 онд 7,5 хувиар, 26 онд 5 хувиар, 27 онд 4 хувиар гэсэн ийм зорилт тавьж байгаа. Энэ нь бол мэдээж Монголбанкны нөгөө 6 дээр +2, -2 гэдэг зорилтод түвшиндээ бол байгаа. Дээр нь ЗГ-ын зүгээс бас инфляцыг нам доор түвшинд барих нь өөрөө эдийн засгийн, макро эдийн засгийн тогтвортой байдал цаашилбал иргэдийн орлого, орлогыг хамгаалах энэ утгаараа бол бас зорилтот түвшинийг бууруулна гэж ажиллаж байгаа. Яг 2025 онд 7,5 хувь гэж байгаа шалтгаан нь бол бид

нарын анх тавьж байснаас бага зэрэг 1,5 хувиар нэмсэн байгаа. Энэ шалтгаан нь бол эрчим хүчний салбарын либералчлал гэх зэрэг салбаруудын либералчлал реформтой холбоотой нэмэлт зардлууд, дарамтууд гарах хүлээлт бас бид нарын хувьд тооцоон дээр байж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Харин, нэмж хариулах хүн байна уу? Энэ Сангийн сайдыг орж ирэхээр Идэрбат гишүүний түүрүүний хоршоо, хоршооны хөрөнгө оруулалт, ирэх жилийн зээл бодлоготой холбоотой асуудлаар тодорхой хариулт өгүүлье. Харин хариулах хүнгүй болчихоод байна шүү дээ. Хариулах хүн байдаггүй. Хувьчлал мэддэг хүн байна уу? Төрийн өмчийн хорооны дарга нэг хариулж үзэх үү? Цэнгэл дарга нэг хариулаад үзье дээ. 2 дугаар индрийн микрофон өгөх үү? 18, гараа өргөхгүй байна албаны хүмүүс асуултад хариулъя гэхээр.

**Б.Цэнгэл:** Батшугар гишүүний асуултад хариулъя. Бид нар Их Хурлын үндсэн чиглэл гараад ЗГ-аас жагсаалт батлаад 26 ААН-үүдэд IPO гаргах ажлыг бол хийгээд явж байгаа. Та бүхэн мэдэж байгаа Монголын хөрөнгийн бирж 100 хувь байсан бол 34 хувийг бирж дээр олон нийтийн болж амжилттай гарсан. Төрийн банк бас олон нийтийн болоод явж байгаа. Цаана нь бол бас 20 АЗЗА, мэдээлэл, технологийн хэдэн компани байж байгаа. Энэ дээр бол бид бол салбарын яам, ЗГХЭГ-тай яриад зарим нэгэн компани дээр бол бас бодлогын хувьд бол бас эргэж харъя. Тухайлбал Мэдээлэл холбооны сүлжээ компани дээр бол стратегийн гэдэг ангилалд багтахаар компани учраас энэ дээр бол үндэсний энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн компаниуд бол саналаа илэрхийлээд байгаа. Тэгэхээр энийг бол эргэж авч үзье гэдэг байдлаар бол.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** 21 дүгээр микрофон Сангийн яамны ТНБД Ганбат дарга хариулъя.

**Ж.Ганбат:** Би Идэрбат гишүүний тэр хоршоотой холбоотой асуудал дээр хариулт өгье. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024 оны 9 сарын байдлаар 518 тэрбум төгрөгийн зээлийг нийт 15,1 мянган малчинд бол олгоод байна. Энэ хүрээнд нийтдээ 4026 хоршоонд санхүүжилт олгосон байна. 2024 онд нийт 500 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөж банкнуудтай гэрээ байгуулаад хэрэгжүүлж байгаа. Энэ оны эхний 8 сарын байдлаар төлөвлөсөн хэмжээнд хүрсэн тул энэ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж тус гэрээний хүрээнд 2025 оныг дуустал хүртэлх хугацаанд 1 их наяд төгрөгийн зээлийг олгохоор өөрчлөлт оруулаад хэрэгжүүлж эхлээд байгаа.

**Д.Амарбаясгалан:** Энэ Ганбат даргаа ингэж асуугаад байгаа юм. Нэгэнт ЗГ 5 жилийн 5 их наяд төгрөгийн хөтөлбөр баталчихсан. Жилд 1 их наяд төгрөгийн зээл олгохоор төлөвлөлт хийгдсэн гэсэн үг. Тэгээд яагаад ирэх оны төсөв дээр 500 тэрбумын зээлийн эх үүсвэрийг шийдэж орж ирсэн бэ гэдэг асуултыг энэ гишүүд, сая тэр Улсын Их Хурлын гишүүдийн төсвийн хэлэлцүүлэг хийх үеэр асууж байсан. Тэгэхээр энэ болбол яг тодруулж асуух нь, Идэрбат гишүүн тодруулаад асууя. Асуугаад байгаа зүйл нь энэ шүү?

**Ц.Идэрбат:** Тийм энэ яг 2 асуудал байгаа юм. 1 дүгээрт бол төлөвлөснөөс хэтэрсэн. Гэхдээ он гартал бол ингээд 12 сар дуустал явуулъя гээд нэг ийм асуудал байгаа. 2 дахь нь бол 2025 оны шинэ төсөв ингээд хэрэгжээд эхлэхээр зээлийн эх үүсвэрийн хэмжээ 500 тэрбум, 1 их наяд гэдэг 2 эх үүсвэр яригдаад байгаа юм. 3 дахь асуулт бол бидний энэ асууж байгаа асуулт, хариултыг яг иргэд, малчид хараад сууж байгаа учраас Төсвийн хууль хэрэгжиж эхэлсэн тэр цагаас энэ арилжааны банкнууд дээр зээлийн олголтууд хэвийн явагдах уу гэдэг. Жишээ нь энэ хугацаанд материалаа өгөөд, бүх шаардлагаа хангачихсан олон хоршоонууд зээлээ авч чадахгүй бас хүлээгдээд байгаа. Тэгэхээр энэ зохицуулалтууд яаж уялдаж

орж ирэх юм бэ гэдэг л үндсэндээ ийм 3 асуулт л байгаа юм л даа.

**Д.Амарбаясгалан:** Энхбаяр сайд ХХААХҮ-ийн сайд.

**Ж.Энхбаяр:** Өнөөдөр манай МАА-н салбарт нийт 298 мянган малчин байгаа. Энэ нь өөрөө Монгол Улсын нийт хөдөлмөрийн нөөцийн ¼ энэ салбарт ажиллаж байна гэсэн үг. Малчид маань энэ хоршооны хөдөлгөөнд талархан дэмжээд идэвх зохион байгуулалттай оролцож байна. Эх үүсвэр эхний эх үүсвэр дууссан. Шинээр дахин 500 тэрбум баталсан. Банкнууд дээр судалгааны ажлууд үргэлжлээд зээл олголт явагдаж байна. ЗГ дээр энэ асуудал дээр нэлээн ач холбогдол өгч байгаа. Ингээд эрчимжүүлэх үүднээс Шадар сайд Амарсайхан энэ хоршоог Үндэсний хороо болгон өргөтгөх ийм санал гарч, энэ дэмжигдсэн. Ингээд Шадар сайд энэ хоршооны асуудлыг хариуцахаар ЗГ-аас шийдвэрлэсэн байгаа. Энэ гол зорилго маань өөрөө энэ хоршооны бодлого маань Хүнсний хувьсгал, Цагаан алт хөтөлбөр, Атрын 4 дүгээр аян гэсэн бусад түлхүүр бодлогуудтайгаа ингээд нэг цогц болж хэрэгжих учиртай.

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулъя. Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Тэгэхээр Үндэсний хороо болон өргөтгөж, ач холбогдлыг нь өргөж, Шадар сайд хариуцаж ингэж ажиллахаар болсон. Тэгээд энэ 4, энэ 25 онд хэрэгжих 4 том цогц ХАА-н салбарын бодлого маань хоорондоо уялдаатай, малчдыг өөрийн үйлдвэрлэлтэй холбох, хариуцлагатай байх, хамгийн гол нь энэ байгаль, цаг уурын эрсдэл, глобал уур амьсгалын өөрчлөлтөд Монгол Улсын мал сүргийг тэсэн гаргах, даван туулах чадавхтай болгох, малчдыг хөдөлмөрөөр нь хорших гээд энэ МАА-гаас гадна энэ нийгмийн, улс төрийн маш олон ач холбогдлыг багтаасан ийм том хөтөлбөр болж өргөжихөөр ингэж бэлтгэгдэж байна. Тэгэхээр хөтөлбөр, бодлого, зээл,

санхүүжилт тасралтгүй тогтвортой үргэлжилнэ.

**Д.Амарбаясгалан:** Батиугар гишүүний асуулт явж байгаа, тодруулъя.

**Э.Батиугар:** ТӨХ-ноос ахиад асууя л даа. Энэ 5 компанийнхаа IPO хийхдээ шинээр хувьцааг гаргах юм уу аль эсвэл одоо эзэмшиж байгаа хувьцаагаа зарах гээд байгаа юм уу? Тэгээд тэр олсон мөнгөөрөө яг ямар, яаж зарцуулах юм бэ? Мөн тэр valuation болон үнэлгээг нь яаж хийх гэж байгаа юм бэ гэж асууя.

Эрдэнэбүрэн сайд ирчихсэн байна. Энэ 1500 ухаалаг гэрлийн дохио болон 500 камераа хэдэн төгрөгөөр худалдаж авах вэ, хэзээ хэрэгжүүлэх вэ? Үр дүнд нь түгжрэл хэдэн хувиар буурах вэ? Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ренчинбямбын Сэддорж гишүүн асуулт асууя. Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганы үдээс өмнөх хуралдаан 13 цагт завсарлаад, 14 цагаар эхлэхээр байгаа. Тэгэхээр энэ ЗГ-ын бас зарим гишүүдийг хурал чуулгандаа ирж, энэ гишүүдийн асуултад бүрэн хариулах үүрэг хариуцлагаа ухамсарлаж ажиллахыг бид бас анхааруулж хэлж байна. Хэрвээ үдээс хойших хуралдаан дээр бас ирц иймэрхүү байдалтай байх юм болбол уг асуудлыг цаашаа хэлэлцэх боломжгүй болно гэдгийг бас урьдчилаад анхааруулаад хэлчихье. Ренчинбямбын Сэддорж гишүүн асуултаа асууя. Уучлаарай. Эрдэнэбүрэн сайд нэмж асуулт тийм, нэмж хариулт өгье.

**Р.Эрдэнэбүрэн:** Энэ нийслэлийн замын хөдөлгөөний иж бүрэн ухаалаг системийг нэвтрүүлж, хотын гэрлэн дохионы удирдлага менежментийг ухаалаг системд шилжүүлнэ гэсэн ийм заалттай. Тэгээд энэ ажил бол ерөнхийдөө энэ жил хэрэгжээд эхэлчихсэн юм билээ. Техникийн хувьд тендер нь орон нутгийн Улаанбаатараас хөрөнгө мөнгийг нь гаргаад, техникийн хувьд боломжоо бол ерөнхийдөө

бүрдүүлээд явж байгаа. Тэгээд ирэх жилээс эхлээд болбол замуудын уулзварууд дээр энэ мод барьсан цагдаа үзэгдэхээ болино гэсэн ийм юу мэдээлэл өгч байгаа. Яг нарийн тоо хэмжээ энэ нь болбол нэг 10-аас 15 хувиар замын хөдөлгөөний эрчмийг сайжруулна гэсэн ийм мэдээлэл өгсөн. Яг төслийнх нь төсвийнх нь дун, тендер яаж явагдсан энэ бүхнийг нь болбол Нийслэлээс манай ажлын хэсэгт байгаа хүмүүс нэмээд хариулчих байх. Нарийн тоо хэмжээг нь.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсэгт хэн байна вэ Эрдэнэбүрэн сайд? Хотоос хүн байна уу? Босож ирээд хариулъя. Та хэд чинь яачихсан юм бэ? Буланд суучаад л нэг гараа жижигхэн намхан өргөчхөөд л суугаад байх юм. Ажлаа хариуцаж байгаа юм бол хариуцаад тодорхой бай л даа. Тоглоом хийгээд байгаа юм шиг. 2 дугаар индрийн микрофон өгье.

**Д.Амгалан:** НЗДТГ-аас Амгалан. Ер нь энэ Замын хөдөлгөөний удирдлагын төв дээр бол энэ замын хөдөлгөөн зохицуулалтыг цагдаагаар буюу гараар, программ хангамжаар ийм зохицуулж ингэж ирсэн өнөөдрийг хүртэл явж байгаа. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар бол энэ жил бол энэ замын хөдөлгөөний уулзварууд, зам дагасан ухаалаг систем, камерын системийг бол нэвтрүүлэх ажил төсөл, тендер шалгаруулалт яваад ажил нь эхэлчихсэн явж байгаа. 11 сарын 30 гэхэд ийм дуусах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Мөн Google компанитай хамтраад энэ ухаалаг системийг хөгжүүлэх энэ гэрээ хэлэлцээрийн шатны ажил бол явагдаж байгаа. Ийм байдалтай байгаа.

**Д.Амарбаясгалан:** Тэр нөгөө өмнөх системийг чинь бас асуугаад байх шиг байсан шүү дээ. Одоо ашиглалтад ордоггүй юм уу? RFID-ынх чинь. 2 дугаар инд индрийн микрофон өгье.

**Д.Амгалан:** RFID-н төсөл бол одоогоор дуусаагүй. Яг тодорхой нарийн



мэдээлэл бол надад бол байхгүй байна, уучлаарай.

**Д.Амарбаясгалан:** Гүйцэтгэгч нь хаанах гэлээ?

**Д.Амгалан:** Гүйцэтгэгчийн талаар бас мэдээлэл авч, дахиж тодруулж өгье.

**Д.Амарбаясгалан:** Хаанах гүйцэтгэгч билээ? Манай энэ парламентын систем шиг юм болчихсон юм биш биз дээ бас. Хотын дарга хаачив? Энэ ер нь үдээс хойших хуралдааныг би бүр анхааруулаад хэлчихье. Албан ёсны хариулт өгч чадах хүмүүс нь байхгүй болбол энэ асуудлыг хэлэлцэхийг хойшлуулна шүү. Улсын Их Хурлын энэ намрын анхдугаар чуулган эхэлж байна шүү дээ. Албан ёсоор байгуулагдсан Их Хурлын албан ёсны анхдугаар хурал эхэлж байна. Хуралд ийм байдлаар хандаж, хүндэтгэлгүй байх юм болбол бид бас асуудал дээрээ хариуцлагатай илүү няхуур хандана шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй. Яах вэ одоо хариултаа авсан гэж тооцох уу Батшугар гишүүн? Тэгэхээс. Ренчинбямбын Сэддорж гишүүн асуултаа асууя.

**Р.Сэддорж:** Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Хэрлэн-Тооно, Орхон-Онги төслийн бэлэн байдлыг 25 онд 100 хувь хэрэгжүүлнэ, хангана гэсэн байна. Төслийн бэлэн байдлыг хангана гэдэгт ямар ажлууд хийгдэх вэ? Энэ жил Хэнтий, Дорнод аймгуудыг харж байхад аймгийн төвийг нь авч явчих гээд байгаа тэр их үерийн усыг хуримтлуулах тийм ажлууд эхэлж байна уу? Тэгээд өчигдөр Байнгын хороон дээр сайд ирээгүй учраас би өнөөдөр бас сайдууд ирээгүй учраас, цөөхөн ирсэн учраас өнөөдөр ингэж асууж байна.

Тэгээд хилийн усны хэлэлцээр гэдгээр ам таглаж олон жил явлаа. Энийг хийхийн, хийхийг хүсэж салбарууд ажиллаж байгаа байх гэж итгэж байна. 60км Булган аймаг Эрдэнэт хотыг усаар

хангаж байгаа жишээ байгаа шүү дээ. Жилд 34 тэрбум төгрөг Булган аймгийн төсөвт ордог усны мөнгө гэж Эрдэнэт хотоос. Тэгээд энийг л 9 дахин уртасгаад л энэ говийн ард түмэн, говийн аж үйлдвэрийг бол усаар хангачих ийм боломжтой юм байгаа юм.

2 дугаарт нь бол энэ Тавантолгойн цахилгаан станцын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг 25 онд бол 20 хувьд хүргэнэ гэсэн байна. Энэ 20 хувьд яг ямар, ямар ажлууд хийгдэх вэ? Станц яг хэзээ тогоо өгч эхлэх вэ? Мөн сэргээгдэх эрчим хүчний төслүүд хэрэгжилт 70 хувьтай байгаагаас 25 онд 80 хувьд хүргэнэ гэсэн байна. Гадаадын зээл, тусламжаас санхүүжүүлнэ гэсэн байна. Тэгээд энэ зээл тусламж гэдгээ энэ сэргээгдэх дээр арай багасгаад, ороод ирчихсэн байгаа гадаадын хөрөнгө оруулалтуудаа дэмжээд үр дүнг нь үзэхгүй бол өнгөрсөн жил Ерөнхий сайд Германд очиход Германы Ерөнхий сайд тэр манай гадаадын хөрөнгө оруулалтыг та нар дэмжинэ гээд манайх хөрөнгөө оруулчихсан байгаа тэр компанийн ажлыг дэмжээд өгөөч, гэрээг нь хийгээд өгөөч гэж Ерөнхий сайдад хэлсэн байдаг. Тэгээд энэ нарны цахилгаан станцын эх үүсвэрийг айл өрхүүд хэрэглээндээ нэвтрүүлэхэд эндээс дэмжлэг үзүүлэх нөхцөл бололцоо байгаа юу? Амины орон сууцууд нарны эрчим хүчний үүсгүүрийг хэрэглэхэд улс орны нөхцөл байдал сайжрах уу гэдэг асуулт байна.

Зам тээврийн яам дээр энэ Гашуунсухайтын Ганцмодны боомт энэ хил дамнасан төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминал барина холболтын. Энэ 25 онд 20 хувьтай гүйцэтгэхээр байна гэж байгаа юм. Бүтээн байгуулалтын ажлууд хэдэн жилийн хугацаанд хийгдэх вэ, хэзээ дуусах вэ?

Мөн дээрээс нь энэ говийн бүсэд тавигдсан Зүүнбаян-Тавантолгойн төмөр зам байгаа. Энэнийхээ хашааг хийгээгүйн улмаас мал дайрагдаж, ХАА-н

салбарт говийн малчдын амьдрал эдийн засагт үлэмж их хохирол үүсэж байна. Энийг шийдэж өгөөч, яагаад хашихгүй байгаа юм бэ?

Дээрээс нь энэ Монгол Францын хамтарсан ураны төсөл 25 онд 100 хувьд хүрнэ гэсэн байна. Ажил эхлүүлэх. Тэгээд энэ ямар ажлууд хийгдэх, хийгдэнэ гэж ойлгох вэ? Ийм асуултууд байна.

**Д.Амарбаясгалан:** Эрчим хүчний сайд эрчим хүчний бодлого ярина, байна уу? Энх-Амгалан сайд хариулах юм уу, Үндэсний хороо байхгүй юу? Эхлээд юу яая Одонтуяа сайд Орхон-Онги голын асуудалтай говийн усжуулалтын хөтөлбөрийн талаар хариулт өгье. Араас нь Эрчим хүчний ТНБД Тавинбэх сэргээгдэх эрчим хүчний нөхцөл байдалтай холбоотойгоор хариулт өгье.

**С.Одонтуяа:** Сэддорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монгол Улс бас нэлээд олон жил энэ Хөх морь төсөл гэж нийт Монгол Улсын хэмжээнд энэ усны асуудлыг шийдэх талаар том төсөл хэрэгжүүлж байсан. Энэ төсөл бол нийт 33 байршилд хэрэгжүүлж чадвал 52 тэрбум м<sup>3</sup> усыг цуглуулах ийм боломжтой гэсэн ийм төсөл гарч байсан. Энэ удаагийн ЗГ-ын гол төсөлд манай Хэрлэн-Тооно, Орхон-Онги гэсэн төслүүд орж байгаа. Хэрлэн-Тооно төслийн хувьд бол ТЭЗҮ нь 2014 онд гараад, энийг боомт барих нийт хөрөнгө оруулалт нь 300 сая орчим доллар гэж гарч байсан. Тэгэхээр энэ дээр бол Хэрлэн-Тооно дээр яах вэ нэг хүндрэлтэй асуудал нь хилийн усны хэлэлцээр байдаг. Энэ жилийн бас хилийн усны хэлэлцээрээр энэ асуудал нэлээд яригдсан. Энэ дээр бол бас их амжилттай гэж хэлэх боломжгүй байна. Тэгэхдээ энэ гэрээ хэлцлүүд бол хийгдээд явж байгаа. Хэрлэн-Тооно усан цогцолбор бий болсноор нийт 11, 1,6 тэрбум м<sup>3</sup> усыг хуримтлуулна. Энд бол бид 235км ус дамжуулах ийм далд шугам хоолой барина гэсэн нэг ийм төсөл байгаа юм.

Хэрлэн-Тооно төсөл дээр, Орхон-Онги төсөл дээр болохоор одоо энэ асуудлуудыг нь нэлээд яригдаж байгаа. ТЭЗҮ нь болбол бас нэлээд хуучирчихсан, дахиад энийг хийх ийм зүйл байгаа. Оюу толгой компани бол бас энэ усны төсөл дээр ТЭЗҮ боловсруулахаар амлалт өгөөд, энэ ТЭЗҮ-ээ сая 7 сарын 2-нд зарласан, 8 сарын 20-нд нээх юм байгаа. Өөрөөр хэлбэл Хэрлэн-Тооно гэсэн ТЭЗҮ-ийн тодотгол хийсэн ийм тендерийг зарласан. Тэгэхээр энэ тендер зарлагдаад, шалгарагдаад энэ нэг жилийн хугацаанд энэ ерөнхийдөө ТЭЗҮ хийгдэнэ гэсэн үг байгаа. Тэгээд энэ төсөл дээр бол ЗГ-аас бүр онцгойлон анхаарч, дараагийн ЗГ-ын хурал дээр бас энэ төслийн дэлгэрэнгүй танилцуулгууд хийгдэх ийм ажлууд байгаа.

**Д.Амарбаясгалан:** Нансалын Тавинбэх ТНБД 2 дугаар индрийн микрофоныг өгье.

**Н.Тавинбэх:** Сэддорж гишүүний асуултад хариулъя. Тавантолгой ДЦС-ын хувьд говийн бүсэд байгаа импортоор эрчим хүч авч байгаа хэрэглэгчдийг түүн дотроо уул уурхайн томоохон төслүүд, ОТ төслийг эрчим хүчээр хангахаар баригдах гэж байгаа, нүүрсний технологитой эх үүсвэр. Бид нар тендер зарласан. Тендерт 2 компани орсон. Шүүхийн маргаан Тендерийн үнэлгээний хорооны дүнд гомдолтой байсан тул шүүхийн маргаан гарсан. Шүүхэд гомдол мэдүүлсэн. Анхан шат болоод давж заалдах шатын шүүхийн шийдвэр гарчихсан. Дээд шүүхэд гомдол гаргачихсан байна. Удахгүй Дээд шүүхийн шийдвэр гарч, энэ төсөл эзэнтэй болж барилга угсралтын ажил эхэлнэ гэж ингэж бодож байна. 450 мвт-н хүчин чадалтай ийм эх үүсвэр байгаа.

Таны саяын асуудаг Өмнөговь аймагт баригдах Германы хөрөнгө оруулалттай 102мвт-ын салхины эх үүсвэрийн хувьд ЗГ-аас.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулах уу? 2 дугаар индрийн микрофоныг нэмж өгье.

**Н.Тавинбэх:** 102мвт-ын хүчин чадалтай 2008 онд тусгай зөвшөөрлөө авсан. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл барилга угсралтын ажлаа огт эхэлдэггүй. Цаасан дээр бол маш олон ажил хийсэн гэдэг, тайлагнадаг, хөрөнгө оруулалт бэлэн гэж ярьдаг. Гэхдээ өнөөдөр газар дээр нь яваад очвол барьсан хаашаанаас өөргүй нэг ийм маргаантай төсөл байгаа. Гэхдээ Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо холбогдох төрийн байгууллагууд болбол энэ төсөлд зөвшөөрлийг нь 2025 оны 1 дүгээр сарын 1 хүртэл сунгачихсан хэвээрээ л байгаа. Одоо зөвхөн хөрөнгө оруулагч нар ажлаа хийх л үлдсэн.

Ер нь зөвшөөрлөө авсан сэргээгдэх эрчим хүчний олон ийм эх үүсвэр ажлаа хийдэггүй ингээд өөрсдөө юмаа хийдэггүй, үүргээ биелүүлдэггүй, бусдад боломж олгодоггүй. Энэнээс болоод ч өнөөдрийн энэ чадлын дутагдалд орсон нэг шалтгаан байгаа гэдгийг ингээд хэлье. Клинтехийн хувьд би энэ товч хэлье. Сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн хувьд болбол бид хэрэгжиж байгаа төслүүдийн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Доржханд гишүүн, Шадар сайд сэргээгдэх эрчим хүчний бодлогын хэрэгжилтийн асуудлаар Сэддорж гишүүн асуулт асуусан.

**Т.Доржханд:** Сэргээгдэх эрчим хүч бол Монгол Улсын хамгийн том давуу тал. Бид нар яг газар дээрээ 14 мянган гегаваттын ийм хүчин чадалтай. Дэлхийд бол яг энэ нөөцөөрөө бол эхний 2-т орж байгаа. Маш том газар нутагтай. Тэгэхээр энэ бол ирээдүй юм, ийшээ явахаас өөр аргагүй. Ийшээгээ явъя гээд тэгэхээр нөгөө өмнө нь байгаа хөрөнгө оруулалт хийчихсэн тэр сэргээгдэхийн компаниуд дээр нөгөө өндөр тарифаар ингээд хийчихсэн. Тэгээд тэрэнд ингээд

асуудал үүсгээд шийдэгддэггүй хаячихсан байгаа нь бид нарын буруугийнх байхгүй юу.

Өөрөөр хэлбэл нэгэнт шийдсэн бол шийдвэрээ хатуу барьдаг байх ёстой, соёлтой байх ёстой. Гэтэл одоо нөгөө ингээд хэтэрхий өндөр байна гэсэн байдлаар гагцхиаад байгаа нь бол бодитой үнэн юм билээ. Тэгээд цаашаага бол энэ тарифын шинэчлэлээ хийгээд, зах зээлийнх нь зарчим руу нь оруулж байж энэ хөрөнгө оруулалтууд ерөөсөө сэргээгдэх рүү л орж ирэх юм байна лээ. Ногоон руу нар, салхи, ус гээд. Тэгээд ЗГ-ын зүгээс бол энэ шилжилтийг хийнэ.

**Д.Амарбаясгалан:** Сэддорж гишүүн, Учрал сайд нэмж хариулах уу? Учрал сайд хариулт өгье.

**Н.Учрал:** Энэ Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээг Улсын Их Хуралд бас өргөн мэдүүлэхээр яг энэ өдрүүдэд 5 дэд ажлын хэсгүүдийн саналуудыг нэгтгээд бид ажиллаж байгаа. Тэгээд ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан энэ 14 мега төсөл болбол бид экспортын орлогыг нэмэгдүүлэхэд л гол зорилго чиглэгдэж байна. Тийм ч учраас энэ Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээ болбол ОТ-гоос хойш хийгдэж байгаа гуравдагч хөрштэй хийгдэж байгаа 2 дахь том хөрөнгө оруулалт.

Нөгөө талаасаа болбол гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ийм сайн жишиг болгох боломжтой ийм төсөл байлгая гэдэг дээр л өнгөрсөн хугацаанд ажиллаж байгаа. Тийм ч учраас энэ эрэлт өндөртэй байгаа стратегийн бүтээгдэхүүнийг эх орондоо үйлдвэрлэх, цаашидаа болбол геополитикийн хувьд ч гэсэн мөн бас Атомын цахилгаан станц байгуулах, цаашидаа болбол энэ хүхрийн хүчил, хог хаягдлын үйлдвэр байгуулах гээд олон давуу талууд ийм үүсгэх хөрөнгө оруулалтын.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя. Учрал сайдад нэмж микрофон өгье.

**Н.Учрал:** Тэгэхээр бид болбол шууд болон шууд бус утгаараа болбол энэ Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээ бол манай эдийн засагт бас томоохон өөрчлөлтийг өгнө гэдэгт бол бас эргэлзэхгүй байгаа. Тийм ч учраас бид өнгөрсөн хийгдсэн энэ ОТ-н алдааг давтахгүйн тулд тэр 34 хүртэлх хувийн ноогдол ашигийг жишээ нь хэдэн хувийг нь яг иргэдийн хуримтлалын дансанд шилжүүлэх вэ? Мөн дээрээс нь ингээд зардал нэмэгдүүлээд, ноогдол ашиг хуваарилах хугацаа хойшлоод байдаг энэ алдааг давтахгүйн тулд бид нар бас тодорхой хувийг нь Амнатаар орлуулах, ер нь бол Үндэсний баялгийн сан дахь хуримтлалыг нэмэгдүүлэх чиглэлээр болбол өнгөрсөн хугацаанд бол ажлын хэсэг болбол ажиллаж байсан. Тэгээд энэ удаа ч гэсэн болбол Их Хуралд өргөн мэдүүлэхдээ илүү Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх чиглэлээр бас онцгой анхаарч ажиллаж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Доржханд сайд сэргээгдэх эрчим хүчний асуудлаар нэмж хариулъя, гүйцээж хариулъя гэсэн тийм ээ. Микрофон өгье.

**Т.Доржханд:** Тэгэхээр ЗГ-ын зүгээс бол энэ эрчим хүчний шилжилтийг бол хийнэ гэдгээ мэдэгдсэн байгаа албан ёсоор. Үндэсний хороо бол байгуулагдсан байгаа. Эрчим хүчний шилжилт нь юу юм бэ гээд тэгэхээр зөвхөн үнэ тарифыг өсгөх асуудал биш юм. Энэ бол богино хугацааны асуудал. Дунд хугацаандаа бид нар энэ салбарын бүтцийн өөрчлөлтийг хийнэ гэж байгаа юм. Зах зээлийн систем рүү шилжүүлнэ гэж байгаа юм. Үр ашгийг нь нэмэгдүүлэх, энд үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын нээлттэй, ил тод байдлыг нь, засаглалыг нь зөв болгох энэ ажлуудыг бол хийнэ. Харин урт хугацаандаа бол Монгол Улс бол эрчим хүчний орон юм байна, экспортын орон

юм байна. Монгол Улс уул уурхайн салбар дээр ингээд төсвөөс экспорт хийдэг бол дараагийн бодитой салбар бол хөрөнгө оруулалт хийх, экспорт хийх боломжтой салбар бол энэ эрчим хүч, тэр дундаа сэргээгдэх эрчим хүч юм байна гэдэг бодлогоо тодорхойлоод явж байгаа. Тэгээд цаашидаа яг энэ чиглэлээр бол бодитой хөрөнгө оруулалт бол хангалттай хийгдэнэ гэсэн ийм хүлээлттэй байгаа. Хөрөнгө оруулалт, нийлүүлэлт өссөн тохиолдолд бол эргээд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууя. Байж байгаарай, уучлаарай, тодруулга байгаа юм уу? Сэддорж гишүүн тодруулга.

**Р.Сэддорж:** Зам тээврийн яамнаас асуусан асуулт хариулт авсангүй. Гашуунсухайт-Ганцмодны боомтод тэр хил холболтын ажил хэзээ дуусах юм бэ? 25 онд 20 хувьтай гээд байгаа юм. Энийг яагаад хариулахгүй байна вэ? Говийн бүсийг дамнасан сайхан төмөр зам тавьсан Зүүнбаян руу Тавантолгойгоос. Одоо үүгээр Улаанбаатар хотыг утаагүй болгох нүүрс зөөж байна. Энэ мал дайрч байгаа учраас энийг бол малчид зогсоож магадгүй шүү. Хүний амь нас эрсдэж магадгүй байна. Саяхан 1 айлын 80 ямаа саалийн ямааг дайрсан байна, 15 тэмээ дайрсан байна 1 өдөрт. Тэгээд энэ өчигдөр Байнгын хорооны хурал дээр хашихыг, хашаа хийхгүй гэж яамны нэг хүн тэгсэн. Говь, хангай 2 чинь өөр л дөө. Говийн тэмээгээ шөнөжин хариулаад хашна гэсэн ойлголт бол байхгүй шүү дээ. Ямаагаа ингээд хашаад. Говьд чинь тийм өвс ногоо байхгүй шүү дээ бэлэн хаяад өгдөг. Тэгэхээр талаар нэг бэлчиж байж, өөрөө өөрийгөө авч явдаг хөдөө.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энэ Зам тээврийн яамнаас хүн байгаа болов уу? ТНБД нь байна уу? Сайд нь алга байх юм. Сайд нь хаачсан юм бэ? Учрал сайд. Гадаадад томилоттой. ТНБД нь байна



уу, Бодлогынх нь газрын дарга байна уу? Үгүй ээ ядаад сайдынх нь зөвлөх гэж хүн байна уу? Орон тоогоор цалин аваад ажиллаж байдаг хүмүүс байгаа биз дээ. Энэ чинь юу болоод байна вэ Гантөмөр Шадар сайдаа. Энэ арай хариуцлагагүй байгаа юм биш үү? Орлодог энэ Улсын Их Хурлын чинь бас өмнө хүлээсэн хариуцлагаа биелүүлж, хариултаа өгөх хэмжээний албан тушаалтнууд байх ёстой шүү дээ. Гантөмөр сайд хариулъя.

**Л.Гантөмөр:** Ер нь Сэддорж гишүүний яриад байгаа зүйл бол зөв байгаа юм. Урагшаа явж байгаа төмөр замын хашаажуулах ажлыг бол заавал хийх хэрэгтэй. Сэддорж гишүүн энэ хөгжлийн төлөвлөгөөндөө энийгээ оруулах хэрэгтэй. Бид өнөөдөр 2025 оны хөгжлийн төлөвлөгөө ярьж байгаа. ЗГ-ын хөтөлбөр яриагүй, хөгжлийн төлөвлөгөөг Их Хурал батална. ЗГ, Их Хурал 2 энийг хамтдаа хийнэ. Тийм учраас Эдийн засгийн байнгын хороо ч гэсэн энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй. Би Сэддорж даргад зөвлөж байгаа юм. Эдийн засгийн байнгын хороо тогтоол гарга. Тодорхой эдийн засгийн бодлоготой холбоотой шийдвэрүүдийг Байнгын хороон дээр гаргаж болно. Их Хурлын тогтоолын хавсралтад ч гэсэн юмаа оруулж болно. 1 дүгээрт энийг болбол гарцаагүй шийдэхгүй болбол тэр мал ахуйн асуудал бол хүндрэх юм байна лээ. Энийг Зам, тээврийн сайдад үүрэг болгож, энэ удаагийн хөгжлийн төлөвлөгөөнд заавал оруулах хэрэгтэй гэсэн ийм бодолтой байгаа. Нөгөө талдаа.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр сайдын микрофоныг өгье, нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Энэ яамнуудын ТНБД нар энэ хуралд бүрэн сууна шүү, чөлөө авсан хүн болбол байхгүй гэж ойлгож байгаа. Цөмөөрөө суугаад асуултдаа хариулаад, хийж байгаа ажил, хийх боломжтой ажлуудаа шууд хэлээд явах хэрэгтэй. Бид нар нэгнийгээ хуурах эсвэл худал мэдээллээр хангаж ерөөсөө болохгүй. Хил холболтын хэлэлцээр одоо

эд явагдаж байгаа. Магадгүй энэ Зам, тээврийн сайд өнөөдөр байхгүй байгаа нь тэр ажлынхаа араас л явж байгаа болов уу гэж ингээж харж байна. Ер нь бид нар болбол энэ хил холболтын ажлыг өнгөрсөн жил, ирэх 2, 3 жилийн хугацаанд амжиж хийхгүй болбол цаашидаа эдийн засгийн өсөлтийн тухай ойлголт ерөөсөө байхгүй. Тийм учраас энэ ажил болбол маш эрчимтэй, хурдтай хийгдэнэ гэдгийг хэлье.

**Д.Амарбаясгалан:** Одоо бараг гишүүдийг асуулт асуухаас би чинь өмнөөс чинь айгаад уналаа шүү, одоо яана хүмүүс нь байхгүй. Байна уу? Лодойсамбуу гишүүн асуултаа асууя.

**Ч.Лодойсамбуу:** Гишүүд, ажлын хэсгийнхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ шинэ парламент хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөө эхний жилийнхээ төлөвлөгөөг хэлэлцэж байна. Тэгээд өнгөрсөн жилүүдэд амь тариа хийж явсан асуудлуудыг нэг дор бяр гаргаад, зориг гаргаад шийдчихье гэж байгаа энэ төлөвлөгөөг ерөнхийд нь дэмжиж байгаа.

Тэгээд нөгөө талдаа хөгжлийн гол багана болсон энэ нөгөө хувийн хэвшлийг дэмжинэ гэж бид нар байнга ярьдаг. Бизнесийн таатай орчныг бүрдүүлнэ гэж байнга ярьдаг. Энэ асуудлууд маань ерөөсөө орхигдчихсон харагдаад байгаа юм л даа. Яг бизнес эрхэлж байгаа ААН-үүдтэй яваад уулзахаар ерөөсөө 2 л юм хэлдэг юм. НДШ-ийн асуудал энэ байгууллага дээр хариуцуулдаг НДШ, тэгээд дээр нь нэмэгдсэн өртгийн албан татвар. Ерөөсөө энэ татварын асуудлууд. Ямар ч үйл ажиллагаа цаашидаа явуулах боломжгүй, хөгжин тэлэх боломжгүй, өндөр цалин олгоод ажилтан, ажилтнаа ажил олгогч нь тогтоон барих ямар ч боломжгүй ингээд дамнуурах ч боломжгүй ийм нөхцөл байгаад байдаг. Тэгээд яг энэ дээр энэ хөгжлийн төлөвлөгөө дээр энэ жил бид нар яг энэ хувийн хэвшлийг дэмжинэ гэдэг ийм үгийгээ яаж амилуулж энэ жил

хэрхэн, ямар амилуулах ийм төлөвлөгөө, бодол бодлого байгаа вэ гэж Сангийн сайд, Нийгмийн хамгааллын сайдаас асуумаар байгаа юм. НДШ-ийн асуудал бол үнэхээр бүх бизнес эрхлэгчид хэлж байгаа. Тэгээд энэ дээр яг тодорхой асуудал ажил хийх үү гэж?

Нөгөө тал дээрээ бид нар энэ дотоодын үйлдвэрлэлийг дэмжих тухай байнга ярьдаг. Тэгээд дотоодын үйлдвэрлэлээ үнэхээр татаж унагааж байгаа жишээнүүд маш олон байгаа. Жишээлбэл аравхан жилийн өмнө бид нар дотооддоо гурилаа хийдэг болъё, хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудал авч ирээд л явсан. Атрын 3 дугаар аян хүртэл өрнүүлээд л бид нар ингээд тариалан эрхлэлтээ дэмжээд ингээд босгоод ирсэн. Дотооддоо цементээ хийе л гэсэн цементээ хийдэг болсон. Евро стандартаар хийдэг болсон. Тэгээд өнгөрсөн жил ерөөсөө энэ гурилын үйлдвэрийг, үйлдвэрлэлүүдээ дотоодын үйлдвэрлэлүүдээ татаж унагаах бодлого хэрэгжүүлээд одоо үндсэндээ эхнээсээ сөхөрч байна. Тэгээд энийгээ энэ ЗГ энэ жилээс үнэхээр энэ хөгжлийн төлөвлөгөө гаргаж байгаа болбол энэ хөгжилд манай энэ дотоодын үйлдвэрлэл хамаагүй гэж үзэж байгаа юм уу? Энийг яах вэ? Энэ гурил, цемент 2 дээр тогтоосон энэ татварын боомилсон энэ арга хэлбэрүүдээ өөрчлөх үү? Энэ дээр бодол байгаа юу гэдгийг тодорхой асуумаар байгаа юм.

Ер нь болбол Монгол Улсын ЗГ цаашидаа энэ цемент, гурил гэх мэтчилэн энэ стратегийн ач холбогдолтой зүйлүүд дээр яг ямар бодлого баримтлах юм бэ? Зүгээр ингээд хямдхан ямар ч байсан нэг хана босгодог зүйл хэрэгтэй, тэгээд хямдхан цементтэй болъё. Хоол хийхэд нэг гурил хэрэгтэй, боов боорцог хийхэд гурил хэрэгтэй, тэгэхээр хямдхан гурилаа идье гэдэг байх юм уу. Үнэхээр Монголын, Монгол үндэстний хувьд чанартай зүйл хэрэглэдэг байя гэх юм уу? Цөмийн энергийн газрын цацрагийн хяналтын лаборатори сая энэ манайд нийлүүлэгдэж

байгаа манайхны үйлдвэрлэж байгаа цементүүд дээр харьцуулсан судалгаа хийсэн, шинжилгээ хийсэн. Ингээд цацрагийн идэвх нь, цацрагийн хэмжээ нь импортынх нь цемент, дотоодын үйлдвэрлэж байгаа цементээсээ 2 дахин их байна шүү дээ. Тэгээд бид нар зүгээр ингээд нэг ямар ч байсан цементтэй болъё гэдэг бодлоготой байх юм уу, чанартай байхыг нэгд авч үзэх юм уу? Ер нь дотоодын үйлдвэрлэлүүдийг хэрхэн дэмжих юм бэ, яг яах юм бэ гэдэг дээр тодорхой хариулт өгөөч. Энэ жилийн төлөвлөгөө нь байгаа юу Сангийн сайдаа? Нэмэгдсэн өртгийн албан татварын асуудал байна. НДШ-ийн асуудал Нийгмийн хамгааллын сайд. Баярлалаа. Тэгээд тодруулъя, хариулсны дараа.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд хариулт өгөх үү? Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Сангийн яамтай холбоотой би хэд хэдэн асуултад нь мэдээлэл өгье гишүүний асуултад. Лодойсамбуу гишүүн энэ асуудлыг бол хэд хэдэн удаа ярьж байгаа. Байнгын хороонууд дээр ч гэсэн бас ярьж байсан. Ер нь энэ хувийн хэвилийг дэмжинэ гэдэг маань бидний энэ таны түрүүхэн бас дурдсан ингээд зориглоод сүүлийн жилүүдэд бас хийж амжаагүй байсан хэт их жижиг тойргийн асуудлууддаа автаж, төсвийн хөрөнгө оруулалтууд маань нэлээн бас тарамдаж байсан ийм он жилүүд байгаа. Тэгвэл ирэх 4 жил бид энэ хөгжлийн хөтөлбөр ЗГ-ын хөтөлбөрөө баталсны үр дүнд зам, эрчим хүч гээд үнэхээр хөгжлийг боомилж байгаа энэ хөрөнгө оруулалтууд руугаа онцгой анхааръя гэж байгаа.

Харин үүний үзүүр дээр жинхэнэ хувийн хэвилийг дэмжиж байгаа ийм л хөшүүрэг бодлого юм байгаа юм. Энэ барих гэж байгаа замын үзүүр дээр, энэ эрчим хүчний үзүүр дээр хэрэглэгч нь хувийн хэвилийнхэн л залгагдана. Баялаг бүтээнэ, боловсруулах үйлдвэрүүд баригдана. Аялал жсуулчлал, хилийн

боомт, экспорт, хилийн худалдаа, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөө орон нутгийн ХАА-н салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гээд. Энэ төр өөртөө зориулж энэ зам барьж байгаа биш. Төр өөртөө зориулж эрчим хүчээ нэмэгдүүлэх гэж байгаа зүйл биш. Хамгийн том дутагдаж байгаа хувийн хэвшлийг төрөөс үүрэг гүйцэтгэж, төрөөс хариуцлага хүлээж туслах ёстой хамгийн том зүйл нь энэ бүтээн байгуулалтын хувьд. Энэ ингээд төсвийн бодлогоор орж ирнэ. Маргааш хэдүүлээ бүтэн өдөр төсөв ярина.

Төсөв дагаад мөн хувийн хэвшлийг дэмжиж байгаа татварын урьд өмнө нь орж ирж байгаагүй 3 том бодлого заалт орж ирнэ татварын хувьд. Хамгийн 1 дүгээрт бүсчилсэн хөгжлийн татварын бодлого. Өөрөөр хэлбэл бүс бүр өөрсдийнхөө тэргүүлэх чиглэлүүдийг дэмжсэн ялгаатай бодлогуудын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж өгч энд өөрчлөлт орж ирнэ.

2 дугаарт хамгийн том өөрчлөлт болбол боловсруулах шатны үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмжийн гаалийн татварыг бүрэн тэглэж байгаа. Өмнө нь болбол бид ЖДҮ-лэл ч гэдэг юм уу, эсвэл яг салбар салбараар нь, бүтээгдэхүүн бүтээгдэхүүнээр нь чиглүүлж чөлөөлдөг байсан болбол салбар харгалзахгүйгээр дараагийн шатын боловсруулах чиглэлийн үйлдвэрүүдээ ингэж дэмжиж байгаа.

Дээрээс нь төрөөс олон нийт рүү төсвийн бодлогоор дамжуулж үзүүлдэг нийгмийн чиглэлийн хөрөнгө оруулалтууд, урсгал зардал дээр үнэхээр тэр ачааллыг авахаар, мөн нийгмийн хариуцлагынхаа үүднээс баялаг бүтээгч хувийн хэвшлийнхэн маань спорт, соёл, урлаг, ногоон байгууламж, хандив тусламж гээд ийм төрлийн зардлууд дээрээ нийт орлогынхоо нэг хувь хүртэл, хувь хүртэлх татварын чөлөөлөлт хөнгөлөлт эдлэх ийм бас татварын бодлого оруулж ирж байгаа юм. Энэ болбол татварын хувьд

бол маш том ийм 3 бодлого орж ирж байгаа. Тийм. Хувийн хэвшлийг бодитойгоор дэмжих бодлого маань яг энэ дээр суурилагдана гэж ингэж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Би нэмэлт мэдээлэл өгье. НӨАТ болбол нэмүү өртөг, нэмүү өртөг энэ чинь бол төлбөр байдаг тийм ээ, тэгээд татвар байдаг. Тэгэхдээ энэ маань өөрөө хэрэглэгчийн татвар шүү. Энэ бол үйлдвэрлэгчийн татвар биш, эцсийн хэрэглэгч, хэрэглэгч төлдөг. Өөрөөр хэлбэл яг НӨАТ-ын системдээ үнэн зөв явж байгаа ямар ч ААН дээр НӨАТ дарамт болдоггүй ийм систем юм. Дээрээс нь НӨАТ маань бид түүх ярих юм бол 2006 оноос эхэлсэн байдаг юм. Анх 14 байж байгаад, 10 болоод, одоо ингээд буцаан олголт тооцох юм бол 8 хувьтай явж байгаа. Манайтай ижил зээлжих зэрэглэлтэй, мөн Дэлхийн банкны ижил ангилалд байдаг улс орнуудтай харьцуулах юм бол манайх маш багадаа ордог НӨАТ-ын хувь хэмжээ. Тийм учраас цаашидаа болбол энэ НӨАТ-ын хувь хэмжээг бол оролдох нь өөрөө төсвийн болон бусад бүртгэлийн шинжтэй энэ өнөөдөр бий болсон энэ цогц энэ байдлаа бид нар алдах аягүй өндөр эрсдэлтэй. Дээрээс нь 2015 онд шүү дээ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жадамбаагийн Энхбаяр гишүүн, сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Энэ өнгөрсөн өвөл их МАА-н салбар их том хохирол амссан, 8,1 сая мал хорогдож, малчдын амьдрал нэлээн хүндэрсэн. Иймд Улсын Их Хурлаас яаралтай зохицуулалтын ажил хийх хүрээнд гурилын үнийг хямдруулах ийм зайлшгүй шаардлага үүссэн. Энэ хүрээнд Их Хурал энэ гаалийн татвар дээр босгыг чөлөөлж, гурил болон тэжээлийн малын тэжээл дээр татварын бодлого хэрэгжүүлсэн. Энэ бол үр дүнгээ өгсөн.

Нөгөө талаас сөрөг эффект буюу газар тариалангийн салбарт хэрвээ энэ бодлого цаашиа үргэлжилнэ гэсэн мессеж дээр нийт 56 мянган га талбайд улаан буудайн тариалалт багассан. Тэгэхээр ЗГ сая энэ асуудлыг авч хэлэлцээд Их Хуралд өргөн барихаар бэлтгэж байна. Мөн Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг гарчихсан, Баярбаатар гишүүн ахлаад бүхий л салбар, үйлдвэрлэл, энэ газар тариалан, энэ улаан буудайн үйлдвэр.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Бүх энэ оролцогч нартай нь ингээж нэг бүрчлэн уулзаж, учир шалтгааныг тодруулах ийм ажлын хэсэг Баярбаатар гишүүнээр ахалсан ажиллаж байна. Бид Хөдөө аж ахуйн яам хамтран ажиллаж байгаа. Тэгэхээр гадаад аюулгүй байдлын орчин хүндэрч байгаа энэ цаг үед улаан буудай бол хүнсний манай стратегийн гол бүтээгдэхүүн. Иймд үйлдвэрлэлийг тогтвортой барих, газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой байлгах нь бол манай тэргүүн том бодлогын зорилт байх ёстой юм шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд цементээ ярья.

**Б.Жавхлан:** Энэ цементийн эрэлт, нийлүүлэлттэй холбоотой асуудал бол яг Барилга, хот байгуулалтын энэ салбарын бодлогын их чухал суурь асуудлуудын нэг. Тийм учраас өөрөөр хэлбэл татварын бодлого, энэ салбарын бодлогууд дээрээ дэмжиж ингээж хавсарч явдаг гэсэн үг. Энэ шийдвэрийг гаргаж байх тухайн үед бол дотоодын үйлдвэрлэлүүд маань дотоодын эрэлт хэрэгцээгээ хангаж чадахгүй, хомсдол үүсээд, эрэлт, нэмэлт эрсдэл, эрэлт үүсээд энийг хангах зорилгоор үнэ өсөөд, ингээд импортыг нээж өгч байсан, түр хугацааны ийм арга хэмжээ байсан. 10 сарын 1-нээр энэ хугацаа дууссан шүү сая хэдхэн хоногийн

өмнө. Одоо буцаад 20 болчихсон гэсэн үг. Энийг бол Улсын Их Хурал дээр биш, ЗГ өөрөө шууд ингээд тохиргоогоо хийгээд шийдээд явдаг юм байгаа юм. Хэрвээ цаашидаа хэрвээ дахиад одоо байгаа дотоодын үйлдвэрлэлүүд маань дотоодын эрэлт хэрэгцээгээ хангаж чадахгүй, хүчин чадал нь дутуу ажиллаад ингээд үнэ өсөөд явах юм болбол эцсийн хэрэглэгч дээрээ тэдний эрэлт хэрэгцээг хангах зорилгоор ЗГ буцаагаад буулгахыг.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Ер нь бид нар энэ нийгмийн даатгалынхаа буюу энэ тэтгэврийн тогтолцооны том шинэчлэл хийхээс өөр арга байхгүй. Тэгэхээр үндсэндээ болбол нөгөө хойд хормойгоо авч, урд хормойгоо нөхсөөр байгаад ингээд л ийм том хүндрэл өнөөдөр үүсэж байгаа байхгүй юу. Тэгээд яах вэ манай ажил олгогч нар маань бол бид нарын энэ төлж байгаа шимтгэлийн үр өгөөж их муутай байна, энэнийхээ үр өгөөжийг хүртээж чадахгүй байна гэдэг нэг ийм асуудал яриад байгаа юм. Энэ зөв. Би бас би тантай санал нэг байна.

Тэгэхээр гол асуудал өнөөдөр яг энэ нийгэмд байгаа ер нь НДШ төлж байгаа ажилтнууд, ажил олгогч нарын нэг ойлголт бол энийг татвар юм шиг ойлгоод байдаг байхгүй юу. НДШ гэдэг бол татвар биш шүү дээ. НДШ гэдэг болбол ирээдүйд хуримтлал хийгээд, тэгээд тэтгэвэрт гараад, тэтгэврээ тэтгэврийнхээ хуримтлалыг хийж байгаа л ийм л тогтолцоо юм байгаа юм. Энэ дээр болбол бид нар яг үндсэндээ цаашидаа бид нар ер нь яг НДШ төлж байгаа энэ ажил олгогч нарт энэ төлж байгаа шимтгэл нь ямар өгөөжтэй байх юм бэ, шимтгэл.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Лодойсамбуу гишүүн тодруулга.



**Ч.Лодойсамбуу:** Яах вэ энэ НДШ-ийг татвар гэж ойлгоод байна гэж та бүхэн л хэлээд байгаа. Яг тэгж ойлгоод байгаа юм бол байхгүй. Зүгээр тэр хэмжээний дарамт үүсгээд байна л гэдгийг л хэлээд байгаа юм. Энэ дарамтыг жоохон багасгах боломж байдаг юм болов уу? Үнэхээр энэ Монгол Улсын хөгжилд энэ бизнес эрхлэгчид, хувийн хэвилийнхний оруулдаг жин нэмэр гэж байдаг юм болбол энэ төрөөс үзүүлж байгаа татвар, хураамж, баахан олон шимтгэлүүдийн дарамт багасгах боломжтой юм болов уу л гэдэг талаас нь яриад байгаа юм.

Тэгээд энэ дээр нөгөө бид нарын энэ удаагийн ЗГ-аас бүр тодорхой асуумаар байгаа юм л даа. Манай энэ хөгжлийн бодлогод бид нар ингээд яг татвар төлдөг хэсгээсээ их хэмжээний татвар авах, эсхүл татвар төлдөг хэсгийнхээ хэмжээг тэлж бага татварын аргаар татвар төлөгчдийнхөө тоог нэмэх энэ бодлого руу явах юм уу, аль руу нь явах юм бэ? Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ бол төлж байгаа хэсгийнхээ татварыг л жил жилээр, шимтгэлүүдийг жил жилээр нэмээд л ингээд л нөгөө хэд дээрээ л овоолоод байдаг. Энэ асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандаад Жавхлан сайд бид хоёрын дунд бас нэг ийм Үндсэн хуулийн нэг маргаан үүссэн л явж байгаа. Цэц дээр нөгөө нэг шаталсан татварын асуудлаар. Ингээд төлдөг хэсгүүдийнхээ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Үндсэндээ санал хэлчихлээ тийм ээ. Ринчиндорж, энэ чинь цаг 56 болж байгаа юм байна, ер нь 13 цаг болж байгаа учраас үдээс өмнөх чуулганаа өндөрлүүлэх нь зөв байх гэж бодож байна.

Бас Улсын Их Хурлын гишүүдэд албан ёсоор нэг зүйл зарлахад парламентын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, ард иргэдийн мэдэх эрхийг бүрэн хангах, парламентынхаа үйл ажиллагаанд Улсын Их Хурлын гишүүд,

албаны хүмүүсийн хэрхэн яаж оролцож байгаа вэ гэдэг дээр бас бодитой үнэлэлт, дүгнэлт хийж байх зорилготойгоор сэтгүүлчдийг энэ зочдын танхимд чөлөөтэй ордог болгох нөхцөлийг өнөөдрөөс эхлээд хангасан. Өнөөдрөөс эхэлж хангаж байгаа.

Гэхдээ мэдээж сэтгүүлчид маань камертай, зургийн аппараттай орж ирж, янз бүрийн ойр зуур асуудлаар хөөцөлдөхөөсөө илүүтэйгээр байнгын ажил хэрэгчээр үйл ажиллагаанд оролцоно. Ер нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад нээлттэй болно гэдэг ойлголт бол 2 зүйл агуулагдаж байгаа. 1 дүгээрт биеэр оролцох боломжийг, 2 дугаарт энэ парламент дээр явагдаж байгаа үйл ажиллагаа, процесст нээлттэйгээр оролцох боломжийг нь хангаж өгөх нь энэ ажлын хэсгүүд, энэ Байнгын хорооны хурлуудын үйл ажиллагааг сурвалжлахад нээлттэй байлгах зарчмыг баримтлах нь хэвлэл мэдээлэлд нээлттэй болж байна, олон нийтийнхээ мэдэх эрхийг хангаж байна гэсэн энэ зорилго хангагдаж байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлье. Тэгээд өнөөдөр “Өнөөдөр сонин”-ы сэтгүүлч Оргилмаа анхны сэтгүүлч ирж оролцож байгаа юм байна. Амжилт хүсье та бүхэнд.

Ингээд 13 цаг болж байгаа учраас үдээс өмнөх чуулганы хуралдааныг өндөрлүүлье. 14 цагт чуулган үргэлжилнэ.

12.57 цаг

2024 оны 10 дугаар сарын 03, Пүрэв гараг,

Төрийн ордон “Их хуралдай” танхим  
14 цаг 04 минут.

### ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Улсын Их Хурлын дэд дарга  
Х.Булгантуяа 14 цаг 04 минутаас  
хуралдааныг даргалав.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын үдээс хойших чуулганы хуралдаан эхэлж байна. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын хөгжлийн төлөвлөгөөг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй байгаа. Улсын Их Хурлын гишүүд асуулт асуухаар нэрээ өгсөн байна. Одоо асуулт асуухаар Батболд гишүүн.

**Р.Батболд:** Дарга аа, хариулах хүн байгаа юм уу? Оруулж ирж байгаад асуувал яасан юм бэ дарга аа.

**Х.Булгантуяа:** Энэ ЗГ-ын гишүүд ирцээ бүрдүүлээрэй. Энд одоо 4 сайд л байна. Гантөмөр даргаа ЗГ-ын гишүүд нь хааччихав? Хөгжлийн төлөвлөгөөгөө ярих гээд байдаг.

**Р.Батболд:** Хариулах хүмүүсээ оруулж ирж байж асууя тэгэх үү?

**Х.Булгантуяа:** Үдээс өмнөх хуралдаанаар бас ингээд ЗГ-ын гишүүдийн ирцийн асуудал яригдаад байсан. Алтангэрэл сайд аа, Энх-Амгалан сайд, Тулга сайд ирцээ бүрдүүлэе. Жавхлан сайд орж ирж байна. Тэгээд ЗГ-ын 20 гаруй сайд нараас одоо энд ерөөсөө 4, 5 сайд л байна. Сайд нарынхаа ирцийг бүрдүүлмээр байна. 6 байна уу? Одбаяр сайд, Эрдэнэбүрэн сайд, Батцэцэг сайд, Туваан сайд, Номин сайд, Одонтуяа сайд, Боловсролын сайд Наранбаяр, сайд, Дэлгэрсайхан сайд, Хот байгуулалтын Батсуурь сайд, Хүнс, хөдөө аж ахуйн Энхбаяр сайд, Цахим хөгжил, инновацын Баатархүү сайд, Эрчим хүчний Чойжилсүрэн сайд, Эрүүл мэндийн Мөнхсайхан сайд нар, Шадар сайд Амарсайхан, Доржханд нар чуулгандаа сууж, жилийн төлөвлөгөөнийхөө гишүүдийн асуултад хариулмаар байна.

Үдээс хойших хуралдаанд одоо ахиад хэд хэдэн сайд нар дутуу байна. Нэмж орж ирмээр байна. Улсын Их

Хурлын гишүүд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг чуулганаар хэлэлцүүлж байгаа энэ цаг үед асуултад хариулахаар сайд нар бүгдээрээ байж баймаар байна ирцээ бүрдүүлээд. Улсын Их Хурлын гишүүн Батболд. Батболд гишүүний микрофоныг өгье.

**Р.Батболд:** Өдрийн мэнд хүргэе эрхэм гишүүд. Тэгэхээр хэдэн асуулт асууя. Энэ хөгжлийн төлөвлөгөө дээр эрчим хүчний үнэ тарифыг шинэчлээд индексжүүлнэ гэсэн байна. Тэгэхээр энэ 25 онд явж таарах гээд байх шиг байна. Үүнтэй холбогдуулаад энэ Монголбанк, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамнаас нэг юм асуучихмаар байна. Та бүхэн инфляцыг 6 хувь дээр барина гээд байгаа. Энэ чинь яг баригдах юм уу, энэ дээр яаж тооцоо хийсэн байдаг юм бэ? Эрчим хүчний үнэ өсөхөөрөө суурь үнэ өсчихнө. Тэгээд л дагаад л бүх бараа, бүтээгдэхүүний үнэ өсөөд явчихна. Тэгээд одоо хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх гээд байгаа төсөл, хөтөлбөрүүд чинь ирэх жилээс эхлээд л дахиад л нэг үнийн өсөлт тооцно гэсэн нэг бөөн асуудал үүсгээд явах болов уу. Энэ дээр нэг тооцож гаргасан юм уу, энэ эрсдэл дээр нэг тооцсон тооцоо байгаа болов уу, үгүй болов уу?

2 дугаар асуулт. Энэ нөгөө зээл, гадаад зээл, үнэт цаасыг ерөөсөө яг хаана бүртгээд яваад байгаа билээ гэдгийг би нөгөө Сангийн сайдаас асуучихмаар байна. Энийг юутай холбох гээд байна гэхээр нийслэл дээр 25 онд гэхэд 2 их наядын зээл үнэт цаасны санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ тусгагдсан яваад байх шиг байна. Тэгэхээр энийг ер нь яаж явах юм бэ? Хот ингээд үнэт цаас гаргаад л яваад байх юм уу? Одоо жишээлбэл Сэлбэ сэргэлт бол 10 хувийн зорилтот түвшинтэй 1,5 их наяд яваад байна. Бодох юм бол энэ чинь цаашаа гүйцэхэд 15 их наяд болох гээд байдаг. 4 орчим, 4-өөс 5 тэрбум долларын асуудал зөвхөн Сэлбэ сэргэлт дээр яваад байдаг. Энэ тал дээр юу гэж бодож байгаа вэ?

Тэгээд үүнтэй холбогдуулаад хотынхон байж байвал асуулт асуучихмаар байна. Хотын бодлого нь ер нь ямар байгаа юм бэ? Дэд, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулаад энэ эко ногоон хаус барилгыг дэмжээд явах тал дээр ер нь бодсон бодол байдаг юм болов уу? Энэ жилийн хувьд харахад 2500 айлын хашааг дахин төлөвлөлтөд оруулаад, дээр нь мянга, 12 мянган айлын орон сууц барина гэж яриад байгаа юм. Тэгэхээр энэ чинь нөгөө төвлөрлийг сааруулаад байгаа хэрэг яг мөн үү? Дээрээс нь 12 мянган айл тухайн орчинд байгаа зам тийм ээ, нөгөө замын түгжээ чинь дахиад багасах юм уу, улам ихсээд явах юм уу? Энэ дээр яг нийслэл яг юу гэж бодож байгаа юм бэ гэдэг нэг.

3 дугаар асуудал энэ Хөдөө аж ахуйн яамнаас асуучихмаар байна. ХАА-н гаралтай бараа, бүтээгдэхүүний гадаад худалдааны хориг хязгаарлалтыг цуцална гээд байгаа юм. Тэгэхээр энэ бодвол нөгөө арьс шир бусад бүтээгдэхүүнүүдийг л ярьж байгаа байх. Тэгэхээр ХАА-н бирж гэж нэг газар уг нь 10 жил ажиллаад байгаа. Энийг яг сонгодог утгаар нь биржийн утгаар нь ажиллуулах уу? Энэ хориг цуцлагдах гэж байгаа бараа бүтээгдэхүүнүүд чинь биржээрээ арилжаалагдах юм уу, зүгээр хаана хамаагүй гараад явчих юм уу? Ард нь хамгийн гол нь боломжит боомтуудаар экспортолно гээд биччихсэн байгаа юм. Тэгэхээр яг энийг юу гэж ойлгож байгаа вэ, энэ биржийн асуудлыг яаж авч үзэж байгаа вэ гэдэг?

4 дүгээр асуудал энэ ЭХЯ-наас нэг юм асуумаар байна. Энэ ердийн ачааллын үед цахилгаан эрчим хүчинд хуримтлуулах хуримтлуур бол ерөнхийдөө нэг ашиг багатай гэж яриад байсан санагдаж байх юм. Тэгээд 25 оны төлөвлөгөө дээр болохоор Багануурт тэр 200 тэрбумаар дахиад нэг шинэ хуримтлуур байгуулах гээд байх шиг байна. Энийг юу болгож болохгүй юу энэ сэргээгдэх эрчим хүч рүүгээ шилжүүлэх юм уу эсхүл тэр тал

руу нь анхаарч болохгүй юу? Дахиад шинээр хуримтлуур тэнд барих юм уу?

Энэ ЗТЯ-наас нэг юм асуучихмаар байгаа юм. Энэ Улаанбаатар-Лүнгийн бас 101,7км замыг 4 урсгалтай эгнээтэй болгоно гээд байна. Энийг та бүхэн яаж хийх гэж байгаа вэ? Аргачлал нь ямар байгаа вэ? Зорилтот түвшин нь 20 хувь байгаад байна. Тэгэхээр энийг юу та нар 100км замыг маань дахиад хуулаад хаячих юм биш биз дээ? Дарханы зам шиг 5.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Эхлээд Эрчим хүчний сайд Чойжилсүрэн, дараа нь Жавхлан сайд. Хотоос хүн байна уу, Монголбанкнаас хүн байгаа билүү ажлын хэсэг дээр? Хот, Монголбанк 2 ер нь байх ёстой юм биш үү? Хотоос уу тийм ээ? Хотоос байгаа юм байна. Монголбанкнаас бас хүн байх ёстой юм шиг байна шүү. Чойжилсүрэн сайд.

**Б.Чойжилсүрэн:** Батболд гишүүний асуултад харцулъя. Батболд гишүүнээ энэ хуримтлуур батарейн төслийг бол бид нар тийм ашигтай, ашиггүй гэх шалгуур тавихаасаа түрүүлээд нар ороод эсвэл салхи зогсчихоор сэргээгдэх эрчим хүчнээс эх үүсвэрүүд станцууд маань цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж чадахгүй байгаа учраас тэрнийг нөөцлөхийн тулд барьж байгаа юм. Яг цэнэглэх цахилгаан эрчим хүчний үнийг 2 центээр өгөөд, буцаагаад оргил ачааллын үед 15 орчим центээр сүлжээнд нийлүүлэхээр ийм тооцоолууд гараад байгаа. Багануур дээр бол Улаанбаатар хотоос нэг юу тендер зарласан, 50мвт-ын хуримтлалаар storage батарей хуримтлуулах төсөл хэрэгжээд явж байгаа. Энэ 12 сарын 1-нээс өмнө ашиглалтад оруулъя гэсэн ийм тооцоололтой явж байгаа. Ийм л байдалтай байгаа.

Манай энэ эрчим хүчний салбарт нэг хүндрэл байгаа нь манай хэрэглээ маань ахуй давамгайлдаг. Өвлийн улирал буюу оргил ачааллын үеэр 11, 12, 1, 2, 3

дугаар сарууд дээр оройн 17 цагаас үдшийн 22 цагийн хооронд манай хэрэглээ огцом 30 гаруй хувиар, зарим үедээ 40 хувиар ч нэмэгдэж байсан тохиолдол бий. Ингэж хэрэглээ савладаг учраас энэ тохируулгад энэ батарей төслүүдийг хэрэглэж байгаа юм. Гарцаагүй гарцгүй болчхоод. ОХУ-аас урьд нь болбол одоогоос хэдэн жилийн өмнө болбол ОХУ-аас бид нар энэ тохируулгын функцийг хэрэглэж 220 киловольтын хос шугамаар цахилгаан эрчим хүч импортлодог байсан. Одоо бол энэ шугамын хэмжээ дээд хязгаартаа тулсан. Орос талаасаа 345мвт, яг Дархан дээр ирэхэд болбол 310мвт болоод энэ 2 хос шугамаар болбол импортлох чадлын хэмжээ бол дээд хязгаартаа тулсан учраас энэ батарейн төслүүдийг хэрэгжүүлэхээс ондоо аргагүй. Эс бөгөөс хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хязгаарлах ийм нөхцөл байдалд тулчихсан учраас энэ төслүүд хэрэгжиж байгаа гэдгийг хэлье.

Үнэ тарифын өсөлтийг болбол мэдээж үнэ тариф ерөнхийдөө болбол 1квт цаг эрчим хүчийг төвийн бүсдээ бид нар 285 төгрөгөөр өртөг нь үйлдвэрлэж байна. Борлуулах үнэ болбол яг ахуй талдаа болбол 140 орчим төгрөгийн үнэтэй 2 дахин бага 50 хувиар нь борлуулж байгаа ийм учраас цахилгаан эрчим хүчний тарифыг нэмэгдүүлэх зайлиггүй шаардлага үүсчихсэн. Алдагдал өр болбол нэлээд хяналтаас гарч томорч байгаа. Яг өнөөдрийн байдлаар болбол богино хугацаатай өр төлбөр Эрчим хүчний сайдаар зорилтот түвшин, бизнес төлөвлөгөө батлуулдаг ТӨЖ-удын тухайд 540 орчим тэрбум төгрөг, 539,6 орчим тэрбум төгрөгийн богино хугацаат өр төлбөр, 1,8 их наяд төгрөгийн урт хугацаатай өр төлбөрүүд байгаа. Гадаад зээлийн ашиглалт буюу гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төслүүдийг Сангийн яам буцаагаад яг тэр төслийг хэрэгжүүлж байгаа.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Чойжилсүрэн сайдад нэмэлт цаг өгье.

**Б.Чойжилсүрэн:** Тэр гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлсэн төслүүдийн эргэн төлөлтийг болбол манай салбарын тухайд болбол Сангийн яамтай дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулаад төсөл нь өөрөө төлөхөөр ийм гэрээнүүд хийгдсэн байгаа. Баярлалаа, хариулж дууслаа.

**Х.Булгантуяа:** Бондтой холбоотой Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Батболд гишүүний асуултад хариулъя. Түрүүн Цогтгэрэл гишүүн бас асууж байсан. Төсөл энэ байгаа шүү гишүүд маань энийг авсан байх гэж бодож байна. Энэ төсвийн танилцуулга энэ зузаан ном байгаа. Эндээс ардаасаа 8 дахь хуудас дээр 2,2 их наяд төгрөг буюу 90 төслийн зээлийн аль хэдийн эхэлчихсэн байгаа ийм төслүүд байгаа. Эд нарын үргэлжлэл нэмэлт санхүүжилт буюу зээлийн ашиглалтыг энэ дээр маш дэлгэрэнгүй ингээд гишүүдэд мэдээлэл аль хэдийн 9 сарын 1-ний байдлаар хүргүүлчихсэн байгаа шүү.

Дээрээс нь ЗГ-ын үнэт цаас яг төсвийн зардал шиг төсөв дээр бүртгэгдээд явна. Орон нутгийнх ч мөн адил төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг болоод явна. Харин орон нутаг буюу Улаанбаатар, аймгууд үнэт цаас гаргах эсэхээ.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Нэмээд хариулчихъя.

**Б.Жавхлан:** Нийслэл бол Иргэдийн хурлаараа энийгээ шийдээд, тэндээ бүртгээд, давхар төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг болоод бүртгэгдээд явна гэсэн үг зарцуулалтаараа.

**Х.Булгантуяа:** Хүнс, хөдөө аж ахуйн сайдаас бас биржтэй холбоотой асуулт асуусан байгаа.

**Ж.Энхбаяр:** ХАА-н бирж өнөөдрийн байдлаар бол нийт Монгол Улсын экспортод гарч байгаа ноолуурын



харилцааг бүрэн зохицуулж байгаа. Энэ намраас улаан буудайн арилжааг хийж эхэлсэн. Ер нь цаашид тодорхой хэсгийг нь олон нийтэд нээлттэй ХК болгох ийм бодлого барьж байгаа. Мах болон ХАА-н гаралтай арьс шир, амьд малын арилжааг мөн ХАА-н биржээр хийх бэлтгэл ажлууд эд явагдаж байна. Ер нь энэ Шинэ хоршоо хөдөлгөөн, Атрын 4 дүгээр аян, Цагаан алт гээд энэ бүх бодлогын гол багц буюу энэний гол төвлөрөл нь энэ урсгал нь ХАА-н биржээр дамжиж гол арилжаа, захиалга, худалдаа цаашидаа явах болно.

**Х.Булгантуяа:** Батболд гишүүн тодруулах уу? Батболд гишүүн тодруулъя.

**Р.Батболд:** Энэ нөгөө юу асуусан юм. Биржээр явах нь бол тодорхой. Зүгээр нэг энэ хориг хязгаарлалтыг цуцална гэхчхэн байгаа юм. Тэгэхээр тэр ямар, ямар бараа бүтээгдэхүүнүүд байгаа юм бэ? Тэд нар чинь биржээрээ яг дамжиж явах юм уу, сонгодог утгаараа бирж явах юм уу л гэж асуусан юм.

Тэр гадаадын зээлтэй холбоотой Сангийн яамнаас асуудаг нь би зүгээр нөгөө хотын холбогдолтой юм асуусан шүү. Энэ хот дээр 2 их наяд яваад байгаа юм энэ 25 онд. Тэгэхээр энэ хот чинь өөрөө ингээд хамаагүй бонд гаргаад л яваад байдаг. Энэнийхээ зээлийн санхүүжилт, удирдлага менежментийг бодвол Сангийн яам хяналт тавиад явдаг байлгүй дээ л гэдэг талаар асуугаад байгаа юм. Тийм.

**Х.Булгантуяа:** Жавхлан сайд нэмж тодруулж хариулъя.

**Б.Жавхлан:** Батболд гишүүнээ би таны асуултад хариуллаа шүү. Та өөрөө завгүй байх шиг байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу орон нутаг үнэт цаас гаргахад ЗГ-аас зөвшөөрөл өгдөг байгаа. Тэрийг нь мэдээж Сангийн яам хариуцаж судлаад үгүй, тийм гэдэг хариугаа өгөөд, ЗГ-аар

баталгаажуулдаг байгаа. Тийм. Тэгээд ирэх оных чинь 2,4 их наяд орчим байгаа. Нийт ашиглаад явах нь, одоо эхэлчихсэн байгаа, энэ жил эхэлчихсэн байгаа. Энэ жил 800-гаад орчим тэрбум нь ашиглалтад гарчихсан, ирэх жил 1,6 орчим нь нэмж ашиглалтад гарна гэсэн үг. Тэгэхээр тэр нь ирэх оны Монгол Улсын төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг болоод явна гэсэн үг. ЗГ-ын баталгаатай ч бай, баталгаагүй ч бай ЗГ-ын өр дээр нэмэгдээд явна. Энэ жилийн нөгөө түрүүн бас гишүүд асуугаад байсан өр ирэх жил яагаад нэмэгдэж байгаа юм бэ гэж байгаа. Тэрний нэг хэсэг нь 1,6 их наяд нь жишээ нь нийслэл.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Хүнс, хөдөө аж ахуйн яаманд экспортыг нэмэгдүүлэх том даалгавар ногдсон. Өнөөгийн байдлаар манай ХАА-н гаралтай түүхий эд нийт 960 орчим сая долларын экспорт хийж байгаа. Энэ тоог нэмэх ийм том зорилт байгаа. Юуны түрүүнд мах, махан бүтээгдэхүүнтэй холбоотой бүх төрлийн квот хориг хязгаарыг бүрэн цуцалсан. Энэ бол бүрэн ямар нэгэн хорио хязгааргүйгээр экспортод гарч байна. Махны зах зээл идэвхтэй гадаад талдаа захиалга ихтэй идэвхжиж байна.

Мөн ЕАЭЗХ-той Монгол Улс 2 талын гэрээ хэлэлцээр байгуулж байна. Энэ байгуулагдсан нөхцөлд 375 төрлийн ХАА-н гаралтай бүтээгдэхүүн гаалийн татваргүй, квотгүй хязгаарлалтгүйгээр Евро Азийн холбоонд гарах ийм гэрээ хэлэлцээрүүд эцэслэх шатдаа орж байна. Мөн Өмнөд Солонгостой хийсэн чөлөөт худалдааны хэлэлцээр бас эцэслэх шатдаа орж байна. Ингэснээр манай ХАА-н гаралтай түүхий эд экспортод томоохон боломж өрсөлдөх чадвар бий болно гэж үзэж байгаа.

**Х.Булгантуяа:** Нэмж тодруулах уу? Батболд гишүүн микрофон.

**Х.Батболд:** 1 асуулт нөгөө дутуу орхигдчихлоо. Нөгөө Улаанбаатар-Лүнгийн хоорондох замыг яаж хийх гэж байгаа вэ? Хуулж хаячхаад дахиад 5 жил явахгүй биз дээ. Энэ дээр нөгөө нэг зорилтот түвшнийг нь 20 хувь байгааг нь жоохон нэмээд ядаж 50 хувь болгоод шахаад явж болохгүй юу? 2 жилийн дотор дуусгахаар гэдэг асуулт асуусан юм. Тийм зорилтот түвшин нь 20 хувьтай л юм байна лээ.

**Х.Булгантуяа:** Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** ЗТЯ-наас өгч байгаа судалгаагаар манай Монгол Улсын хамгийн өндөр ачаалалтай яг трасс хэсэг нь болбол энэ Улаанбаатар-Лүн байдаг юм байна лээ. Улаанбаатар-Лүн, дараа нь Дархан-Улаанбаатар, дараагийнх нь Налайх цаашаа Тэрэлж гээд энэ хэсэг хамгийн ачаалалтай эхний 3 зам трасс байдаг юм байна. Тийм учраас энэ Лүнгийн зам болбол маш өндөр чухал ач холбогдолтой болж ирж байгаа. Лүнгээс цаашаа баруун аймгууд бүгд ингээд задардаг учраас зам нь. Энэ жил уг нь эхлүүлж гэж бид хичээсэн боловч Лүнгийн зураг төсөв ТЭЗҮ нь зураг нөгөө замын дууссангүй. Тийм учраас ирэх жил эхэлж чадахгүй нь, эхлэх боломжгүй гэсэн үг.

Хэрвээ ирэх жил ингээд зураг төсөв нь дуусаж чадах юм бол ирэх оны 9 сарын 1-д бид нар өргөн барих төсөвт болбол орж таарах байх. Яг таны ярьж байгааг бид бас дотроо ярьж байгаа. Тэгээд энэ алдааг давтаж болохгүй. Энэ бол 2 урсгалтай, 4 эгнээтэй ийм зам болно. Тэгэхээр одоо байгаагаа ашиглаж байгаад яах вэ ингээд хөндлөн орж, гарна биз. Тэгээд 1 урсгалаа хийгээд тэгээд ээлжлэх ийм зохион.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр.

**Д.Батбаяр:** Сайн байцаана уу бүгдээрээ? 2 асуулт байна. ЗГ-ын 2025 оны хөгжлийн хөтөлбөрийн эхний хэлэлцүүлэг явж байгаа энэ хүрээнд нь

асууя. Тэгээд энэнээс эхний асуулт нь юу гэхээр ЗГ-аас Хэрэг эрхлэх газраас асуумаар байна. 25 оны хөгжлийн хөтөлбөрийг ярихаасаа өмнө 24 оны хөгжлийн хөтөлбөрийн гүйцэтгэл ямар байсан бэ гэдэг дээр ямарваа нэгэн дүгнэлт байна уу? Тайлан байна уу? Гүйцэтгэл ер нь яаж явсан юм бэ? Энэ ЗГ-аар орсон уу, Улсын Их Хурал дээр хэлэлцэгдсэн үү? Хэрвээ хууль дүрэмтэй болбол. Бид нар ингээд хариуцлагатай байх ёстой гэдгээ хаана хаана шаардаад байгаа юм. Тэгэхдээ ингээд хөгжлийн хөтөлбөрүүдийг батлаад л байдаг. Энэ бол маш чухал. Урьд урьдынх нь хөгжлийн хөтөлбөрүүд нь гол нь их ямархуу үр дүнтэй, хэдэн хувийн хэрэгжилттэй байгаа юм бэ гэдэг нь асуумаар байна 1 дүгээр асуулт нь.

2 дугаар асуулт нь энэ хөгжлийн хөтөлбөрийн ажлын хэсгээс бас асуумаар байна. Манай төвийн бүс болохоор энэ дэд бүтэц хөгжсөн, мал ахуй, мал аж ахуй, газар тариалангийн нөөц нутаг гэж байгаад байгаа юм. Тэгээд энэ их олон жил ярьж байгаа юм л даа энийг. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг эхлүүлнэ гэдэг юм уу, дэмжинэ гэдэг ч юм уу ийм байдлаар яагаад оруулчхаж болохгүй байгаад байгаа юм бэ гэж би асуух гээд байгаа юм. Энэ ЗГ дээр болбол манай сайд нар байгаа яг манай төвийн бүсийн Тулга сайд байна, Энхбаяр сайд байна, Жавхлан сайд байна, Туваан сайд байна, бүгдээрээ мэдэж байгаа. Яг малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийн ач холбогдлыг мэдэж байгаа. Манай бүсийн, тэр манай тойргийн иргэд болбол байнга асууж байдаг надаас лав. Манай сайд нараас бас асууж байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр энэ хөтөлбөртөө ер нь яагаад оруулчхаж болохгүй байгаад байгаа юм бэ энэ үйлдвэрийг? Яах вэ хэлэх байх л даа. Аж үйлдвэрийн парк байгуулна гээд л ярих байх. Энд бас яг адилхан ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Шохойн үйлдвэр барина, аялал жуулчлалын цогцолбор барина гээд бас ороод ирчихсэн байгаа юм. Эсвэл бас тэгж ярих байх. Төр,

хувийн хэвшилтэйгээ өрсөлдөхгүй, төр бизнес хийхгүй гээд л ярих л байх. ХК байгуулаад явж болно.

Хамгийн гол нь энэ хөгжлийн хөтөлбөр байгуулж байгаагийн гол үндэс нь болохоор энэ хэн ч барьдаг байсан бай энэ үйлдвэрүүдийг барих ажлыг нь дэмжих байгаад байгаа байхгүй юу. Татварын орчноор нь ч байдаг юм уу, зээлийн орчинд нь ч юм уу, баталгаа гаргадаг ч юм уу. Гол нь энэ хөгжлийн хөтөлбөрт л оруулчихмаар байгаад байгаа юм. Тэгээд заримыг нь оруулж болоод байдаг, чухам ямар шугамаар оруулдаг юм бол? Ер нь яагаад энийг оруулж болохгүй байгаа юм бол гэсэн ийм 2 асуулт байна ажлын хэсгээс.

**Х.Булгантуяа:** ХХАА-н сайд Энхбаяр.

**Ж.Энхбаяр:** Хөгжлийн хөтөлбөрт Цагаан алт гэсэн нэр томъёогоор энэ бүх бодлого багцлагдаж орж байгаа. Цагаан алт хөтөлбөрийн маань гол зорилго бол арьс шир, ноос ноолуурныхаа боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, энэ боловсруулах үйлдвэрүүдээ дэмжих ийм том бодлого байгаа. Энэ хүрээндээ ноос ноолуур, арьс ширний бэлтгэл, үйлдвэрлэлийг дэмжих томоохон зээлийн багц, хөнгөлөлттэй зээлийн багц явна. Мөн бодлогодоо Цагаан алт гэж албан ёсны бодлого болж малгайлна. Мөн үйлдвэрүүдийнхээ түүхий эдийг тогтвортой нийлүүлэлтийг хангахын тулд арьс ширэнд, ноос ноолуур, хөвөр, сүү, сүүн бүтээгдэхүүн, сүү, улаан буудай, ногоо гэсэн энэ 5 багц дээр татаас буюу урамшууллын бодлого давхар хэрэгжинэ. Энэ хөнгөн үйлдвэрийг босгох энэ бодлого бол энэ 25 оноос нэлээн шинэ түвшинд эрчимжих байх. Хамгийн гол нь Монгол Улсын Ерөнхийлөгч маань өөрөө маш сайн дэмжиж, энэ өөрийнхөө санаачилга дор энэ Цагаан алт хөтөлбөрийг оруулж ирж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлж баталсан байгаа. Төсөв боломжийн хэмжээнд суусан байгаа.

Нөгөө талаар энэ арьс ширний боловсруулалтын түвшнийг нэмэхийн тулд Дархан хотод, Ховдод, Баянхонгорт, Улаанбаатар Эмээлтэд аж үйлдвэрийн парк буюу арьс шир ноос, ноолуурын боловсруулалтын түвшнийг сайжруулах ийм паркууд хөрөнгө оруулалтууд хийгдээд явж байна. Төрийн барьж байгаа бодлого бол бид газрын асуудлыг нь шийднэ, дэд бүтцээр нь хангана, цэвэрлэх байгууламжийг нь барина. Дотор нь баригдах үйлдвэрүүд бол хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэнэ гэсэн ийм бодолтойгоор хэрэгжүүлэлт явагдаж байгаа. Тэрнээс төр бол арьс элдэхгүй, төр бол ноос угаахгүй, зөвхөн тэр ААН үйл ажиллагаа явуулах таатай нөхцөлийг нь бүрдүүлнэ. Нэмэгдээд энэ татварын бодлогын Бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалд тааруулаад тэнд төвлөрч байгаа үйлдвэрүүдийг дэмжих энэ татварын бодлогууд бас хэрэгжихээр бэлтгэгдэж байна.

**Х.Булгантуяа:** Эдийн засаг, хөгжлийн яамнаас Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД 6 номерын микрофон дээр байна уу? 6 номер.

**И.Батхүү:** Батбаяр гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө яг одоо хэрэгжээд явж байгаа. Энэ он дуусаад гүйцэтгэл нь ирэх онд үнэлэгдэнэ. Тэгэхээр таны асуулттай холбогдуулаад 23 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээллийг өгье. 23 оны төлөвлөгөөний хэрэгжилт нь жилийн эцсийн дүнгээрээ 79,2 хувьтай гэсэн үнэлгээ гарсан байгаа. Дотроо бүлгээр нь авч үзэх юм бол иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого нь 92 хувь, нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого 82 хувь, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, ногоон хөгжлийн бодлого 79,1 хувь, хүний хөгжлийн бодлого 76,2 хувь, эдийн засгийн бодлого 76,1 хувийн хэрэгжилттэй гэж гарсан байгаа. Энэ жилийн хөгжлийн төлөвлөгөө, бусад дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүд бүгд тодорхой

цаг хугацаанд үнэлэгддэг зохицуулалт журамлалтай байгаа. Тэрний дагуу мэдээлэл цаг тухай бүрд хүргэгдээд явна.

Төвийн бүсийг бас сая таны хэлсэн тэр хөгжлийн асуудал болоод энэ бүсчилсэн хөгжлийн чиглэлээр бүс бүр дээр цаашид ТЭЗҮ судалгаа хийгдэхээр байгаа. Энэ дээр бас нарийвчлаад хаана.../минут дуусае/

**Х.Булгантуяа:** Далайн Батбаяр гишүүн нэмж тодруулъя.

**Д.Батбаяр:** Баярлалаа. Хагас жилээр хөгжлийн хөтөлбөрийн дүгнэлт гардаг юм болов уу 2024 оны 1 дүгээр асуулт нь.

2 дугаар асуулт нь Энхбаяр сайдтай яг санал нэг байгаад байгаа юм. Яг энэ төрийн дэмжлэг гэдэг бол яг ийм утгаараа байх ёстой. Тэгээд л энэ хөгжлийн хөтөлбөртөө тусгагдаад явчих юм болбол бүр тодорхой болоод илүү амар болчих болов уу гэж бодоод байгаа юм л даа. Тийм учраас яг энэ малын гаралтай түүхий эдийг боловсруулах энэ үйлдвэрийг Дархан-Уул аймагт байгуулах ажлыг эхлүүлнэ, дэмжинэ гэдгээр нь оруулчихмаар байна. Ийм хүсэлт байгаад байгаа. Яагаад гэхээр энэчээ бас нөгөө нэг Энхбаяр сайд аа, шохойны үйлдвэр, аялал жуулчлалын цогцолбор энэ тэр гээд өөр иймэрхүү яг нэр заагаад оруулчихсан юмнууд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр нэр заагаад л оруулчих боломж байна уу гэдгийг л асуумаар байна. Ажлын хэсгээс бас асуучихъя, яг бэлдээд хийгээд яваа улсуудаас нь. Дахин, дахин асуугаад л яваад байгаа юм.

**Х.Булгантуяа:** Гантөмөр Шадар сайд.

**Л.Гантөмөр:** 24 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт болбол ерөнхийдөө их дажгүй байгаа. Гол нь нөгөө эдийн засгийн өсөлт, инфляц гээд ийм том, том зорилтууд болбол хангагдаж байгаа. Мэдээж хэрэг дутуу

хөтүү юм бол байна. Сонгуулийн үеэр орхигдсон ажлууд бол байна. Тэд нарыг бид нар 25 ондоо гүйцээгээд хийх шаардлага байгаа Батбаяр гишүүнээ. Таны хэлж байгаа энэ Дархан-Уул аймагт арьс ширний цогцолбор байгуулах ажлыг болбол заавал хийх хэрэгтэй. Тэгээд дутуу орхигдсон болбол хэлэлцүүлгийн явцад та бас Эдийн засгийн байнгын хороон дээр саналаа гаргаад, гаргахдаа та нэг дэх өдөрт амжиж бичгээр санал гаргах юм байна лээ шүү. Тэгээд яг дэгийнхээ дагуу нэмж оруулаад, тэрийгээ ажил хэрэг болгохын төлөө хэдүүлээ ажиллацгаая.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Батжаргал гишүүн байхгүй байна уу? Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг, Ганхүлэг гишүүн байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан.

**Д.Жаргалсайхан:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Миний хувьд энэ хөгжлийн хөтөлбөр 25-ыг баталж байна л даа энэ. Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөөс авч баталж байна уу, энэ ямар байдлаар энэ бас дараалалд оруулж байгаа вэ? Нэг дэх асуудал.

2-т нь бидний хувьд бас энэ бүсчилсэн хөгжлийн асуудал Шадар сайд дээр байгаа. Тэгээд бүсчилсэн хөгжлийн маань энэ асуудлыг хэзээ ярих вэ? Бүс бүсээр нь яаж энийг хэлэлцүүлэх вэ, санал авах вэ? Энэ ажлын бас төлөвлөгөөнд байгаа юу? Би бол олж харахгүй байна.

Мөн дээрээс нь ХАА-н бүтээгдэхүүнийг боловсруулах асуудал их чухал байгаа юм. Монгол Улсын 250 гаруй мянган малчин буюу мал бүхий иргэн байгаа юм. Үүнээс орлогоо авч, амьдрал ахуйгаа залгуулдаг. Гэтэл сүүлийн жилүүдэд юмны үнэ маш өссөн, малын гаралтай түүхий эд үнэгүй болоод ингээд хаягдаж байгаа асуудал байгаа юм. Тэгэхээр энийг боловсруулах дээр, бүр эцсийн бүтээгдэхүүн болгож байгаа үйлдвэрүүдийг олноор нь байгуулж, энийг



бодлогоор яаж дэмжих вэ? Хөнгөлөлттэй зээл өгөх юм уу, татвараас чөлөөлөх юм уу энэ дээр ямар бодлого барьж байна вэ? Мөн энэ бүсчилсэн хөгжлийн хувьд бас энэ үндсэндээ ингээд 2 асуулт хэлчихлээ.

Одоо 3 дахь нь энэ бүсчилсэн хөгжлийн хувьд аль аймагт, ямар сумд ямар үйлдвэрүүд байгуулах вэ ийм асуултыг асууя.

**Х.Булгантуяа:** Эдийн засаг, хөгжлийн сайд, Шадар сайд Гантөмөр.

**Л.Гантөмөр:** Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Жаргалсайхан гишүүнтэй санал нэг байгаа. Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийг болбол бид нар их бодитоор хийх шаардлага тулгарч байгаа. Үнэхээр хангайн бүсийн хөгжлийг яаж харах юм бэ, хэдэн жилээр харах юм бэ, ирээдүй нь юу юм бэ гэдгийг гаргахын тулд энэ онд 24 онд бид нар 60 тэрбум төгрөгөөр бодлого төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг хийнэ. Энэ хүрээнд Шадар сайд Амарсайхан дээр ажлын хэсэг байгуулаад ажиллаж байна. Амарсайханы яг шууд удирдлагын доор тодорхой төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулагдаж байгаа. Энд болбол яг бүсийн бодлогоор мэргэшсэн хүмүүсийг цуглуулж байна.

Бодлогын бичиг баримт боловсруулах ажил бол нэлээн цаг зарж байгаа шүү гишүүнээ. Тэгэхээр та бүхэн ч гэсэн хангайн бүсээрээ яг Амарсайхан Шадар сайд дээр байгаа ажлын хэсэгтэй уулзалт зохион байгуулаад, бодож санаж байгаа зүйл, байгаа төлөвлөгөө, тооцоо материал, судалгаа гээд энэ зүйлээ бүгдийг нь өгмөөр байна. Яг би бодит үнэнийг хэлэхэд яг өнөөдөр энэ аймагт ийм үйлдвэр байгуулчих юм бол бүсчилсэн хөгжил болох гэж байна гэдэг ийм бүтэн зураг бол алга байна. Бүтэн зургаа гаргаж ирэхийн тулд бид нар 60 тэрбум төгрөгийг бодлого төлөвлөлтөд суулгасан байгаа гэдгийг гишүүд маань

ойлгож, яг бүсийн хөгжил дээрээ ямар бодол санаа байна тэрийгээ тусгаарай гэдгийг хүсмээр байна. Ингээж чадах юм болбол яг ХАА-д чиглэсэн бодлого нь ХААЯ-ан дээр байгаа тэр Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд бид нар үйлдвэрүүдийнхээ төсөөлөл, санхүүжилтээ болбол бид нар хийгээд явах нэг ийм хэрэгсэл байгаа.

Нөгөө талдаа Аж үйлдвэрийн яаман дээр бас үйлдвэржилтийн бүрэн бодлогоо гаргана. Энэ бодлогын хүрээнд болбол үйлдвэрээ дэмжих төсөл санхүүгээ болбол хэдүүлээ шийдээд явна гэсэн ийм төлөвлөгөөтэй байна. Түүнээс биш яг өнөөдөр бүсийн тэр кластер бүтэн угсрагдсан зүйл болбол бид байгуулагдаад, энэ парламент байгуулагдаад анхныхаа чуулганы анхны хэлэлцүүлгийг хийгээд сууж байгаа гэдгээ хэдүүлээ бас мэдэрч ойлгож, харин богино хугацаанд бидний бодлого бүтэн гарах ёстой, алдаагүй гарах ёстой гэдэг ийм л баримжаатай байгаа шүү гишүүнээ.

**Х.Булгантуяа:** ХХАА-н сайд Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Үнэхээр ХАА-н гаралтай түүхий эдийн дотроосоо бид нар нэг арьс ширний, ноосны салбар жсоохон муу байгаа. Гадаад зах зээл нэлээн амаргүй байгаа. Энэ хэрэглээний бүтцэд нэлээн өөрчлөлт ороод, нано технологи тэгээд л биед аль болох хөнгөхөн нэг ийм хувцас хунар материал хэрэглэдэг болчхоод байгаа нэг тал байна.

Хамгийн гол бид нараас шалтгаалж буй зүйл бол өнөөдөр байгаа Монгол Улсын мал сүргийн чанарлаг байдал нэлээн асуудал үүссэн. Зөвхөн сүүлийн 30 жил гэхэд бод 30-аас 40 кг-аар, бог 6-аас 8 кг давжаарсан. Монголын үхрийн арьсны шир Дэлхийн олон улсын худалдааны тэр тоо хэмжээндээ хүрэхээ больчихсон. Ноосны бүтэц нэлээн эвдэрсэн. Ер нь мал хувьчлагдсанаас.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Малыг малчид хувьчилснаас хойш энэ малын үржил селекцийн асуудал тэр хүний хувийн асуудал гэж орхигдуулсан байгаа юм байна лээ. Энэтэй холбоотойгоор малын маань тэр төрийн онцгой анхаарах ёстой тэр үржил селекцийн бодлого алдсантай холбоотойгоор нэгж малаас авах ашиг шимт байдал эрс унасан. Хамгийн гол нь МАА маань нөгөө үйлдвэрлэлийнхээ технологи, үйлдвэрлэлтэйгээ нийцэж хөгжих ёстой, төрөлжих ёстой тэр зүйл хаягдсан. Ингээд тоо толгойгоор мал өссөн боловч нөгөө талдаа л түүхий эдийн чанар байдал маш хүчтэй унасан. Энэ хамгийн сайн явж байгаа нь бол ноолуурын салбар маш амжилттай явж байна, 400 гаруй сая долларын экспорт. Энийг нэг дээш нь тэрбум доллар хүргэх бололцоо байна.

Нөгөө талаар махны малын тоотой холбоотойгоор махны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, экспортыг дэмжих ажлууд нэлээн идэвхтэй хөнгөлөлт чөлөөлөлт, хязгаарлалт квотыг бүгдийг нь тэг болгоод явж байна. Энэ 300 гаруй сая долларын экспортод даваад явж байна. Энийг бол 500 сая долларт хүргэх бас бодитой бололцоо байгаа. Тэгэхээр Цагаан алт хөтөлбөрийнхөө хүрээнд бид ноос ноолуур, арьс шир дээрээ төвлөрч байгаа.

**Х.Булгантуяа:** Жаргалсайхан гишүүн тодруулъя.

**Д.Жаргалсайхан:** Аль аймагт, аль сумд яг ямар үйлдвэрүүд байгуулагдах вэ гэж?

**Х.Булгантуяа:** Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** МАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах гол үйлдвэрүүд жишээлбэл арьс ширний салбар гэхэд 40 гаруй үйлдвэр Улаанбаатар хотод төвлөрч байгаа. Энэ нь Эмээлт парк дээр төвлөрөх байх.

Дархан бол гол ганц арьс шир гэлтгүй манай хөнгөн үйлдвэрийг боловсруулалт хийх, хөнгөн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, хөнгөн үйлдвэрийг төвлөрүүлэх, Дарханы хөнгөн үйлдвэрийн парк, Дарханы хүнсний үйлдвэрийн парк гэсэн 2 том цогцолборыг Дархан хотод төвлөрүүлж хийхээр төсөв тооцоо нь явж байна.

Мөн баруун бүсийнхээ түүхий эдийг Ховдод Ховдын ХАА-н парк дээр, мөн Баянхонгорт бас дунд зэргийн хэмжээний бас энэ паркийн зохион байгуулалт ороод ажил нь нэлээн идэвхтэй явж байна. Одоогийн байдлаар ийм Ховд, Баянхонгор, Улаанбаатар, Эмээлт, Дархан гэсэн энэ 4 ажил бол бодитой үр дүн үзүүлэхээр ийм хэмжээнд очиж байгаа.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд.

**Л.Соронзонболд:** Гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрье. Мөн ажлын хэсгийн гишүүдэд бас энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр энэ 14 мега төслийн нэг нь бол энэ хиймэл дагуулын төсөл байгаа. Хөдөө орон нутагт энэ боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулахад, бүтээмж нэмэгдэхэд маш их чухал үүрэгтэй гэж ойлгож байгаа. Харин зарим хүмүүсээс тодруулга асуугаад байгаа нь бол энэ хиймэл дагуул хөөргөх энэ старлинк байхад заавал шаардлагатай юу эд нар гэж бол асуудал яригдаж байна. Тэгэхээр энэ талаар яг тодорхой тайлбар өгөхийг бол хүсэж байна 1 дүгээрт.

2 дугаарт болохоор бол энэ хөдөө орон нутагт ялангуяа бүсэд ажиллаж байх хугацаанд бол энэ сум орон нутагт яригдаж байгаа асуудал юу байна вэ гэхээр энэ төрийн болоод төсөвт байгууллагуудын сургууль, эрүүл мэндийн газар, эмнэлэг, тамгын газрын үл хөдлөх хөрөнгүүд элэгдлийн хугацаа дууссан, 40, 50 жил болсон гэдэг асуудал их ярьдаг. Шинээр барилга барьж өгөөч гээд.

Тэгэхээр энэ улсын хэмжээнд энэ нэгдсэн бүртгэл маань ер нь хэр сайн байдаг юм бол? Ер нь одоо бодит байдал нь ямар байгаа юм бэ? Энэ 40 жил болсон гэдэг чинь бүртгэлийнхээ бодлого журмаараа бол элэгдлийн хугацаа нь дуусчихсан, шинэ барилга барих зайлиггүй шаардлагатай болсон байгаа гэж бол үзэж байгаа. Тэгэхээр энэ тал дээр ер нь ямар бодлого баримтлах юм бэ? 2025 онд энэ тал дээр тодорхой ажил төлөвлөсөн зүйл байгаа юу гэж асуумаар байна.

Тэгээд 3 дугаарт нь болохоор бол энэ төсөвт байгууллагууд мэдээллийн технологийн олон систем ашиглаж байна. Эдгээр системүүдээ болохоор бол энэ зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй олон хэлбэрээр л ашиглаад байх шиг байгаа юм. Тэгэхээр бол яг зөвшөөрөлгүй ашиглахын эрсдэл гээд бас олон зүйл байгаа. Тэгэхээр 2025 онд яах вэ төлөвлөгөөг ингээд нарийн харахаар бол яг тодорхой заалтууд бол байхгүй харагдаад байна лээ. Тэгэхээр энэ тал дээр 2025 онд энэ системүүдийг тодорхой зөвшөөрөлтэйгөөр хэрэглэх тал дээр, худалдаж авах тал дээр ямар төлөвлөгөө, төсөв орсон байгаа вэ гэж асуумаар байна?

4 дүгээрт нь бол орон нутагт энэ тойрогтоо ажиллаж байхад бол энэ жижиг, дунд бизнес эрхлэгчид ялангуяа энэ төслийн зээл авах үе шатад орон нутгийн удирдлагаас албан бичиг авах, Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанд хамрагдахад бол маш хүнд сурталтай, удаан байна гэсэн ийм гомдлуудыг бол тавьж байгаа. Тэгэхээр бол энэ жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих энэ төслийн үе шатад эдгээр энэ чиглэлээр тодорхой ахиц дэвшил гаргахаар ямар ажлууд төлөвлөж байгаа вэ гэж 4 дүгээрт нь асуумаар байна.

5 дугаарт нь болохоор бол энэ уул уурхайн компаниуд бол ус ашигласны төлбөрөө бол аймгийн төсөвт бүрдүүлж өгдөг, төлдөг. Харин аймаг нь болохоор бол нөгөө ус ашиглуулж байгаа сумынхаа

төсөвт бол аймгийн төсвөөсөө хуваарилдаггүй асуудал бол манай тойргийн хэд хэдэн сумд бол байдаг юм байна. Тэгэхээр энэ асуудлыг ер нь цаашидаа ямар байдлаар шийдэх ёстой вэ? Энэ тал дээр одоо төлөвлөгөө гаргаж ажиллах тийм зүйлс байгаа юу гэж бол асуумаар байна 5 дугаарт.

6 дугаарт нь болохоор бол энэ цаг агаарын өөрчлөлттэй холбоотойгоор зарим орон нутагт энэ ургамлын үр хаях хугацаа нь бол 14 хүртэл хоногоор хойшилсон нь бол судалгаагаар бол гарч ирж байгаа юм байна. Жишээлбэл Хэнтий аймгийн Дадал сумд бол энэ судалгаа хийгдсэн байдаг юм байна. Тийм учраас болохоор бол энэ хадлан хадах хугацааг бол бас тоо хэмжээгээр хойшлуулах ёстой гэдэг тийм судлаачдын дүгнэлт байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ талаар бол манай улс ер нь цаашидаа ямар бодлого баримтлах юм бэ? 25 онд энэ талаар төлөвлөж байгаа зүйл байгаа юу гэж асуумаар байна?

7 дугаар асуулт маань болохоор бол энэ хогтой холбоотой. Сумын төв, аймгийн төв, тэгээд ер нь аялал жуулчлалын бааз дагаад бол маш их хэмжээний хог хуримтлагдсан байна. Тэгэхээр энэ хогийн асуудлыг ер нь одоо Байгаль орчны яам маань яг шийдэх талаар ямар бодитой ажил хийхээр 25 онд төлөвлөж байна вэ гэж асуумаар байна.

**Х.Булгантуяа:** Эхлээд чанарын шаардлага хангахгүй байгаа насжилт ихтэй байгаа барилга байшингуудын тухай Жавхлан сайд хариулах уу? Барилга, хот байгуулалтын сайд байхгүй байгаад байна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Тэр ус ашигласны төлбөр байна. Өөр хэд хэдэн орон нутгийн шууд орлого болдог ийм татвар хураамжийн орлогууд байдаг юм. Тэрийг буцаагаад

хаана, яаж зарцуулах нь аймгийн Иргэдийн хурлаараа шийднэ, сумын Иргэдийн хурлаараа шийднэ. Тийм учраас аймаг, сумаа төлөөлж тэнд суугаа тэдгээр төлөөллүүдээрээ дамжуулж энэ бодлогодоо хариулт авах хэрэгтэй юм байгаа юм. Улсын төсвөөс дээд шатных нь төсвөөс бол энд оролцдоггүй. Тэгэхээр тэнд л яг аймгийн бодлого, орон нутгийн бодлого хэрхэн яаж хэрэгжиж байгаа тэр дагуу л яв даг ийм зүйл юм байгаа юм шүү. Тэгэхээр иргэдийг өөрсдөө сонгож байгаа сумынхаа төлөөллүүдтэйгээ энэ асуудлаа сайн ярилцаж, ойлголцож ард иргэдтэйгээ уулзаж, тэр хүмүүс нь даалгавар авч ингэж явж байх хэрэгтэй. Ганц энэ орлого ч биш малын хөлийн татвар байна. Бас яг ижилхэн. Орон нутагтаа орлогоо аваад л шууд тэндээ өөрсдөө мэдэж зарцуулдаг гэх мэт хэд хэдэн томоохон орлогууд байгаа.

Барилгын насжилтын хувьд хэрвээ элэгдэл нь хэрвээ дууссан болбол түүн дээр мөн Барилгын хуулийн дагуу түүн дээр бүрэлдэхүүн ажиллах ёстой. Хэрэв цаашидаа ашиглах боломжгүй гэвэл ингээд дараагийн арга хэмжээгээ авах ёстой. Ингээд засаж янзлаад их засвар хийдэг ч юм уу, урсгал засвар хийдэг ч юм уу цаашаа ашиглаад явах боломжтой гэвэл мэргэжлийн экспертүүдийн тэр акт дээр үндэслэж, цаашаа хэрхэж яахыг шийдээд явдаг ийм хуультай байгаа.

**Х.Булгантуяа:** Насжилттай барилга байгууламжийн тухай саяын юугаар тийм ээ. Гантөмөр шадар сайд нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Эрхэм гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ сургууль, цэцэрлэгтэй холбоотой бүх мэдээлэл бол Боловсролын яаман дээр нэгдсэн мэдээллийн сан бол байгаа. Энэ сан дээр болбол бүх мэдээлэл төвлөрсөн байдаг юм. Ирэх жил болбол бид нар 90 сургууль, 62 цэцэрлэг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Энэ болбол ерөнхий олон жилийн энэ дунджаас болбол ахисан түвшинд очиж сургууль, цэцэрлэгийн

хангалт сайжирна гэж ингэж ойлгох хэрэгтэй. Ер нь ирээдүйд бид нар энэ сургууль, цэцэрлэг болоод бусад энэ төрийн өмчөөр барьж байгаа барилга байшингийнхаа стандартыг шинэчлэх тухай яригдаж байгаа. Бид нар болбол ногоон хөгжил гэдэг зүйлийг тавьж, тэрийг хийж явахгүй болбол манай энэ дулаан, цахилгаан болоод бусад энэ урсгал зардал болбол ер нь ирээдүйдээ бас дийлдэхээргүй харагдаад байгаа юм. Тэгэхээр бид нар бол дулааны хэмнэлттэй сургууль, дулааны хэмнэлттэй цэцэрлэг гэдэг ийм жишиг зураг, жишиг төсөл, жишиг хөтөлбөр хэрэгжүүлэхийг хэрэгжүүлэх энэ суурь нөхцөлийг ирэх жил бол бүрдүүлнэ.

**Х.Булгантуяа:** Одонтуяа гишүүн, Одонтуяа сайд хог хаягдалтай холбоотой гээд хэд хэдэн асуултауд асуусан. Одонтуяа сайдын микрофоныг өгье.

**С.Одонтуяа:** Цогтбаатар гишүүн маш чухал асуудал хөндлөө. Энэ байгаль орчныг бохирдуулж байгаа хамгийн том хүчин зүйлийн нэг бол энэ хогийн асуудал байгаа. Би ажлаа аваад энэ Монгол Улсад хогийн чиглэлээр ажиллаж байгаа ААН-үүд үйлдвэрүүдийг бүгдийг нь хүлээж авч уулзсан. Эдгээр байгууллагууд бол 1 дүгээрт энэ хогийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлж өгч болох уу гэсэн. Сая Улсын Их Хурал хуралдаад бид бас их чухал хууль баталсан. Энэ нь боловсруулах үйлдвэрүүдийг үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлнө гээд. Тэгэхээр энэ хог дахин боловсруулах үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжүүд бол тэгээд гаалийн татвараас бүгд чөлөөлөгдөж байна гэсэн үг.

2 дугаар асуудал бол энэ Монголын энэ, сая манайх ногоон, нөгөө ногоон экологид ээлтэй үзэсгэлэн худалдаа гаргасан. Энэ дээр бол Монголын маш олон инженерүүд энэ хог шатаах зуухнуудыг.../минут дуусав/



**Х.Булгантуяа:** Тэгье, Одонтуяа сайдад нэмж микрофон өгье.

**С.Одонтуяа:** Монгол инженерүүд энэ хог шатаах зуухыг төрөл бүрээр зохион бүтээсэн байгаа, энийг нь дэмжээд бас хамтарч ажиллаж байна. Хамгийн гол хогийн асуудлыг шийдэх юм бол төр энийг бүгдийг нь хийнэ гэж бол хүчрэхгүй юм байна лээ. Тэгэхээр тарифыг нь нэмээд, ерөөсөө хувийн хэвшилд бүгдийг нь шилжүүлбэл энэ хамгийн үр дүнтэй гарна. Хувийн хэвшил өөрөө хогоо ангилан ягадаг, тэр хогоо өөрөө мөнгө болгодог, өөр бүтээгдэхүүн болгодог энэ зүйлийг хувийнхан бол маш сайн хийж байгаа. Ийм олон хувийн хэвшилд байгаа. Тийм учраас бид бол нэг өрхөөс зарим газар 2500 төгрөг сарын мөнгө авч байгаа энэ бол дэндүү бага. Тэгэхээр тарифыг нэмж, энэ хувийн хэвшил рүү шилжүүлэх нь хамгийн зохимжтой арга байна. Ер нь би энэ хогийн бүх төхөөрөмжийн дахин ангилдаг энэ үйлдвэрүүдээр явсан. Ерөөсөө манай энэ үйлдвэр бол 20 хувийн хүчин чадалтай л ажилладаг юм байна. Өөрөөр хэлбэл том хогийн үйлдвэрүүд нь байгаад байдаг. Эргээд тэд нарыг нь нөгөө.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Соронзонболд гишүүн нэмж тодруулах уу? Соронзонболд гишүүн нэмж тодруулъя.

**Л.Соронзонболд:** Би нөгөө хиймэл дагуултай холбоотой бас нөгөө нэг энэ хадлангийн хугацаа, үр тариа, юу ургамлын үрээ хаях хугацаа хойшлогдсон гэж асуусан шүү дээ. Тэгээд нөгөө Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг сайжруулах талаар ямар ажлууд байна вэ гээд. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд нөгөө төсөл авах үе шатад нь орон нутгийн төрийн байгууллагуудын цахимжилт хангалтгүй зүгээр албан бичиг авах гэж маш удааж байна гэдэг эд нар гомдол яриад байгаа байхгүй юу. Тийм учраас энэ талаар асуусан шүү.

**Х.Булгантуяа:** Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** ЖДУ-ийн газар гээд агентлаг манай харьяанд ажиллаж байгаа. Бодлого, үйл ажиллагаанд нэлээн өөрчлөлт орсон. Одоо бол агентлагийн үндсэн үүрэг бол ЖДУ-ийн дэмжих, гадаад арга хэмжээ үзэсгэлэн худалдаанд оролцоход нь туслах, сурталчлах, хөрөнгө оруулалтыг зуучлах, сургалт зохион байгуулах гэсэн үндсэн чиг үүрэгтэй байгаа. Ер нь тодорхой хэмжээний бас санхүүгийн эх үүсвэр Японы олон улсын хамтын ажиллагааны Жайка байгууллагаас анх олгож эхлээд хэрэгжиж байсан ийм нэг зээлийн багц байгаа. Энэний эргэн төлөлт нь жилдээ нэг 20-оод тэрбум төгрөг эргэн төлөгддөг. Энэ эргэн төлөгддөг зээлийг нь арилжааны банкуудаар дамжуулаад 7 хувийн хүүтэйгээр олгож байгаа. Нэг онцлог зүйл бол өмнө нь бол агентлаг өөрөө.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Өмнө нь агентлаг өөрөө эх үүсвэрээ гаргаад зээл олгодог байсан байдал үндсэндээ зогссон. Зөвхөн арилжааны банкаар дамжуулаад, арилжааны банк тэр зээлийг судлаад, эрсдэлээ хариуцаад олгодог болсон. Нийт нэг дээд хэмжээ нь 300 хүртэл сая төгрөгийн зээл олгож байгаа юм байна лээ. Ерөнхий эх үүсвэр өөрөө 20-иодхон тэрбум болохоор үндсэндээ ингээд нэг шалгаруулалтыг нь нэлээн сайн чамбай хийгээд ингээд явуулж байна. Сүүлийн 2 жилийн үр дүнгээр бол эргэн төлөлт их сайжирсан, зээлийн багц нь их сайжирсан ийм мэдээ тайлантай байгаа. Ер нь хүртээмж их муу байгаа.

Зээлийн батлан даалтын сан бол үндсэндээ энэ малчны хоршоонд гаргаж байгаа зээлийг эрсдэлгүй болгох үүднээс батлан даалтын ажлыг нэлээн хийж байна. Өнөөгийн байдлаар нийт 2981 хоршоо 9419 малчны 311 тэрбумын зээлд 230-аад сая төгрөгийн батлан даалт

гаргаад ингээд явж байна. Ирэх оны улсын төсөвт.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Баатархүү сайд хиймэл дагуултай холбоотой асуултад нэмж хариулъя.

**Ц.Баатархүү:** Маш чухал асуудлыг хөндөж байна. Одоогийн байдлаар дэлхий даяар 91 улс өндөр болон нам орбитын хиймэл дагуулыг бол хөөргөсөн байгаа. Өнөөдөр Улсын Их Хурлаар яригдаж байгаа гео орбитын хиймэл дагуул бол 10 гаруй улс албан ёсоор хөөргөсөн. Хамгийн гол давуу тал бол нэг хиймэл дагуулаар Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийг интернэт, холбоо харилцаа, өргөн нэвтрүүлгийн телевизийн бүх үйлчилгээг үзүүлэх ийм хүчин чадал өндөртэй хиймэл дагуул гэж үзэж болно. Старлинкийн хиймэл дагуултай хүмүүс харьцуулж бас асуугаад байх шиг байгаа. Старлинкийн хиймэл дагуулын газрын станц буюу удирдлага нь бол өөр улсад байдаг. Монгол Улс бол энэ өөрөө удирдах ямар ч боломж байхгүй. 2 дугаарт нь бол хил орчмын бүс нутгуудад бол старлинк бол үйл ажиллагаа нь ажилладаггүй. Тийм учраас манай улсын үндэсний хиймэл дагуул бол удирдлагын станц нь Монголдоо байна. Салхитай, шороотой, шуургатай үед малчид нүүхэд ийш тийшээ.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Баатархүү сайд нэмж хариулъя.

**Ц.Баатархүү:** Хиймэл дагуулынхаа сүлжээгээр сургуулийн, төрийн, эрүүл мэндийн, боловсролын энэ үйлчилгээгээ бол тасалдалгүй авах ийм боломж бүрдэж байгаа юм.

2 дугаарт нь нэг зүйлийг онцолж хэлмээр байгаа юм. Хиймэл, гаднын хиймэл дагуулд Монгол Улс жилдээ нэг дунджаар 9,6 сая долларын түрээс төлдөг ААН-үүдтэйгээ нийлээд. Энийг хэдүүлээ 15 жилээр үржүүлэх юм бол 144 сая долларыг бол бид нар ингээд түрээсийн төлбөрт төлдөг. Тэгэхээр

үндэсний хиймэл дагуултай болсноор нийгмийн, боловсролын, эрүүл мэндийн энэ ялгаатай байдал арилна. Байнга нүүж байдаг малчид маань байнгын харилцаа холбоотой байна. Нэмээд эдийн засгийн ийм ач холбогдолтой зүйл гэж гэдгийг хэлмээр байна.

Соронзонболд гишүүн 2 дахь чухал зүйлийг асууж байна. Энэ төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлаар. Зарим нэг аймгууд бол тодорхой төрийн үйлчилгээ дээр аймгийн Засаг дарга нь өөрөө мэдээд нэмэлт ийм шаардлагуудыг бол тавьсан байдаг. Тухайлбал зарим аймагт галын дүгнэлт авахад 5 янзын бичиг баримт шаардаж байгаа бол зарим аймгууд дээр 8 байдаг. Энийг жигдлэх ажлыг бид нар эхлүүлсэн.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахушиг гишүүн.

**Г.Уянгахушиг:** Энэ өдрийн мэнд хүргэе. 4 асуулт байна. 1 дүгээрт болохоороо хөтөлбөрийн нэгийн 3.14 дээр байгаа төрийн болон орон нутгийн өмчит компаниудын талаар байгаа. Энэ дээр асуулт болохоороо төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын засаглалыг сайжруулах талаар ярьж байгаа биз дээ гэдгийг тодруулмаар байна. Яагаад гэхээр хөтөлбөрт нөгөө төрийн өмчийн оролцоотой буюу нөгөө Хөрөнгийн бирж, ЭТТ, тэгээд Төрийн банк гэдэг эд нар маань орохгүй болчихоод байна төрийн өмчит гэхээр. Нөгөө талаасаа яг энэ хөтөлбөрийн энэ заалт дээр болохоор олон улсын жишээлбэл менежментийн багийг оруулж ирнэ гэж байгаа. Энэ нь өөрөө ТУЗ буюу төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа одоогийнхоор явж байгаа тохиолдолд менежментийн багийг хэчнээн сайжруулаад энэ бол үр дүн гарахгүй байх. Тэгэхээр энэ ТУЗ-ийн бүтэц буюу энд төрөөс төлөөлөл орж ирж байгаа дээр нэлээн сайн ажиллах ёстой байх. Энэ дээр бас ямар төлөвлөгөө байгаа бол энэ талаар бас тодруулж асуумаар байна?

2 дугаар асуулт болохоороо хөтөлбөрийн 1.2.14-д байгаа уул уурхайн биржийн тогтолцоог бэхжүүлнэ гэж байгаа. Энэ дээр асуулт нь болохоор одоог болтол хувийн хэвшлийн брокерууд орж чадахгүй байгаа. Гэтэл хууль дээрээ болбол брокероор дамжуулна буюу брокеруудыг оролцуулах боломжийг нь бий болгоод СЗХ-ноос тусгай зөвшөөрлүүдийг нь олгоод тийм ээ, тэрийгээ дагаад хувийн хэвслээс компаниуд хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлээд, тусгай зөвшөөрлөө аваад бүх системийн бэлтгэлээ хангаад, хөрөнгө мөнгөө зараад явж байтал өнөөдрийг болтол брокеруудыг оролцуулах боломжоор хангаагүй байна. Гэтэл энэ хөтөлбөрийн 1.3.12 дээр хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ. Төр өрсөлдөхгүй байна гэсэн атлаа яг энэ хөрөнгийн бирж уул уурхайн бирж дээр заавал оролцох ёстой нэг субъектийгээ одоо болтол оролцуулаагүй байна. Тэгэхээр энэ хөтөлбөрийн хүрээнд тухайн брокеруудыг оролцуулах талаар буюу системийн шинэчлэлтэй холбоотой зардал мөнгө, төлөвлөгөөгөө оруулж байгаа юу? Энэ тал дээр ер нь ямар төлөвлөгөө байна вэ? Ойрхон сонсоход бол журам өөрчлөгдсөн гэдэг юм сонсогдоод байна л даа. Тэгэхээр энэ талаар бас нэг тайлбар авмаар байна.

3 дугаар асуудлын асуултын хувьд болохоор Хүний эрхийн Комисс байртай байх ёстой. Нөгөө талаасаа яг энэ ЗГ-ын байруудад түрээсээр байгаа нь өөрөө Хүний эрхийн Комиссын мэдээлэл хүргэх, олон нийтийн байгууллагуудтай ажиллах, хүмүүстэй яг хүний эрх, эрх нь зөрчигдөөд байгаа хүмүүстэй зөвлөгөө өгч ажиллахад болбол нэлээн хүндрэлтэй нөхцөл байдал ажиглагдсан. Тэгээд тэр утгаараа ХЗБХ-н дээр болбол энэ Хүний эрхийн Комисс өөрөө тусдаа байртай байх ёстой. Тэрнийхээ хажуугаар НҮБ-ын сургалтын байрыг барьж байгуулна гэдэг тэр амлалтаа бас биелүүлээд л явах ёстой гэдэг энийг ХЗБХ-н дээр бол дэмжээд явсан. Гэтэл яг энэ төсөл, энэ

хөтөлбөрийг 25 оны хөтөлбөрийг харахад бол энэ асуудал тусгагдаагүй байна. Мөн түүнчлэн төсөв дээр болбол орж ирээгүй байна. Тэгэхээр энэ яагаад орж ирээгүй юм бол? Энэ дээр бас тайлбар авмаар байна.

4 дүгээр асуудал болохоор ер нь энэ 25 оны хөгжлийн хөтөлбөр гэдэг маань нэг жил яг энэ 25 ондоо л хэрэгжих ёстой үйл ажиллагаанууд байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр яг одоо юу гэдэг юм ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр гэдэг шиг нэлээн ерөнхий тусгагдсан юмнууд харагдаад байна л даа. Тэгэхээр 1 жилд хэрэгжүүлнэ, 1 жилийн хөтөлбөр гэдэг бол яг тухайн жилд жишээлбэл маш том хэмжээний төсөл байлаа гэхэд тэр төслийн яг аль хэсэг нь 25 онд хэрэгжих юм бэ гэдэг юм зүйл чинь энэ хөгжлийн хөтөлбөр дээр тусдаа байхгүй болохоор нөгөө урт хугацааны 4, 5 жилийн хөтөлбөрөөсөө ямар ялгаатай болчихоод байгаа юм бэ гэдэг нэг ийм зүйл байна. Жишээлбэл энэ юун дээр тусгагдсан байна л даа хөтөлбөр дээр. 1.3-ын байж байгаарай, тийм хотод хэрэгжүүлэх.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Уянгахыг гишүүн нэмээд тодруулах дээр асуулт асуучхаарай. Энэ нөгөө санхүүжих дүн гэдэг нь их том дүнтэй, яг 20 онд яг хэд нь санхүүжигддэг юм бэ гэж асууж байх шиг байна тийм ээ 25 онд яг тэгж харагдаад байна. Энэ зүүн бүсийг говийн бүстэй интеграциалсан коксожсон гэхэд 175 тэрбум төгрөг энэ ирэх жилдээ тэр чигээрээ санхүүжүүлэгдэх юм уу, үгүй юм уу гэдэг шиг тийм асуултууд байгаад байна. Эхлээд эхний асуултад Жавхлан сайд хариулах уу? Учрал сайд хариулах уу? Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн энэ 14 эрх зүйн реформын нэг бол энэ төрийн өмчийн компанийн засаглал. Тийм ч учраас энийг агуулгаар нь их томоор харах шаардлага бол зүй ёсоор тулгараад байгаа юм. Жишээ нь өнөөдөр энэ статусуудыг нэлээн их ойлгомжтой

болгохгүй бол зарим нь ТӨК гээд ТУЗ-тэй, зарим нь УТҮГ гээд ТУЗ байхгүй. Тэгээд Эрдэнэс Монгол нэгдэл нь өөрөө энэ баялгийн сангийн орлого бүрдүүлэгч байгууллага гэхсэн мөртөө зарим компани УТҮГ-таа ТУЗ байдаггүй ийм үйл ажиллагаа явуулаад байгаа болохоор энийг том зургаар нь нэг реформын шинжтэй зохицуулалт хийхгүй бол үнэхээр болохгүй байна.

Тийм учраас Уянгахишиг гишүүн бас тухайн үед тэр ЭТТ компанийн нөгөө Тавантолгой түлшийг орон нутаг руу шилжүүлэх гэж байгаа асуудал дээр бас саналаа хэлж байсан. Үнэхээр Эрдэнэс Тавантолгой компанийн бараг 28 хувь болбол 3,4 сая иргэн эзэмшиж байгаа. Гэтэл өнөөдөр яг бирж дээр листэд биш, тэгээд тэр Үнэт цаасны хадгаламжийн газар билүү тэнд нэг листэд болсон гэсэн нэртэй. Ер нь яагаад энэ уул уурхайн салбарыг 10 хувийг нь та нар стратегийн орд эзэмшиж байвал 10 хувийг нь листэд болго гээд байгаа юм. Үүний гол зорилго бол засаглалыг нь л ангид байлгая, ил тод байлгая, орлого, зарлага нь ард түмний нүдэн дээр байлгая, шийдвэр гаргалтад хувьцаа эзэмшигч нарын оролцоог хангуулъя гэдэг зорилготой л ингэж хийгээд байгаа юм.

Гэтэл ЭТТ компани дээр гэхэд өнөөдөр ч гэсэн бас гишүүд асууж байна. ЗГ шийдвэрлээд, шаардлагатай төслүүдэд хөрөнгө оруулалт хийчихье. Тэгээд ийм байдлаар хэрвээ засаглал руу нь шууд ороод байвал цаашидаа хэн ч хүрч ирээд энэ менежментийг зөв авч явж, үр ашгийг нэмэгдүүлнэ гэж байхгүй. Тэгэхээр яг өнөөдрийн байгаа тогтолцоо дээр бид ямар ч хүн авчраад, авчраад тавьсан хүн чинь нэг ах дүүтэй, амраг садантай, найз нөхөдтэй, нөгөө худ урагтай, тэгээд тэр нь очоод нэг улс төрчийг таньдаг ийм л байдалтай. Тэгэхээр дахиад бид нар нүүрсний сонсгол хиймээргүй байна шүү дээ. Дахиад энэ нэг улс төрчид бас нэг хүнтэй хамааралтай болоод ийм байдал үүсмээргүй байна шүү дээ. Тийм учраас ерөөсөө энэ 3,4 сая

хүнтэй цөөхөн Монголчууд бид 8 янзын боломж байгаа. Үүн дээр бид нар анализ хийж байна. тэр Чилийн Коделко дээр хийсэн, Саудын Арабын компаниуд дээр хийсэн янз бүрийн хэлбэр байгаа. Аутсорсинг менежмент хийх эсвэл. Эсвэл *toplevel*-н менежерүүдийг нь сольж тавих.

Тэгэхдээ энэ дээр гол зарчим нь болбол листэд буюу нээлттэй болж байж л энэ ажил хийгдэхгүй болбол хэн нэг А-г Б-ээр солиод юу ч өөрчлөгдөхгүй, А-г Б-ээр солиод. Тийм учраас олон улсын нээлттэй сонгон шалгаруулалт хийгээд, аль зам нь зөв бэ гэдгийг дүгнээд, үүн дээрээ үндэслэсэн шийдвэрээ гаргаад явах нь зарчмын хувьд нийцнэ. Тэгэхгүй болбол ийм захирал сольж тавиад болбол цаашидаа ямар ч үр дүнд хүрэхгүй юм байна. Тийм учраас.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Учрал сайдад нэмж минут өгье.

**Н.Учрал:** Тийм учраас энэ менежментийг нь *toplevel* түвшинд ч бай эсвэл бүхлээр нь юу гэдэг юм, одоо жишээ нь нөгөө хөрс хуулалт дээр гэхэд л менежментийн гэрээ хийгээд л явдаг шүү дээ тэрэн шиг, энэ бол бүр том агуулга. Тэгэхээр бид нар нээлттэй сонгон шалгаруулж аваад, ард түмний нүдэн дээр ил тод, тухайн менежментийн компани болбол яг ийм үр ашигтай ажиллана, ийм шаардлагуудаа бид нар тавиад, тэр шаардлагуудыг давж байх, тэгээд тайлан баланс, орлого, зарлага бүх юм нь ил тод байх, хувьцаа эзэмшигч нартайгаа нээлттэй саналуудаа тавьж байх, тэгээд тэр ТУЗ-д хувьцаа эзэмшигч нарын оролцоог хангах гээд бүхэлд нь *management structure* хийхгүй болбол цаашидаа болбол бид ер нь гарцгүй болж байгаа юм байна лээ шүү. Тийм учраас хурдхан шийдвэр гаргая л гэдэг зорилгоор ийм ажил руу бид Ажлын хэсэг байгуулаад орсон байна.

**Х.Булгантуяа:** Жавхлан сайд.



**Б.Жавхлан:** Уянгахишиг гишүүний асуултад нэмж хариулъя. Би асуултыг ингээж ойлгосон шүү. Бирж дээр явж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний харилцаа дээр брокеруудыг оруулж болохгүй байгаа юм уу гэж асуусан байх тийм ээ. Тийм, тэгэхээр энэ дээр ЗГ төр оролцоод хувийн хэвшил брокеруудтай өрсөлдөөд байгаа ч юм уу тийм зүйл ерөөсөө огт байхгүй шүү Уянгахишиг гишүүнээ. Энд болгоомжлол байгаа энэ эрсдэлийн болгоомжлол байна. Нэг жоохон хугацаа хэрэгтэй байна, харах хэрэгтэй байна. Энэ бол уул уурхайн биржийн арилжаа чинь өөрөө ч бас жигдрээгүй байна. Зарим гишүүдийн маань асуугаад байгаа энэ бирж дээр үүсэж байгаа энэ доголдууд маань нэг том эрсдэл байгаад байгаа юм. Жишээ нь бүтээгдэхүүнээ зарж байгаа компаниуд чинь бирж дээр арилжаалчхаад, мөнгөө авчхаад, хугацаанд нь хил дээрээ нөгөө бүтээгдэхүүнээ нөгөө энэ зам тээврээсээ асуудлаасаа болоод хүргэж өгч чадахгүй байх жишээтэй. Дундуур нь брокерууд ороод ирвэл энэ эрсдэлийг брокер хүлээж чадах уу, үгүй юу. Дээрээс нь дэнчингийн мөнгөний асуудал байна гэх мэт ийм яг томоохон хэмжээний эрсдэлүүд бас байгаа учир.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Нэмж тодруулах уу? Уянгахишиг гишүүн. ХЭҮК-ын байртай холбоотой бас асуулт байсан. Жавхлан сайд нэмээд хариулчхаач тэгэх үү? Брокерын асуултаа нэмж. Тэгээд ХЭҮК өөрийн гэсэн байргүй байгаа, тэгээд түрээсээр үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ ХЭҮК-ын үйл ажиллагааг доголдуулж байгаа юм биш биз дээ? Тусдаа байртай үйл ажиллагаагаа бие дааж авч явах ёстой гэдэг ийм асуултыг асууж байсан юм Уянгахишиг гишүүнээс.

**Б.Жавхлан:** Тийм, үнэхээр яг шаардлага үүссэн болбол төсвийн ерөнхийлөн захирагч нар энэ асуудлыг ярилцаад, хэрвээ зураг төсөвтэй болбол энийг төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулаад ЗГ-т хүргэх хэрэгтэй. Тэгээд энэ жилдээ бид нар нийтлэг зарчим

бариад аль ч төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр шинэ байшин барилга болбол эхлэхээр зүйлүүд байхгүй байгаа. Том дэд бүтцүүд дээрээ тавьсан байгаа. Үнэхээр шаардлага үүссэн, зураг төсөв нь бэлэн, төсвийн бүтээн байгуулалтын бэлэн байдал хангах юмнууд нь бүрдсэн болбол 26 онд асуудал яригдах болов уу гэж бодож байна. 26 оны төсөв дээр. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Улсын Их Хурлын дарга.

**Х.Булгантуяа:** Тийм Улсын Их Хурлын дарга. Зарим яамд бас яам, агентлаг бас хотоос бас нүүж байгаа учраас Улаанбаатар хотоос бас нүүж байгаа учраас бас төрийн барилга байгууламжийн дунд зарим нэг зохицуулалтуудыг бас хийж болох байх гэж бас бодож байна. Гантөмөр дарга нэмж хариулах уу? Шадар сайд Гантөмөр.

**Л.Гантөмөр:** Гишүүд маань одоо ирэх оны төсвийг хэлэлцэнэ. Тэгээд тэрэн дээр хамаагүй барилга байшин эхлүүлэх тухай төсөл битгий санаачлаасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байгаа. Яагаад гэвэл бид нар ирэх оныхоо хөгжлийн төлөвлөгөөг болбол үнэхээр Монгол Улс нэг тийм айдас хүйдэсгүйгээр юмаа мэддэг, хөгжиж чаддаг, хөгжиж байгаагаа ойлгодог тийм улс болох суурийг тавихыг л бид нар хүсэж энэ төлөвлөлтийг хийж байгаа. Тэгээд энэ төлөвлөлт ер нь ямар, яаж хийгдсэн бэ гэдэг асуулт Уянгахишиг гишүүн асуусан. Энэ бол өөрөө хуультай. Монгол Улсын тухайн оны хөгжлийн төлөвлөгөө болбол 5 жилийн хөгжлийнхөө төлөвлөгөөнд 1 дүгээрт захирагдах ёстой. 2 дугаарт ЗГ-ынхаа үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдэх учиртай. 3 дугаарт Урт хугацааны хөгжлийн бодлого бол батлагдчихсан байдаг. Тэр нь бол Алсын хараа 2050 гээд урт хугацааны хөгжлийн бодлоготой. Тэр хөгжлийн бодлогыг жишээлбэл дэмжсэн тэр бодлогыг.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Уянгахишиг гишүүн болчхов уу тийм ээ? Нэмж тодруулах уу? Уянгахишиг гишүүн тодруулъя.

**Г.Уянгахишиг:** Тэгэхээр саяын 4 асуултын хүрээнд тодруулгуудаа хэлчихье. 1 дүгээрт болохоор Учрал сайдын хэлсэнчлэн өөрөө яг энэ нэр, нэршил, томъёолол энэ бүх юм ерөнхийдөө өөрчлөгдөх ёстой. Гэхдээ яг өнөөгийн байгаагаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой гэж тусад нь ялгачихсан байгаа. Тэгэхээр энэ дээр хөтөлбөр дээрээ дан төрийн өмчит гэхээс илүүтэйгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой гэж оруулаасай гэдэг хүсэлт байгаад байгаа юм. Тэгэхгүй бол нөгөө төрийн өмчийн оролцоотой компаниуд дээр ч гэсэн засаглалын нөхцөл байдлаас муу засаглал гэж хэлж болно л доо. Төрийн оролцооноос хамаараад энэ менежментийн баг өөрөө ажлаа сайн хийж чадахгүй нөхцөл байдал үүсээд байгаа юм. Жишээлбэл Хөрөнгийн бирж гээд л тэгэхэд чинь ТУЗ нь өөрөө угаасаа төрийн төлөөлөлтэй байж байдаг. Тэгэнгүүт ТУЗ дээр шийдвэр гаргалт уддаг, ТУЗ хуралдахгүй байдаг гэх мэтчилнээс шалтгаалаад нөгөө гүйцэтгэх захирлаа томилох гэхээс авхуулаад.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Эхлээд хариулт авч байж шаардлагатай гэж үзвэл нэмж тодруулж болно Дэгийн тухай хуулиар. Учрал сайд нэмж хариулах уу? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Монгол Улсын хөрөнгийн биржийн 34 хувь нь листэд болсноор үйл ажиллагаа менежментийн хувьд бол харьцангуй олон нийтийн хяналт, хувьцаа эзэмшигчдийн хяналт шаардлага доор ороод жишээ нь ашигт ажиллагаа нь ч хүртэл нэлээн сайн нэмэгдсэн. Дээрээс нь түрүүний бид нар брокертой холбоотой юман дээр нэмж хариулахад энэ бол өөрөө хар даа брокертой арилжаанд оролцож болно, брокергүй ч шууд биржтэйгээ харилцаж

болно ийм сонголттой. Одоо ч гэсэн сонголттой байгаа шүү дээ. Хэд хэдэн арилжаанууд нь брокероороо дамжсан байна лээ. Үгүй ээ байгаа, хэд хэд байгаа, та байгаа. Тэгээд энэ чинь болбол ер нь сонголттой байх хэрэгтэй. Бүтээгдэхүүнээ арилжаалж байгаа компанийн хувьд брокероор дамжих уу, үгүй юү гэдэг сонголттой байх хэрэгтэй. Тэгэхгүй ингээд заавал бүх арилжаа брокероор дамжина гэдэг тийм хатуу зохицуулалт байж болохгүй. Ийм хүчтэй лобби явуулж ерөөсөө бас болохгүй. Бид энд бас тэрийг нь өөгшүүлээд байж болохгүй. Аль болох нээлттэй, ил тод.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Уянгахишиг гишүүн тодруулъя.

**Г.Уянгахишиг:** Энэ дээр уг нь Хөрөнгийн бирж болон СЗХ-ноос байвал яг тодруулгыг нь хэлчих байхгүй юу. Ерөөсөө хувийн хэвшлийн брокеруудыг оруулж эхлээгүй байгаа шүү. Тэгээд түүн дээр нөгөө систем яасан ийсэн гээд янз бүрийн тайлбарууд байгаа юм. Тийм учраас би тэр тайлбарыг авах гээд байсан юм.

Нөгөө талаас яг 3 дахь асуултын хүрээнд нөгөө байр сав гэдэг юм яригдсан шүү дээ. Түүн дээр энд Хавдрын эмнэлэг ч гэсэн бас яригдаж байгаа зүйл. Яагаад гэхээр зураг төсөл, газар нь шийдэгдчихсэн байдаг, зураг төслийнх нь төсөв юм гарчихсан, зураг төсөл нь бий болчихсон байж байдаг. Гэтэл тэр өөрөө барилгын ажлууд нь эхэлдэггүй, төсөвтөө суудаггүй тийм төслүүд байгаад байна. Тэгэхээр жишээлбэл энэ иймэрхүү ажлуудаа ингээд төсөвтөө суулгаад, хөтөлбөртөө оруулаад явж болдоггүй юм уу гэдэг санаа байсан. Тэр 1 дүгээр нээлттэй компанийн тэр 1 дүгээр асуудал дээр буюу төсөл хөтөлбөрүүдийн хувьд жишээлбэл хотод хэрэгжих төсөл хөтөлбөр байгаа шүү дээ. Нөгөө замууд, том замын төслүүд байж байгаа. Одоо энэ жишээлбэл.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Эрдэнэбүрэн сайд саяын асуултад хариулах уу? Одоо нэмэлт гэж байхгүй, та 2 удаа 1, 1 минутаар л тодруулах боломжтой. Тэгвэл эхлээд Жавхлан сайд хариулъя. СЗХ-ноос хүн байхгүй байгаад байна уу? Тэгвэл Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Уянгахишиг гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье. Тэр биржээр жишээ нь тэр TDB Капиталд нэг нүүрсний арилжаа дээр орсон гэж мэдээ ирж байна. Голомт капитал мөн саяхан холбогдчихсон байгаа гэсэн ийм мэдээлэл ирж байна. Тэгэхээр ер нь ороод л байгаа юм байна шүү. Та мэдээллээ аваарай.

Харин нэг зүгээр дутуу мэдээлэл үлдчих гээд байна. Жишээ нь тэр Хавдрын 2 дугаар эмнэлэг дээр болбол ЗГ бидний хувьд болбол энийг бол бүрэн дэмжиж байгаа, аль болох энийг байшинг нь эхлүүлчих гээд л ноднингоос хойш үзээд байдаг. Ноднин бүр төсвийн хэлэлцүүлгийн үеэр зураг төсөв нь бэлэн болоогүй байсан ч гэсэн зураг төсвөө хийгээд, мөнгө нь тавигдчихсан. Дээрээс нь энэ ажлыг эхлүүл гээд Их Хурал дээр хэлэлцээд бүр 10 тэрбум төгрөг тавьсан шүү дээ. Гэтэл сая ингээд 9 сарын 1-нд бид төсөв өргөн барихад зураг төсөв нь бэлэн болоогүй. Зураг төсөв нь бэлэн болоогүй байхгүй юу. Тендер нь зарлагдсан. Саяхан 1 компани шалгарсан юм шиг байна лээ. Тэгээд тэр нь бэлэн болоогүй, одоо ч бэлэн болоогүй байгаад байна. Түүн дээр болбол маш.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Эрдэнэбүрэн сайд нэмж хариулъя.

**Р.Эрдэнэбүрэн:** Уянгахишиг гишүүн болохоор ингэж асуугаад байна л даа. Энэ томоохон төслүүдийг ялангуяа энэ 2.2.19 дээр энэ замын төслүүдийг хэрэгжүүлнэ гэхчхэн байна. Энэ чинь нэг жилдээ дуусах юм уу гээд тэгж байна. Үнэхээр бас санал нэг байна. Хэрэгжүүлнэ гэдэг энэ үгийг нөгөө хэлэлцүүлгийн явцад

засах хэрэгтэй байх. Тухайлбал энэ дээр 3 замын 3 төслийг заачихсан байгаа 2.2.19 гээд. Шинэ тойрог авто зам болбол сая тодотголоор ТЭЗҮ, зураг хийгдэнэ гээд ингээд явж байгаа. Тэгэхээр энэ ондоо багтаагаад зураг төсөв нь хийгдээд ингээд явах ажил. Туулын хурдны зам болбол зураг төсөвтэй, 14 оноос конценц зураг нь гараад ингэж явсаар байгаад сая бол зураг төсөв нь батлагдчихсан. Одоо ингээд 11 сард барих-ашиглах-шилжүүлэхээр тендер нь зарлагдаж байгаа. Нисэхийн хурдны зам засвар энэ гүүрний байгууламж болбол зураг төсөвтэй, хотын төсвөөр хийгдэх ийм ажил байгаа юм.

**Х.Булгантуяа:** Эрдэнэбүрэн сайд нэмж хариулъя.

**Р.Эрдэнэбүрэн:** Энэ ажлуудаа энд ингээд ерөнхий үгээр хэрэгжүүлнэ гэхчхэн байна гэж асууж байна л даа. Тэгэхээр энийг хэлэлцүүлгийн явцад засаад, эхлүүлнэ ч гэдэг юм уу, илүү тодорхой болгоё гэж хэлмээр байна.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Дашицэрэнгийн Энхтүвшин.

**Д.Энхтүвшин:** Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Хэдэн асуулт байна. 1 дүгээрт нь энэ төсөл дээр нэлээн хэдэн кокс химийн үйлдвэртэй холбоотой 2 төсөл бараг 400-д хагас тэрбум, хагас их наядын хөрөнгө оруулалтын дүн тавигдсан байна. Тэгээд энэ кокс хими, тэгээд гангийн үйлдвэр, газрын тос гэх мэтчилэнгээр Монголд үйлдвэрлээд дотоодын хэрэглээг хангана гэсэн ийм хэдэн төслүүд энэ 14 төсөл дээр байгаа юм. Тэгээд энэ төслүүдийн би энэ дээр тодорхой асуумаар байна. Кокс химийн үйлдвэр дээр жишээлбэл юу экспортолно гэж байгаа юм, 1,5 сая тонноо гэж байсан. Тэгэхээр энэний өртөг нь жишээлбэл боломжит зах зээлийн нийлүүлэлтийн өртгийн муруй дээр аль хавьцаа нь байришиж байгаа вэ? Дээр нь энэ арматур Монголд зарна гэж байгаа. Тэгэхээр энэ арматурын үнэ нь өртгийн

муруй дээрээ бас яг л 50 байгаа. Өөрөөр хэлбэл өрсөлдөх чадвар бас ямар байгаа гэдгийг харахгүй болбол одоо жишээлбэл бид нар дотооддоо үйлдвэрлэл дэмжинэ гээд цемент ч юм уу, гурил ч гэдэг юм уу үйлдвэрүүдийг дэмжинэ гээд тэгсэн мөртөө өртөг өндөр байна гээд гаднын зах зээлүүд дээр бас ингээд харьцуулж харж байгаа. Тэгэхээр энэ бодлогуудыг тодорхой болгохгүй бол эдгээр хөрөнгө оруулалтуудад заримыг нь болохоор төр, хувийн хэвилийн түншлэлээр гэгчихсэн байсан. Тэгэхээр энэ дээр эргэлзээ төрөхөөр, хөрөнгө оруулалт хийхгүй байхаар ийм хандлагууд байгаа учраас эд нарын өрсөлдөх чадвар дээр тэр өртгийн муруй дээр аль хавьд нь байгаа талаар мэдээлэл хүсэж байна.

2 дугаарт нь болохоор юу Энх-Амгалан сайдаас энэ хүний нөөцтэй холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой асуудал дээр наанаа цаанаа гээд их удлаа. 4 сард ЗГ-ын хуралдаанаар энэ гаднаас ажиллах хүчний энэ хураамжийг 50 хувь хөнгөлсөн гэдэг мэдээ авсан. Гэхдээ одоо болтол яг ингээд энэ нь хэрэгжиж байгаа юм нь бид нар хайгаад олсонгүй. Эсвэл өөр газар байгаад байна уу? Тэгээд энийг байгаа болбол илүү тодорхой яг хаана байгааг нь хэлж өгөөч. Бид нар ерөөсөө хайгаад олохгүй байна. Яамныхнаас асуугаад яг тодорхой эргэж хэлье гээд хэлэхгүй байна. Тэгээд хэрвээ гараагүй байгаа болбол энэ чиглэлээр арга хэмжээ авч өгөөч гэж хүсмээр байна. Тэгэхээр энэ жишээлбэл гаднаас орж ирж байгаа энэ олон том төслүүд байна, ер нь бол ажилтангүй боллоо, зогслоо гэдэг асуудлууд бол эрчтэйгээр ААН-үүдэд тулгарч байгаа том асуудал байна.

Дээр нь Улсын Их Хурлын энэ бид нарын хэлэлцэж байгаа хууль маань болохоор хуулиа зөрчиж байгаа. Тэгэхээр энэ хуулийн 5 сарын 25-нд Улсын Их Хуралд ЗГ өргөн барих ёстой байсан. Тэгээд энэтэй холбоотой хуулийн хариуцлага гэдэг заалт дээр 24.5 дээр болохоор хариуцлага тооцохоор байгаа. Тэгэхээр энэ дээр хууль хугацаандаа өргөн

бариагүйгээс болоод ямар нэгэн хариуцлага тооцсон асуудал байгаа юу, үгүй юү? Энэ талаар бас мэдээлэл өгөөч гэсэн.

**Х.Булгантуяа:** Эхлээд Эдийн засаг, хөгжлийн яам хариулах? ТНБД Батхүү дарга, 6 номерын микрофон ажлын хэсгийн.

**И.Батхүү:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. ЗГ-аас Монгол Улсын хөгжлийн 2025 он жилийн төлөвлөгөөг хаврын чуулганы үеэр хуулийн хугацаанд нь тухайн үед өргөн барьсан байгаа Улсын Их Хуралд. Улсын Их Хурал сонгуулийн үр дүн шинэчлэн шинээр байгуулагдсантай холбоотой өргөн барьсан хуулийн төсөл нь хэлэлцэгдэхгүй буцаагдсан байгаа ийм хуулийн асуудал үүссэн. Саяын таны дурдсан нүүрс, хими, кокс хими, гангийн цогцолборын төслүүдийг бол Эрдэнэс Монгол компанийн компани хариуцаж хэрэгжүүлэх төлөвлөгөөг нь ажиллаж байгаа. Тэгэхээр Эрдэнэс Монгол компаниас хариулт өгье.

**Х.Булгантуяа:** Эрдэнэс Монголоос ямар хүн байгаа юм бэ, хүн байгаа юм уу? Ажлын хэсгийн 19 номерын микрофон.

**С.Наранцогт:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Эрдэнэс Монгол нэгдлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд бол 6 стратегийн ордоо түшиглээд боловсруулах үйлдвэрлэлийн цогцолборыг үйлдвэр технологийн паркийн загвараар хөгжүүлэх ийм стратеги гаргаад, энэний хэрэгжилтийн ажил эхэлж байна. Бид нар бэлтгэл ажилдаа ингээд ороод явж байгаа. Тэгээд энэ дотор орсон 4 төсөл бол энэ 14 мега төслийн жагсаалтад орсон байгаа юм. Кокс хими, химийн үйлдвэрийн нүүрсний 2 парк, нэг нь Багануур, нөгөөх нь бол Тавантолгой дээр гангийн үйлдвэр, зэс боловсруулах үйлдвэрийн цогцолбор гээд.



Тэгэхээр энэ үйлдвэрүүдийн хүчин чадлын эхний энэ тооцооллуудыг бол ер нь бид нар 2030 он хүртэлх Монгол Улсын импорт болоод бүтээгдэхүүн хэрэглээ дээр тулгуурлаж ингээд ерөнхий тооцоог гаргаад, энэ дээрээ тулгуурлаад боловсруулах үйлдвэрийн гинжин хэлхээг үүсгэх ийм ерөнхий төлөвлөгөөнүүд нь хийгдээд дууссан. Энэ ерөнхий төлөвлөгөөг одоо экспертүүд болоод холбогдох яамнуудын санал авах түвшинд ингээд ажиллаж байгаа юм. Энэний дараа бол таны асууж байгаа энэ өрсөлдөх чадварын үнэлгээг бол энэ бүх төсөл дээр хийгдэнэ. Нийтдээ бол 62 дагалдах үйлдвэрүүдийн энэ төсөл гарчихсан байгаа. Энэ болгон дээр бол яг энэ өрсөлдөөний, энэ хөршийн зах зээлийн үнэ, энэ дээр өрсөлдөх чадварын үнэлгээ гэж хийгдэнэ. Яг энэ үнэлгээ дээр үндэслээд бол тэр хугарлын цэгүүд нь гарч ирэх учиртай.

Юуны арматур дээр асуусан. Арматурын хувьд бол ер нь ингээд хувийн хэвшил үйлдвэрлэхээр энийг үр ашиггүй байна гэж үзээд үйлдвэрлэхгүй байгаа юм. Тэгэхдээ л бол бид нарт орон сууц бүтээн байгуулалтад бол зайлшгүй арматурын үйлдвэрлэл хэрэгтэй байгаа. Тэгэхээр Эрдэнэс Монголын нэгдлийн компаниудын үндсэн барьж байгаа стратеги бол хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй. Нэгэнтээ уурхай бол бид нарын харьяанд байгаа учраас бид нар аж үйлдвэрийн үндсэн түүхий эд буюу ган бэлдэц ширмийг үйлдвэрлээд, дээр нь энэ улсын хөгжлийн бодлогод тусгасан бүтээн байгуулалт хэрэгтэй байгаа, хувийн хэвшил авч явахад хүндрэлтэй ашиг багатай байгаа хэдхэн тодорхой үйлдвэрлэлүүдийг авч явна гэж байгаа. Энэ дээр бол арматурын үйлдвэрлэлийг бол төрийн өмчийн компани өөрөө.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Энх-Амгалан сайд хариулах уу? ЗГ-ын тогтоолтой холбоотой. Тэр legalinfo дээр одоо хүртэл тавигдаагүй байна лээ албажиж.

**Л.Энх-Амгалан:** Тэгээд яг legalinf дээр тавих нь болбол яг шууд ЗГ-ын юу биш биз дээ тийм ээ. Энэ тогтоол Энхтүвшин гишүүнээ энэ 24 оны 4 сарын 10-ны өдрийн энэ ЗГ-ын тогтоол ингээд батлагдчихсан. Энэ тогтоол. Энэ тогтоолоор болбол эдийн засгийн 21 салбараас 16 салбарыг нь квотгүй буюу хязгаарлалтгүй болгочихсон байгаа. 2 дугаар асуудал болбол нөгөө юуны энэ 16 салбар дээр хязгаарлалтгүй орж ирэх энэ гадаадын ажиллах хүчний төлөх төлбөрийн юуг чинь бид нар 50 хувиар хөнгөлчихсөн энэ тогтоол бол хүчинтэй байгаа. Тэгээд харин яагаад манай энэ ААН-үүд энэ боломжуудаа ашиглахгүй байгаад байгаа юм бол гэдэг бас нэг асуудал байгаа 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал болбол бид нар энэ намрын чуулганд бараг ер нь ирэх сар гэхэд бид нар энэ Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд байгаа нэг ийм хязгаарлалтууд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хязгаарлалтуудыг бид нар цуцлах ийм хуулийн төслийг өргөн барина. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд маань бол энийг хурдан баталж өгөөрэй гэж хүсэж байгаа юм. 2 дугаарт.../минут дуусав/

**Х.Булгантуяа:** Энх-Амгалан сайдад нэмж минут өгье.

**Л.Энх-Амгалан:** Энэ ажиллах хүчний тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийхөө тухай хуулийн энэ хязгаарлалт хийчихсэн энэ заалтуудыг л бид нар яаж байж цуцалж байж энэ нөгөө нэг одоогийн энэ жил олгогдчихсон байж байгаа 16 эдийн засгийн 16 салбарынхаа ажиллах хүчний орж ирэх хэмжээг квотгүй болгох, тэгээд цаашидаа ер нь энэ 16 салбар дээрх энэ ажиллах хүчний төлбөрөө үнэгүй юу яах цуцлах ийм л эрх зүйн үндэснүүд бий болох ёстой юм байна лээ. Энийгээ дамжуулж бид нар ерөнхийдөө энэ одоогийн байдлаар бас нэг байгаа том хүнд суртал болбол энэ ажиллах хүчний зөвшөөрөл авахад маш их асуудал байдаг юм байна. Бүтэн 2 сар

зарцуулдаг юм байна. Тийм учраас бол яг энэ Ажиллах хүчний энэ шилжилт хөдөлгөөний тухай хууль дээр байгаа энэ зөвшөөрөл олгож байгаа энэ процессуудыг бид нар автоматжуулах, хүнээс хамааралгүй болгох, энэ хүнд суртлын энэ юуг арилгаж байж яг Монгол Улс гаднаас ажиллах хүчин оруулах энэ асуудал дээр нэлээн томоохон ийм зоригтой ийм шинэчлэл хийгдэх хийгдэнэ гэж би харж байгаа энэ намрын чуулганаар.

**Х.Булгантуяа:** Энх-Амгалан сайд энэ нөгөө *legalinfo* чинь хөтөлж авч явах нь ХЗДХЯ-ны Хууль зүйн үндэсний хүрээлэн дээр байгаа шүү дээ. ЗГ-ын тогтоол *legalinfo* дээр тавигдахгүй болохоор хувийн хэвилийнхэн яаж авч үзэх вэ дээ. Тэгээд Энхтүвшин гишүүн надаас бас олон удаа асууж байсан. Тэгээд *legalinfo* дээр тавигдахгүй болохоор хувийн хэвшил ерөөсөө олж мэдэх гүй байна. ЗГ-ын тогтоолын төслийг нь олж харахгүй байна гээд. Учрал сайд Хэрэг эрхлэхээс энэ ЗГ-ын тогтоолын төслүүдийг ялангуяа хувийн хэвшил, иргэдэд нэн чухал энэ төслүүдийг ЗГ-ын тогтоолуудыг *legalinfo* дээр тэр даруйд нь тавьдаг. Ялангуяа хөрөнгө оруулалттай холбоотой тогтоолын төслүүдийг Англиар орчуулаад тавьдаг бид нар бас нэг ийм уг нь байх ёстой шүү дээ Хууль тогтоомжийн тухай хуулиараа ч гэсэндээ. Тэгэхээр үүнийг хийхгүй болохоор ингээд хувийн хэвшил мэдээлэлгүй байгаад байна л даа. Тэгээд авч ашиглаж чадахгүй байж байгаад энэ жилийн эдийн засгийн сезон бол ингээд дуусчих шиг боллоо. Тэгэхээр үүн дээр бас анхаармаар байна.

Таны хэлж байгаа үнэн. Гадаадаас ажиллах хүчин авахад Англи хэлний сургалтын төв авахад Боловсролын яамны зөвшөөрлийн хугацаа хүртэл өгдөг гэнэ. Тэгээд тэр нь болохоороо 6 сар хүртэл өгдөг гэнэ. Тэгээд оны сүүлээр ажиллах хүчнийхээ зөвшөөрлүүдийг хөөцөлдөж эхэлдэг гээд ингээд ерөөсөө аль, аль зөвшөөрлүүдийнх нь хайчин дунд

байсаар байгаад 2-оос 3 сарын хугацаатай л гарч байна гэдэг ийм гомдлууд бас байна лээ. Тэгэхээр үүн дээр бас холбогдох сайд нар Хэрэг эрхлэхийн дарга, Энх-Амгалан сайд нар анхаараарай. Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

**Д.Энхтүвшин:** Эрдэнэс Монгол дээр нөгөө кокс химийн үйлдвэртэй холбоотой би яах вэ гайхаад л байна л даа. Хийчхээд хөрөнгө оруулалт жишээлбэл 2 кокс химийн үйлдвэр дээр бараг нийлээд 400, 500-гаад тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын юу энэ төлөвлөгөө дээр байгаа мөртөө одоо өрсөлдөх чадвар нь ямар байх бол, 1,5 сая тонн кокс жишээлбэл өөр зах зээл рүү энэ зарна гэж байгаа юм. Тэгэхээр яах вэ ер нь бол өрсөлдөх чадвар болбол жишээлбэл Хятад бол ямар билээ тэгээд ингээд бодохоор бол бас асуудалтай. Тэгээд яах вэ зүгээр юмаа явуулчхаад дараа нь өрсөлдөх чадвараа судална гэхээр би гайхаад байна л даа. Гэхдээ энэ эхэлж судалсан тоо бас байгаа байх тийм ээ?

**Х.Булгантуяа:** Учрал сайд.

**Н.Учрал:** Эдийн засгийн өсөлт бол яг ард түмний амьжиргаанд шууд нөлөөлөхгүй байгаа бол мэдээж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй байгаатай холбоотой. Тийм учраас энэ Эрдэнэс Монгол нэгдэл дээр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хувийн хэвилийн оролцоог хангуулах чиглэлээр 5 том бүтээн байгуулалтыг хийе гээд өнгөрсөн хугацаанд энэ логистикийн цогцолбор байгуулна гээд ийм зорилт реформыг хэрэгжүүлнэ гэж зорьж байгаа. Энэ хүрээндээ энэ ЗГ-ын энэ үйл ажиллагааны хөтөлбөр дээр ч гэсэн улсын төсвийн хөрөнгө оруулалт шаардахгүйгээр энэ дараах энэ үйлдвэрийн цогцолборуудыг байгуулна гэдгийг болбол тусгаж өгсөн.

Жишээ нь тэр нүүрс химийн үйлдвэр болбол жилд бараг 600 гаруй мянган тонн хөх нүүрс үйлдвэрлэх

Улаанбаатар хотын хэрэглэгчдэд хүргэнэ гэдэг ийм бас зорилтыг дэвшүүлж байгаа учраас цаашидаа болбол зүгээр гол зорилго нь бол яг энэ логистикийн цогцолбор байгуулагдсанаараа болбол бид тэнд хувийн хэвшлийн оролцоог хангуулах гэж зорьж байгаа юм. Яагаад гэвэл Үйлдвэр технологийн паркийн хуулийг Их Хурал баталсан.

**Х.Булгантуяа:** Энхтүвшин гишүүн болчихсон уу, нэмж тодруулах шаардлагатай юу?

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 15 цаг 31 минутаас хуралдааныг даргалав.

**Д.Амарбаясгалан:** Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуултаа асууя.

**Н.Батсүмбэрэл:** Энэ төвлөрлийг сааруулах, орон нутгийг хөгжүүлэхтэй холбоотой асуудлыг л хөндье дахиад. Улаанбаатар хотод хүн амын 60 орчим хувь нь, 60-аас багагүй хувь нь, эдийн засаг ДНБ-ий 60-аас 70 хувь нь, ААН бүтээмжийн 70-аас 80 хувь нь байгаад байна. Тэгээд үүнийг дагаад Улаанбаатар хотод маш их нягтрал, түгжрэл бий болчихсон. Үүнийг задлахын тулд сүүлийн жилүүдэд маш идэвхтэй, эрчимтэй ярьж байгаа. Энэ дээр ЗГ санаачилга гаргаад эхэлчихсэнд их баяртай байна. Энэ ажлыг цааш нь үргэлжлүүлэх ёстой.

Ялангуяа энд Хүнс, хөдөө аж ахуйн яам орон нутаг руу шилжсэн эхний алхам хийгджээ. Энэ ажил цаашаа 2025 онд хэрхэн үргэлжлэх вэ? Өөр бусад яамнууд төрийн байгууллагуудыг явуулахаар хийсэн судалгаа байна уу, төлөвлөгөө байна уу? Түүнтэй холбоотой зардлыг суулгасан уу гэдгийг холбогдох сайд нараас асууя. Мөн ХААЯ бас энэ шилжих хөдөлгөөнтэй холбоотой асуудлаараа ямаршуу ажлууд зохион байгуулж байгаа талаар Энхбаяр сайдыг бас мэдээлэл өгөхийг хүсье.

Тэгээд өчигдөр бас Байнгын хороон дээр ярьж байсан энэ 21 аймгийн төвд байгаа 21 сумыг ер нь ирээдүйд татан буулгадаг юм уу, нэгтгэчихмээр байгаа юм. Яг тодруулаад хэлбэл Булган аймгийн төвд байгаа Булган сум яг ямар хэрэгтэй юм бэ? Тэнд сумын Засаг дарга, сумын Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, Иргэдийн хурлын дарга давхцаж байх шаардлага юу байгаа юм бэ? Иргэдийн хурлын Төлөөлөгч байх шаардлага юу байгаа юм бэ? 21 аймгийн сумын төвийг үзэх юм бол 21 нь Засаг дарга, 21 орлогч, 21 нь Тамгын дарга, 21 иргэдийн Хурлын дарга нийтдээ 84 хүн. Дээр нь хамгийн багаар бодоход 21 аймгийг 21-ээр үржихэд 441 иргэдийн хурлын Төлөөлөгчийг бид нар хэмнэж байна. Ойролцоогоор 530 орчим даргыг хэмнэж байна. Үүнтэй холбоотой холбогдох зардлыг хэмнэж байна. Энэ талаар та бүхэн хийсэн судалгаа юм байна уу? Тэгээд энэ бүсийн хөгжил, бүсчилсэн хөгжил, орон нутгаа хөгжүүлэх асуудал гэж яриад яваад байдаг. Энэ асуудлыг судалсан юм байна уу? Энийг хийснээр бодитойгоор нөгөө сум орон нутаг маань томоор хөгжих, эдийн засгийн хувьд хэмнэлт хийх, дарга даамлын давхардал багасах, бүсийн төвийг бодитойгоор хөгжүүлэх боломж гэж харж байгаа. Энэ дээр хариулт авъя.

**Д.Амарбаясгалан:** Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү. Ажлын хэсгийн 6 дугаар микрофон. Учрал сайд эхлээд хариулъя.

**Н.Учрал:** Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжгийн асуудал болбол Үндсэн хуулийн асуудал. Тийм ч учраас манай улс болбол төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс. Тэгэхээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжгийн асуудлыг болбол Үндсэн хуулиар болбол бид нар шийдэж шийдэх ёстой. Тийм учраас шууд ЗГ энэ асуудлыг шийдээд явна гэж бол ойлголт байхгүй. Гэхдээ энэ хамтарсан ЗГ-ын гэрээ дээр ч гэсэн энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагыг анхан шатанд нь

шилжүүлэх буюу аймаг орон нутагт бие даан хөгжих төсөв мөнгөө бүрдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр болбол ажиллахаа бол бас илэрхийлсэн.

Тийм ч учраас бид бол цаашидаа энэ улс орныхоо 0,3 хувийн газар нутаг дээр түгжирчхээд байгаа энэ төвлөрлийг задлахад энэ 14 эрх зүйн реформ болбол том түлхэц болно гэж зорьж байгаа. Жишээ нь энэ болбол зөвхөн ийм замын түгжрэл гэхээсээ илүүтэйгээр эрх мэдлийн төвлөрөл болчихсон. Тэгээд дүрэм журмын түгжрэл болчихсон. Тэгээд бүртгэл нэртэй олон зөвшөөрлүүдийн гацаа бий болчихсон. Тэгээд ингээд хороо анхан шатанд иргэддээ үйлчилгээ үзүүлэх нэрийдлээр өнөөдөр очер дараалал нь үүсчихсэн. Төр нэг сувгаар ярьж чадахаа больчихсон. Тэгэхээр энэ болбол зөвхөн замын түгжрэл гэхээсээ илүүтэйгээр энэ эрх мэдэл, дүрэм журмын түгжрэл. Тийм учраас энэ төрийн албаны реформ, энэ төрийн өмчийн компанийн засаглалын реформ, энэ зөвшөөрлийн тогтолцоог бас амилуулах энэ асуудлууд болбол бүхэлдээ энэ Улаанбаатар хотод үүсчхээд байгаа түгжрэл гацааг арилгахад том нөлөө үзүүлнэ.

Тийм ч учраас энэ 14 мега төслийг хэрэгжүүлэх болбол мэдээж экспортын орлогыг нэмэгдүүлнэ. Нийслэл дээр хэрэгжүүлэх гэж байгаа 14 энэ мега төсөл болбол яг түгжрэл, төвлөрлийг л задлах л ийм зорилготой. Энэ ч утгаараа энэ төрийн үйлчилгээний нэгдсэн цогцолбор буюу энэ яам, агентлагуудыг болбол бид нар үе шаттайгаар энэ Улаанбаатар хотын дагуул хотод тооцогдож байгаа Шинэ Зуунмод хот дээр нүүлгэн шилжүүлэх ажлыг хийе гэдэг зорилгоор ирэх оны төсөв дээр санхүүжилтийг нь тавьж өгсөн. Тийм учраас цаашидаа болбол бид нар Улаанбаатар хотын хаана ч яам, агентлагууд байришиж болно шүү дээ. Тийм учраас Нийслэлийн эрх зүйн байдлын хуулиар ч тэр энэ Улаанбаатар хотын дагуул хотод тооцогдож байгаа энэ шинэ

Зуунмод хот дээр яам, агентлагуудыг шилжүүлэх ажлыг хийх юм болбол энэ бас Улаанбаатар хотод төвлөрөөд байгаа, түгжрээд байгаа энэ гацаа саадыг болбол арилгана.

Тийм учраас ер нь энэ нийслэл дээр хэрэгжих гэж байгаа бүтээн байгуулалтуудыг урагшлуулах, тэр GoMongolia гүүр, энэ туннел, энэ тойрог замууд энэ бүтээн байгуулалтын ажлууд болбол өөрөө улс эх орныхоо энэ 0,3 хувь дээр байгаа гацааг л арилгахад чиглэж байгаа. Тийм учраас ХАА-н салбарын зарим салбарууд эхнээсээ энэ тариалангийн бүс нутаг руу нүүж байна гэдэг болбол энэ том хандлагын өөрчлөлтийг бий болгоход Засгийн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Төвлөрлийг сааруулах, энэ түгжрэлийг багасгахын тулд бид зайлшгүй хотын энэ хэт төвлөрөөд байгаа энэ төвлөрлийг сааруулахын тулд хөдөөг хөгжүүлж байж л саарна. Тэрнээс энэ ямар нэг албадлагын арга хэмжээ аваад энэ саарахгүй нь өнгөрсөн 20, 30 жил тодорхой болсон. Хөдөөгийн хөгжлийг хангахад ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн гол тэргүүлэх чиглэл болсон энэ төвийн бүсийг хүн ам шилжин суурьшихад, ажил хөдөлмөр эрхлэхэд, ажлын байраар хангахад хамгийн бололцоотой таатай гэж үзэж байгаа. Энд аж үйлдвэрийн паркууд болон бусад бодлогын хөрөнгө оруулалт нэлээн төвлөрнө. Учир нь өөрөө энэ газар тариалан үйлдвэрлэлийн 96 хувь энэ бүс нутагт байгаа. Мөн аж үйлдвэр дэд бүтцийн хамгийн таатай хүний нөөцтэй ийм бүс нутаг. Иймд энэ бодлогыг Улсын Их Хурал, ЗГ-ын шийдвэр гараад Хөдөө аж ахуйн яам хэрэгжүүлж байна. Тодорхой нүүлгэлтийн зардал төсөвт суусан, өргөн барьсан. Тэр хүрээндээ зохион байгуулалтыг хангаад.../минут дуусав/



**Д.Амарбаясгалан:** Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү, ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

**И.Батхүү:** Батсүмбэрэл гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Энэ хаврын чуулганаар Улсын Их Хурлаар батлагдсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулахдаа бүс, орон нутгийн онцлог, байгалийн нөөц баялаг, дэд бүтэц, эдийн засаг, нийгмийн чадавхыг харгалзаад ер нь 20 гаруй шалгуур үзүүлэлтээр нийтлэг шалгуур үзүүлэлтээр боловсруулж, тооцоо судалгааг гаргаж, 90 байрилыг тодорхойлсон байгаа. Товчхондоо хэлэх юм бол энэ 90 байриил дээр аливаа их хөрөнгө оруулалт хийх нь эдийн засгийн хувьд хамаагүй илүү үр ашигтай байна гэсэн товчхон дүгнэлт хийж болно.

Энэ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах явцад олон нийттэй хийсэн хэлэлцүүлгийн үеэр бас яг энэ хүн амын нутагшил суурьшилыг Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах талаар санал асуулга авсан байгаа. 266 хүн оролцсон санал асуулгын үр дүнд ер нь энэ 90 төв бүлэг сууринаар нь хөгжүүлэхийг бол дэмжиж байгаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэх, хот, тосгоны зэрэглэл ангиллыг өөрчлөхийг дэмжиж байгаа гэсэн саналууд нэлээн их гарч ирсэн байгаа. Гэхдээ сая Учрал сайд хэлж байсан. Энэ тодорхой хуулийн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн нэмэлт асуулт тодруулна.

**Н.Батсүмбэрэл:** Тэгэхээр энэ бол уг нь их чухал байгаад байгаа юм. Бид нар нөгөө олон яриад байгаа олон дарга нараасаа цөөрүүлж, төсөв мөнгөө хэмнэе гэдэг дээр л хэлээд байгаа санаа шүү дээ. ЗГ-ын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай ч яв цав нийцэж байгаа юм. Тэгээд яг энэ бүсчилсэн хөгжлийг улам боловсронгуй болгох, хөгжүүлэх,

ялангуяа энэ сум орон нутгийг тодорхой үзүүлэлтүүдээр нь шинэчлэн зохион байгуулах чиглэлээр хийгдэж байгаа ажлын хэсэг байгуулчихсан ажлын хэсэг байна уу, ЗГ дээр байна уу, Эдийн засгийн яаман дээр байна уу, Их хурал дээр байна уу? Тэрэнд нь Их Хурлын гишүүд оролцох бололцоо байна уу? Үүнийг тодруулж асууя. Тодорхой хариулт авъя.

**Д.Амарбаясгалан:** Эрдэнэбүрэн сайд нэмж хариулъя.

**Р.Эрдэнэбүрэн:** Өнгөрсөн парламентын 24 оны 6 сард, 5 сард батлагдсан тэр Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийн энэ хэрэгжих хугацаа дөхөж байгаа. 25 оны 6 сарын 1 гээд ингээд явж байгаа. Тэгэхээр тэрэнтэй холбогдуулаад ажлын хэсэг байгуулагдаад, бэлтгэл ажлыг нь хангах ийм ажлын хэсэг болбол байгуулагдаад явж байгаа. Энд Их Хурлын гишүүд оролцох бүрэн боломжтой. Одоогийн байдлаар болбол Алдаржавхлан гишүүн ахлаад явахаар тохиролцоод ингээд явж байгаа. Тийм учраас тэнд бүгд оролцоод явж болно.

Зүгээр яах вэ энэ хуулийн талаар ойлголтоо нэгтгэх болбол шаардлагатай байгаа. Ялангуяа шинэ парламентын гишүүд болбол. Тэгэхээр энэ чиглэлээр хэлэлцүүлэг, танилцуулга тийм ажлууд их хийгдэх байх. Тэгээд орон нутгийн сонгуулийн дараа дахиад энэ орон нутгийн шинээр сонгогдсон удирдагуудыг бас цуглуулж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Ням-Осорын Учрал сайд нэмж хариулъя.

**Н.Учрал:** Батлагдсан хуулийг хэрэгжүүлэх нь ЗГ-ын үүрэг л дээ. Тийм учраас Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль бол парламентаас батлагдсан. Тэгэхээр бэлтгэл ажлыг хангуулахаар бол ЗГХЭГ дээр ажлын хэсэг байгуулж ажиллаж байгаа. 26 оны 1 сарын 1-нээс хэрэгжих ёстой. Тийм учраас бол батлагдсан хуулийг хэрэгжүүлэх үүргийг

болбол ЗГ хүлээж байгаа учраас энэ хуулийн хэрэгжилтийг хангуулж болбол цаашдаа ажиллана. Үүн дээр бас Их Хурлын гишүүдийг бас урьж оролцуулж саналуудыг нь сонсоод явна.

Тэгэхээр Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар болбол нийслэлд нэлээдгүй бас өөрчлөлт реформ хийгдэхээс гадна энэ 21 аймаг дээр орон нутгийн зэрэглэлтэй хотууд байгуулагдах, дээрээс нь энэ орон нутгийн зэрэглэлтэй хотууд төсөв мөнгөө өөрөө бүрдүүлэх ийм эрх зүйн шинэчлэлүүд болбол хийгдэнэ.

**Д.Амарбаясгалан:** Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуултаа асууя.

**М.Энхцэцэг:** Сайн байцаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би 3, 4 асуултаа асууя. Нэгдүгээрх нь болохоор 2025 оны хөгжлийн хөтөлбөр дээр эрчим хүчтэй холбоотой нийт 24 заалт байгаа. Үүнээс гуравхан заалт нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ гэсэн байгаа. Тэгэхээр энэ дээр бусад 21 төслийг гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлнэ. Тэгэхээр эндээс юу харагдаж байна вэ гээд тэгэхээр бид нар ерөнхийдөө гадаадын зээл, тусламжийг олж авахад ямар их цаг хугацаа хүч хөдөлмөр зарцуулдаг билээ. Энийг бүгдээрээ мэдэж байгаа. Гэтэл эрчим хүчнийхээ бүхий л эх үүсвэрийг гадаадын зээл, тусламжийг горьдоод суугаад байвал өнөөдөр бид нар яаж эрчим хүчний эх үүсвэрийн дутагдлаас гарах юм бэ? Тэгэхээр ядаж улсын төсвийнхөө хөрөнгө оруулалтаар нэг бага оврын нар, салхины эх үүсвэрүүдийг барьж болдоггүй юм уу?

Би дөнгөж саяхан Баянхонгор, Өвөрхангай, Архангай гээд аймгуудаар явлаа. Тэр аймгуудыг тэжээж байгаа нэг хэлхээтэй маш насжилт өндөртэй шугам дээр зун засвар орж байна. Өвөл энэ шугамууд дээр бас тулгуур унах асуудал үүсдэг. Тэгэхээр энэ бүхэл бүтэн аймаг маш олон сумууд хөлдөх хэмжээнд хүрэх

ийм цахилгаан хангамжийн хувьд найдваргүй байгаа юм. Гэтэл энэ аймгуудын төвүүдээр нарны эх үүсвэр батарейтай нь тавьж болдоггүй юм уу? Энэний хөрөнгө оруулалт нь маш бага, 16-аас 17 тэрбум. Гэтэл бид нар улсын төсөвтөө маш их хэмжээний замуудыг тусгачихсан байгаа. Тэгэхээр энэ аймгуудынхаа найдваржих юмыг бага оврын. Тэгээд эх үүсвэрүүдийг дандаа гаднын хөрөнгө оруулалтаар зээлээр санхүүжүүлнэ гээд байгаа юм. Тэгэхээр гаднын хөрөнгө оруулалтаар мэдээж том төслүүд явна. Тэгтэл яг улсынхаа төсвийн хөрөнгө оруулалтаар нэг ийм бага оврын бүүр нэн тэргүүний яаралтай байгаа эх үүсвэрүүдээ барьж болдоггүй юм уу гэсэн ийм асуулт байна.

Хоёрдугаарх нь болохоор хамтарсан ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр дээр маш их ажлууд орсон. Тэгэхээр энэ болохоор энэ хөгжлийн хөтөлбөрт тусгагдаж орж ирээгүй байна л даа. Тухайлбал 3.3.38 дээр цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох ийм реформ хийнэ гэж ингэж тусгагдсан. Гэтэл энэ 25 оны төлөвлөгөө дээр тусгагдаж орж ирээгүй. Та бүхэн мэдэж байгаа сүүлийн үед бол цахилгаанаас үүдэлтэй гал түймэр маш их гарч байгаа. Цахилгаан гүйдэл хүн тогонд цохиулж нас барж байгаа. Дарханд нэг айлын 3 хүүхэд гэгчихсэн л байгаа, тогонд цохиулаад л нас барчхаж байна. Улаанбаатар хотод зүгээр эмийн сан руу орох гэж байсан хүүхэд бариулаас бариад л нас барж байна. Маш их хэмжээний хөрөнгө санхүүгийн хохирлыг хүмүүс амсаж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг засах реформыг хийе гээд л бас л хөтөлбөрт орж ирсэн. Өнөөдөр хөгжлийн хөтөлбөр дээр орж ирээгүй ингээд л байж байна.

Дараагийн нэг юм нь болохоор эрчим хүчний тогтворжилтыг хангах гээд 3.3.20 гээд бас заалт ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан, бас энэ ингээд л Хөгжлийн хөтөлбөртөө орж

ирээгүй байна. Та бүхэн мэдэж байгаа эрчим хүчний системийг нэг системдээ гарах богино залгаа нэг шугам тасрахад тэг зогсчихгүй байгаасай, тийм чадвартай байгаасай гэж бид нар хүсдэг. Тэгэхээр энэ чадвар юуны чадвараар, ямар чадвараар тодорхойлогддог юм бэ гэхээр өнөөдөр энэ системд ажиллаж байгаа бүхий л оролцогч талуудын чадавхаар тодорхойлогддог. Тэгэхээр нөгөө сэргээгдэх эрчим хүч, нөгөө ДЦС-ууд яг ямар чадвартай байх ёстой юм бэ гэдгийг цагаан дээр хараар биччихсэн ийм үндсэн бичиг баримт бол сүлжээний дүрэм. Гэтэл өнөөдөр манай тэр дүрэм 2010 он дээр гацчихсан. Энэ дээр сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой ямар ч заалт байхгүй. Тэгсэн мөртөө бид нар тогтвортой ажиллаасай, тэгсэн мөртөө бид нар сэргээгдэхийг олноор холбох юм сан гээд хүсээд сууж сууж байгаа. Гэтэл нөгөө гол үндсэн бичиг баримт нь 2010 он дээр гацчихсан. Тэгэхээр энийгээ орчин үеийн болгож шинэчлээч. Энэтэй холбоотой менежментээ хэрэгжүүлээч, реформоо хэрэгжүүлээч, тогтолцоогоо бий болгооч гээд ЗГ-ынх нь үйл ажиллагааны хөтөлбөр дээр оруулаад өгдөг. Гэтэл 25 оныхоо хөгжлийн хөтөлбөр дээр оруулж өгдөггүй.

Гэтэл энэ ажлууд дээр тэгтлээ их хэдэн тэрбумын хөрөнгө оруулалт зарцуулахгүйгээр хэрэгжүүлээд. Яагаад гэвэл энэ маань өнөөдөр бид нар тогтвортой ажиллах уу, сэргээгдэхийг олноор холбож чадах үү, үгүй юү гэдгийг тодорхойлох үндсэн бичиг баримт. Тэгтэл орж ирэхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр би энэ ийм л асуултуудыг асууя даа. Сонсохгүй байна гэсэн үү?

**Д.Амарбаясгалан:** Энэ микрофондоо жоохон ойрхон ярьсан нь зөв юм шиг байна тийм ээ.

**М.Энхцэцэг:** Тийм үү?

**Д.Амарбаясгалан:** Дахиад асуух уу? Чойжилсүрэн сайд хариулах уу? Тийм ер нь эрчим хүчний салбарын сэргэлттэй

холбоотой асуудлууд яригдаж байна. Чойжилсүрэн сайд хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Голдуу санал хэллээ. Гэхдээ ганц нэг, гуравхан эх үүсвэрийг эрчим хүчний эх үүсвэрийг салбарт улсын төсвөөс гуравхан төсөл хэрэгжүүлэх нь, бусдад юу зээл, тусламжаар хэрэгжүүлнэ гэдэг ийм асуулт, санал ярьж байна. Яг бодит байдал нь энэ. Манай эрчим хүчний салбарын маань төсөвт өртгүүд нэг цахилгаан станц гэхэд чинь 300мвт-ын цахилгаан станц гээд ингэхэд чинь 600 сая доллар, 2 их наяд хүрчхээд байгаа учраас төсөв дээр бүгдийг нь суулгах ийм орон зай харамсалтай нь бага байгаа. Гадаад зээл, тусламжаар болбол юу эрчим хүчний салбарт бол нэлээдгүй олон төрлийн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа ийм байдалтай байгаа нь сүүлийн хэдэн жилд давтагдаж байгаа нь үнэн. Бидний байгаа боломж л энэ гэсэн үг.

2 дугаарт Энхцэцэг гишүүнээ энэ Эрчим хүчний тухай хуулиар 2019 онд өөрчлөлт орсон. Одоо болбол бид нар нар, салхины цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүч юу барьж ашиглалтад оруулъя гэвэл хувийн салбарынхан дунд бол уралдаант сонгон шалгаруулалтын зарчмаар барих ийм эрх зүйн тогтолцоо байгаа. Одоо энэ үүнээс гадна урьд нь 2019 оноос өмнө авчихсан төвийн эрчим хүчний системд 6 нарны станц, 3 салхины станц нийтдээ нийт хүчин чадал нь 245 мянга суурилагдсан хүчин чадал нь ийм сэргээгдэх эх үүсвэрүүд холбоотой байна. Түүнээс гадна 8 нарны станц, 3 салхины станцын тусгай зөвшөөрлүүд авчихсан. Өнөөдөр бид нар хэлэлцээр хийгээд явж байгаа ийм асуудлууд байгаа юм.

Сэргээгдэх эрчим хүчийг холбуулахад дэмжихэд 2 төрлийн бид нарт хүндрэл байна. Эхнийх нь сэргээгдэх эрчим хүч маань тогтвортой цахилгаан эрчим хүч нийлүүлж чадахгүй байгаа учраас эсвэл нар орсны дараа юм уу, эсвэл цас зогссоны дараа тэр хэмжээний

чадлыг хаана нэг газар нөөцлөх учиртай. Энийгээ хийж чадахгүй байгаа учраас бид нар 2019 оноос хойш Монголын эрчим хүчний салбарт болбол тендер зарлаагүй байгаа. Энэ 11 тусгай зөвшөөрөл авчихсан байгаа ААН-үүдтэй бол хэлэлцээр хийгээд явж байгаа. Нарны станцын тухайд 1квт цагийг нь болбол бид нар 10 цент, суурилагдсан хүчин чадлын 20 хувьтай тэнцэх хэмжээний батарей 4 цагийн хугацаанд хадгалах ийм батарейтай байсан тохиолдолд энэ төслийг хэрэгжүүлбэ гэж ярьж байгаа.

Салхины станцуудын тухайд болбол төвийн эрчим хүчний системд нийлүүлэх үнэ нь болбол 8,5 цент, салхи маань өөрөө нарыг бодоход илүү тогтворгүй байгаа учраас 40 хувьтай тэнцэх хэмжээний батарей storage-г хамт барьсан тохиолдолд болбол эрчим хүчний систем нийлүүлье гэдэг ийм шийдвэрийг 2024 оны 4 сарын 22-ны өдрийн Эрчим хүчний сайдын зөвлөлөөр батлаад, ийм шийдвэр гаргаад, хэлэлцээр хийгээд явж байгаа иймэрхүү л байдалтай байгаа. Гол асуудал үнэтэйгээс гадна.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя. Чойжилсүрэн сайдын микрофон.

**Б.Чойжилсүрэн:** Үнэтэйгээс гадна сэргээгдэх эрчим хүч маань цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж чадахгүй болсон тохиолдолд хаанаас энэ чадлыг эх үүсвэрийг нөхөх вэ гэдэг асуудал дээр хамгийн тулгамдсан асуудлууд болоод байгаа учраас сэргээгдэх эрчим хүчийг болбол бид нар нэг дэмжиж сүлжээнд нэмэлт холбуулж чадахгүй байгаа ийм хүндрэл байна.

2 дугаарт энэ хувьсах эх үүсвэрүүдийг системд холбох болбол бас найдваржилтад нэлээн тийм сайнгүй нөлөөтэй байгаа. Түүнээс гадна манай хэрэглээ маань өөрөө өвлийн оргил цагаар 30 хувь хүртэл дээш өсдөг ийм хувьсах чадвартай байгаа учраас системийн

тогтвортой байдалд бас нэлээн анхаарахгүй болбол 2018 онд нэг удаа, 2021 онд нэг удаа Төвийн эрчим хүчний систем тэг зогсолт хийсэн тийм айхтар хүнд нөхцөл байдлууд үүссэн. Азаар бид нар дулааны улиралд энэ тэг зогсолтууд хийсэн учраас гайгүй бага хохиролтой давсан ийм байдалтай байгаа гэдгийг бас.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энхцэцэг гишүүн тодруулж асууя.

**М.Энхцэцэг:** 2 дугаар асуулт буюу тэр цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарч байгаа, цахилгаанд хүн цохиулж нас барж байгаа тэр асуудал нөгөө ЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд суусан мөртөө 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд сууж орж ирээгүй байна. Тэгэхээр энэтэй холбоотой маш их хэмжээний ажлууд хийгдэх ёстой. Энэ ажлыг хийнэ гэж орж ирэхгүй юм уу?

3 дугаар асуулт болохоор тэр эрчим хүчний системийн тогтворжилтыг хангах, сэргээгдэх эрчим хүчийг зөв зохистой хөгжүүлэх нөгөө нэгдсэн сүлжээний дүрэм гээд би та бүхэнтэй уулзахдаа ярьж байсан. Энэ дүрэм өнөөдөр бид нар 2010 он дээр гацчихсан байгаа. Гэтэл энэ маань өнөөдөр систем яг тогтвортой ажиллах уу, сэргээгдэхүүд дээр ямар шаардлагыг бид нар тавьж, эхнээс нь хөрөнгө оруулалтаа тодорхойлохоос нь өмнө тавих юм бэ гэдэг нь маш тодорхой байх ёстой. Тэгэхээр энэтэй холбоотой маш том үйл ажиллагаанууд бас явагдаж байх ёстой. Гэтэл энэ бас үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мөртөө Хөгжлийн хөтөлбөр дээр ингээд тусгагдаагүй орж ирсэн байна. Энэ 2 асуултад хариулаач.

**Д.Амарбаясгалан:** Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Энэ Аюулгүй ажиллагааны дүрэм энийг бол заавал мөрийн хөтөлбөрт суулгасан



гэхгүйгээр ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт суусан бүх арга хэмжээнүүдийг авна, хэрэгжүүлээд явна. Суусан, суугаагүй.

2 дугаарт энэ 2025 оны жилийн төлөвлөгөө боловсруулахад бүгдийг нь ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг нэг жилд суулгах юм болбол хэт нурушингүй байна гэдэг ийм ойлголт Эдийн засаг, хөгжлийн яам дээрээс бид нарт өгсөн учраас зарим нэг зүйлийг нь болбол 25 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт суулгахгүй, төлөвлөгөөнд суулгахгүйгээр хэрэгжүүлээд явна гэсэн ийм байр суурьтай байгаа шүү.

**Д.Амарбаясгалан:**

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууна.

**Л.Мөнхбаясгалан:** Их Хурлын даргаа энэ Нямбаатар гуай хаачсан юм бол Хотын дарга? Энэ хүнээс асуулт асуумаар байдаг. Учрал сайд туслах нь юм шиг өмнөөс нь хариулаад байх юм. Хотод амьдардаг хүний хувьд хотын даргаас юм асуумаар байна.

Хөдөөгөөс сонгогдсон, говийн бүсээс сонгогдсон гишүүний хувьд нэг хэд хэдэн асуудлыг асуух гэсэн юм. Уул уурхай их хөгжиж байгаа, уул уурхай их түрж орсон манай говийн бүсэд мал, малчин 2 амьдрах газаргүй болсон гэдэг гомдол хаа сайгүй байна. Малчид, малчдыг шилжүүлэн нүүлгэдэг, өвөлжөө бууцаа алддаг, тэгээд 5 сая юм уу, 8 сая төгрөг өгдөг. Тэгээд л дахиад юу ч байхгүй болчихдог. Залуу малчид байхгүй болсон. Мал сая хавар хорогдсон. Одоо тэгээд бид нар зээлтэй мал, малчин хоёроо хайхрахгүй байна гэсэн ийм нэг гомдол яваад байгаа юм. Тэгээд малчдын талаар авч хэрэгжүүлж байгаа ажил юу байна вэ гээд сая энэ хөгжлийн хөтөлбөр дотроос яахаар яах вэ байна л даа. Гэхдээ яг хувь хүнийх нь хувьд тэр хүмүүсийг амьдрах орчныг нь яаж хангах юм бэ, малын гаралтай түүхий эдийг үнэтэй болгоё, арьс ширний үйлдвэр байгуулъя эд нар

гээд л ингээд л бид нар яриад байна. Яг залуу малчдыг байлгах, малчин өрхийг тайван амьдруулах, газар нутагтай байлгах асуудлыг малчид их хөндөж байна.

Нөгөөдөх нь Эрүүл мэндийн сайд юм уу, Нийгмийн хөдөлмөрийн сайд хариулах ёстой юм болов уу. Жишээ нь Цогтцэций сумаар жишээ авъя. Энд Цагаан-Овоо гээд баг байдаг юм. 1000 гаруй иргэнийг нүүлгэн шилжүүлсэн. Тэгээд энэ хүмүүс нөгөө нөлөөллийн бүсэд амьдарсаар байгаад астматай, уушгины сүрьеэтэй, хавдартай, сүүлдээ одоо ингээд хүүхэд нь хэвлийдээ устдаг боллоо гэдэг гомдол гаргаж байгаа байхгүй юу. Тэгээд эрүүл мэндийн нөхөн төлбөр гэдэг юм байхгүй байна. Суурьшлын бүсийг шилжүүллээ, тэрний нөхөн төлбөр бол байна. Эрүүл мэндийн нөхөн төлбөр гэж байх юм уу? Уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа иргэд, сумыг яах юм бэ?

Ингээд сумд том уул уурхай байхаараа нутгийн өөрөө удирдах ёс нь бас алдагдаад байна. Жишээ нь Ханбогд сумд Говийн хөгжлийн хурдасгуур Оюу толгой гээд 50 сая доллар өгнө гээд ингээд сан байгуулчихсан. Энэ дээрээ ганц нэгхэн компанийг ингээд тендерт шалгаруулдаг. Тэд нар нь иргэдийн хуралдаа ороод суучихсан. Нутгийн иргэдийн Төлөөллийг ерөөсөө хангадаггүй ийм байдал ажиглагдаж байна. Цогтцэций сумын иргэд бол тэр чигээрээ нөлөөллийн бүсэд амьдардаг. Тэгэхээр энэ нөлөөллийн бүсэд амьдарч байгаа иргэдийнхээ нөхөн төлбөр юм уу юуг нь харж үзэх ёстой юм бэ эрүүл мэндийн байдлаас нь.

Дараагийн асуулт Эрүүл мэндийн сайдаас 2024 оны хөгжлийн хөтөлбөрт орсон Хавдар 2 төсөл яг юу болсон бэ 24 онд? 25 онд дахиад орсон. Гэхдээ бол мөнгө тавигдаагүй байна.

Тэгээд ЗГ-ыг Цогтцэций сумд очиж хуралдаач гэж урьж байна. Яг тэр нөлөөллийн бүсэд нь та бүхэн очоод, тэр уур амьсгалыг нь мэдрээдхээч. Тэнд ямар

их уушгиар өвдөж байна, ямар их тоосжилттой байна. Ерөөсөө говийн аймгууд бас усны эрүүл мэндийн шаардлага хангадаггүй. Тэгэхээр Байгаль орчны сайдаас асууя. Байгаа усаа яаж хайрлаж авч үлдэх үү гүний усаа? Гүний ус доод тал нь 10 мянга, тэгээд 30 мянга, 1 сая жилийн дараа нөхөгддөг. Бид нар Хэрлэн-Тооно, Орхон-Онги усыг авчрах гэсээр байтал энэ газрын гүний усаар уул уурхайдаа хэрэглэсээр байгаад дуусгалаа. Тэгэхээр энэ дээр байгаа усаа яаж хайрлаж, хамгаалж үлдэх вэ? Энэ дээр ямар бодлого байгаа вэ?

Бид нар бүсчилсэн хөгжил рүү ороод Монгол Улсаа бүсчилж хөгжүүлнэ гээд бүгдээрээ ингээд зорьж байна. Гэтэл энд байна шүү дээ жижиг асуудал хаягдаж байна. Одоо та нар намайг жижиг юм л ярина гэж бодож байгаа байх. Цагаан хад суурьшлын бүс тэнд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Мөнхбаясгалан гишүүнд нэмэлт нэг минут.

**Л.Мөнхбаясгалан:** Цагаан хад суурьшлын бүсэд амьдарч байгаа иргэдийн эрүүл ахуй гэж бүр байхгүй. Эмнэлэг нь контейнерт байдаг, та бүхэн тэнд очиж үзвэл үнэхээр нүд эмтэрмээр дүр зураг үзнэ. Бороо орсны дараа бүх модон бие засах газар нь урсаад, тэр цагаан хад суурьшлын бүс тэр чигээрээ балчиг жаваг өмхийд ингээд живчихдэг. Тэгээд бид нар энэ жижиг, жижиг асуудлаа яах юм бэ? Бид нар том асуудлаа яриад байгаа нь сайн. Бүсийн гишүүд ЗГ-ын хэмжээний том, том асуудал ярилаа гээд бид нар өөрсдөө хөөрцөглөөд байгаа хэр нь тэр мал, малчин хоёрын амьдрал, тэр жижигхэн багийн иргэдийн амьдралыг яах уу?

Багш нар хөдөө орон нутагт дутагдалтай байна Наранбаяр сайдаа. Нэг жижигхэн өрөөнд 2 айл амьдарч байна. Эмч нар ч гэсэн яг тэгж амьдарч байна. Тэгэхээр хөдөө орон нутагт боловсон хүчин хангалтгүй байна. Яг

тэрүүгээрээ хүүхдүүдэд өнөөдөр хичээл зааж байгаа багш алга. 9 дүгээр ангийн хүүхэд хичээл зааж байсан сум байна. Би сая очиж үзээд ирлээ.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Энх-Амгалан сайд эхэлж хариулах уу? Нийгмийн асуудлаар. Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан сайд хариулъя.

**Т.Мөнхсайхан:** Тэр хавдрын эмнэлгийн асуудал миний санахын л өнгөрсөн жил ямар нэгэн зураг төсөв байхгүй мөртөө 10 тэрбум төгрөгийн төсөв тавигдсан. Ингээд шаардлагатай дэд бүтэц тавих ёстой төсөв тавигдсан. Тэгээд энэ жил зураг төсвийг нь хийхээр 3 тэрбум төгрөг Эдийн засаг, хөгжлийн яамнаас төлөвлөгдсөн боловч одоогийн байдлаар тендерт шалгарсан компани байхгүй байна. Одоо тендер нь бас дахин зарлагдаад, 10 сарын 17-нд нээгдэх явцтай ийм байгаа. Тэгэхээр зураг төсөв, ажлынх нь зураг төсөв нь эцэслэн гарч батлагдаагүй байгаа зүйл дээр хэдэн төгрөг гэж санхүүжилт тавих ямар ч боломжгүй байна л даа. Хэрвээ энэ зураг төсөв нь батлагдаад, эцэслээд гарчих юм бол ирэх оны төсөвт хэдэн төгрөг тавьж болох юм энэ саналыг би Сангийн сайдад тавина гэж бодож байгаа.

ЭМЯ болон ЭМД-ын сантай холбоотой ямар нэгэн нөхөн төлбөртэй холбоотой санхүүжилт бол манай яаман дээр байдаггүй. Нэн шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой санхүүжилтийг ЭМД-ын сангаас гаргадаг. Тэгэхээр энэ нөхөн төлбөртэй холбоотой энэ асуудлууд маань Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны талаас хариулах байх.

**Д.Амарбаясгалан:** Энхбаяр сайд хариулах уу? Өмнөговьд мал аж ахуйтай холбоотой. Мөнхбаясгалан гишүүний, тэгье Одонтуяа сайд байгаль орчны талаас нь бас хариулъя.

**С.Одонтуяа:** Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр

ЗГ-ын хурлыг энэ Өмнөговьд энэ говийн бүсэд очиж хийгээч гэж маш чухал асуудал ярьж байна. Би санаж байна. Алтанхуягийн ЗГ-ын хувьд бас Өмнөговь аймагт яг элсэн цөлд ЗГ-ын хурал хийж байсан. Тэгээд сая ЗГ-ын хурал хуралдах журмыг боловсруулахад би бас энэ саналыг оруулсан байгаа. Зөвхөн Төрийн ордонд биш бас энэ өөр аймгуудад очиж бас хуралдах энэ саналыг оруулаад дэмжигдсэн байгаа.

Усны асуудал бол үнэхээр маш хүнд ийм тулгамдсан асуудлын нэг. Ер нь улсын төсвөөс сүүлийн жилүүдэд энэ усны хайгуул судалгаанд ерөөсөө мөнгө төсөвлөгдөж тавигддаггүй. Тэрнээсээ болоод бид энэ усныхаа хайгуул судалгааг бас хийж чадахгүй байгаа. Одоо судлагдсан усны хайгуулын хэмжээгээр бол бид тун удахгүй энэ усны.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмэлт минут өгье.

**С.Одонтуяа:** Говийн бүсүүдэд сая би өөрөө Дундговь, Өмнөговьд ажиллаад ирсэн. Ер нь энэ хөв цөөрөм усан сангуудыг бид бас олноор байгуулж, гадаргын усаа бас бороотой үед хадгалах, ашиглах ийм зүйл дээр бол маш их олон ажлыг хийх ёстой. Ингээд манай яамнаас Усны газраас 2024 онд загварчилсан ТЭЗҮ хийгдээд дуусна. Тэгэхээр 25 онд бид бүх аймаг, сумтуудад 333 хөв цөөрөм санаачилгыг өрнүүлэхээр бэлтгэж байгаа. Энэ санаачилгын хүрээнд бол сум болгон ямар ч байсан хөв цөөрөм байгуулах энэ ажлыг хийж байна.

Мөн сая татвараас бас чөлөөлөх нэг чухал заалт гарсан. Байгаль орчноо хамгаалах, хөв цөөрөм байгуулах, усан сан байгуулах, ой мод тарихад татвараас шууд хасагдаж тооцохоор ийм хуулийн төсөл батлагдсан гэдгийг түрүүн бас манай сайд нар хэлсэн. Энэ хөв цөөрөм, ер нь энэ зөвхөн улсын төсөвт найдаад байхаар бас энэ байгаль орчны.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Уул уурхайн бүсэд амьдарч байгаа иргэдийн амьдралын чанарт нөлөөлөл учирч байгаа тухай хөндөж байна. Тэгэхээр Орхон аймаг Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр, Дархан хот Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Шарын гол сум Шарын голын уурхай, Багануур Багануурын уурхай гээд үндсэндээ томоохон суурин газар уурхай яг мөр зэрэгцэн оршиж байгаа. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн судалгаа хийгдсэн байдаг эсэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам уг нь анхаарах ёстой. Хэрвээ тэнд уул уурхайн нөлөөлөл иргэдийн амьдралын чанар болон эрүүл мэндэд нөлөөлж байгаа бол яг тэрийг их сайн судалж та нар анзаараач. Эрдэнэт дээр жишээлбэл ямар нөлөөлөл гараад байгаа юм. Тэнд ямар арга хэмжээ авагдаж байгаа юм, ямар өвчлөл их давамгайлж байгаа юм. Энэтэй холбоотойгоор говийн бүсэд малчдад нөлөөлж байна гээд нэг асуудлыг босгоод ирвэл бүгдээрээ хамтраад тэр нөлөөлөл, өвчин бусад асуудлыг бодлого болгож.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Та ч тодруулах минутаа авчихсан даа. Мөнхбаясгалан гишүүнд нэг минут тодруулж асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Малчдын амьдран суугаад, бэлчээр эзэмшээд, өвөлжөө, хаваржаа, намаржаатай газар нь уул уурхайн бүс түрж эзэмшээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг малчид бид нар тайван амьдармаар байна төрсөн нутагтай гэж байгаа юм. Тэгээд энийг хариуцаад энд тайлбар өгөх яам байхгүй юм уу? Эрүүл мэндийн сайдаа ийм юм тавьсан шүү. Жишээ нь энэ Цогтцэций сумын Цагаан-Овоо сумд энэ бол ингээд батлагдчихсан, эмч авчраад, өөрөө энийг хөөцөлдөөд яваа хүн эмч хүн байхгүй юу. Тэгээд ЭМЯ-нд хандсан. Бид нарыг ингээд шинжилгээ судалгаанд оруулаад өгөөч. Тэгэх юм бол бид нар энэ нөхөн олговрын

асуудлыг хөөцөлдмөөр байна гээд байгаа юм. Хэрвээ танай ЭМЯ-наас энэ асуудлыг нь зохицуулаад, тэр иргэдийг үнэхээр хохирсон гэдгийг нь тогтоогоод өгөх юм бол Эрдэнэс тавантолгой төлбөр төлөхөд бэлэн, Энержи ресурс төлбөр төлөхөд бэлэн гэж байгаа юм. Хэрвээ энэ батлагдах юм бол Монгол Улсад суурьшлын бүсэд амж амьдарч байгаа иргэдийн эрүүл ахуй гэдэг юм яригдана. Говийн бүсэд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:**

Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Золжаргал:** Утаа үнэртээд эхэлсэн. Утаа бол ер нь орон байрны асуудал юм байна. Түлшээр оролдоод айхтар амжилтад хүрэхгүй юм байна гэдгийг нийтээрээ нэлээн хүлээн зөвшөөрсөн болов уу. Тийм болохоор энэ ипотекийн эх үүсвэрийн талаас илүүг гэр хороолол, дагуул хот энэ юунуудад зарцуулна гээд тусгасан шүү дээ. Энэ хөгжлийн төлөвлөгөө дээр байхгүй байгаад байгаа юм. Тэгээд яах вэ энд тэнд ингээд бичсэнийг нь харахаар загвар эрчим хүчний хэмнэлттэй байшингийн төсөл боловсруулна, тэндээ ипотека олгоно энэ тэр гэсэн юм байна. Одоо бол тийм шаардлага байхгүй. Барилгын норм дүрэм шинэчлэгдчихсэн, тэр хүрээндээ хөргөгч дээр наадаг шиг дулааны ийм шошго өгдөг болчихсон. Одоо зүгээр хүн хашаандаа байшин барихад дэд бүтцээс үл хамаараад, төлөвлөлтөөс хамаагүй захдуу уулын орой дээр байгаа хүмүүст нь эрчим хүчний хэмнэлттэй бол ипотека олгож өгмөөр байгаа юм. Тэгэхгүй бол өөр тийшээ энэ мөнгө нь яваад, өөр юм руу яваад байна.

Шинэ суурьшлын бүс гээд жишээлбэл хавсралт 2 дээр байгаа дэд бүтэц, инженерийн дэд бүтэц нь 343 тэрбум төгрөг болж байна нийлбэр нь Хөшигийн хөндий энэ тэр гээд. Тэгээд тэнд хэдэн хүн амьдардаг билээ, гэр хороололд хэдэн хүн амьдардаг билээ, хаана их хүн байна тэр нь ач

холбогдлынхоо эрэмбээр тэргүүнд явах ёстой. Тэгэхээр асуулт. Хашаандаа дулаан байшин барих гэж байгаа хүмүүст ипотекийн зээл хэдэн байшинд, хэдэн төгрөгөөр олгохоор төлөвлөсөн юм бэ нэг.

Дараагийн 2 дахь асуулт нь агаарын бохирдлыг бууруулах гээд хэсэг дээр 1.10.11 дээр байна л даа. Цахилгаан халаалт бууруулах технологиудыг дэмжинэ гээд төслүүдийг дэмжинэ. Цахилгаанаар халаахад 25 тэрбум, хийн халаагуур 15 тэрбум, янз бүрийн ногоон зээлүүд 6,5 тэрбум ингээд нийлбэр нь 40, бас 40 гаруй тэрбум байна. Эд нарыг бид нар хийхээр утаа буурах юм уу? Үзэгдэж харагдах нөлөө бол байхгүй шүү дээ. Тэгээд ер нь энэ туршилтуудаа боливол яасан юм бэ? Хойно нь ямар нэгэн хэмжээгээр бизнес байгаа, тэр хүмүүсийн ашиг сонирхол байгаа л байх. Гэхдээ дорвитой өөрчлөлт орохгүй юм бол энэ мөнгөнүүдээ тэр дулаан байшинд нь зарцуулж байвал яасан юм бэ? Тэгэхдээ барилгын бас нэг том лобби биш, өөрсдөө барьдаг, гэрчилгээнд стандартад, барилгын норм дүрэмд нийцсэн бол тэгээд л тэрийг нь олгодог болбол яасан юм бэ гэдэг санал бөгөөд асуулт нь 2.3.1.19 дээр хавсралт 2-ын Агаар орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээнд 31 тэрбум төгрөг байна. Цогц арга хэмжээ гэдэг маань юу вэ, энэ томъёоллыг задалж хэлж өгнө үү гэж хүсмээр байгаа юм?

3 дугаарт нь яг иймэрхүү тодорхойгүй томъёололтой холбоотойгоор тоног төхөөрөмжүүд гээд салбар бүрд байгаа. Тэр талаар яах вэ төсөв дээр хэлэлцэгдэх байх. Тэгэхдээ тоног төхөөрөмжүүд гэдэг нь дотроо хэд нь компьютер юм, хэчнээн ширхэг нь программ хангамж юм, хоёр, гурван зуун тэрбум төгрөгийн тийм нийлбэр дүн харагдаж байна лээ. Тэгээд энийг бас задалж ингэж харж баймаар байна. Энийг задалж өгөөч гэдэг хүсэлтийг Сангийн яам руу явуулчихсан байгаа. Ирэх долоо хоногт төсөв харин хойшлогдчихлоо. Түүнээс наана Байнгын



хороо хуралдахаас өмнө задаргааг ирүүлэх байх гэж найдаж байна, тийм үү? 10 хэдэн секунд байгаа юм байна. Нэг зүйл нэмээд хэлэхэд оршил хэсэг дээрээ бид нар Хятадын эдийн засгийн өсөлт саарч болзошгүй, экспорт нь буурч болзошгүй, үйлдвэрлэл, дэд бүтэц, гангийн хэрэглээ буурч болзошгүй гэсэн. Нөгөө талдаа нүүрсний экспортоо нэмээд тавьсан байгаа шүү. Энийгээ бас анхаарна биз дээ гэж хэлье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр дарга хариулах уу? Ажлын хэсгийн 5 дугаар микрофон Эдийн засаг, хөгжлийн яамнаас.

**Ц.Эрдэнэбат:** Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Золжаргал гишүүний хариулт асуултад хариулъя. Ипотектэй холбоотойгоор ипотекийн зээлийн 50-аас багагүй хувийг дэд төв, дагуул хот, гэр хорооллын өрхөд олгоно гээд гэх мэтчилний нэлээн хэдэн ийм тодорхой заалтууд байгаа. Тухайлбал, нийслэл, орон нутагт өрхийн төлбөрийн чадварт нийцүүлэн ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн олгоно. Миний анхны байрыг байр хөтөлбөрийг дэмжинэ гээд. Тэгэхээр яг таны хэлж байгаачлан гэр хороолол мөн энэ төлбөрийн чадварт нийцсэн орон сууц энэ чиглэлээр бол тодорхой холбогдох заалтууд нь орсон байгаа.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн 14 дүгээр микрофон нэмж хариулъя.

**С.Төмөрхүү:** Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам. 2025 онд гэр хорооллын амины орон сууцыг дэмжих чиглэлээр 30 тэрбум төгрөг суусан байж байгаа. Энэнээс 30 сая төгрөгийг эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан 1000 өрхөд олгохоор суусан. Энийг бол ер нь бодлогын хүрээнд бол дэд бүтэц, хөрс, агаарын бохирдолгүй ийм амины орон сууц барьсан иргэдэд олгохоор туссан. Ер нь өнөөдрийг хүртэл амины орон сууцанд олгогдсон ипотекийн

зээл бол ерөөсөө 1000 гаруй л юм байна лээ. Ипотекийн зээлийг амины орон сууцанд олгодог болгох чиглэлээр бол манай яам идэвхтэй ажиллаж байгаа. Эрх зүйн орчныг нь бүрдүүлэх, энэ амины орон сууцыг комисс орж баталгаажуулах, аудит хийлгэх чиглэлээр дүрэм журмыг боловсронгуй болгох аргачлалаа боловсруулаад ингээд ажиллаж байгаа. Энэ орсны дараа бол 80м<sup>2</sup>-аас бага талбайтай амины орон сууц гэр хороололд барьсан тохиолдолд ипотекийн зээлд орох бүрэн боломжтой болно. Бүсчлэлийг нь.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулъя.

**С.Төмөрхүү:** Нэг хязгаарлалт байгаа нь амины орон сууцын ипотекийн зээлд хамаарах бүсчлэлийг Нийслэлийн ерөнхий төлөвлөгөө 20, 40-ийг батлагдахаар бүсчлэл тогтоогоод, энэ бүсчлэлд яндангүй, нүхэн жорлонгүй амины орон сууцад олгоно гэж ингэж төлөвлөж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Учрал сайд нэмж хариулъя.

**Н.Учрал:** Энэ гэр хорооллын дахин төлөвлөлт гэдэг нэрийн дор жишээ нь та бүхний сайн мэдэх энэ хойшоо энэ Дөлгөөн нуур луу бараг 3 хороо чинь тэр чигээрээ нэг ч сургууль, цэцэрлэггүй, дахин төлөвлөлт гээд анхныхаа төлөвлөгөөг өөрчлөөд тоглоомын талбай барих газар баахан барилга барьчихсан. Одоо яаж зохицуулах вэ гэдэг асуудалд орчхоод байна шүү дээ. Тэгэхээр энэ Азийн хөгжлийн банкны төслөөр хийсэн энэ Баянхошуу дэд төв дээр хийсэн сайн туршилагаа үндэслээд энэ Сэлбэ дэд төв дээр энэ 12 мянган айлын орон сууц барих ажил гараанаас гарсан. Одоо ингээд 1300 айл болбол төлбөр мөнгөө авчихсан байна. 2200 айл болбол үүнд хамрагдах гэж байна. Тэгэхээр цаашдаа утааг бууруулъя гэх юм болбол орон сууцжуулах бодлогоо барихаас өөр зам байхгүй. Тийм учраас энэ нийслэл дээр хэрэгжих

төлөвлөгөө болбол энэ удаа тэр 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөнд үндэслэсэн энэ гэр хорооллыг орон сууцжуулах бодлого болбол одоо бас илүү бас амьдрал дээр бодит биеллээ олно гэдгийг бас хэлье.

**Д.Амарбаясгалан:** Одонтуяа сайд нэмж хариулъя.

**С.Одонтуяа:** Тэгэхээр агаарын бохирдол дээр бас энэ зөвхөн гэр хороолол биш автомашины утаа бас нэлээдгүй агаар бохирдуулдаг. Тэгэхээр хэд хоногийн өмнө манай сайдын албан даалгавар гарсан байгаа. Ер нь энэ Евро 5 стандарт руу шилжих ажлаа бид нар түргэвчлэх ёстой. Яагаад гэхээр өнөөдөр мөрдөгдөж байгаа Агаарын бохирдлын тухай хууль болбол евро 5 стандартыг хэрэглэхээр өөрөөр хэлбэл стандарт хангасан шатахуун хэрэглэх гээд заачихсан байхад бид нар хуулиа биелүүлэх үүднээс хэрэглэх ёстой. Хэрвээ евро 5-ыг ашиглаж чадах юм бол автомашины утаанаас ялгарах тоосонцрыг 95 хувь, нүүрс хүчил болон метан хийг 80 хувь, азотын ислийг 90 хувь хүртэл бууруулдаг ийм ач холбогдолтой байгаа. Мөн шатахуунд агуулагдах хүхрийн агууламж нь евро 2 евро, 5 стандарт бол 200 дахин ийм зөрөөтэй байгаа. Тийм учраас хот дотор явж байгаа энэ 3000-аад энэ тээврийн нийтийн тээвэр болон төрийн үйлчилгээнд явж байгаа ядаж 3000 машинаа.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Эдийн засаг, хөгжлийн яам ТНБД Батхүү нэмж хариулъя.

**И.Батхүү:** Золжаргал гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам эдийн засгийн тооцоолол, өсөлтийн тооцоолол, экспортын тооцооллоо гаргахдаа гол зах зээл худалдан авагчдынхаа өсөлт, хэрэгцээг бас байнга харж тоог нь ажиглаж ажилладаг. Энэ өнгөрсөн эхний энэ оны эхний хагас жилийн байдлаар БНХАУ-ын хойд мужуудын эдийн засгийн

өсөлт нь бол 5.8, 6.2 гэх мэтчилэн тухайн улсын зорилтот түвшин болох 5 хувиас илүү өндөр гарсан байгаа. Дээр нь бас нэмээд саяхан 9 сард БНХАУ-ын эрх баригчдаас эдийн засгаа өсөлтийг нь 5 хувьд хүргэх бодлогын арга хэмжээг зарласан. Энэ бодлогын арга хэмжээг дагаад өнгөрсөн долоо хоногуудад бас Хятадын хөрөнгийн биржийн хувьцааны хани 15 хувиар өсөөд, ер нь Хятадад хөрөнгө оруулж байгаа олон улсын хөрөнгө оруулагч итгэл сэргэсэн үзэгдэл ажиглагдаж байгаа.

Тэгээд манай Эдийн засгийн яамнаас гаргаж байгаа эдний экспортын тооцоолол бол яг манай уул уурхайн голлох компаниудын экспортын төлөвлөгөө, бодитой худалдан авалт, борлуулалтын төлөв, бүртгэгдсэн гэрээнүүд дээр нь үндэслээд нэлээн бодитой тооцоолол гаргаж ажиллаж байгаа. Өнгөрсөн хугацаанд бодитой хийсэн экспортын гүйцэтгэл дээр нэмээд төмөр замын холболт экспорт тээвэрлэлтийн бас сайжруулах ажлууд үргэлжлэн хэрэгжих учраас ирэх оны экспортын төлөвлөгөө биелнэ гэсэн хүлээлттэй байгаа.

**Д.Амарбаясгалан:** Хариултаа бүрэн авсан уу Золжаргал гишүүн? Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

**М.Бадамсүрэн:** 3 асуудлаар асууя. Орон нутагт тулгамдаж байгаа асуудал. 1 дүгээрт хүний нөөцийг дэмжих чиглэлээр 320 сумаас аймгийн төвийн 20 сумыг хасаад 300 сумд улсын төсвөөс 30 хувь, аймгийн төсвөөс 30 хувь, сумын төсвөөс 30 хувийг гаргаад 8 айлын орон сууцыг эхний ээлжид баримаар байна. 1 шатны төсвөөс нь 70 орчим тэрбум төгрөг гаргаад. Яагаад гэхээр Дорнод аймаг бүх сумдаа ийм 8 айлын төрийн албан хаагчдын орон сууц барьсан, үнэхээр өндөр ач холбогдолтой байгаа. 2 л асуудал гол тулгамдаж байгаа шүү дээ. Боловсон хүчнийг хөдөө орон нутагт тогтвортой ажиллуулахад 1 дүгээрт

цалин хөлс, энэ нэмэгдлийг бол өмнөх Их Хурал, ЗГ шийдсэн, 80 хүртэл хувийн нэмэгдэл өгч байгаа. 2 дахь нь орон сууц. Яагаад гэвэл одоо түлээ түлш түлээд байдаг залуучууд шинэ боловсон хүчнүүд бол ховор байна. Тийм учраас энийг нэг ийм төсөл болгоод хэрэгжүүлж өгөөч.

2 дугаарт нь ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр. Төрөөс бизнесийг дэмжихийн тулд, хувийн хэвшлийг дэмжихийн тулд 3 гол зүйл хийдэг. 1 дүгээрт нь дэд бүтэц. Энэ бол ирэх онд нэлээн сайн явагдана. Авто замуудаар холбож байгаа. 2 дугаарт нь хөнгөлөлттэй зээл. Шинэ хоршоо хөдөлгөөн бол үнэхээр жишиг боллоо гэж би бол хувьдаа үзэж байгаа. Орон нутгийн иргэд ч гэсэн үүнийг бол маш их дэмжиж байгаа. Ер нь бид нар иргэддээ итгэл үзүүлж, бизнес эрхлэх боломжийг нь бас нээж өгөх хэрэгтэй. Ер нь бүх л улс орнууд ийм бага хүүтэй, хөнгөлөлттэй, урт хугацаатай зээл олгож үүгээр хувийн хэвшлээ дэмжиж, ажлын байр гаргаж, эргээд энэ татвараараа олж байгаа орлого нь эргээд хүүгийн татаас Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 12 хувийг хариуцаж байгаа. Энэнээсээ ч илүү үр дүн гаргах ийм боломжтой байгаа. Тийм учраас энэ орон нутагт ялангуяа энэ ЖДҮ сангийн 27 тэрбум төгрөг гээд нэг сан байгаа, өөрөө ингээд ийм арилжааны банк, арилжааны хэлбэрээр ингээд аваад явах энэ нь чухал уу эсвэл Шинэ хоршоо шиг ингээд 500 тэрбум төгрөгийн 12 гээд бодоход 60 тэрбум төгрөг хүүгийн татаасанд өгч байгаа. Тэгээд энэ шиг энэ 27 тэрбум төгрөгийг жил болгон энэ хүүгийн татаасанд өгөөд явах боломжтой юу? Тэгэхгүй бол ингээд 27 тэрбум төгрөг өөрөө өөрийгөө санхүүжүүлээд явна гэхээр аягүй эх үүсвэр нь маш бага байгаад байгаа юм. 1 аймагт гэхэд 1,5 тэрбум төгрөг л очдог. Өнөөдөр нэг бизнес хийхийн тулд нэг ЖДҮ 300-аас 500 сая төгрөгөөс наашигүй. Ингээд нэг 3-аас 5 ААН аваад, ингээд үр дүн гарахгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр энийг нэмэгдүүлэх ийм боломж байна уу?

Малчдын талаар. Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх энэ бодлогын зохицуулалт хийж, үнийг удирдах асуудлыг бас авч үзэхгүй бол нөгөө зах зээл өөрөө зохицуулна гээд орхисноос болоод бас өнгөрсөн өвөл нэлээн хүндрэлтэй байдал үүссэн. Яах вэ улс нөөц байнга бүрдүүлэхдээ чухал биш. Шатахууны үнийг барьдагтай адилхан малчдад бол ачааллыг багасгахын тулд энэ өвс, тэжээлийн нөөцийг ялангуяа тэжээлийг импортоор оруулж ирэх, өвс, тэжээлийг бүрдүүлж, энийгээ эргээд хомсодсон үед нь зах зээлд тодорхой үнээр гаргаж, энэ үнийг барих бодлогыг хэрэгжүүлэхгүй бол энэ үнэ маш өндөр болох вий.

Энэтэй холбоотой би ХААЯ-ны сайдаас бас асуух асуулт байна. Энэ хурдны чиглэлийн үржлийн цэвэр азарга, гүүг жилдээ 500-г импортолдог гэж ойлгосон. Энэ бол 100 сая төгрөгөөр нэг азаргыг бодох юм бол ингээд 50 тэрбум төгрөг гадаадын зах зээлд очиж байгаа юм. Хурдны өлгий Сүхбаатар аймагт адуун сүргийн манлай азарга 11-хэн уралдсан шүү дээ өнгөрсөн онд. Тэгээд хөдөөгийн залуучууд морь уяхыг гол хөдөө бас өөрсдийнх нь гол тийм хобби нь бас хөдөө байгаагаараа бахархах ийм зүйл болдог. Гэтэл энэ маань өнөөдөр маш хүнд цохилт болж байна. Жирийн малчин залуучууд ийм цэвэр азарга авч чадахгүй, цэвэр гүү авч чадахгүй. Дээр нь өвсний үнийг өсгөж байгаа хамгийн гол зүйл чинь энэ уралдуулах зорилгоор хэдэн мянгаар нь үржүүлж байгаа энэ цэвэр азарга, түүний төлүүд шүү. Тэгэхээр энэ дээр ямар бодлогын арга хэмжээ авах вэ гэдгийг асууя.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Ажлын хэсгийн 14 дүгээр микрофон Барилга, хот байгуулалтын яамны ТНБД-ын үүрэг гүйцэтгэгч.

**С.Төмөрхүү:** Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам. Орон нутагт төрийн албан хаагчдыг дэмжихээр Миний сонголт төрийн алба гэдэг хөтөлбөрийг

хэрэгжүүлж байгаа. Энэ хүрээнд түрүүн томъёолсон 90 суманд 8 айлын түрээсийн орон сууцыг барих, мөн ашиглах хэлбэрээр ингэж барихаар төсөвт хөрөнгийг нь суулгаад явж байгаа. Ирэх оны төсөвт бол 30 тэрбумын санал явж байгаа. Ингээд 90 суманд 720 айлын орон сууцыг барина гэж төлөвлөж байгаа. Мөн Миний сонголт төрийн алба хөтөлбөрийн хүрээнд орон нутагт төрд ажилласан жилээс нь хамаараад ипотекийн зээлийн хүүг бууруулах, ипотекийн зээлийн хүүгийн татаасыг төсөвт суулгах замаар шийднэ гэж ингэж оруулж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Тэргүүн шадар сайд Гантөмөр сайд нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** Олон гишүүн энэ үндэсний үйлдвэрлэл, жижиг, дунд үйлдвэрлэлийг ер нь хэрхэн дэмжих вэ гэдэг ийм асуудлыг хөндөж байгаа юм. Тэгээд бид нарын хувьд бол хамгийн чухал нь эхлээд зах зээл хэрэгтэй, бараа үйлдвэрлэж болно зарах хэрэгтэй гэдэг. Тэр утгаараа бид нар 3-аас 4 улстай худалдааны хэлэлцээр хийж байна. Энэ хүрээнд бид нар тодорхой зах зээлээ олно нэг.

2-т нь болбол бүтээгдэхүүнээ бойжуулах хэрэгтэй. Юу ч хамаагүй үйлдвэрлээд зарна гэх юм бол зарагдахгүй. Юу ч хамаагүй тариад зарна гэх юм бол зарагдахгүй. Тийм учраас бид нар энэ бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварын судалгааг хийж байна. Ялангуяа Дэлхийн банк болоод олон улсын байгууллагуудтай хамтраад энэ Монголын Монголчуудын үйлдвэрлэж чаддаг энэ бүтээгдэхүүн явал дэлхийн хүмүүст зарагдах юм бэ, үнэ цэнтэй байх боломжтой вэ гэдэг энэ өрсөлдөх чадварын судалгаа гарснаар бид нар болбол энэ үйлдвэрлэгч нараа бол дэмжээд явах боломж бол бүрэн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулъя.

**Л.Гантөмөр:** 3 дахь нь болбол мэдээж технологи. Технологитой байхын тулд үйлдвэрлэл хэрэгтэй. Тийм учраас энэ үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг бид нар ирэх онд гаалийн татвараас нь бүрэн чөлөөлж байгаа. Ийм байдлаар бид нар ажил хийж чаддаг хүнээ дэмжихгүй болбол мах зарж чаддаггүй хүнд мах зар гээд мөнгө өгөөд байдаг, сүү хийж чаддаггүй хүнд сүү гээд хий гээд мөнгө өгөөд байдаг, талх хийж чадахгүй хүнд талх хийгээд мөнгө өгсөөр байгаад өнөөдөр хүртэл энэ ЖДҮ бол ерөнхийдөө унасан. Ер нь Монгол Улсын ХАА-н салбарын өрсөлдөх чадваргүй байгаа зүйл болбол тэжээгчийн сэтгэхүйгээр засаг төр дандаа ханддаг. Та нар чадахгүй байна, бид мөнгө өгье гэдэг. Ер нь цаашидаа бид нар энэ салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд та нарт ямар илүү зүйл байгаа юм бэ, бидэнд ямар илүү зүйл байгаа юм бэ тэрийгээ хэрхэн үнэд хүргэж борлуулах вэ гэдэг ийм шинэ төлөвлөлт рүү хэдүүлээ шилжинэ. Мэдээж хэрэг өнөөдөр хүртэл хэрэгжүүлсэн бодлого, зорилтуудыг үгүйсгээгүй. Чанарын өндөр түвшинд гаргая л гэж байгаа. Би бол Хөдөө аж ахуйн сайд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд нэмж хариулах уу? Энхбаяр сайд хариулах уу? Жижиг, дунд үйлдвэрлэлд төсөвлөгдөөд байдаг мөнгийг арилжааны банкны хүүгийн татаас хэлбэрээр өгвөл илүү өргөн хүрээг хамрахгүй юу гэж асуусан. Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн 4 жил, тэрний өмнөх 4 жилд ч тэр энэ ЖДҮ-лэлтэй холбоотой их асуудлууд үүссэн. Тэндээс хойш болбол энэ жижиг, дунд үйлдвэрлэлийн санг аль болох төсвөөс холдуулж, одоо нэгэнт тэр үед нэгэнт үүссэн байсан эх үүсвэрийг нь эргэлтэд оруулж, арилжааны хэлбэрээр явуулах бие даасан ийм корпорацын өөрийн бие даасан хуультай болгож ингэж явуулсан байгаа. Эндээс хойш болбол ер нь жил бүр улсын төсвөөс татаас тавьдаг байсныг



нь болбол зогсоосон гэсэн үг. Одоо бол нэгэнт би яг сүүлийн үед бол мэдээ тоо аваагүй байна. Ер нь бол дор хаяж 500-гаад тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгө тэнд бол байх ёстой. Энэ сүүлийн үеийн сүүлийн жилүүдэд энэ томоохон үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн тулд аль болох банкны эх үүсвэрийг шахааж гаргаж байгаа юм. Тэгэхийн тулд татаас буюу хүүгийн.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Улсаас өгч байгаа мөн бас яг хүртээмжийн тал дээрээ болбол үлэмж илүү үр дүн гарч байгаа гэсэн үг. 100 тэрбумыг 200 хүнд тараах, 300 хүнд тараах, 100 тэрбум төгрөгөөр хүүгийн татаас өгснөөр энэ чинь бараг 1000-гаад хүнд зээл болж ингэж банкнаас мэргэжлийн байгууллагаар дамжиж очиж байгаа юм. Энэ 2 ингээд бодлого өөрөө ингээд аль, аль хэлбэрээрээ явж байгаа гэсэн үг. Одоо байгаа ЖДҮ-лэлийн энэ багахан энэ эх үүсвэрийг хэрвээ хүүгийн татаас хэлбэрээр явчих юм бол энэ чинь өөрөө буцаж орж ирдэггүй орлого байхгүй юу. Тэр чигээрээ нөгөө 4-өөс 500 тэрбум төгрөг чинь яваад, яваад дуусчихна. Харин ЖДҮ-лэлийн энэ хууль дээр яаж зохицуулалт хийх юм байгаа юм. Зүгээр хүүгийн татаасыг бол харин арай өөр хэлбэрээр гадаад эх үүсвэрээр ч юм уу, өөр эх үүсвэрээр олж ирээд, нэмээд ингээд явуулах бол боломж энд бол нээлттэй байдаг. Тэрнээс биш одоо байгаа жоохон эх үүсвэрээ тогтмол ашиглах ёстой эх үүсвэрээ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Яах вэ Бадамсүрэн гишүүн ингэж асуусан юм Жавхлан сайдаа. Энэ мөнгийг хүүгийн татаас хэлбэрээр өгөөд, аж ахуй үйлчилгээ эрхлэх боломж нь өргөжихөөрөө эргээд татвар хэлбэрээр энэ орлого чинь улсад төвлөрнө. Тэгэхээр энэ эргэлт нь илүү өргөн хүрээтэй биш үү гэдэг ийм асуултыг асуугаад байна лээ. Энхбаяр сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Жилдээ үүссэн сангаас 20 гаруй тэрбум төгрөг эргэн орж байгаа. Энийгээ тэгээд сонгон шалгаруулалт хийгээд, 300 сая төгрөг хүртэл хэмжээд ингээд арилжааны банкаар дамжуулаад зээл олголт явагдаж байгаа. Өмнө нь бол агентлагийн удирдлагууд, Төрийн нарийн гээд улс төрийн томилгоотой улсуудын шийдвэрээр зээл олгодог байсан байдал бүрэн зогссон. Зөвхөн арилжааны банкнууд судалгаа зээлээ хийгээд явж байгаа. Эх үүсвэр хангалтгүй байгаа нь тодорхой. Манай салбарт хэрэгжиж байгаа энэ хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, хоршооны малчны зээл, ингээд ноос ноолуур, арьс ширний бэлтгэл үйлдвэрлэлээ дэмжих, Атрын 4 дүгээр аян гэсэн 5 багц хүрээнд энэ хөнгөлөлттэй зээлүүд явж байгаа. Мөн бас энэ үйлдвэрээ дэмжихийн хүрээнд 5 багц ийм урамшууллын бодлогууд хэрэгжиж байгаа. Тэгэхээр энэ болгон бол яг хэрэгжсэний дараа, арилжааны банкнууд зээл олгосны дараа, улаан буудайгаа үйлдвэрт тушаасны дараа, сүүгээ үйлдвэрт тушаасны дараа буюу энэ бодлогыг хооронд нь уяж, энэ зээл санхүүжилтүүд шийдэгдэж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Гантөмөр сайд нэмж хариулт өгье.

**Л.Гантөмөр:** Бадамсүрэн гишүүний асуулт дээр энэ морь, адуу үржүүлгийн асуудал хөндөгдсөн. Ер нь Монголын хамгийн өсөж байгаа салбар бол аялал жуулчлал байна лээ. Ялангуяа зүүн бүсэд бол ирээдүйд хамгийн өндөр түвшинд хөгжих юм байна гэж бид нар харж байгаа. Ингэхээр аялал жуулчлал дээр бүтээгдэхүүн хэрэгтэй байгаа. Ирсэн хүмүүс юу авах юм, юу үзэх юм, юу харах юм, хаагуур явах вэ гэдэг. Тэрний нэг төрөл дотор энэ Монгол ахуйтай холбоотой адуу, морины уралдаан гэж их том бүтээгдэхүүн байна. Тийм учраас би Номин сайдад саяхан юу хэлсэн бэ гэхээр энэ Бооцоот морин уралдааны хуулийг яаралтай баталмаар юм биш үү? Ингээд

орж ирж байгаа тэр аялал жуулчлалын очиж байгаа бүс болгон дээр энэ бооцоот уралдааныг ер нь идэвхжүүлэх юм болбол магадгүй Монголын хөдөө аж ахуй эрчимжсэн хэсэг нь болбол нэлээн том орлоготой байж, магадгүй цаашаага дэлхийн хэмжээний салбар болох боломж бол харагдаж байгаа шүү гишүүнээ. Тэгэхээр аймаар хутгаад нэгийг нь дараад, нөгөөдхийг нь дэмжинэ гэхээс илүү хэн нь ирээдүйд асар их нөөцтэй байна тэр лүү нь.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Энхбаяр сайд нэмж хариулъя. Дараа нь Бадамсүрэн гишүүн тодруулна.

**Ж.Энхбаяр:** Жилдээ 300-аас 500 хүртэл үржлийн адуу орж ирж байгаа. Нийт Монгол Улсад 5 сая гаруй адуу байна. Тэгэхээр энэ орж ирж байгаа энэ үржлийн адуутай холбоотойгоор энэ өвсний хомсдол үнэ өсгөөд байгаа зүйл байхгүй. Энийг бас хамаагүй тэгээд туйлширч болохгүй. Ер нь нийтээрээ бэлчээрийн доройтол, малын сүргийн бүтэц тоо толгой ихэссэнтэй холбоотойгоор бэлчээрийн нөхөн сэргээгдэх чадвар их муудаж байгаа. Энэтэй холбоотойгоор малын тарга хүч тэвээрэг авах байдал их муу байна. Ингээд зудыг давах, эрсдэлийг давах чадавх нэлээн суларч байгаа. Иймд ирэх жилүүдэд Атрын 4 дүгээр аян гэсэн бодлогын хүрээнд тэжээлийн үйлдвэрлэл, тэжээлийн бааз, тэжээлийн талбайг эрс нэмэгдүүлэх, тэр эрсдэлийг даван туулахад дэм болох энэ том бодлогууд хэрэгжинэ. Тэгээд энэ төсөвт өргөн барьсан байгаа. Энэ хэрэгжсэний дараа бол энэ тэжээл эрсдэлийг хаах тал дээр бол нэлээн том ахиц гарна.

**Д.Амарбаясгалан:** Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

**М.Бадамсүрэн:** Би Барилгын яаманд ингэж хэлээд байгаа юм. 90 орон сууцыг барих мөнгийг улсын төсөвтөө тусгачихсан юм байна. Энийгээ үржүүлэхийн хүрд буюу 3-аар үржүүлчих.

Нэг сум нь 250 сая төгрөг гарга, сум болгонд бас ингээд хариуцлага үүрүүлэе. Нэг аймагт гэхэд 2-оос 3 тэрбум төгрөг гаргая. Яагаад гэвэл энэ загвар чинь Дорнод аймагт хэрэгжээд үр дүнтэй болчихоод байна. Тийм учраас Монгол Улсынхаа 300 суманд бүгдэд нь нэг Монгол төр юм бол 8 айлын орон сууц бариад өгчхөөч. Тэгээд малын эмч нь, хүний эмч нь, багш нар нь тэндээ байгаад, дараагийн жилд нь дахиад 8 айлын орон сууц бариад өгөөч. Заавал хөдөө суманд гэхээрээ гал түлээд байж болохгүй гэдэг энийг хэлээд байгаа юм. Энийг анхааралдаа авч, энэ юун дээр тусгаж өгөөч Хөгжлийн төлөвлөгөө дээр.

2-т нь Шинэ хоршооны загвараар банкны эх үүсвэр хүүгийн татаас өгье гэдэг Их Хурлын даргатай би санал нэг байгаа. Ер нь Шинэ хоршоо гээд энэ маш зөв загвар гарчхаад байгаа. Яг үүгээрээ аялал жуулчлалын салбар, эмэгтэйчүүдийн бизнесийг дэмжих салбар, ариун цэврийн байгууламж үйлдвэрлэх, угсрах, хүлэмж үйлдвэрлэх, угсрах, сургалтын төвүүдийг дэмжих гээд энэ тодорхой нэр төрлийн зүйлүүд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гонгорын Дамдинням гишүүн асуултаа асууна.

**Г.Дамдинням:** Бид нар яах вэ дээ тэгээд л нэг татвараас цугласан нэг хэдэн төгрөг, тэгээд гадаадын зээл, тусламжаас нэгэнт батлагдсан байгаа ашиглагдаагүй байгаа зээлүүдээсээ аваад л 14 төсөл хэрэгжүүлээд л явах гээд байх шиг байгаа юм. Энэ оны 25 оны зорьж байгаа 4 том төсөл гээд бид нарт бас мэдээлэл ирж байгаа. Энэ төслүүд дээр болбол санал нэг байгаад байгаа юм. Тэр хил холболтын цэг, төмөр замууд, тэгээд л тэр Францын ураны төсөл гээд л, тэгээд энэ Тавантолгойн цахилгаан станц гээд энэ томоохон төслүүд ингээд явахаар төлөвлөгдөж байгаа. ЗГ-ын энэ ажлуудыг бол маш сайн дэмжиж байгаа. Ер нь болбол мөнгө олж ирэх, орлого олох юмнууд л яваад байгаа юм.

Зүгээр бид нар энэ хөрөнгө оруулалтыг татах тал дээрээ ирэх жилүүдэд ер нь ямар бодлого барих юм бэ? Ялангуяа бид нарын хамгийн том олон улсад гаргаад тавьдаг салбар болбол тэгээд л яалт ч үгүй л ашигт малтмалын салбар шүү дээ. Өөрөөр хэлбэл бид нарт орлого олж ирдэг 3 дахь эх үүсвэр буюу энэ гуравдагч хөрөнгө оруулалтын орчныг хэрхэн дэмжье гээд байгаа юм бэ? Санаа нь уг нь зөв боловч, өгч байгаа мессеж нь бол их л далий явах юм. Өгчихсөн байгаа лицензүүдээ алгын чинээ цаас маягаар дуудаад байж бас болохгүй л байх, зүгээр Учрал сайд энэ дээрээ тайлбар хийнэ байх гэж бодож байна. Зүгээр ер нь болбол ард түмэнд Баялгийн сан дээр орж ирсэн орлого орж ирэх ёстой гэдэг нь болбол зөв. Тийм л санаагаар хэлсэн байх. Алгын чинээ цаас дээрээ тулбал бидний барьж яваа паспорт, иргэний үнэмлэх, бидний баталж байгаа хууль ч гэсэн алгын чинээ цаас л даа. Тэрний цаана байгаа эрх зүйн зохицуулалтын асуудлаа бас нэг олон улсад өгөх мессежээ энэ ЗГ бас жоохон бодмоор байна. Үгүй ээ ядаж л энэ зэсийн роялтийн 20 хувийнхаа асуудлыг энэ Эрдэс баялгийн сайд ЗГ юу гэж бодоод байгаа юм. Шинэ өнгөт металлын төслүүдтэй болмоор байдаг. Дараа дараачийн Оюу толгойтой болно гээд яриад байдаг. Зэсийн роялти нь 20 хувь гэсэн хуультай байхаар хэн орж ирэх вэ дээ, байхгүй. Энэ талаар ер нь ямар ажил хийх вэ?

Дараачийнх нь энэ алтны НӨАТ байна. 4 том төсөл хэрэгжүүлээд явахаар зэрэг импорт ихэснэ, импорт ихсэхээр зэрэг ханшаа алдах эрсдэл рүү орно. Ханшаа алдах юм болбол юмны үнэ өснө л гэсэн үг. Тэгэхээр 1 амортизатор бий болгох ёстой учраас энэ алтны салбар дээр НӨАТ-ын хөнгөлөлт, тэглэлт гэдэг юмнууд байгаа юу? Алтан дээр болбол жишээ нь гэхэд НӨАТ-ыг чөлөөлөх гээд байгаад байгаа байхгүй юу. Энэ чинь яг бодит байдал дээрээ болбол яг хөрөнгө оруулалтын зардал болоод л явчхаж байгаа юм. Дараа нь энийг худалдан

авалт, үйл ажиллагаа дээрээ оруулаад, хөнгөлүүлээд явах гэхээр байдаггүй. Тэгэхээр тэглэх талаар ч гэдэг юм уу тийм ээ, ер нь зүгээр энэ ханшаа барих тал дээр, хөрөнгө оруулалтыг тогтворжуулах тал дээр та нар маань ер нь юу бодож байгаа юм бэ? Ийм нэг асуулт байна.

Дараачийн асуулт болбол би өмнө нь энэ гишүүдийн хэлээд байгаа саналууд дээр зориуд цуурайтуулж олон гишүүн дэмжиж байгаа шүү гэдэг санаагаар 2 санаа хэлье. 1 дүгээрт энэ Дархан арьс, ширний цогцолборын асуудал байгаа юм. Дархан арьс, ширний цогцолборыг энэ үйл ажиллагааны хөтөлбөртөө тусга, олон жил ярилаа хиймээр байна. Олон мянган ажлын байр бий болгох ёстой энэ төсөл шүү. Энийг заавал хийж өгөөч.

Төгсгөлд нь болбол энэ гадаадын ажиллах хүчний орлогоос энэ жилийн 140 тэрбум төгрөг л тавьчихсан байна лээ дээ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээр тийм ээ Энх-Амгалан сайдаа? Тэр мөнгөөр нэг их айхтар хөдөлмөр эрхлэлтийг дэмжээд байгаа юм байхгүй шүү дээ. Тэр гадаадын ажиллах хүчний квотыг нь чөлөөлөөд, төлбөр мөнгийг нь бас бууруулчхаж болдоггүй юм уу? Ер нь нэгмөсөн. Тэгэхгүй бол энэ ажил хийх хүн алга байна шүү дээ. Энэ төслүүдийг чинь хэрэгжүүлэх хүн алга байна шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал хариулт өгнө.

**Н.Учрал:** Тэгээд алгын чинээ байна уу, алд дэлэм байна уу ер нь хамаагүй л дээ. Гол нь агуулгадаа л оршоод байгаа юм. Тэр алгын чинээ цааснуудыг чинь арын хаалгаар ар, өврийн хаалгаар авлигадаж авдаг болчихсон болохоор энэ ард түмэн чинь газрынхаа хэвлийн баялгийнхаа ноогдол ашигийг хүртэхгүй байна шүү дээ. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр яг энэ парламентад бид хамтдаа газрын хэвлийн баялгийнхаа дийлэнхийг ард түмэн эзэмшинэ, эзэмших арга зам нь бол Үндэсний баялгийн сан

байна гээд хуульчилсан. Ингээд өнгөрсөн парламентад одоогийн Их Хурлын даргыг Хэрэг эрхлэхийн даргаар ажиллаж байхад энэ Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсан. Энэ Үндэсний баялгийн сангийн хууль дээр стратегийн ач холбогдол бүхий ордуудыг эзэмшиж байгаа компаниуд нэгд 10 хувиа хөрөнгийн зах дээр нээлттэй болгох үүрэг хүлээлгэсэн. Өнөөдөр нээлттэй болоогүй. Засаглалаа ил болгохоос орлого, зарлагаа, балансаа тодорхой хэлэхээс яагаад нуугдаад байгаа юм. Ил тод байх ёстой шүү дээ.

2-т ард түмэнд тэр ноогдол ашгийг иргэдийн хуримтлалын дансаар дамжуулаад хэрвээ улсын төсвөөр нөөцийг нь тодорхойлсон бол 50 хүртэлх хувийг нь, хэрвээ хувийн санхүүжилтээр нөөцийг нь тодорхойлсон бол 34 хүртэлх хувийг нь иргэдийн хуримтлалын дансанд хийнэ. Төр авахгүй, засаг авахгүй, үүнийг нь эрүүл мэнд, боловсрол, орон сууцад зарцуулна гээд хуульчилчихсан. Тэгэхээр ЗГ-ын үндсэн үүрэг юу юм бэ гэхээр хуулиа биелүүлэх, хууль биелүүлэх. Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн хуулийг биелүүлэх үүрэгтэй ЗГ тогтоол гаргаад, эдгээр компаниудтай хэлэлцээр хийе л гэж байгаа юм. Хэлэлцээр хийгээд эцсийн үр дүнд ард түмэн, иргэд хожих ёстой. Хуримтлалын дансанд хуримтлал нэмэгдэх ёстой. Өнгөрсөн хугацаанд төрийн эзэмшлийн 7 хуулийн этгээд ноогдол ашгаа хуримтлалын дансанд хуримтлуулахад хуримтлалын дансанд 500 тэрбум төгрөг хуримтлагдсан юм байна. Үүнийг 5 мянган айлыг ипотекийн зээлд хамруулах асуудалд зарцуулсан юм байна.

Тэгвэл хуримтлалын данс цаашидаа энэ хуримтлал нь нэмэгдэх юм бол олон айлын ипотекийн зээлд хамруулах асуудлыг шийдвэрлэх юм байна. Эрүүл мэнд, боловсролд зарцуулах юм байна л гэдэг ийм л зорилгоор хэлэлцээр хийж байгаа юм. Ингэсний үр дүнд өнөөдөр энэ улс төрийн тогтворгүй байдлаас болоод хөрөнгө оруулагч нарыгаа хөөгөөд

явуулчихдаг байдлыг таслан зогсооно. Одоо гаднын хөрөнгө оруулалт орж ирэх гэхээр ЗГ-ын үе, үе бүрд өөр, өөр бодлого шийдвэр гаргадаг. Өнөөдөр тэр Чайна Энержитэй холбоотой хэлэлцээр ч гэсэн 18 жил улс төржсөөр байгаад л өнөөдрийг хүрчихсэн. Тэгэхээр шаардлагатай болбол цаашидаа энэ хөрөнгө оруулалтын гэрээ, орд ашиглах гэрээнүүдийг нь ЗГ-аас Их Хуралд оруулаад, Их Хурлаар шийдээд явчихвал гаднын хөрөнгө оруулагч нар итгэл үнэмшилтэйгээр цаашидаа ямар нэгэн асуудлаас болж энэ асуудал зогсохгүй юм байна гээд Их Хурлаар батлагдсан гэрээтэй төслүүд дээр хөрөнгө.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Дамдинням гишүүний асуултад хариулъя. Тэр зэс дээр болбол нэг ийм юм байгаа шүү. Яах вэ олон жил Монголын ард түмнийг тэжээж ирж байгаа, цаашидаа ч ер нь олон жил тэжээх шинжтэй байна шүү манай Эрдэнэт үйлдвэр маань. Одоо бараг бүх татвар нь нийлээд 2 их наяд гарч байна жилд төлдөг нь. Оюу толгой бол дөнгөж 1 их наяд орчим байгаа. Эндээс 20 хувийн роялти төлдөг нь бол үнэн, анхнаасаа л ингэж явж ирсэн байдаг. Тэгэхээр цаашидаа энэ зэсийн салбар дээр зэс ялангуяа боловсруулалт хийдэг катодын зэс гаргах, үйлдвэрлэх энэ салбар дээр Эрдэнэт үйлдвэр хамаарахгүй төрийн өмчийн үйлдвэр хамаарахгүй гэж байгаад шинэ хөрөнгө оруулагч нарыг татах энэ асуудал болбол сүүлийн жилүүдэд яригдаж байгаа. Саяхан Туваан сайд энэ асуудлыг хөндөж тавьсан. Мөн хөрөнгө оруулж болзошгүй байгаа энэ салбарыг сонирхож байгаа улсууд ч бас энд ийм асуудлууд.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд гүйцээж хариулъя.

**Б.Жавхлан:** Тийм. Тэгэхээр энэ асуудал бол удахгүй ер нь нэлээн өндөр



түвшинд яригдаад асуудал нэг тийшээ болох байх нэгд.

2-т алтны НӨАТ дээр болбол хөнгөлөх, чөлөөлөх, тэглэх эд нар гээд ингээж яриад байдаг. Одоо бол бүрэн чөлөөлчихсөн байгаа. Татварын зарлагаасаа хасаж чадахгүй байгаа нь болбол үнэн мэдээж. Хэрвээ хасдаг болоод явъя гэвэл 90 хувийг нь хөнгөлөөд, 10 хувиа төлдөг ч юм уу тийм хэлбэрээр явах бас хувилбар байгаа. Бүрэн хөнгөлж бол бас болохгүй юм байгаа юм. Энэ чинь тэгэхгүй болбол нөгөө яг нүүрс шиг бас тэнд, энд *moral hazard* үүснэ. Өөрөөр хэлбэл энэ чинь шууд экспортолж байгаа биш, дотоодынхоо бид өөрсдийнхөө үндэсний Төв банкандаа тушааж байгаа учраас энэ бол экспорт биш. Тэгэхээр тэр лүү бол шилжээд яваад орчхож болохгүй. Зүгээр 90, 10 гэдэг ийм хувилбар болбол байж болно.

**Д.Амарбаясгалан:** Хөдөө аж ахуйн сайд Энхбаяр сайд хариулах уу? Аж үйлдвэрийн сайд хариулах ёстой юм уу? Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Төвийн бүсийг ХАА-г эрчимжүүлэн төрөлжүүлэн хөгжүүлэх аж үйлдвэрлэлийн дэд бүс гэж бодлогод заасан. Тэр хүрээнд 2 үйлдвэрлэлийг онцгой анхаарч байгаа. Хунсний үйлдвэрлэлийн агро паркуудыг Дархан хотод, мөн хөнгөн үйлдвэрүүдийн агро парк буюу энэ арьс шир, ноос ноолуурын эцэслэн боловсруулах үйлдвэрүүд Дархан хотод төвлөрнө. Тэгэхээр энэ бодлого хэрэгжинэ. Төсөвт нэлээн тодорхой эх үүсвэрүүд суусан. ЗГ зөвхөн дэд бүтцийг нь барих, ажиллах тэр орчныг нь бүрдүүлэх хэмжээнд оролцоно. Дотоодод хийх хөрөнгө оруулалтыг бол хувийн хэвшил өөрсдөө чиглэл чиглэлийн дагуу хийнэ. Бодлого тодорхой. Одоо эд зураг төсөл, ТЭЗҮ-үүд нь боловсрогдоод дуусаж байна. Яах вэ ганц нэг, зарим нэгэн өмнө хэрэгжүүлсэн маргаан үүссэн асуудлыг хэлэлцээрийн ширээний ард сууцгаасан. Тэгээд учраа ойрын үед олчих байх гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Энх-Амгалан сайд нэмж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Энэ гадаадаас ажиллах хүчин авах асуудлыг их олон гишүүд хөндөж тавьж байгаа юм. Тэгээд яах вэ зүгээр ер нь болбол энэ ЗГ-ын шийдвэр 16 салбарт болбол ингээд хязгаарыг нь ингээд авчихсан. ЗГ-ын шийдвэр албажаад саяхан энэ *legal info* дээр хэвлэгдсэн юм байна лээ. Энийг бас нэлээн хүлээсэн хүлээлт байсан болов уу гэж бодож байна 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал болбол тэр 50 хувийн хөнгөлөлтийн асуудал нь Их Хурлын тогтоолоор хөнгөлсөн юм байна лээ. Их Хурлын тогтоолоор. Тэгэхээр нэг нь нөгөө хязгаарлалтыг авсан нь ЗГ-ын тогтоол, хөнгөлөлт хийсэн нь болбол Их Хурлын тогтоол байгаа учраас энэ 2 тогтоолыг бид нар ойрын хугацаанд ер нь хэрэгжүүлэх энэ боломжуудыг л хангаж ажиллая л гэж харж байгаа юм. Энэ дээр л нэг ийм жаахан үл ойлголцлууд үүссэн юм байна, хэрэгжүүлэхэд бас нэг жаахан хүндрэлүүд үүссэн юм байна гэж харж байгаа 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал болбол яг энэ зөвшөөрөл олгож байгаатай холбоотой 2 сар алддаг юм байна. Яг үнэхээр үнэн юм байна. Тэгэхээр энэ 2 сар болж байгаа энэ хүнд суртлын энэ процессуудыг л бид нар автоматжуулах хүнээс хамааралгүй болох ёстой юм байна гэж харж байгаа. Тэгээд 3 дугаарт нь болбол бид нар хуулийн энэ хязгаарлалттай заалтууд дээр өөрчлөлт хийхээс өөр.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Нэгэнт ЗГ-ын шийдвэр гарчихсан юм чинь зарим процессыг нь бүүр байхгүй болгох хэрэгтэй байхгүй юу. Заавал ч үгүй нэг шат дамжлага байх ёстой юм шиг л хандаад байдаг тийм ээ. Тэгэхээр тэр процессуудыг нь байхгүй болгох дээр анхаарах хэрэгтэй. Дамдинням гишүүн тодруулж асууя.

**Г.Дамдинням:** Тэгэхээр яах вэ дээ яах вэ ЗГ-ыг маань ард түмэн маань сонсож байгаагаас гадна гаднын хөрөнгө оруулагчид сонсож байгаа шүү гэдэг утгаар л хэлсэн шүү Учрал сайдаа. Тэгэхээр бид нарт шинэ мөнгө хэрэгтэй. Шинэ мөнгө хэрэгтэй. Шинэ мөнгө хэрэгтэй энэ мөнгө хөрөнгө оруулалтаар орж ирнэ. Хөрөнгө оруулалтын орчныг таатай болгох асуудалд манай ЗГ-ын бодлого чухал. Мөн бас илэрхийлэх үг, үйлдэл чухал байгаа учраас бас анхаарна биз ээ. Яг тантай яг ижилхэн санал нэг байгаа. Би өөрөө ажлын хэсэгт нь орж ажилласан Үндэсний баялгийн сангийн хуулиа бол хэрэгжүүлэх тал дээр санал нэг байгаа.

2 дугаарт бас энэ 10 хувийн стратегийн ордуудыг 10 хувийг нь Хөрөнгийн бирж дээр гарах ёстой, листэд нээлттэй болох ёстой гэдэг зарчмыг хэрэгжүүлэх тал дээр ЗГ нэлээн ажилламаар байгаа. Тэгээд энэ хөрөнгө оруулалтын орчин энэ тал дээр уг нь энэ бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд л хариулах ёстой юм байгаа юм даа. Энэ лицензтэй холбоотой асуудлуудыг. Тэгээд байхгүй юм.

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

**С.Эрдэнэбат:** Анх удаагаа байж магадгүй Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын бас төлөөллийн хувьд төлөөлж орж ирсэн гишүүний хувьд энэ эрүүл мэндийн салбарынхан маань бас тодорхой санал, шаардлага тавиад төсөв энэ төлөвлөгөө хэлэлцэж байгаатай холбоотойгоор хэдэн шаардлага, санал хэлж өгөөч гэж хүссэн юм. Тэгээд миний бие бас төлөөлөөд очоод уулзсан. Тэгээд бүх гишүүдийн шууданд нь бас энэ санал, шаардлагуудаа тавьсан. ЭМД-ын санхүүжилтийн тогтолцооны гажуудлыг засъя гэж байна. Бид нар бас зарим талаар бол сайн зүйл их байгаа боловч хажуугаар нь гажуудалтай холбоотой нэлээн олон зүйл бас яваад

байна. Өнөөдөр эмч, ажилчид зарим талаар бол зүгээр мөнгө олох хэрэгсэл мэт болчхож. Гүйцэтгэл гэдэг үүднээс. Мааш олон, хурдан олон хүнийг үз, олон мөнгийг олж ирэх тэгж байж нэг цалин хөлсөө нэмэх гэдэг юм уу. Тэгээд энэ бол буруу тийшээ явах бас магадлалтай.

Үдээс хойш бас манай боловсролын салбарынхан уулзсан. Гүйцэтгэлийн үнэлгээ гэсэн чинь хүүхдэд нь муу дүн, бодит дүн тавиад байх юм бол багшийнх нь цалинг хасна гэдэг нэг иймэрхүү гажуудал бас яваад эхэлж байна шүү дээ. Тэгээд энэ 2 суурь салбар дээрээ бас нэг онцгой анхаарахгүй бол болохгүй юм шиг байна. Энэ тал дээр бол гишүүд маань бүх тойрог дээрээ бүгд л боловсрол, эрүүл мэндийг мэдэж байгаа учраас бас энэ тал дээр анхаарч өгөөч.

Энэ шаардлага дээр нь бол энэ төрөөс даатгал, даатгуулагчдыг хариуцдаг эрүүл мэндийн даатгалд 3 хувь болгож өгөөч гэж байгаа юм байна лээ. Одоо бол ингээд 2 хувь байгаа. 12 мянган төгрөг орчмын даатгал төлөөд бараг сая, 10 сая төгрөгийн үйлчилгээ авдаг. Ингээд ирэхээр чинь даатгалын сан чинь даахгүй болчихоод байгаа юм. Тийм учраас хүүхэд, ахмадуудынхаа төлөө төлж байгаа энэ юун дээр нэмэх боломж байна уу Сангийн сайдаа гэдгийг асуумаар байна.

Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэх ёстой гээд би өчигдөр бас Байнгын хороон дээр бол хэлсэн. Жил болгон бид нар бага багаар нэмээд явъя. Ачаалал хүндрэл өгөхгүйгээр. Энэ тал дээрээ бас та бүгд маань анхаараач. Суурь цалинг нь нэмэхгүйгээр цалинг индексжүүлж байна гэж ярьж болохгүй. Манай суурь цалин маань цагийн 1,2 доллар л байгаа. Монголчуудын цуваад байгаа Солонгост 8 доллар байгаа. Тэгэхээр Монгол хүний мөрөөдөл, ажил хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол Монголдоо байх ёстой, Солонгост байж болохгүй. Тийм учраас энэ тал дээр бол

анхаарч үзээч энэ төлөвлөгөөндөө оруулаач. ЗГ-ын юун дээр бол алга.

Дараагийн нэг асуудал нь энэ бага орлоготой иргэдийг татварын хөнгөлөлт үзүүлнэ гээд Гантөмөр дарга сайд яриад байсан. Тэгээд энэ хөтөлбөр дээр байхгүй юм. Нэмэлт орлого олох юм бол харин тэрийг нь хөнгөлнө гээд оруулаад ирчхэж. Тэгэхээр хүмүүс маань бага орлоготой болж харагдаж байгаад нэмэлт орлого олоод ирэх юм бол татвар нь хөнгөлөгдөнө гээд орж ирэх энэ чинь буруу тийшээ явчих биш үү? Тийм учраас энэ бага, дунд орлоготой иргэдээ энэ татварын бодлогоор дэмжих. Хаа байсан 200, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 240 мянга байхад л нэг хөнгөлөлт үзүүлж байсан юм. Тэрнээс хойш бас нэмэгдээгүй байгаа, индексжих ёстой болов уу гэж бодож байна.

Дараагийн асуудал нь энэ орчны аюулгүй байдал гэдэг дээр энэ хөдөлмөрийн аюулгүй байдал, энэ орчны аюулгүй байдал дээр бас анхаарахгүй бол Улаанбаатар хот ч гэдэг юм уу, хаана ч гэдэг юм нэг газ дэлбэрлээ, олон хүн үхлээ ингэлээ тэглээ энэ өөрөө улс төр болоод яваад байдаг. Тэгэхээр энэ тал дээр Их Хурал маань энэ хууль стандарт, дүрэм журмыг хянах тал дээр энэ ЗГ-ын мөрийн хөтөлбөр дээр энэ 25 оны төлөвлөгөө дээр оруулж өгөөч. Магадгүй энийг хамгийн сайн чадах хянах энэ төрийн бус байгууллагуудад нь бас өгөөд, хамтраад ингээд ажиллахгүй бол магадгүй энэ зун хэдэн кран унах юм, энэ намар, өвөл, хэдэн газ дэлбэрэх юм мэдэхийг нь таашигүй байгаад байгаа юм.

Хамгийн сүүлд нь хэлье. Төрийн албан хаагчийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангуулна гээд ЗГ-ын мөрийн хөтөлбөрт орчихсон. 25 онд энийг хангах чиглэлээр хөтөлбөртөө оруулж өгөөд, тодорхой ажил хиймээр байна. Төрийн албан хаагчдын зүгээс маш их бас санал, гомдлууд ирээд байна. Халаа сэлгээтэй холбоотой, янз бүрийн ялгаварлан гадуурхахтай холбоотой саналууд ирээд

байдаг. Өөрөө өөрийгөө хамгаалдаг тийм юуг нь бий болгох, энэ хүний эрхийг хангах гэсэн парламентын маань бас гол зорилтын нэг нь энэ байх болов уу гэж бодож байна. Тийм учраас энэ тал дээрээ хөтөлбөр дээрээ бас оруулж өгөөч гэж хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Саналууд голицуу хэлсэн. Гантөмөр сайд хариулт өгье.

**Л.Гантөмөр:** Эрдэнэбат гишүүний саналуудыг дэмжиж байна. Ялангуяа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бол нэмэгдэнэ. Тэрийг парламент ярьж байгаад хэдүүлээ ЗГ-тайгаа хамтраад хийчих хэрэгтэй гэж бодож байна. Ер нь тэр татварын реформ болбол яаран хийж чадахгүй байгаа бодит үнэнээ хэлмээр байна. Бид ирээдүйд ирж магадгүй эрсдэлүүдийг хаах нь ирэх оны хөгжлийн төлөвлөгөөний гол зорилт гэдгийг л хэлмээр байгаа юм. Эхлээд нэг тийм айдасгүй болчихмоор байна. Яагаад гэвэл өнөөдөр хуртэл ингээд туулсан зам маань дандаа уналт, босолт дунд энэ улс яваад байна. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байхад сайхан амьдраад, үнэ муудахаар зэрэг доошоогоо орчихдог. Эсхүл газрын тосны үнэ жоохон өсөхөөр амьдрал муудаад, газрын тосны үнэ гайгүй болчихоор амьдрал гайгүй болчихдог гээд ийм савлагаатай амьдрал өөрөө Монгол Улсын хөгжлийг уруу татаад байна. Тийм учраас нэг.

2 дахь нь болбол ерөөсөө энэ нэг ДНБ-ийг бид нар 10 мянган доллар луу аваачих яг тэр суурийг л цаг хугацаатай уралдаж хэдүүлээ хиймээр байна. Тэгвэл бид нар энэ нэг баялгийн хараалаас гарчих юм байна. Энэ баялгийн хараалын ард гарахад бол бидний хэлж байгаа энэ эрүүл мэнд, боловсролын салбарын хүмүүсийн маань амьдрал ахуй тогтвортой байдал, нийгмийн баталгаа гэдэг зүйл болбол бодитой байх нь. Тэгэхээр хэдүүлээ нэг айхтар савлагаагүйгээр эхний хийх ажлуудаа нэг хийх гэж оролдоод ард нь

гарья л гэсэн ийм л төлөвлөлттэй байгаа. Түүнээс биш таны урдаа тавьчихсан байгаа лоозонг болбол бид нар бүгдээрээ дэмжиж байгаа. Ийм болох ёстой. Тийм учраас бол тэрний төлөө хийх ажлын төлөвлөгөөгөө л хэдүүлээ энэ улс орны хөгжлийн төлөвлөгөө гээд өнөөдөржингөө ингээд хэлэлцээд сууж байгаа юм гишүүнээ. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Дашдондогийн Ганбат гишүүн асуултаа асууя.

**Д.Ганбат:** Бид нар ингээд бас оролдоод байгаа нь сайн л даа. Тийм. Үгүй ээ тэгээд энэ чинь юу л байна л даа. Ингэж хөгжсөн улс орон байхгүй л дээ. Энэ бол тэгээд л нөгөө бид нар 70 жил социализмын гээд социализм ярьж байсан. Бас л нэг үлгэр яриад л нэг их сайхан, сайхан юм ярьдаг байсан. Яг энэ маягаараа бол Аргентин гэж сайхан улс орон байж байгаад л хүнд байдалд орсон. Дараа нь бас Венесуэл бас энэ байдал руу орсон ийм байгаа юм. Хэд хэдэн тодорхой асуудлууд асууя.

Эрчим хүчний үнэ чөлөөлнө гээд байгаа. Эрчим хүчнээс бол бид нар бол хараат шүү дээ. Эх үүсвэр бол хангалттай биш, тийм байж уг нь эрчим хүч чөлөөлдөг. Одоо чөлөөлөөд цахилгааны үнэ чинь хэд болох юм бэ, дулааны үнэ чинь хэд болох юм бэ, хэдийнээс чөлөөлөх юм бэ? Энийг нэг сонсмоор байх юм. Уг нь бол АН-ыг байх үед 700мвт-ын цахилгаан станц Багануур дээр бол бараг барьж ашиглалтад оруулах гээд хүмүүс нь ирчихсэн байсныг тэгээд зогсоосон. Тэр Бөөрөлжүүт дээр бол хувийн хэвшил хийж байгаа гэж байгаа. Тэр нөгөө ямар санхүүжилтээр яаж хийж байгаа юм бэ? Тэрийг нэг асуучихъя.

Энэ манай хангайн бүс 1 дүгээр тойрог Баянхонгор, Архангай, Өвөрхангай гээд байна л даа. Манай Баянхонгор бол ямаагаар бол нэгд ордог улсдаа. Архангай бол хониор нэгд ордог. Бид нар бол энэ 3 аймаг бол гадагшаа

гарах гарц байхгүй, боомтгүй гэсэн үг. Тэгээд энэ малчид маань уг нь ажиллах хүчний 25 хувь, ХАА бол Монгол Улсын эдийн засгийн 12 хувийг эзэлж байна л даа. Яг энэ малчдын талаар ямар ажил хийсэн бэ, хийх юм бэ? Ирж байгаа энэ жилд. Ямар ч юм алга байна шүү дээ. Энэ өвөл бол нэлээн хатуу өвөл болох байх. Энд бэлтгэлтэй байна уу? Энэ зун бол тэгс ингэс гээд л сандал, ширээ ярьсаар байгаад л дуусгалаа шүү дээ. Энд надад нэгд хариулаарай. Тэр малчид сонсох байх.

Хурал цуглаан хийх юм. Ер нь л их хуралдаад л, уриа лоозон гараад л, нэг сүржин, сүржин юм яриад л, тэгээд л даржин төгсгөлтэй л байдаг л даа. Баахан л макет хийх юм шиг байна. Энэ сайд нар дээр баахан зураг, төслийн мөнгө төгрөг гээд тавьчихсан байна лээ. Хэд, хэд дээр хэдэн төгрөг тавьсан юм бэ? Өмнөх макетууд бид нарт байж л байгаа шүү дээ. Одоо хэдэн макет байгаа, цаашидаа хэдэн макеттай болох юм бэ? Жишээлбэл нефтийн үйлдвэр гэж байна. Хэчнээн жил ярилаа. Тэгж байгаад нэг орно, тэгээд нөгөө нефть нь байхгүй, бүгдийг нь гадагш нь гаргачихсан нөөц нь. Тэгээд нэг болохгүй бүтэхгүй юм хийчхээд л, дараа нь нефть түүхий эд нь алга л гэж ярих байх. Мааш их мөнгөөр 3, 4 зам өргөн төмөр зам аваачаад тулгачихсан боомтууд руу. Мэдээж хэрэг урд хөрш юу гэж л өргөн төмөр замыг хилээр оруулах вэ? Урд хөрш бол бүх улс оронтойгоо нарийн царигаар холбогдчихсон байна. Энийгээ яах юм бэ?

Хиймэл дагуул гэж байна. Манай бас Цахим хөгжлийн яам бас нэлээн ажил хийсэн, сайн байсан. Тэрийг нь ч дэлхий нийт үнэлээд нэлээн дээгүүр байранд оруулчихсан байна лээ. Гэхдээ энийгээ бас төрийн албан хаагчдаа багасгах энэ юм хум руу чиглүүлэх хэрэгтэй. Нөгөө талаар бол хиймэл дагуулаа хэдэн саяар хийх гээд байгаа юм бэ? Техник технологи мааш хурдацтай хөгжиж байна.



**Д.Амарбаясгалан:** Хэн хариулт өгөх вэ? Чойжилсүрэн сайд эхлээд хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Ганбат гишүүнээ эрчим хүчний салбар сүүлийн жилүүдэд алдагдалтай байгаа нь үнэн. Сая таны урд талд Энхцэцэг гишүүний асуултад бид нар бас хариулсан. Яг өнөөдрийн байдлаар хуримтлагдсан богино хугацаатай өр төлбөр 540 орчим тэрбум төгрөгийн өртэй. Урт хугацаатай өр төлбөр 1,8 их наяд байна. Эрчим хүчний өөрийнх нь үнэ болбол жишээлбэл 285 төгрөгийн өртөгтэй, ахуйн хэрэглэгч нарын борлуулж байгаа үнэ болбол дунджаар 140 төгрөгийн үнэтэй ийм алдагдалтай явсан. Олон жил алдагдалтай явсан учраас энэ алдагдлууд маань өр төлбөр болоод хувирчихсан ийм хүнд байгаа нь үнэн.

Тэгэхээр эхний ээлжид тэр эрчим хүчний либералчлал хийе гэдэг болбол өргөн ойлголт бий. Эхний ээлжид ямар ч байсан цахилгаан эрчим хүч борлуулах үнийг өртөгт нь дөхүүлэх ийм тооцооллуудыг Эрчим хүчний зохицуулах хороон дээр хийгээд явж байгаа. Энэ оны 4 дүгээр улирлаас энэ асуудлыг шийдэх болов уу гэсэн ийм баримжаа хүлээлттэй байгаа. Бүрэн эрхээрээ Эрчим хүчний зохицуулах хороо үнэ тарифыг баталдаг ийм зохицуулалттай.

Багануурын дулааны цахилгаан станцын төсөл явж байгаад харамсалтай нь зогсчихсон байгаа. Хятадын ТӨК-д энэ төслөө болбол цаашаа үргэлжлүүлээч гэдэг шаардлагыг би сүүлийн 2 жилийн хугацаанд уулзаад явж байгаа. Шинэ хөрөнгө оруулагч хайж байна гэдэг ийм мэдээлэл, ийм хариулт өгдөг. Бөөрөлжүүдийн цахилгаан станцын тухайд болбол хувийн хэвшил хэрэгжүүлж байгаа. Нийт хүчин чадал нь бол 600мвт, түүнээс эхний 150мвт-ыг нь энэ 10 сарын 5-ны өдөр ажиллагаанд авч туршилтад, холболтын туршилтын холболт хийх нээлт хийх ийм

төлөвлөгөөтэй явж байгаа. Хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан. Тусгай зөвшөөрөл цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг болбол 12-оос 16 оны хооронд хийгдсэн ийм төсөл байгаа.

Түүнээс гадна хэд хэдэн төслүүд хэрэгжилтийн шатандаа эхлээд явж байна. Эхнийх нь бол энэ Баян сум дээр 660мвт-ын цахилгаан станцын шав тавих ажиллагааг бас 10 сарын 5-ны өдөр бид нар хийнэ. Сэлэнгэ аймагт 70мвт-ын цахилгаан станц ажил нь эхлээд явж байгаа. Тосонцэнгэл сумд Завхан аймгийн 30мвт-ын цахилгаан станц энэ ондоо багтаад ашиглалтад орохоор төлөвлөгөөтэй явж байна. Дорнод бүс дээр 50мвт-ын цахилгаан станц бид нар ашиглалтад авсан, сүлжээнд холбосон, Улсын комисс ажиллаж байгаа ийм байдалтай явж байгаа. Ямар ч байсан 2027-гоос 28 оны өвлийн оргил ачааллын үеэс эхлээд болбол төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон эх үүсвэрийн хүчин чадал, хэрэглээгээ баттай давах, цахилгаан хязгаарлахгүй болох нөхцөл болбол 27 оны өвлөөс 28 онд шилжих өвөлд болбол асуудал хийгдэнэ. Энэ жил жишээлбэл бид нар 230 орчим мегаваттын хүчин чадалтай эх үүсвэр оруулаад байгаа боловчиг манай энэ.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя, Чойжилсүрэн сайдад микрофон өгье.

**Б.Чойжилсүрэн:** Өвлийн оргил ачааллын үед чадлын өсөлт маань хэрэглээний чадлын өсөлт маань өнгөрсөн жил 11,8 хувьтай өссөн. 2024-өөс 25 оны өвлийн үед болбол энэ хэмжээгээр өсөх юм болбол магадгүй хэрэглээ маань 300 орчим мегаваттаар нэмэгдэх учраас яг энэ 230мвт-ыг оруулаад байгаа боловчиг бид нар бас яг шууд бүрэн хязгаарлахгүй байж чадахгүй гэдэг чадлынхаа хэрэглээнийхээ өсөлтийг давж чадаагүй байдалтай ингээд явж байгаа юм. Тэгэхээр бид нар судалгаа хийж үзэхээр нийт судалгаанд хамрагдсан иргэдийн

маань 70 орчим хувь нь яг өвлийн оргил ачаалал эхлэхээр бид нар цахилгаан хэрэглээгээ нэмэгдүүлэх эсэхээ шийднэ гэдэг ийм судалгааны дүн гараад, харамсалтай нь судалгаа маань бүрэн гүйцэд, чанартай хийгдэж өгөхгүй ийм хүндрэл бол байгааг нууцгүй үнэнээр хэлэх ёстой.

**Д.Амарбаясгалан:** Нэмж хариулах хүн байна уу? Учрал сайд нэмж хариулъя.

**Н.Учрал:** Энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт суусан 14 мега төсөл болбол ер нь экспортыг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа. 2-т болбол энэ удаагийн ЗГ-ын хөтөлбөр болбол энэ шинжлэх ухаан, эх өгөгдөл, хиймэл оюун ухааныг ашиглах буюу ер нь бол цаашидаа энэ дэд бүтцээ сайжруулах чиглэл рүү л анхаарч байгаа. Жишээ нь зүгээр хиймэл дагуул дээр нэг зүйлийг хэлэхэд жишээ нь Баянхонгор аймаг гишүүд бол сум руу, баг руу шилэн кабелиар интернэт оруулж өгөөч гэж их хүсэлт тавьдаг байсан. Одоо бүх сумд болбол шилэн кабелийн интернэт орсон хэдий ч сумаас сумын хооронд, багаас багийн хооронд, суурин газрууд дээр интернэт сүлжээ, холбоо харилцаа байхгүй. Үүнийг цаашидаа шийдвэрлэвэл бараг 29 их наяд төгрөг улсын хэмжээнд хэрэгтэй байгаа.

Ингээд дэд бүтцийнхээ төрлийг өөрчилж гээд Франц Монголын ЗГ-ын хоорондын хэлэлцээрээр 15 жилийн хугацаатай зээлээр энэ төслийг явуулах нь. Ингэсний үр дүнд болбол нэг талаасаа болбол зардлаа ч нөхнө. Нөгөө талаасаа үндэсний аюулгүй.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууна.

**Д.Ганбат:** Би тэр үнэ чинь хэд болох юм бэ? Ард түмний нуруун дээр эрчим хүч, цахилгаан, дулааныхаа үнийг яаж болохгүй шүү гэж хэлээд байгаа шүү дээ. Тэр цаг нь биш. Эхлээд эх үүсвэрүүдээ баталгаатай болго, хангалттай болго гэж хэлж байгаа юм.

Тэр аягүй хөгжилт, техник технологийн дэвшил аягүй хурдтай явж байна. Старлинг хэдхэн жилийн ч юм уу, сарын өмнө ямар үнэтэй байлаа тийм ээ, одоо ямар үнэтэй буучихсан байна. Орон нутгийн сонгуулиар бүгдээрээ л хэрэглэж байсан шүү дээ. Наад хиймэл дагуул чинь тэгээд яг ашиглаж бариад оруулчихдаг тэр үед чинь ямар ч хэрэггүй болчихсон байх юм биш үү? Ийм нэг юм байна.

Тэгээд нөгөө талаар бол энэ юу байна. Энэ би боловсролын асуудлаар яримаар байна бас. Энэ Кембрижийн хөтөлбөртэй сургууль энэ 3 аймагт 1, 1 хийгээд өгчхөж болохгүй юу. Тэгээд Хэнтий рүү болохоор бүүр сумдаа хийдэг гэж дуулдаад байх юм, үнэн юм уу?

**Д.Амарбаясгалан:** Минут дууссан. Нэмж хариулт өгөх хүн байна уу? Энхбаяр сайд, дараа нь Учрал сайд нэмж хариулъя, дараа нь Наранбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Монголын нүүдлийн соёл иргэнийл, энэ биет болон биет бус өвийг гол тээж байгаа малчид түмнийхээ төлөө Монголын төр томоохон бодлого хэрэгжүүлж байгаа. Тэрний илрэл нь энэ чинээлэг малчин энэ хоршооны хөдөлгөөн. Энэ хүрээнд малчдаа хөдөлмөрөөрөө эвлэх, нэгдэх ийм бололцоог санхүүжүүлж зохион байгуулалтад оруулж байгаа. Энэ зохион байгуулалт маань улмаар боловсруулах үйлдвэрүүдтэйгээ холбогдох ийм иж бүрэн томоохон арга хэмжээ болж хувирна. Зудын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас нэлээн үүссэн эрсдэлийг бууруулах чиглэлээр томоохон арга хэмжээ авсан. 23-аас 24 оны өвлийн зудын холбоотой малчны зуун найман мянга найман зуун, 108 мянган малчны зээлийн 1,3 их наяд төгрөгийн энэ зээлийн хүүгийн 22-оос 14 хувийг ЗГ төлж хариуцаж явж байгаа. Мөн энэ хоршоо хөдөлгөөний хүрээнд өнөөгийн байдлаар 1 их наяд төгрөгийн зээл гараад.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Гүйцээж хариулъя Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** 1 их наяд төгрөгийн санхүүжилт гараад энэ хоршоо хоршооллын хөдөлгөөнийг бүрэн дэмжиж байна. Улс орон даяар энэ арга хэмжээ өрнөж байна. Мөн түүнчлэн мал эмнэлэг, малын эрүүл мэндийн чиглэлээр томоохон ажлыг төр хариуцаж хийдэг. Зөвхөн өнгөрсөн онд гэхэд л 35 сая малыг дархлаажуулалтад хамрагдаж, эрсдэлээс бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн Атрын 4 дүгээр аян гээд энэ хөтөлбөр төсөвт өргөн баригдсан байгаа. Хэрвээ энэ бүгдийг та бүгд баталбал тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, энэ байгаль цаг уурын энэ эрсдэлийг даван туулах чадавхыг бүрдүүлэх чиглэлээр нэлээн томоохон ахиц гарч, бүсчилсэн бүс нутгийн тэжээлийн аж ахуй, тэжээлийн том бааз, тэжээлийн үйлдвэрүүдийг барьж байгуулах ийм зорилтыг бас ЗГ-аас дэвшүүлж байгаа. Тэгээд энэ малчдадаа чиглэсэн бодлого цаашидаа ч тогтвортой ч байнга үргэлжлэх болно гэдгээ хэлье.

**Д.Амарбаясгалан:** Ням-Осорын Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** 2011 оноос хойш энэ үндэсний хиймэл дагуулыг хөөргөх чиглэлээр олон ТЭЗҮ боловсруулсан, олон судалгаанууд хийгдсэн. Харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн Франц улсад айлчлах үеэр энэ төсөл гараанаас гарсан. Энэ үндэсний хиймэл дагуулын гол онцлог бол хамгийн сүүлийн үеийн тоон технологийн хиймэл дагуул. Яг Korean sat-тай адилхан, Солонгосын хиймэл дагуултай адилхан. Ингээд Солонгосын хиймэл дагуулд манай хувийн компаниуд яг одоогийн байдлаар жилд 9,2 сая орчим доллар төлдөг. 2 жилийн дараа энэ тоо 20-д хүрнэ. Ингээд 15 жилийн хугацаанд бараг 400 руу хүрнэ шүү сая доллар. Тэгэхээр 15 жил хөөргөчих юм бол зардлаа нөхнө, 2-т улс эх орны өнцөг булан бүрд интернэт харилцаа холбоо баталгаатай болно. Старлинк болбол

газрын станц нь Монголд байхгүй, Японд байгаа шүү. Энэ тохиолдолд бол бид нар газрын станцуудыг Монголд хийснээрээ үндэсний аюулгүй байдлын хувьд бол баталгаажна л гэсэн үг.

**Д.Амарбаясгалан:** Наранбаяр сайд хариулт өгье.

**П.Наранбаяр:** Энэ ер нь бол энэ ахлах сургуулийг төрөлжүүлэх, энэ сургалтыг ер нь зөвхөн Кембриж гэдэггүй олон ийм янз байдалтай болгох явдал бол чухал байгаа. Тэгэхээр жишээлбэл төрөлжсөн ахлах сургуулиуд ийм зүйлүүдийг бүсүүдэд байгуулах энэ ийм бодлого бол тусчихсан байгаа юм.

2 дугаарт нь энэтэйгээ зэрэгцээд олон улсын сургалт бүхий ийм сургуулиудыг бас байгуулах асуудлууд бас туссан байгаа юм. Түүний зэрэгцээ энэ Коосэн гээд энэ технологийн чиглэлээр сургалт явуулдаг инженер бэлддэг ийм сургалттай сургуулиуд ч гэсэн бүсүүдэд байгуулахаар туссан байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгөхийг хүсье. Дуламын Бум-Очир гишүүнээр тасаллаа. Нийт 13 гишүүн үг хэлнэ. Отгоншиарын Батнайрамдал гишүүн үг хэлье.

**О.Батнайрамдал:** Баярлалаа. Монгол Улс бол уул уурхайн өндөр баялагтай орон. Бидний 2025 оны хөгжлийн төлөвлөгөө ярьж байгаатай ч уялдуулаад ер нь бид нарын хамгийн том асуудал эргээд л энэ байгалийн баялгийн ерөөсөө шударга хуваарилалт. Байгалийн баялгийн шударга хуваарилалтыг бид нар хийхгүй бол улс төрд, нийгэм, эдийн засагт, ард түмний бухимдал дээр ч гэсэн асуудлууд цогцоороо шийдэгдэхгүй гэсэн үг юм. Тэгэхээр яг энэ асуудалтай холбоотойгоор 2019 оны Үндсэн хуулийн маш чухал бол нэмэлт, өөрчлөлт дээр орсон. Үндсэн хуулийн 6.2 дээр энийг зарчмын хувьд бол маш ойлгомжтой

тусгаж өгсөн байгаа юм л даа. Газрын хэвлийн баялаг бол төрийн нийтийн өмч. Нэг ёсондоо энэ бол ард түмний өмч юм. Үр өгөөжийг нь Үндэсний баялгийн санд бид нар төвлөрүүлж, илүү шударга хуваарилалтыг хийнэ.

3 дугаарт бас нэг чухал зүйл бол энэ Үндсэн хуулийг уншиж байгаа шүү. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд дийлэнх нь ноогдохоор гээд зарчмыг бол маш ойлгомжтой тусгаж өгсөн байгаа юм л даа. Тэгэхээр үүнтэй уялдуулаад Үндэсний баялгийн сангийн тухай хууль ч батлагдсан. Энэ хууль бас ер нь бол бараг 10 хэдэн жил бас хууль болно гэж яригдаж зөндөө явсан. Миний хувьд Уул уурхайн дэд сайдаар ажиллаж байхдаа ч гэсэн бараг энэ хууль дээр 3 жил бас ажилласан. Тэгээд ямар ч байсан Баялгийн сангийн тухай хууль маань батлагдлаа. Тэр дундаа яг олон нийт рүү чиглэсэн, тэр дундаа хүний хөгжил рүү чиглэсэн хамгийн чухал сангийн нэг бол яалт ч үгүй Хуримтлалын сан. Үндэсний баялгийн санд хамаарах 3 сангийн нэг Хуримтлалын санд бол уул уурхайн баялгаар дамжуулаад цаашидаа бид нар энэ орон сууцын томоохон асуудлуудыгаа шийдэцгээе, хүний хөгжил болох яг үр хүүхдийнхээ боловсрол руу боловсролын чанар луу, мөн иргэдийнхээ эрүүл мэнддээ даацтай хөрөнгө оруулалтыг байгалийн баялгийн хуваарилалтын энэ механизмаар Үндсэн хуулийн 6.2-т заасны дагуу хийе гээд энэ Үндэсний баялгийн сангийн тухай хууль маань батлагдсан байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр бид нар зөвхөн нийслэлийг аваад үзэхэд Улаанбаатар хотод ер нь цаашидаа бид нар гэр хорооллыг хэрхэн орон сууцжуулах вэ. Энэ дээр бол жишээлбэл Сэлбэ дэд төвийн хүрээнд ч гэсэн бид нар газар чөлөөлөлт хийгээд томоохон шийдлүүд гаргаад явж байгаа юм. Тэгэхээр Улаанбаатарт тулгарч байгаа, Монгол Улсад тулгарч байгаа нийтлэг асуудлууд шийдэл байхгүйдээ биш. Хамгийн гол нь тэр

шийдлүүдийг санхүүжүүлэх эх үүсвэр, санхүүжилт нь байна уу гэдэгтээ л хамгийн гол асуудал байгаад байгаа юм л даа. Тэгэхээр энэ баялгийн шударга хуваарилалт хийе гэсэн ч гэсэн энэ Баялгийн сангаар дамжуулж тэр дундаа энэ Хуримтлалын сангаар дамжуулж бид бүхэн энэ хуваарилалтыг бас заавал яг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасны дагуу тусгах ёстой. Тэгэхээр яг үүн дээр одоо л яг эд яригдаад эхэлж байна л даа. Яг хөрсөн дээр буугаад ажил хэрэг болгоход бол Үндсэн хуулийн 6.2 дээр заасан тэр стратегийн ач холбогдол бүхий ордууд дээр Хуримтлалын сан дээр бол 34 хувийн ноогдол ашиг Хуримтлалын сандаа бий болсноороо буцаад орон сууцжуулалт, боловсрол, эрүүл мэнд рүү даацтай томоохон хөрөнгө оруулалт орох энэ үүд хаалга энэ санхүүжилт нь босох юм.

Тэгэхээр ямар ч байсан ЗГ бол шийдвэр гаргаад, Учрал сайд ЗГХЭГ-ын дарга ахлаад энэ хэлцлийг эхлүүлсэн байна. Тэгэхээр энэ хэлцэл өөрөө заавал амжилттай болох ёстой. Ингэж байж Хуримтлалын сан өөрөө ажил хэрэг болж, яг ард түмний амьдралд өөрчлөлт орох, орон сууцжуулалтыг томоохон санхүүжилтээр хийх энэ боломж нь бас нээгдэх учиртай. Тэгэхээр ер нь 2025 онд, цаашидаа дараагийн 4 жилдээ ч гэсэн бид нарын заавал анхаарах ёстой зүйл энэ Үндэсний баялгийн сангийн санхүүжилт хийгдэх нь үү, энд буцаад хөрөнгө оруулалт нь хийгдэх нь үү, энэ дээр бид нар заавал.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Дуламын Бум-Очир гишүүн үг хэлнэ.

**Д.Бум-Очир:** Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд боловсролын салбарт бол маш их ахиц дэвшил гарсан гэж ойлгож байгаа. 2020 онд боловсролын салбарын төсөв 1,3 их наяд байсан, 2024 онд 4,2 их наяд болсон, ДНБ-ий 5 хувьд хүрсэн үзүүлэлтэд хүрсэн. Энэ бол түүхэн үзүүлэлт. Цаашид энэ үзүүлэлтийг улам



нэммээр, нэмэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл өнгөрсөн хугацаанд боловсролын салбарт бол томоохон сэргэлт ирсэн. Энд бол бид нар төр засагтаа баярлах ёстой, ЗГ-т баярлах ёстой.

Миний хэлмээр байгаа гол зүйл бол юу вэ гэхээр цаашид энэ салбараа бид яаж дэмжих юм бэ? 25 оны хувьд бол 90 сургууль нэмж ашиглалтад орно гэж байна. Энэ нь 40610 суудал юм байна. 62 цэцэрлэг ашиглалтад орно гэж байна. Энэ нь 9540 ор юм байна. Энэ боловсролын салбарын сэргэлт бол зөвхөн эхлэл юм гэдгийг би онцгойлон хэлмээр байна. Мааш олон ажил хийгдэхээр хүлээгдэж байна. Мааш олон ажил хийгдэхээр хүлээгдэж байна. Бид өмнө нь олон удаа ярьсан. Энэ багш нарын дутагдалтай байдал, энийгээ дахиад ярих гэж байна. Энэ багш нарын дутагдлаа энэ 25 онд яг яаж тодорхой нөхөх юм бэ? Цалин бол гол асуудал биш юм шигээр бас Боловсролын сайд нэг тийм яриа өгчихсөн байх юм. Үнэндээ бол цалин гол асуудал мөн шүү дээ. Энэ гэрчилгээ тараагаад яг багшийнхаа дутагдлыг бид нар шийдэж чадах юм уу? Хүмүүс маш их эргэлзэж байна.

Тэгэхээр бидний авах ёстой гол бодлого бол энэ үе шаттайгаар багш нарынхаа цалинг нэмэх тухай асуудал байгаа. Яг энэ хөтөлбөр дээр үе шаттайгаар нэмэгдүүлнэ гээд байна. Энэ инфляцтай уялдуулан 6 хувь нэмэхээс тусад нь энэ асуудлыг яримаар байна. Тэр бол тэртээ тэргүй автоматаар нэмэгдэх 6 хувь. Түүнээс гадна үе шаттайгаар хэрхэн нэмэгдүүлэх арга аргачлалаа, хэдэн төгрөг болох юм, тэр мөнгийг нь хаанаас гаргах юм гэдгээ энэ 25 оны хөтөлбөр, төлөвлөгөөндөө илүү тодорхой тусгаж өгвөл яасан юм бэ. Хамгийн гол нь олон нийтэд хүлээлт үүсчхээд байна шүү дээ. Бид нар боловсролын тухай зөндөө ярьсан. Асуудлуудыг нь гаргаад тавьсан. Тэгээд энийгээ дорвитой үргэлжлүүлэхгүй бол магадгүй энэ хүлээлт өндөр байгаа, тэр хүлээлтэд бидний хийж төлөвлөж байгаа ажил хүрэхгүйд хүрэх юм биш үү. Тэрнээс чинь

болоод магадгүй энэ багш нар зарим нь бол салбар дундаасаа Боловсролын сайдыг огцруулах хүртэл ийм санал хүргүүлээд байна шүү дээ. Тэгэхээр энэ асуудлаа ЗГ, Боловсролын яам, сайд анхаараад, ялангуяа миний хэлмээр байгаа гол зүйл бол юу вэ гэхээр хэрхэн үе шаттайгаар нэмэгдүүлэх юм бэ гэдгээ тодорхой санал санаачилга гаргаад, тодорхой тайлбар хэлбэл яасан юм бэ. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Загджавын Мэндсайхан гишүүн үг хэлнэ.

**З.Мэндсайхан:** Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Өглөөнөөс хойш Их Хурлын дарга ч гэсэн шаардлага тавиад л байх шиг байна энэ сайд нарыг байлгах ёстой гээд. Энэ Уул уурхайн сайд гэдэг хүнийг би ерөөсөө хайгаад Байнгын хорооны хурал дээр ч гэсэн олохгүй байгаа юм. Тэгээд Монгол Улсын хөгжлийн гол гарц бол уул уурхай дээр суурилна. Монгол Улс бол ХАА-н орон биш болсон, уул уурхайн орон болсон гээд телевизээр яриад энд тэнд харагдаад яваад байх юм. Ховд аймгийн Мянгад суманд хувийн хэвшлийн хайгуул хийж байгаа өмнө нь иргэдийн эрүүл ахуйд, аюулгүй орчинд хор хөнөөлтэй ийм төсөл байна гээд зогсоосон төслийг Туваан сайд эхлүүлнэ, ажиллуулна гэсэн. Энэ асуудлаар гэж миний бие сарын өмнө хуулийн хугацаанд асуулга тавьсан. Энэ сайд хуулийн хугацаанд хариулт өгөхгүй байна. Энд ямар эрх ашиг байгаад энэ хүн энэ асуудлаас зугтаад, Их Хурлын гишүүний хуулийн дагуу тавьсан санал асуулгад хариулт өгдөггүй юм бэ? Энэ тал дээр ЗГ энэ хариуцсан сайд нартаа бас хэлмээр байна.

Байгаль орчны сайд бас энэ Халзан бүргэдэйн асуудлаар танай Төрийн нарийнаас би Байнгын хороон дээр асуулт асуусан. Албан ёсоор хариу өгнө гэсэн, өнөөдрийг хүртэл байхгүй. Тэгээд ийм аргацаасан байдлаар зугтаад яваад баймааргүй байна сайд нар. Энэ дээр

албан ёсны хариу өгөөч гэж хэлэх гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн үг хэлнэ.

**Ч.Лодойсамбуу:** Баярлалаа. Ер нь жил жилийн сонгуулийн намуудын мөрийн хөтөлбөр болбол бүгдээрээ л хувийн хэвилийг дэмжинэ, бизнесийн таатай орчныг бүрдүүлнэ, үйлдвэрлэгчдээ үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжинэ, дотоодын үйлдвэрлэлээ дэмжинэ гэдэг ийм заалттай, чимэгтэй л явдаг л даа. Тэгээд энэ чимгээ өнөөдөр хэрэгжүүлэхээ бид нар энэ эхний жилийнхээ шинэ парламент эхний жилийнхээ анхны хөгжлийн төлөвлөгөө дээр бүүр нарийн тусгаж өгмөөр байгаа юм. Тэгээд бизнес эрхлэгчдийн хэлж байгаа асуудлууд болбол бүгдийг нь багцлаад хэлэхэд маш олон хуулиудад бид нар нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа. НӨАТ-ын хууль байна, Нийгмийн даатгалын хууль байна, Эрүүл мэндийн даатгалын хууль байна, Хөдөлмөрийн тухай, Өрсөлдөөний тухай, Хүнсний тухай гээд бүгд ингээд бизнес эрхлэхэд саад тотгор учруулж байгаа гээд зовлонгоо жил болгон л бид нарт хэлж байгаа юм л даа. Тэгэхээр энэ хуулийн дөнгөнүүдээс бид нар салгаж, бизнес эрхлэгчдээ бодитойгоор дэмжинэ гэдгээ энэ ерөнхий төлөвлөгөөндөө бид нар тусгаж өгөх зайлиггүй шаардлагатай байгаа юм.

Тэгээд түрүүн энэ татварын дарамттай холбоотой, даатгал шимтгэлүүдтэй холбоотой энэ дарамтуудтай холбоотой юман дээр би Сангийн сайдтай яриад сүүлд нь тодруулах гэсэн хугацаа маань хүрсэнгүй л дээ. Тэгээд одоо ямар асуулт асууж, хариулт авч болох биш. Гэхдээ нэг зүйл байгаа юм. Бид нар ингээд өнгөрсөн хурал дээр Их Хурал нэг шийдвэр гаргасан. Тэр нь нөгөө иргэд 100 мянган хүн нийлээд, 100 мянгаас дээш хүн нийлээд гарын үсэг зураад, дэмжээд явах юм бол хууль санаачлах эрхтэй болсон. E-petition. Энэ дээр жишээлбэл нэмэгдсэн өртгийн албан

татварыг 5 хувь болгоё гэдэг 200 мянган шахуу гаруй иргэдийн дэмжлэг авчихсан ийм санал байж байгаа. Тэгээд манай дээр хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдсан билүү, яасан билээ, ингээд царцчихсан.

Тэгээд Их Хурлын даргаа цаашидаа энийгээ яах юм бэ гэдгээ бас нэг хэдүүлээ бодолцмоор юм байна. Энэ E-petition-ийг цааш нь ажиллуулах юм уу, яах юм. Ажиллуулахгүй болбол ингээд иргэд хууль санаачлах эрхтэй ч юм шиг, үгүй ч юм шиг ийм байдалтай байх нь өөрөө эргээд энэ парламент, төрийн нэр хүндийг унагааж байна л даа. Тэгээд энийгээ бас хэдүүлээ шийдэх, нэг талд нь гаргах шаардлагатай. Тэгээд энийг нэгэнт ийм байя гэдэг иргэдийн санал байвал хууль санаачлаад, ингээд тэрийг нь хэлэлцье гэдэг ийм шийдвэр нэгэнт гарчихсан юм чинь НӨАТ-ын хуулиа бид нар хэлэлцэх шаардлагатай байх.

Тэгээд энэ ЗГ-ын хөгжлийн төлөвлөгөө жил жилээрээ ингээд гараад явна. Тэгээд энэ хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцээд, бид нар бас энийг энэ парламент бол нэг онцгой цаг үеийн үүрэг хүлээсэн гэдгийг ойлгох хэрэгтэй. Одоо ингээд 126 гишүүн бүрэлдчихсэн, төлөвлөгөөгөө нарийн хэлэлцээд нэг дэх хүртэл ингээд Байнгын хорооддоо саналаа хэлээд, ингээд нарийн хэлэлцээд, дараа нь дүгнэлтээ бас маш нарийн хэмжээнд хийхгүй болбол энэ парламент зүгээр ингээд баримт бичиг, баахан цаас гаргаад орхидог байх юм бол ингээд цаашидаа ер нь төрд итгэх итгэл гэдэг юм байхгүй болно шүү. Тэгэхээр энэ жижиг сажиг ийм явуургүй ойр зуурын ийм улс төрөө орхиод, хэдүүлээ бас энэ улс орны хөгжлийн асуудлууд дээр нэгдсэн байр суурьтай явах нь зөв байх гэж бодож байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Бадрахын Найдалаа гишүүн үг хэлнэ.

**Б.Найдалаа:** 2025 оны Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө болон

төсвийг харьцуулаад үзсэн. Энэ дээр зүгээр анхаарах нэг хэдэн, жижиг асуудлууд бас байна лээ. Төлөвлөгөө дээр тусгачихсан хэр нь жишээлбэл зарим сургууль, цэцэрлэгийг барина гэхихсэн хэр нь төсөв дээр тусгаагүй. Энэ болбол техник алдаа гэж найдаж байна. Энийгээ хянаад, өөр иймэрхүү алдаа байгааг засах байлгүй дээ. Энийг бол анхааруулж байна.

Гол юм ямар ч байсан энэ жилийн хөгжлийн төлөвлөгөө урьд өмнөхийг бодвол ахиц дэвшил байна. 3 нам хамтарсан гол асуудлуудаа, суурь асуудлуудаа хаягласан тийшээгээ чиглэсэн тийм сайн тал байна. Жишээлбэл үндсэн эдийн засгийн суурь шинэчлэлийн чанартай эрчим хүчний реформ бусад явж чадахгүй байгаа том төслүүдээ явуулах талаар төвлөрсөн байна. Бас нөгөө хэрэгтэй, хэрэггүй байшин барилга бариад байдаг байсан бол одоо тэр нь илүү эдийн засгийн суурь бүтэц рүү орсон, дэд бүтэц рүү орсон, эдийн засгийн өсөлтийн суурь болохуйцаар ийм сайн талууд ажиглагдаж байна л даа. Энэ бол сайн тал байна.

Гэхдээ үнэхээр санаа зовж байгаа анхаармаар хэдэн зүйл байна. Ер нь зүгээр яг Монгол Улс ингээд хараад байхад бид нар яаж хөгжих бодлогыг нь цэгцэлж харахгүйгээр шууд ажил руугаа орчихдог. Ажил руугаа орохдоо томоос нь эхэлдэг, жижиг төслийг тоодоггүй, жижиг зүйлийг тоодоггүй, эндээс болж хамаг алдаа гардаг. Би жишээ хэлье л дээ нэг. Жишээлбэл тээвэр логистикийн зүйл дээр байгаа. Монгол Улс сүүлийн олон жил зам бариад л байгаа, зам бариад л, зам бариад л байгаа. Яг үнэндээ болбол яг тэр зам үр өгөөжтэй эсэхийг тооцсон юм байхгүй байгааг байгаа байхгүй юу. Одоо ч гэсэндээ аймгуудыг холбоно гэж байна, сумуудыг холбоно гэж байна. Энэ чинь тэгээд яг хэнд хэрэгтэй, ямар эдийн засгийн өсөлтийг бий болгох юм бэ? Тийм тооцоо байхгүй.

Гэтэл Замын-Үүд боомтын нэвтрэх чадвар ийм муу олон жилийн турш байсаар байгаад Тяньжинь дээр ачаа бөөгнөрснөөс болоод Монгол Улсын гол судас ингээд тасраад, иргэдийн ачааны дийлэнх нь гацчихсан байж байна шүү дээ. Тэгээд хаашаа хөрөнгө оруулахаа тээврийн бодлогоо харж байж, яг хаана эдийн засгийн өсөлт гарах вэ, хаана нь үрэгдэх вэ гэдгээ харахгүй болбол жигдхэн байдлаар бүх бүс рүү, бүх сум руу, бүх аймаг руу логистик бусад дэмжлэгийнх нь систем биш зөвхөн зам бариад байх юм бол энэ бол бүтэхгүй. Тэгээд энэ бол зөвхөн нэг жишээ. Энэ бүх салбар дээр, бүх төслүүд дээр байгаа.

Дараагийн нэг чухал, хамгийн чухал зүйл нь олон том төсөл, мега төсөл гээд хэрэгжүүлж байгаа нь сайн, үнэхээр хэрэгтэй. Гэхдээ нэг санаа зовж байгаа зүйл байна. 3 нам хамтарсан гээд гоё макет хийсэн гээд, гоё үндэслэл хийсэн гээд, том төсөв тавьсан гээд нөгөө Монгол Улсын бид бүгдийн хэрэгжүүлэх чадавх нь хэвээрээ байгаа байхгүй юу. Дарга нар яаж ч хичээсэн энэ том төслийг удирддаг, зохицуулдаг, менежментийг нь хийдэг, судалгааг нь хийдэг, тэгээд нэг төсөв мөнгөө авлига, хулгайгүйгээр явуулж чаддаг тэр чадавх бол бид нар хэвээрээ л үлдэх байхгүй юу. Тэрийг яаж нөхөх юм бэ гэж байгаа. Тэгээд энэ дээр би энэ бол асуулт биш. Бид бүгдээрээ бодит байдлаа мэднэ. Монголд амжилттай явсан том байтугай дунд хэмжээний төсөл хуруу дарам цөөн, ер нь байхгүй гэхэд болно.

Тэгэхээр зүгээр ЗГ-т бол том хариуцлага ирж байгаа. Тодорхой хэмжээний төсвийн орон зай үүссэн. Зээл, тусламж нь байгаа. Энэ дээр энэ том төслүүдийг хэрэгжүүлэхэд авлига, хулгайгаас ангид, үр дүнтэй хэрэгжүүлэх тэр чадавхыг яаж бүрдүүлэх юм энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй байна. Саяхан бид нар бас тэр нефтийн үйлдвэр дээр очсон. Тэр том ажлууд жижигхэн асуудлуудаас болоод нурсан байж байгаа, гацчихсан байж л байгаа байхгүй юу.

Энийгээ шийдэх хэрэгтэй байна. Тийм болохоор ямар ч байсан ЗГ-т том хариуцлага байгаа. Энэ болбол энэ хамтарсан засгийн гол ажил байгаа. Гишүүдийн хувьд болон бусад ХҮН намын хувьд ч гэсэндээ яг саяын байдлууд дээр анхаарч ажиллахгүй алдаа гаргах юм бол хүний өөрийн гэхгүй бид нар шүүмжилж ажиллана. Тэгээд энэ дээрээ сайн хянаад ажиллаарай. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Мөнхтөрийн Нарантуяа-НАРА гишүүн үг хэлнэ.

**М.Нарантуяа-НАРА:** Өдрийн мэнд. Тэгэхээр юуны өмнө 25 оны төлөвлөгөөнд хүний хөгжил, хүний эрхийг дээдэлсэн засаглал гэсэн энэ 2 чухал зүйлийг шингээж өгч байгаад маш их баяртай байна. Хөтөлбөрийн 3.4.21 дээр цалинтай эцэг, эх нийгмийн хамгааллын бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно гээд ингээд заачихсан байгаа. Гэхдээ энэ бол яг 25 оны юун дээр хүний хөгжлийн бодлого, хүний эрхийг юу яах дээр орж ирээгүй байна эсхүл энэ нийт нэгдсэн юугаар явах юм болов уу? Тэгээд хөдөлмөр нийгмийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдад хандаж үнэхээр энэ цалинтай ээжийн 50 мянга гэдэг дүнгээ дахин нэг хараач. 2017 оны 6 сард батлагдсан энэ Цалинтай ээж хөтөлбөр 2018 оны 1 сарын 1-нээс эхэлж хэрэгжиж эхэлсэн. Тэгвэл 2017 оны 6 сард энэ 50 мянган төгрөгөөр юу, юу худалдаж авах боломжтой байсан бэ? Одоо инфляц хэд дахин өсчихсөн байгаа билээ. Тэгээд энийг яг ингээд дахиад энэ 7, 8 дахь жилд нь энэ 50 мянгаар нь үргэлжлүүлэх нь зөв үү. Энийгээ тэгээд олон улсын жишигт нийцсэн хөтөлбөр гэж хэлж болох уу ер нь?

Өнгөрсөн хугацаанд бол өнгөрсөн онд бол нийт хэд гэнэ вэ, 178 мянган, 175 мянга орчим ээжүүдэд юу хийсэн юм байна. Миний бодлоор бол сайдад хандаж хэлэхэд энэ 0-3 нас, 0-3 нас хүртэлх хүүхдэд, хүүхэдтэй ээжүүдэд гэж байна. Энийг миний бодлоор тодорхой

хэмжээгээр насыг нь хумиад 0-2 нас настай хүүхэдтэй ээжүүдэд олгоно гээд. Энэ мөнгөн дүнг нь инфляцад нийцсэн энэ боломжоор нь нэмэгдүүлээд, тэгээд харин нөгөө ясли, цэцэрлэгийн бодлогыг дахин сэргээх, энэ ясли, цэцэрлэгийн хэрэгжилтийг дахин сэргээвэл яасан юм бэ гэсэн ийм саналтай байсан юм. Би түрүүн уг нь санал хэлэх дээр хоцорчихсон учраас үг хэлэх дээр ингээд хэлж байна.

Тэгээд дээрээс нь энэ хүний хөгжлийн бодлого дээр Миний сонголт орон нутаг гэсэн энэ бас хөтөлбөр байгаа юм. Яг үнэндээ Улаанбаатар хотоос залуучууд орон нутгийг зориод, тэнд ажиллаж амьдраад, цэвэр агаарт хүүхдүүдээ байлгаж, тэгээд өөрсдөө боломжит хөдөлмөр эрхэлье, хөдөө аж ахуй, газар тариалан юу байдаг юм боломжит хөдөлмөр эрхэлье гээд очихоор хамгийн том чөдөр тушаа нь ер нь бол тухайн орон нутгийн Засаг дарга нар байдаг шүү. Энэ дээрээ бас сайн анхаараад өгөөсэй гэж бодож байна. Энэ бол бүүр бодит кэйс дээр. Энэ миний асуудал биш, өөр хүмүүсийн асуудал байгаа. Тэгэхээр зэрэг яг энэ Миний сонголт орон нутаг гээд энэ орон нутагт очиж амьдрах хүмүүсийн газрын асуудал дээр ялангуяа орон нутгаас маш их ауткаст тавьдаг байдлыг анхаарч ажиллаасай. Тэгэхгүйгээр энэ Миний сонголт орон нутаг гэдэг хөтөлбөр чинь бол амжилттай сайн хэрэгжихгүй гэдгийг би өөрөө бас мэдэж байна. Тийм учраас энэ тал дээр бас салбар салбарынх нь хариуцсан хүмүүс нь бас анхаарч ажиллаасай гэж бодож байна.

Тэгээд бүүр дахин анхааруулж хэлэхэд энэ Цалинтай ээжийн 50 мянга хөтөлбөрийг үнэхээр яг энэ цаг үед 50 мянган төгрөгт хүүхдийн 2, 3 өдрийн хэрэглээний хэрэгцээний зүйлийг ч худалдаж авах боломжгүй байгаа гэдгийг үнэхээр бодит амьдралаа, хөрсөө, үнийн өсөлтөө, бараа бүтээгдэхүүний үнэ өсөлтөө сайн мэдээсэй. Дээрээс нь халамж тавигдах бүрд үнийн өсөлт явагддаг. Энэ үнийн хөөргөдлийг бас



тодорхой хэмжээнд төр засаг барьж болдог ийм зохицуулалт гэж байна уу? Энэ тал дээр бол үнэхээр төр засаг бас анхаарч ажилламаар байна. Тэгэхээр дахин, дахин хэлэхэд Цалинтай ээжийн 50 мянгыг бол зайлшгүй нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна.

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлнэ.

**С.Эрдэнэболд:** Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг анхааралтай уншлаа. Үндсэндээ 5 бодлогын урт болон дунд хугацааны бодлогын бичиг баримт, Улаанбаатар хоттой холбоотой 1, нийт 6 үндсэн бичиг баримт, 6 төрлийн хөтөлбөр аяны зорилгын хүрээнд буюу нийт 12 төрлийн бичиг баримтын хүрээнд энэ боловсруулагдсан байна. Энд нэг зүйл бол хэлээд байгаа нь 7 сарын 5-ны өдөр бас Ерөнхий сайдыг томилогдоход хэлж байсан санаагаа дахиад хэлэх гээд байгаа нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тэр юуг философийг концепцыг эндээ бас ингэж шалгуур үзүүлэлт болгож явмаар байгаа юм.

Хүнээр төсөөлүүлээд ярих юм болбол бид нар ингээд тодорхой хэмжээгээр өвчин тусчихсан, доторх өвчнөө эдгээхгүй байж шинэ хувцас худалдаж аваад байгаа юм шиг, шинэ машин техник аваад байгаа юм шиг ийм нөхцөл байдалтай Монгол Улс болчихсон байна. Тэгэхээр үндэсний аюулгүй байдлын сэдэв гэдэг чинь өөрөө зөвхөн цэрэг, цагдаа ч юм уу, онцгой сэдэв гэхээсээ илүүтэйгээр бидний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, өдөр тутам зүй бусаар иргэдийн маань амь нас хохирч байгаа энэ нөхцөл байдал болчихоод байгаа. Тийм учраас энэ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тулгуур үзэл санааг энэ жил болгоныхоо хөгжлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт болгож байгаасай гэсэн нэг саналыг хэлэх гэсэн юм нэг.

2 дугаарт нь болохоор Улсын Их Хурлын дарга удаа дараа хүн төвтэй бодлогыг хэрэгжүүлнэ. Энэ парламентын бас нэг зорилго болбол 126 болсон энэ зорилго болбол энэ хүн төвтэй бодлогыг хэрэгжүүлнэ. 2 дугаарт энэ хүний эрхийг дээдэлсэн байна гэдэг энэ зарчмыг яриад байгаа. Би бол дэмжиж байгаа. Тэгэхээр энэ бүлэглэл нь болбол бүлэг нь 1 дүгээрт эдийн засаг, 2 дугаарт бол бүсчилсэн хөгжлийн бодлого, 3 дугаарт хүний хөгжил, 4 дүгээрт хүний эрхийг дээдэлсэн засаглал гэсэн ийм эрэмбэтэй байгаад байгаа юм. Тэгэхээр ер нь болбол энэ Хөгжлийн хөтөлбөр маань ер нь зөв эрэмбэдээ орох ёстой гэж үзэж байгаа юм.

Эхлээд ер нь бид нар ингээд эдийн засгийн асуудал чинь мэдээж хөгжлийн бодлоготойгоо 99 хувь холбогдож байгаа ч гэсэн хамгийн эхлээд энэ эрэмбэ нь хүний хөгжлийн бодлогоосоо эхлэх ёстой. Энэ болбол бодлогын 1 дүгээр эрэмбэ, 2 дугаарт нь болохоороо хүний эрх, нөгөө авлигын асуудал эд нар дээрээ тодорхой зорилтуудаасаа эхэлж явах ёстой. Энэний дараагаар эдийн засгийн бодлого нь эхний тэр хүний хөгжлийн бодлого, Монгол Улсын өрсөлдөх чадвар луу чиглэх ёстой юм, хүний эрх рүүгээ чиглэх ёстой юм гэдэг утгаар нь эдийн засгийн бодлого бол 3 дугаарт, улмаар түүнийг хэрэгжүүлэх арга зам болсон бүсчилсэн хөгжлийн бодлого бол 4 дүгээрт эрэмбэлэх ёстой юм. Тэгэхгүй болохоор хамгийн сүүлд нь эрх чөлөөгөө, хамгийн сүүлд нь хүний хөгжлөө тавьчихдаг. Гэтэл өнөөдөр бид нар хэдэн мянган фэйсбүүкээр өвчтэй хүүхдүүдийн хандивын аян гээд маш олон юмыг үздэг. Утааны асуудлыг ингээд үздэг.

Товчхондоо гэж хэлэхэд ингээд салбарын яамнуудаас орж ирж байгаа бодлогыг зүгээр ингээд багцлаад тавьчихсан байгаад байгаа юм. Энэ дотор чинь уялдаа холбоо, логик, давхцалгүй байдал байх ёстой. Бид нар нэг л улсын тухай ярьж байгаа. Өөрөөр хэлбэл ингээд биологийн организм гэж

үзэх юм болбол бид нарын хамгийн том зорилго болбол хүн төв рүүгээ л чиглэх ёстой энэ бодлого чинь. Тийм учраас энэ ЗГ-аас оруулж ирж байгаа энэ саналаа эрэмбийн хувьд эргээж хараач гэж хэлэх гэж байна.

2 дугаарт дахиад хэлэхэд тэр Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа шалгуур үзүүлэлтүүд болгооч гэж байгаа юм. Тухайлбал энэ жишээлбэл тэр 6 төрлийн аян хөтөлбөр гэдэг нь ихэвчлэн сонгуулийн хөтөлбөрүүд бол явж байгаа. 5 бодлогын үндсэн бичиг баримт гэдэг нь болох юм болбол урт, дунд хугацааных явж байгаа. Гэхдээ нарийн ажиглах юм болбол дотор нь маш олон төрлийн хийдэл, зөрчлүүд байгаа юм. Ижилсээгүй зүйлүүд бас байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар ингээд эмх цэгцгүй байдал дээр логик гарч чадахгүй, логик гарч чадахгүй болбол зорилго бүдэг гарна. Зорилго бүдэг гарах юм болбол хэрэгжилт муу болно, хэрэгжилт муу байх юм болбол хэмжиж чадахгүй болно. Ингээд үр дүн гарахгүй гэсэн үг.

Ингээд 14 мега төсөл, 149 тогтвортой байдлын төслийг явуулна. 4 төрлийн, 4 салбарт реформ эрчим хүч, тээвэр, хөдөө аж ахуй, банк санхүү гэж байгаа. Ийм деталь салбарын реформуудыг явуулна гэж байгаа болбол нөгөө түрүүн Их Хурлын даргын байнга хэлээд байгаа нөгөө хүн төвтэй бодлого, нөгөө хүний эрхийг дээдэлсэн засаглал гэдгээ энэ дотроо болбол маш том удиртгал, хэмжих тийм шалгуур болгож өгмөөр байгаа байхгүй юу. Энэ чинь хэмжигдэхүйц зүйл байхгүй юу. Авлигын индексийг мэднэ, хүний хөгжлийн индексийг мэднэ, өрсөлдөх чадварын индексийг мэднэ гэж. Тэгэхээр бүтцийн хувьд бол би энэ саналыг гаргаж байгаа юм. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Дашицэрэнгийн Энхтүвшин гишүүн үг хэлнэ.

**Д.Энхтүвшин:** Эдийн засгийн бодлоготой холбоотой саналуудаа хэлье.

Ер нь эдийн засгийн бодлого дээр эрэлтийн болон нийлүүлэлтийн гэсэн 2 төрлийн бодлогууд арга хэмжээнүүд авч хэрэгжүүлдэг. Тэгээд өнгөрсөн хугацаанд болбол илүү эрэлтийн шинжтэй өөрөөр хэлбэл төсөвтэй холбоотой, нийтийн санхүүтэй холбоотой, public-тай холбоотой ийм арга хэмжээнүүд авч байсан. Тэгэхээр уг нь хамтарсан ЗГ бий болсон дээрээ эхэнд нь энэ урт хугацаанд үр дүн нь гардаг нийлүүлэлтийн шинжтэй энэ эдийн засгийн бодлогуудаа эхэлж хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй байхаар юм уу гэж бодсон.

Тэгэхээр хугацаа тулаад ирчихээр нийлүүлэлтийн бодлогууд хугацаа шаарддаг учраас үр дүн гарах нь удаан байдаг. Тэгэхээр уг нь энэ сонгуулийн дөнгөж эхний энэ парламентын үедээ энэ чиглэлийн арга хэрэгслүүд авах нь зөв байсан юм уу гэж бодож байна. Энэ дотор жишээлбэл энэ татвартай холбоотой асуудлууд байна. Яг үнэндээ бол жишээлбэл манай татварын гол сууриудын жишээлбэл жижиг, дунд ААН-тэй холбоотой ийм бас хангалттай хэмжээнд байхгүй байна. Жишээлбэл жижиг, дунд ААН-үүдийн хувьд нийт татварын 50 хувь, ажил олголтын 90 хувийг жишээлбэл хангаж байгаа ийм том салбар байгаа.

Яг энэтэй холбоотой энэ бодлогуудаа эхэнд нь жишээлбэл дэмжих, татвартай холбоотой, нийгмийн даатгалтай холбоотой, энэ хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой бодлогуудаа зоригтой хийгээд эхэлчихвэл хугацаа шаардах учраас 4 жилийн дараа гэхэд бол илүү бодитой үр дүн, тэгээд дээр нь энэ эрэлтийн талынхаа энэ эдийн засгийн бодлогуудтай хослуулаад явбал илүү үр дүнтэй байхаар юм уу гэж харагдаж байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр уг нь ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээр бас нэлээн заалтууд орсон байгаа. Үүнээсээ бас аваад, боломжтой болбол энэ Хөгжлийн хөтөлбөр дээрээ оруулаад явбал зүгээр юм уу гэсэн ийм санал байна.

**Д.Амарбаясгалан:** Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн үг хэлнэ, алга байна. Гонгорын Дамдинням гишүүн, алга байна. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн үг хэлнэ.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Үг хэлэх боломжоо ашиглан боловсролын салбарын нийт багш, ажилчдадаа Монголын багш нарын 30 дахь өдөр, Монголын багш нарын 58 дахь өдөр, Дэлхийн багш нарын 30 дахь өдрийн халуун мэндийг хүргэж, Монгол Улсын гэрэлт ирээдүйг сурган хүмүүжих их үйлсэд нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Жил бүр ЮНЕСКО-оос тусгайлсан уриалгатайгаар дэлхийн 100 гаруй улсад багш нарын өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ жилийн уриалгыг Их Хурлын нийт гишүүдийг анхааран сонсохыг бас хүсэж байна. 2024 оны Дэлхийн багш нарын өдрийн уриа бол боловсролын төлөөх шинэ нийгмийг бүтээхэд багш нарын дуу хоолойг хүргэх нь сэдвийн хүрээнд тэмдэглэх бөгөөд анхаарал татаж буй асуудлуудын талаар багш нар дуу хоолойгоо хүргэхийг уриалах, тэдэнд тулгардаг асуудлуудад асуудлуудыг нийтийн анхааралд хандуулах, мөн хамгийн чухал нь тэдний боловсролд оруулж буй мэргэжлийн мэдлэг, оролцоог хүлээн зөвшөөрөх нь хамгийн чухал юм гэж онцлон тэмдэглэжээ.

2025 оны улсын төсөв хэлэлцэж буйтай холбогдуулан Боловсролын сайд Наранбаяраас асуумаар хэдэн асуултууд байгаа юм. 25 оны улсын төсөвт нийт төрийн албан хаагчийн цалинг 6 хувиар нэмэгдүүлэхээр оруулсан байгаа. Гэтэл энэ 6 хувь нь 1 сая 400 мянган төгрөгийн цалинтай багшид 84-хөн мянган төгрөг оногдож байгаа. Түүрүүн Бум-Очир гишүүн хэлсэн. Энэ 84 мянгаас гадна дахиад багшийн цалинд нэмэлт урамшуулал маягаар багш нарынхаа цалинг ямар нэгэн байдлаар нэмэх шаардлага байна гэдгийг бас Бум-Очир

гишүүн сая онцлон хэлж байна. Бум-Очир гишүүнд баярлалаа. 2025 оны улсын төсөвт ингээд 6-хан хувиар нэмнэ гэдэг бол үнэхээр хангалтгүй. Энэ дээр сайд ямар байр суурьтай байгаа вэ? Үндсэн цалинг нэмэгдүүлэх олон боломж байгаа. Жишээ нь гүйцэтгэлийн үнэлгээг үндсэн цалинд оруулахад багшийн цалин 1 сая 800 мянган мянган төгрөгт хүрэх ийм бас тооцоо судалгаа бид нарт байгаа шүү. Энийг Наранбаяр сайд надтай ярилцаж болно шүү гэдгийг бас хэлмээр байна.

Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 3,8 сая төгрөг авч байгаа мэтээр 1000 гаруй багш авч байгаа мэтээр та мэдээлэл өгсөн байгаа. Тэгэхээр 1,4 сая төгрөгийн цалинтай багш 180 хувийн нэмэгдэл авч байж энэ таны хэлсэн 3 сая 800 мянган төгрөгийг авна. Тэгэхээр та яаж энэ дүнг гаргасан бэ гэдгээ бас энэ боловсролын салбарынхандаа тайлбарлаж өгөөрэй. 24-өөс 25 оны хичээлийн жилд 4200 багшийн дутагдалтай байгаа гэсэн. Өнөөдөр хичээл эхлээд сар өнгөрч байна. Энэ хугацаанд энэ орон тоо яг хэдэн багшаар нөхөгдөж, үйл ажиллагаа жигдэрч яваа вэ гэдгийг бас сайдаас асуумаар байна. Өөр мэргэжлийн хүмүүсийг мөн 45 хоногийн курсээр багш бэлтгэх тухай ярьсан. Сүүлдээ бүүр өндөг шидүүлээд, салбарын багш нараа мэдлэг, чадваргүйгээр нь дуудаж, доромжилж, гүтгэсэн. Үүн дээрээ энэ чуулганы индрээс уучлалт гуйхыг танаас бас шаардаж байна. Монголын мянга мянган багш нарын өмнөөс.

Боловсролын салбарт 50 мянга орчим багш байгаа. Энэ багш нартаа жилд ганц тэмдэглэдэг багш мэргэжлээрээ омогишиж, бахархдаг энэ өдрөөр нь чихэнд чимэгтэй дуулгах ямар таатай мэдээ байгаа вэ? Наранбаяр сайдад хаяглаж багш нар асууж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ганзоригийн Лувсанжамц гишүүн үг хэлнэ.

**Г.Лувсанжамц:** Эрхэм төрийн түшээдэд өдрийн мэнд хүргэе. Эдийн засгийн байнгын хороон дээр, та дуугүй байж байхгүй юу, би ярьчихъя тэгэх үү. Би үг хэлж байна шүү дээ. Та, би үг хэлчихье л дээ. Болохгүй юм уу Пүрэвдорж гишүүн ээ?

**Д.Амарбаясгалан:** Пүрэвдорж гишүүн.

**Г.Лувсанжамц:** Миний цаг шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Би цагаа эхнээс нь авъя.

**Д.Амарбаясгалан:** Шинээр эхэлье, минутыг шинээр өгье. Юу болчхов. Пүрэвдорж гишүүн чуулганы хуралдаан үймүүлэхгүй шүү. Лувсанжамц гишүүн, үгийг шинээр эхлүүлэе.

**Г.Лувсанжамц:** Дуугүй болохгүй бол би ярьж чадахгүй юм байна шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** Үг хэлье.

**Г.Лувсанжамц:** Даргаа энэ болихгүй байна шүү дээ, яах вэ?

**Д.Амарбаясгалан:** Сануулах арга хэмжээ авах юм уу?

**Г.Лувсанжамц:** Тийм, сануулга өгмөөр байна.

**Д.Амарбаясгалан:** Лувсанжамц гишүүн үгээ эхэлье. Пүрэвдорж даргаа. Үгээ эхэлье, шинээр эхэлье.

**Г.Лувсанжамц:** Хурлын дэг гэж байгаа шүү дээ, би үгээ хэлчихье Пүрэвдорж гишүүнээ. Та дараа нь бас хэлж болно шүү дээ. Танд хэлэх цагаа энэ кнопоо дараад авчхаж болно шүү дээ. Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Пүрэвдорж гишүүний мэндийг

амрыг эрье. Би одоо яах вэ? Эдийн засгийн байнгын хороон дээр ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 жилд төлөвлөсөн ажлууд нь 25 оны хөгжлийн төлөвлөгөөнд ороогүй байна гэсэн зүйл, заалтуудыг хэлсэн.

Гэхдээ энэ зүйлийг би сая энэ өчигдрийн Эдийн засгийн байнгын хороон дээр анх удаагаа хэлээгүй. Ээлжит бус чуулган дээр яамнууд үр дүн дээрээ суурилоод төлөвлөдөг байя, хөгжлийн төлөвлөгөөгөө гаргая, жил болгоноор бага багаар ингээд урагшаагаа нэг, нэг алхаад явдаг байя гэсэн. Үр дүнд хүрэхийн төлөө л төлөвлөгөө гаргадаг байя гэсэн саналыг хэлээд, ойлголоо, ингээд хэрэгжүүлээд тэрэнд нь нийцүүлээд бодлогын бичиг, хөгжлийн бичиг баримттаа төлөвлөгөөгөө зохиогоод ирнэ гэсэн, байхгүй. Тэгээд ер нь ингээд харж байхад зүгээр нэг тийм асуулт, хариулт нь ямар ч бодлогын мэтгэлцээн ерөөсөө алга байна.

Тэгээд өмнө нь хэрэгжүүлсэн төслүүдийг үргэлжлүүлээд хийнэ гэж байгаа зүйлээ эхлээд үр дүнгээ ярьчихдаг болмоор байгаа шүү дээ. Жишээ нь нийгмийн даатгалаар малчдын нийгмийн даатгалын 50 хувийг нь бусад аж ахуйн хөдөлмөр эрхэлдэг хүмүүс нь дааж байгаа шүү дээ. Тэгээд энэ гол зорилго нь болбол нүүдлийн соёлоо хамгаалъя гэсэн тийм зорилготой л гэж би бодоод байгаа юм. Тэгээд яг 50 хувийг нь дааснаараа малчдын тоо ихсээд байгаа юм уу, нүүдлийн МАА, соёл хамгаалагдаад байгаа юм уу гэсэн үр дүн байгаа юм уу, үгүй юм уу гэдэг дээр л асуулт байгаад байгаа юм л даа.

Барилгын салбар дээр бас адилхан ингээд нэгдсэн нэг л төлөвлөлттэй болъё. Замыг нь тусдаа төлөвлөдөг, дулааны усыг нь тусдаа төлөвлөдөг, бохирыг нь тусдаа төлөвлөдөг, усыг нь тусдаа төлөвлөдөг. Тэгээд дээрээс нь явган замаа тавиад, машины замаа ингээд засаад тавьчихаар дараа жил нь очоод ухаад авчихдаг. Төсвийн ингээд хөрөнгө мөнгө,



татвар төлөгчдийн мөнгийг ерөөсөө ингээд төрийн хоорондын уялдаагүй гэсэн нэг ийм их энгийнээр шийдэх боломжтой ийм зүйлийг хийж чадаагүйгээсээ болоод маш олон тэрбум төгрөгийн зардал ингээд салхинд хийсээж байгаа шүү дээ. 4 жилийн хөтөлбөр дээр оруулсан юм. Нэгдсэн нэг төлөвлөлттэй больё.

Их Хурлын даргын хэлж байгаагаар хүн төвтэй хууль, эрх зүйн орчин бий болох ёстой, хүн төвтэй иргэдийнхээ, оршин суугчдынхаа, ААН-үүдийн саналыг аваад, төлөвлөгөөгөө зохиодог больё ийм ажлыг хэрэгжүүлбэ, эхлүүлбэ гээд 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээр оруулаад тавьсан чинь 25 оны хөгжлийн төлөвлөгөө дээр тэр ажил нь тусгагдаагүй. Уг нь энэ бол их хөрөнгө мөнгө зараад байхгүй, их хямдхан аргаар хийж болох маш том хууль, эрх зүйн орчны, бүтээн байгуулалтын, хөрөнгө оруулалтын сайжруулах боломжтой ийм зүйл байгаа шүү дээ. Ийм зүйлээ хийе гэж хэлмээр байна.

Хоёрдугаарх нь Хяналт үнэлгээний үндэсний хороо гээд Эдийн засгийн байнгын хороон дээр орж ирдэггүй юм байна лээ л дээ. Төрийн энэ дижитал шилжилтийг хариуцаж байгаа нь Хяналт үнэлгээний үндэсний хороо болсон гэж ойлгосон. Төр ядаж нэг хоорондоо энэ үүлэн системтэй болмоор байна. Cloud системтэй, хоорондоо материалуудыгаа харчихдаг, шууд ороод авчихдаг. Хэсгийн ахлагч нартай СХД, ЧД-ийн хэсгийн ахлагч нартай уулзсан чинь ингээд дээрээс 3 өөр байгууллагаас захиалга ирдэг, тэгээд судалгаа гаргаад өгөхөөр нөгөөх нь ингээд хоорондоо жилдээ ингээд ямар судалгаа хийсэн гэсэн нэг жилийн дотор 3 удаа золбин нохой, муурыг тоолуулчихсан байгаа байхгүй юу. Нэг тоолуулаад л тэр датаг үүлэн системд байршуулах ёстой шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлнэ.

**Д.Ганбат:** Бид нар мэднэ ер нь МАН-ын дарга, Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ бол дандаа л үлгэр ярьж байдаг тийм ээ. Үлгэр ярьдаг хүмүүсийн тоо бас ихсээж байна. Манай энэ Гантөмөр, энэ Доржханд энэ тэр гээд. Ер нь бол тэгээд харж байхад бол нэг сүржин, сүржин хөтөлбөрүүд ярьдаг, төлөвлөгөө ярьдаг. Биелэгдэж байгаа биелэлт бол байдаггүй шүү дээ. Бид нар хэдэн макетуудтай л үлддэг. Түрүүн би бас асуулт асуулаа. Үгүй ээ тэгээд яг олигтой хариулт өгчихгүй юм байна шүү дээ. Эрчим хүчний үнэ чинь хэд болох юм бэ, дулааны үнэ чинь хэд болох юм бэ? Тов тодорхой асуулт асууж байгаа байхгүй юу. Кембрижийн хөтөлбөртэй сургууль яахаараа Архангайд байдаггүй юм, яахаараа Баянхонгорт байдаггүй юм, яагаад Өвөрхангайд байдаггүй юм, яахаараа тэр Хэнтийн Бэрх тосгонд байж байдаг юм. Тэр үнэн юм уу, худлаа юм уу гэж асуулаа. Хариулдаггүй. Нэг ийм л байгаа байхгүй юу. Үгүй ээ тэгээд бид нар нэг авлигажсан нийгэм л бүтээж байна шүү дээ. Одоо тэр юу билээ, ямар mining... гэж байсан билүү, үгүй ээ тэрэн дээр ирдэг хүн ч байхгүй болчихсон байна лээ шүү дээ. Гаднын хөрөнгө оруулалт энэ тэр бол. Ийм авлигажсан, ийм хулгайтай газар бол хэн ч орж ирэхгүй тэр ойлгомжтой.

Халамж бол хавтгайрсан. Тэр халамж нь олигтой ч халамж өгдөггүй, эзнээ ч олдоггүй, нэг өдөр өнгөрөөх төдий тийм л байдалтай байна. Эндээс явсан тэр АНУ-д 30-аад мянган Монгол байна гэж байгаа. 2, 3 жил болоход хараар ч бай, ямар ч байдлаар бай бүгдээрээ бизнестэй болж байна шүү дээ. Монгол хүн ингээж чадаж байгаа байхгүй юу. Гэтэл манай улс оронд тийм юм алга. Ардчилсан, ер нь бид нар нэг намтай ч юм уу, ер нь нам байгаа юм уу Монгол Улсад, нэг дэглэм бий болох гээд байгаа юм уу. Охин дагуул намтай ийм л улс орон болчихоод байна шүү дээ. Яг энэний жишиг бол бид нар мэдэхгүй биш мэднэ. Ингээж хөгждөггүй. Одоо нэг нүүрсний үнэ гайгүй байна. Энд бүх хил рүүгээ төмөр замыг

өргөн төмөр замаар тулгачихсан, 3, 4 зам байгаа. Аль нь ч холбогдохгүй. Одоо тэрийг холбоно гэж баахан бас шантааж шиг юм хийнэ. Тэгж байтал нөгөө нүүрсний үнэ нь унана, хэрэггүй болно. Нефтийн үйлдвэр нь баригдаад дууслаа, нефть нь байхгүй, бүгдийг нь зөөчихсөн иймэрхүү л байдалтай байна.

Яаж бодохоороо, яаж юм хийхээрээ ингэж хийдэг юм бэ. Одоо нэг жсоохон уул уурхайн бүтээгдэхүүний үнэ гайгүй байна. Энэ чинь дандаа ийм байхгүй шүү дээ. Тэрийг ойлгомоор байна. Хэрвээ энэ 14 сайхан мега төслөө хэрэгжүүлж чаддаг байсан бол Ардын нам дангаараа хийчихнэ шүү дээ, гоё болгочихно гээд. Тэгээд бүтэхгүй л байхгүй юу даа амьдрал дээр. Өмнө нь хэрэгжиж хийсэн тийм хөтөлбөр, төсөл ямар юм байна вэ? Дарханы замыг 8 жил бариад л одоо болтол оруулж чадаагүй л явна шүү дээ. Нефтийн үйлдвэрийг хэчнээн жил хийж байна. Энэ боомтуудаа төмөр замаар холбож чадахгүй л байна шүү дээ. Энэ манай урд хөршийг тойрсон бүх улс орон энэ дэлхийн 2 дахь эдийн засагтай холбогдохсон байгаа шүү дээ. 2-хон жилийн дотор Хөх хот метро хийж байна шүү дээ ковидын үе. Нэг их хол яваад асуугаад, сураад байх юм ерөөсөө алга. Тэгээд ийм их мөнгийг ийм үр дүнгүй ингэж үрж байгаа нь харамсалтай. Нийгмийн даатгалын сан гэхэд дамтуурсан гэж байна. Бас л яасан юм хулгай зэлгий ороод ажилласан юм уу, ямар байсан юм. Яахаараа багш нар.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** 1 гишүүн үг хэлснээр санал хураалт явагдана. Тэгэхээр гишүүд танхимд цуглахыг хүсье. Ажлын цаг дуусаагүй байгаа. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ.

**Л.Мөнхбаясгалан:** 25 оны хөгжлийн хөтөлбөр эхний хэлэлцүүлгийн үеэр нэг тун харамсалтай гайхалтай юм мэдэж авлаа. Говийн бүсийн малчид надад маш энгийн асуудлыг Монголын

төрд уламжилж өгөөч гэсэн юм. Бид төрсөн сумдаа, төрсөн нутагтаа малаа маллаад тайван амьдармаар байна, энэ бололцоог минь хангаж өгөөч гэсэн юм. Гэтэл энийг хариуцдаг, энийг мэддэг яам ч байхгүй юм байна, сайд ч байхгүй юм байна. Уул уурхайн бүсэд бэлчээр нь орчихлоо, хаваржаа, өвөлжөө нь орчихлоо гэхэд тэр бол тэр хүний хувийн өмч нөхөн төлбөр өгөөд шийдчихэж болж байна. Тэгвэл малчин хүний бизнес малаа маллах, бэлчээрт малаа маллах байхгүй юу нүүдлийн МАА-н бизнес. Гэтэл бид нар өнөөдөр уул уурхайд нь боломж олгоод, малчин хүний боломжийг хааж байгаа. Тэгсэн хэр нь мал бол, малчин бол манай улсын даян дэлхийд дангаарших үндэсний өв, соёл, үнэт өвийг тээгч эд нар гэж ярьдаг хэр нь малчдаа сумд нь, аймагт нь тайван амьдруулахыг хэлчих сайд, бодлого гаргачих яам байхгүй байна гэдэг энэ маш харамсалтай. Үнэхээр харамсалтай байна.

Бид нар хөгжлийн хөтөлбөр ирэх жил яаж 85 сая тонн нүүрс экспортлох вэ гэдэг дээр Сангийн сайд толгойгоо гашилгаж болно. Бусад яамд, Улсын Их Хурлын гишүүд хүн төв рүүгээ жсоохон анхаараад өгөөч. Уул уурхайн нөлөөллийн бүсэд иргэд амьдарч байна. Манай говийн бүсийн урд сумууд бүгдээрээ уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдардаг. Эрүүл мэнд нь доройтож байна, ундны ус нь шаардлага хангахгүй гээд дүгнэлт гарчихсан байхад тэд нар ууж байна. 100км, 200км-ээс уух усаа татаж авчирч байна. Уул уурхайн компаниудын нөлөөлөлд сум орон нутгаараа орчихсон, иргэдийн хурал нь, Засаг дарга нь орчихсон иймэрхүү байр байдалтай байгаа. Тэнд хүн амьдардаг. Жишээ нь Цогтцэций сум усгүй болсон. Цогтцэций сум тэр чигээрээ нөлөөллийн бүсэд орсон. Эрүүл мэндийн байдлыг маань шалгаад тогтоогоод өгөөч, эрүүл мэндийн нөхөн олговор олгох юм бол шалгаад өгөөч гэхэд 4 жил яам нь хайхрахгүй сууж байна. Дөнгөж сая би Мөнхсайхан сайдад энийг ярилаа. Мөнхсайхан сайд энэ дээр харин анхаарал тавиад, ажиллаад өгье гэлээ.

Бид үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар гэж маш гоё үгийг ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт оруулсан. Энэ дээр бид нар техник технологи, мөнгө л тавьсан байна. Нөгөө хилчдийн амьдрал, нөгөө цэргийнхний амьдрал байхгүй, багш нарын асуудал бас л тийм. Хөдөө орон нутагт багш нар 18м<sup>2</sup> байранд 2, 3 гэр бүлээрээ амьдарч байгаа. Хүүхэдтэйгээ, нөхөртэйгөө, эхнэртэйгээ. Энэ асуудлуудыг нь шийдэж өгөх талаар хэдүүлээ бодолцох цаг болсон байна.

Цагаан хад гэж суурьшлын бүс байдаг юм, сонссон байх. Нүүрсээ гаргадаг юм. Тэнд бас хүмүүс амьдардаг. Хайрхан багийнхан тэнд амьдардаг. Хүмүүс амьдардгийг манай энэ яам төрийнхөн мэдэхгүй байна л даа. Эд нар элэгний өвчтэй, ходоодны өвчтэй болсон, харшлын өвчтэй болсон. Тэгээд хэзээ бид нар хүнээ бодож бодлогоо гаргах юм бэ? Одоо хэдүүлээ энэ 25 оны хөгжлийн хөтөлбөр эхний хэлэлцүүлэг явагдаж байна. Дараа нь бид нар маргааш төсөв ярина. Энэ дээрээ хүнээ жоохон түлхүү анхаарцгаая. Энэ саналыг, энэ үгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6-д заасны дагуу жилийн төлөвлөгөөний төсөл Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-д заасан шаардлага хангасан эсэх талаар санал хураалтыг явуулахаар байгаа. Гишүүд танхимдаа цугласан уу? Бүртгэлийн санал хураалт, гишүүдийг тоолъё. Танхимд хэдэн хүн байна вэ, бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд танхимдаа орж ирье, санал хураалт эхэлъе.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-д заасан шаардлагыг

хангасан байна гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгоё, төхөөрөмж гацсан байна. Шинээр эхлүүлъе. Дэлгэц дээр гарч ирэхгүй байна. 6.10-д заасан шаардлагыг хангасан байна гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 51 гишүүн дэмжиж, 50,5 хувиар санал дэмжигдлээ. Дэмжсэн санал өгсөн гишүүдийн төхөөрөмж саатал үүссэн байна. Гишүүд протоколд тэмдэглэе. Номин сайд, Энхтүвшин гишүүн, Баярбаатар гишүүн, Амарбаясгалан миний бие бас төхөөрөмжийн саатлаас болоод өгч чадсангүй. Ингээд нийт 55 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

17.55 цаг

Ажлын цаг дуусаж байгаа учраас өнөөдрийн хэлэлцээж амжаагүй асуудлыг маргаашийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлууллаа. Чуулганы хуралдаан хаасныг мэдэгдъе.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА